



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

Гарын авлага

Зөвлөх:

Доктор, дэд проф. Д.Солонго

Боловсруулсан:

Г.Банзрагч (Доктор, дэд проф)

Б.Тэмүүлэн (Доктор, дэд проф)

Б.Амарбаясгалан (МА)

*Энэхүү гарын авлагыг Хууль зүйн яатнаас хэрэгжүүлж буй
Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах”
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар хот
2012 он

DDC
340.07'015
X-758

Дэлхийн банкны «Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах» төсөл

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ГАРЫН АВЛАГА

Зөвлөх: Доктор, дэд проф. Д.Солонго

Боловсруулсан: Г.Банзрагч (Доктор, дэд проф)
Б.Тэмүүлэн (Доктор, дэд проф)
Б.Амарбаясгалан (МА)

Хэвлэлийн хуудас: 14.2

Цаасны хэмжээ: В5

Хэвлэсэн тоо: 1200

Хэвлэсэн газар: “СОДПРЕСС” Хэвлэлийн компани

ISBN: 978-99962-54-47-5



ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН БАГШ, ОЮУТАН НАРТ



Монгол Улсын Засгийн газрын Хууль зүйн салбараа шинэчлэх санаачлагыг анхлан дэмжсэн хандивлагчдын тоонд Дэлхийн банк зүй ёсоор ордог билээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2002-2008 онуудад Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд эрх зүйн шинэтгэлийн чухал хэсэг болох Эрх зүйн бакалаврын боловсролын агуулга, чанарыг олон улсын түвшинд нийцүүлж, сайжруулах ажлын эхлэл тавигдсан юм. Тухайлбал, “Эрх зүйн дээд боловсролын Монгол Улсын стандарт”-ын анхны хувилбар, түүний дагуу 31 хичээлийн жишиг хөтөлбөр, эдгээрээс 14 хичээлийн оюутанд зориулсан гарын авлага зэргийг боловсруулж, сургалтын арга барилыг шинэчлэхэд чиглэсэн ажлууд хийгдсэн. Эдгээр хөтөлбөр, гарын авлагыг 2007-2008 онд эрх зүйч бэлтгэдэг бүх их, дээд сургуулиудын оюутнуудын хүртээл болгосон.

2009 оноос Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд дээрх ажлын үргэлжлэл болох оюутанд зориулсан нийт 20 гаруй хичээлийн гарын авлага боловсруулах ажил хийгдэж байна. Энэ ажлыг хууль зүйн салбарын нэр хүндтэй, туршлагатай эрдэмтэд, багш нар болон идэвх, санаачлагатай залуу багш нараас бүрдсэн нийт 60 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж байна.

Төслийн зохицуулагч Больхорлоогийн Сарантуяа

ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



Боловсрол судлаачид болон багш нар сургалт явуулах үзэл баримтлалыг боловсруулахдаа хоёр янзын хандлагыг баримталж байна. Нэг дэх нь илүү уламжлалт хэлбэрийнх бөгөөд агуулгад чиглэсэн баримтлалыг дагадаг байхад хоёр дахь нь үр дүнд анхаардаг.

Агуулгад чиглэсэн хандлагаар бол сургалтын агуулгыг тухайн шинжлэх ухааны мэдлэг, ойлголт тодорхойлдог. Харин үр дүнд чиглэсэн хандлага нь мэдлэгт анхаарахаас гадна суралцагчдын ур чадвар, хандлага үнэт зүйлсийн хөгжилд анхаардаг.

1990-ээд оноос хийсэн эрх зүйн шинэчлэлт нь хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг шинэчлэх, боловсронгуй болгохыг шаардсан юм. Хууль зүйн яам, Дэлхийн банкны “Хууль зүйн үйлчилгээг сайжруулах” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг дэмжих” дэд төслийн боловсруулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагын шинэлэг тал нь:

- Агуулгад суурилсан хөтөлбөрөөс агуулга, үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулсан.
- Зорилго, хүрэх үр дүнд тодорхой болгосон.
- Онолын мэдлэгийг эзэмшүүлэхийг зорихоос гадна мэргэжлийн чадвар эзэмшүүлэх, үнэт зүйлсийн төлөвшилд нь нөлөөлөх зорилго тавьсанд оршино.

Төслийн зөвлөх Ухнаагийн Туяа (Ph.D)

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА



Дамдинсүрэнгийн СОЛОНГО **Хууль зүйн ухааны доктор, дэд профессор**

МУИС-ийн Хууль Зүйн Сургуульд 1983 оноос хойш тасралтгүй багшилж байна. Д.Солонго нь Үндсэн хуулийн эрх зүй, Хүний эрхийн чиглэлээр голлон судалгааны ажил хийдэг. Өнгөрсөн хугацаанд дангаар болон бусадтай хамтарч 10 гаруй ном, сурах бичиг, гарын авлага бичиж 30 гаруй илтгэл олон улсын болон улсын хэмжээний эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлж, 40-өөд өгүүлэл хэвлүүлсэн болно.

Түүнчлэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай 10-аад төсөлд багийн ахлагч болон гишүүнээр ажилласан.



Батаагийн ТЭМҮҮЛЭН **МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхмийн эрхлэгч,** **Хууль зүйн ухааны доктор, профессор**

Иргэний эрх зүйн сурах бичиг, нэг сэдэвт судалгааны ном, гарын авлага, бодлогын судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэг 30 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл хэвлүүлсэн. Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн.




Гочоогийн БАНЗРАГЧ **Хууль зүйн ухааны доктор**

МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхмийн дэд профессор, тус сургуулийн Эрдмийн Зөвлөлийн гишүүн, Өмгөөлөгчдийн Мэргэжлийн хорооны гишүүн, ТЕГ-ын дэргэдэх Эрдэмтэдийн Зөвлөлийн гишүүний үүрэгт ажлыг тус тус гүйцэтгэдэг. ХБНГУ-ын Байротын Их сургуульд хууль зүйн ухааны магистрын (LL.M.) болон докторын зэрэг хамгаалсан. Тэрээр дангаараа болон бусадтай хамтран 10 орчим ном, сурах бичиг, гарын авлага, 20 орчим эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, бичиж хэвлүүлсэн бөгөөд төрийн болон олон улсын байгууллагын захиалгаар 10 орчим судалгааны ажилд төслийн багийн гишүүнээр ажилласан. Захиргааны процессын эрх зүй, захиргааны эрх зүйн тусгай анги (эдийн засгийн захиргааны эрх зүй, ашигт малтмалын эрх зүй, барилгын эрх зүй гм.)-ийн чиглэлээр судалгааны ажил хийж байгаа болно.



Болдын АМАРБАЯСГАЛАН **Хууль зүйн ухааны магистр**

МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн ахлах багш. Б.Амарбаясгалан нь дангаар болон бусадтай хамтарч 10 гаруй ном, сурах бичиг, гарын авлага болон судалгаа, шинжилгээний хэд хэдэн өгүүлэл, илтгэл бичиж нийтийн хүртээл болгож, төрийн болон төрийн бус байгууллагын төсөлд удаа дараа орж ажилласан байна.



ӨМНӨТГӨЛ

Эрх зүйч мэргэжлээр суралцаж буй оюутнууд хуулийг тодорхой тохиолдолд тайлбарлан хэрэглэх, хууль зүйн дүн шинжилгээ хийх, тодорхой шийдэлд хүрэх мэдлэг, чадварыг эзэмшсэнээр сайн хуульч болох нэг үндсэн нөхцөл нь бүрдэх учиртай. Иймээс сүүлийн жилүүдэд хууль зүйн их, дээд сургуулиудад “Хууль тогтоомжийн хэрэглээ” хичээлийг тодорхой салбараар системчлэн заах болсон нь практик үндэслэлтэй бөгөөд энэхүү хичээлийг зааснаар чадварлаг хуульчдыг бэлтгэн гаргахад тус дөхөм болох нь гарцаагүй.

Гэвч уг хичээлийг заахад сургалтын хэрэглэгдэхүүн дутмаг, заах багш нарын мэдлэг, ур чадвар хангалттай биш байна. Иймээс Хууль Зүйн Яам, Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн захиалгаар бид Хууль тогтоомжийн хэрэглээ хичээлийг заах багш нарт ерөнхий арга зүй, аргачлал болгох, эрх зүйч мэргэжлээр суралцаж буй оюутнуудад салбарын хууль тогтоомжийг тодорхой тохиолдол буюу маргааныг шийдвэрлэхэд хууль зүйн онолын үндсэн дээр тайлбарлан хэрэглэх, хууль зүйн дүн шинжилгээ хийх, тодорхой шийдэлд хүрэх мэдлэг, чадварыг эзэмшүүлэх зорилго өвөртлөн энэхүү гарын авлагыг бэлтгэсэн болно.

Энэхүү гарын авлагыг боловсруулах, хэвлэх, багш, оюутны хүртээл болгоход дэмжлэг, туслалцаа үзүүлэн ажилласан ХЗЯ болон Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хамт олонд талархал илэрхийлье.

Зохиолчид

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

ГАРЧИГ

НЭГ. ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН БОДЛОГО БОДОХ АРГАЧЛАЛ .. 7

Бодлого 1 (орчуулга ²⁶)	17
Бодлого 2	21
Бодлого 3	25
Бодлого 4	30
Бодлого 5	36

ХОЁР. ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ БОЛОН ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН БОДЛОГО БОДОХ АРГАЧЛАЛ..... 44

Нэгдүгээр хэсэг.

Захиргааны эрх зүй - Ерөнхий болон тусгай анги	47
Бодлого 1	47
Бодлого 2	51
Бодлого 3	53
Бодлого 4	54
Бодлого 5	57
Бодлого 6	59

Хоёрдугаар хэсэг.

Захиргааны процессын эрх зүйн бодлого бодох аргачлал	63
Бодлого 7	67

ГУРАВ.

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО БОДОХ АРГАЧЛАЛ 70


Бодлого 1	72
Бодлого 2	74
Бодлого 3	77
Бодлого 4	79
Бодлого 5	81
Бодлого 6	83
Бодлого 7	85
Бодлого 8	87

ДӨРӨВ. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОН ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН БОДЛОГО БОДОХ АРГАЧЛАЛ..... 91

Нэгдүгээр хэсэг. Эрүүгийн эрх зүйн бодлого бодох аргачлал	91
Бодлого 1	96
Бодлого 2	104
Бодлого 3	110
Бодлого 4	119
Бодлого 5	127

Хоёрдугаар хэсэг.

Эрүүгийн процессын эрх зүйн бодлого бодох аргачлал	133
Бодлого 6	134
Бодлого 7	138



НЭГ. ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН БОДЛОГО БОДОХ АРГАЧЛАЛ

Энэхүү гарын авлагад ХБНГУ-ын хууль зүйн их, дээд сургуулиудад Үндсэн хуулийн эрх зүйн бодлого бодох аргачлалыг хүний үндсэн эрхийн жишээн дээр хэрхэн хэрэглэдгийг авч үзсэн. Учир нь, хүний эрх, эрх чөлөөг үнэт зүйлийн хувьд тунхаглаад 20 гаруйхан жил болж буй манай улсын эрх зүйн хөгжилд ихээхэн ач холбогдолтой билээ.

Үндсэн эрхийн чиг үүрэг

ХБНГУ-ын Үндсэн хуулийн “Үндсэн эрхүүд” хэмээх I бүлгийн 1-19 дүгээр зүйл болон 33, 38, 101, 103, 104 дүгээр зүйлд үндсэн эрхийн талаар зохицуулсан байдаг¹. Үндсэн эрх нь дараах хоёр үндсэн чиг үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

Нэгдүгээрт, үндсэн эрх нь хувь хүнд субьектив эрх олгож, төр ба хувь хүн хоорондын харилцаанд нөлөөдөг. Энэ нь дараах байдлаар илэрнэ:

А. *Хамгаалуулах эрх* – энэхүү эрх нь төрийн үйлдлээс хувь хүнийг хамгаалдаг. Тухайлбал, Үндсэн эрх зөрчсөн төрийн үйлдлийн эсрэг Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх, шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хандах эрх зэрэг багтана.

Б. *Үйлчлүүлэх эрх* – Хувь хүн зөвхөн төрийн аливаа үйлдлээс өөрийгөө хамгаалаад зогсохгүй төрөөс өөрийн эрх ашигт нийцсэн үйлдэл хийхийг шаардах эрхтэй. Гэхдээ үндсэн эрх бүр төрийг тодорхой үйлдэл хийхийг шаардах эрхийг хувь хүнд шууд олгодоггүй, Үндсэн хуульд шууд заасан тохиолдолд л зарим үндсэн эрхүүд хувь хүнд тодорхой үйлдлийг төрөөс шаардах эрх олгодог. Жишээ нь, эхчүүдийн нийгмийн халамж авах эрх (6-р зүйлийн 4 дэх хэсэг), цагаачлах эрх (16-а-р зүйл) гэх мэт эрхүүд хамаарна. Үндсэн хуульд шууд хуульчлагдаагүй тохиолдолд үндсэн эрхийн хэрэгжилтийн тал дээр төр дан ганцаар (монополь) үйлдэл хийх боломжтой ба мөн уг үйлдэл нь Үндсэн хуулийн хэрэгжилтэд зайлшгүй шаардлагатай тохиолдолд л бусад үндсэн эрхүүд хувь хүнд тодорхой үйлдлийг төрөөс шаардах эрх олгодог байна². Тухайлбал, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд заасан “Хүний мөн чанар (үнэ цэн) халдашгүй дархан байна” гэсэн үндсэн эрх нь гудамжны гуйлгачинд орох оромж төрөөс шаардах эрхийг олгодог байна³.

В. *Оролцооны эрх* – Уг үндсэн эрхийн дагуу хувь хүн төрийн үйл ажиллагаанд тодорхой хэмээнд оролцох эрхтэй болдог. Үүний тод жишээ нь Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд заасан сонгох, сонгогдох эрх юм.

Хоёрдугаарт, үндсэн эрх нь хувь хүний үйлдлээс үл хамааран төрд үйл ажиллагаагаа явуулахдаа зайлшгүй харгалзах объектив үүрэг хүлээлгэдэг⁴. Чухам иймээс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагууд Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн гуравдахь хэсгийн дагуу үндсэн эрхийг чандлан хамгаалах үүрэгтэй.

1. Nomos Gesetze, Oeffentliches Recht, 12;

2. Alpmann Schmidt, 6;

3. OVG NW NVwZ 1993, 202;

4. Alpmann Schmidt, Grundrechte, 4;

Үндсэн эрхийг эдлэх чадвар

Юуны өмнө хувь хүн үндсэн эрх эдлэх чадвартай байх учиртай. Хэдийгээр хүн төрснөөсөө эхлэн насан эцэслэх хүртлээ үндсэн эрх эдлэх боломжтой ч Холбооны Үндсэн хуулийн шүүх уг хугацааг арай уртасгасан байна. “Nasciturus” буюу эхийн хэвлийд байгаа ураг нь 14 хоногтойгоосоо эхлэн амьдрах, бие махбодийн халдашгүй дархан байх эрх эдэлнэ хэмээн шийджээ⁵. Мөн алдарт Мефистогийн шийдвэрээр хүний мөн чанар халдашгүй дархан байх эрх шиг түүнийг насан эцэслэсний дараа ч тодорхой хугацаанд идэвхтэй хамгаалж хүний нэр төр, алдар хүнд болон хүнд хамаарах ямар ч үнэт зүйлсийг гутаах аливаа үйлдлээс хамгаалах учиртайг тогтоосон байна⁶. Үүнээс гадна тодорхой тохиолдолд хуулийн этгээд ч зарим үндсэн эрхийг эдлэх чадвартай гэж үздэг. Үндсэн хуулийн 19-ийн III-т заасны дагуу “үндэсний хуулийн этгээд нь үндсэн эрхийг мөн чанарын хувьд эдлэх боломжтой бол түүнд ч үндсэн эрх үйлчилнэ” хэмээжээ. Эндээс үндсэн эрхийн мөн чанар гэсэн ухагдахуун гарч ирж байна. Хамтран эдлэх боломжтой буюу хамтын эрх болох жагсаал цуглаан хийх эрх, мэргэжлээрээ чөлөөтэй ажиллах гэх зэрэг эрхийг үүнд хамааруулдаг. Харин амьд явах гэх мэт эрх нь мөн чанарын хувьд хуулийн этгээдэд үйлчлэх боломжгүй тул түүнд үл хамаарна.

Үндсэн эрхийн ангилал

Үндсэн эрхүүдийг дараах байдлаар ангилна:

1. Эх сурвалжаар нь:

- А. Холбооны: ХБНГУ-ын Үндсэн хуулиар хуульчлагдсан үндсэн эрхүүд хамаарна.
- Б. Муж улсын: ХБНГУ нь бие даасан 16 муж улсаас бүрдэх ба тэдгээр нь өөр, өөрийн Үндсэн хуультай бөгөөд тэдгээртээ мөн үндсэн эрхийн талаар (хэлбэр, агуулгын хувьд хоорондоо их төстэй) зохицуулсан байдаг. Хэдийгээр өөр өөр эх сурвалжаар зохицуулагдсан ч адилхан үндсэн эрхийг хамгаалдаг хэмээн Холбооны Үндсэн хуулийн шүүхээс шийдвэрлэсэн байна⁷.

2. Субъектээр нь:

- А. *Хүн бүрийн эдлэх эрх*: Эдгээр эрх нь бүх хүнд хамаарах бөгөөд хуульд “бүгд”, “бүх хүн”, “хэн ч” гэх мэтээр томъёологдсон байна. (Үндсэн хуулийн 2, 3, 5 дугаар зүйл)
- Б. *Германчуудын үндсэн эрх*: Эдгээр нь зөвхөн ХБНГУ-ын иргэдэд хамааралтай. Тухайлбал, Үндсэн хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу жагсаал цуглаан хийх, 38 дугаар зүйлд заасан сонгох, сонгогдох гэх зэрэг эрх багтана.
- В. *Гадаадын иргэдийн эрх*: Үүнд Үндсэн хуулийн зөвхөн 16а дугаар зүйл хамаарах бөгөөд тухайн зүйлд заасны дагуу тодорхой шаардлагыг хангасан гадаадын иргэн ХБНГУ-д цагаачлах эрх эдэлнэ. Гэвч энэ нь германчуудын эдэлдэг эрхийг гадаадын иргэд огт эдлэхгүй гэсэн үг биш

5. BVerfGE 39, 1, 41;

6. BVerfGE 30, 173, 174;

7. BVerfGE 22, 267, 271;



юм. Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “үйлдэл хийх бүх нийтийн эрх чөлөө”-р дамжуулан гадаадын иргэд германчуудын зарим үндсэн эрхийг эдэлж болно⁸. Үүний нэг сул тал нь 2 дугаар зүйл өөрөө илүү олон төрлийн хязгаарлалтуудтай байдаг учир үндсэн эрхийг харьцангуй сул хамгаалдагт оршино.

3. Хамгаалж буй эрхийн агуулгаар нь:

- А. *Эрх чөлөөтэй байх талаарх үндсэн эрхүүд*: Үүнд хүн төрөл бүрийн үйлдэл хийх, эд юмс өмчлөх, эзэмших гэх мэт эрх чөлөө олгодог Үндсэн хуулийн 2, 4-6, 8-14, 16 дугаар зүйлд заасан эрхүүд хамаарна⁹.
- Б. *Эрх тэгш байх талаарх үндсэн эрхүүд*: Үндсэн хуулийн 3, 6 дугаар зүйлийн 1 болон 5 дахь хэсэг, 33, 38 дугаар зүйлүүд үүнд хамаарна. Эдгээр эрхүүд нь иргэдтэй ямар нэг ялгаваргүйгээр харилцах үүргийг төрд ногдуулдаг.
- В. *Шүүгдэгчийн үндсэн эрхүүд*: Үндсэн хуулийн 19 ҮҮ, 101, 103, 104 дүгээр зүйлүүдэд шүүх процесстэй холбоотой үндсэн эрхийг зохицуулсан байдаг.

Хамгаалж буй эрхийг ийнхүү агуулгаар нь ангилах явдал эдгээр эрхүүд өөр өөрийн өвөрмөц бүтэцтэй болохыг таньж мэдэхэд тустай. Ингээд “Эрх чөлөөтэй байх эрх”, “Эрх тэгш байх эрх”, “Шүүгдэгчийн үндсэн эрх” зөрчигдсэн эсэхийг тогтоох бодлого бодох аргачлалын талаар товч авч үзье.

Бодлого бодох ерөнхий аргачлал

Хүний эрх чөлөөтэй байх үндсэн эрхийг төр зөрчсөн эсэхийг дараах дарааллаар шалгана. Эдгээр шаардлагууд хангагдсан байвал үндсэн эрхийг зөрчөөгүй хэмээн үздэг байна:

А. Үндсэн хуулиар хамгаалагдсан эсэх

Юуны өмнө уг асуудалтай холбоотой хамгаалагдсан байж болох үндсэн эрхийг тогтоох нь чухал. Тухайн үндсэн эрхийн түүх, үндсэн хуульд байрлах сигматик, үг зүй болон өгүүлбэр зүйн үүднээс судлан тухайн асуудалд хамаарагдаж байгаа эсэхийг энэ хэсэгт тогтооно¹⁰. Бараг бүх үндсэн эрхүүд түүхийн явцад олон эрдэмтдийн судалгааны ажил, шүүхийн шийдвэрээр баяжин нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн, тодорхой хамгаалах хүрээтэй байдаг ажээ.

Б. Эрхэд халдлага учирсан эсэх

Төрийн холбогдох үйлдэл нь үндсэн эрхэд халдсан байх учиртай. “Халдлага” нь орчин үеийн тодорхойлолтын дагуу тухайн үйлдэл нь төрийн үйл ажиллагааны үр дагавар байсан тохиолдолд илэрдэг¹¹.

В. Уг халдлага нь Үндсэн хуулийн дагуу байсан эсэх

Зөвхөн Үндсэн хуульд заасан тодорхой тохиолдолд л үндсэн эрхэд төр халдаж болно. Үүнийг Үндсэн хуулийн “хязгаарлалтууд” гэдэг. Зарим эрхэд хязгаарлалт тогтоож үл болох буюу ямар ч тохиолдолд халдашгүй дархан байна. Жишээ нь, хүний нэр төр, алдар хүнд халдашгүй дархан байх эрх энд хамаарна. Бусад эрхэд тавьж болох 3 төрлийн хязгаарлалт байдаг. Үүнд:

8. Alpmann Schmidt, 22;

9. Alpmann Schmidt, 2;

10. Pieroth/Schlink, Rn. 195ff

11. Pieroth/Schlink, Rn. 240

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

- 1) *Үндсэн хуулийн шууд хязгаарлалт.* Зарим үндсэн эрхүүдийн тухайд ямар тохиолдолд хязгаарлалт байж болохыг Үндсэн хуулийнхаа холбогдох зүйл заалтад шууд тусган хуульчилсан байдаг. Тухайлбал, 13 дугаар зүйлд заасан орон байрны халдашгүй дархан байх эрхэд 7 дугаар хэсэгт заасны дагуу зөвхөн хүний амь насанд аюул учирсан тохиолдолд халдаж болох ажээ.
- 2) *Хуулийн хязгаарлалт.* Зарим үндсэн эрхүүдэд ердийн хуульд заасан тохиолдолд халдаж болно.
- 3) *Үндсэн эрхийн өөрийн жам ёсны хязгаарлалт.* Хуулиар хязгаарлалт тогтоогоогүй зарим үндсэн эрхийн хувьд Үндсэн хуульд заасан үнэт зүйлс болон гуравдагч этгээдийн үндсэн эрхийг хамгаалах үүднээс хязгаарлаж болдог¹².

I. Эрх чөлөөтэй байх үндсэн эрх:

Эрх чөлөөтэй байх эрх бүрийг тус тусад нь хязгаарлалтын хамт авч үзэх явдал чухал ач холбогдолтой байна:

- 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг – “Хүний нэр төр, алдар хүнд халдашгүй дархан байна”. Тухайн эрх ХБНГУ-ын Үндсэн хуулийн хамгийн эхний зүйл болон хуульчлагдсан нь дэлхийн 2 дугаар дайнтай холбоотой юм. Зургаан сая гаруй еврейчүүдийг хоморголон устгасан гунигт түүхийг ахин хэзээ ч давтагдуулахгүй байх үүднээс “хүн” гэдэг амьтны мөн чанар, үнэ цэнийг ийнхүү 1949 оны Үндсэн хуулиараа хамгаалжээ.

Хязгаарлалт: Уг эрхэд ямарваа нэг хязгаарлалт тогтоодоггүй.

- 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон 1 дугаар зүйлийн 1 дэх хэсэг – Хүн бүр бие хүний хувьд хөгжих эрхтэй. Уг эрх нь хувь хүний бусад үндсэн эрхүүдээр хамгаалагдаагүй өөрийгөө нийтийн өмнө илэрхийлэх эрх, хувийн нууцаа хамгаалуулах эрх зэрэг хүний хувийн асуудалтай холбоотой эрхүүдийг хамгаалдаг.

Хязгаарлалт: Уг эрх нь ердийн хуульд заасан тохиолдолд хязгаарлагдана.

- 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг – “Хүн бүр бие хүний хувьд хөгжих эрхтэй”. Уг эрх нь бусад ямар нэг эрхийг хамгаалдаг талаар маргаантай байдаг. Гэхдээ ихэнх эрдэмтэд тухайн эрх нь хүний эрх чөлөөтэй байх эрхээр хамгаалагдаагүй бусад эрхүүдийг хамгаалах үүрэгтэй гэж үздэг байна¹³. Энэхүү эрхийг мөн Үндсэн хуулийн “хүн бүр юу хийх, эс хийхээ гуравдахь этгээдийн эрх, үндсэн хуульт дэглэм, ёс суртахууны хэм хэмжээг зөрчилгүйгээр өөрөө шийдэх эрхтэй” гэсэн зохицуулалтаар илүү тодотгосон байдаг.


- 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг – “Хүн бүр амьд явах, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй”.

Хязгаарлалт: Зөвхөн хуульд заасан үндэслэлээр эдгээр эрхийг хязгаарлаж болно. Үндсэн хуулийн мөн зүйлд үүнийг хуульчилсан байдаг.

- 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг – “Хүн бүрийн эрх чөлөө халдашгүй дархан байна”. Бусад үндсэн эрхүүд хүн эрх чөлөөгөө эдлэхэд шаардлагатай, тухайлбал, үг хэлэх гэх зэрэг эрхийг хамгаалсан байдаг тул тухайн эрх

12. Alpmann Schmidt, 44

13. BverfGE 6, 32



нь хүний зөвхөн чөлөөтэй зорчих, эх орноосоо явах, буцаж ирэх эрхийг хамгаалдаг хэмээн үздэг байна¹⁴.

Хязгаарлалт: Уг эрхийг хуулиар хязгаарлаж болно.

- 4 дүгээр зүйл – “Хүн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй ба үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй”. Үүнд аливаа нэг шашин шүтэхээс гадна шашны зан үйл үйлдэх эрх хамаарна.

Хязгаарлалт: Олонхийн үзэж байгаагаар уг эрхийг зөвхөн “үндсэн эрхийн өөрийн хязгаарлалт”-аар хязгаарлаж болно¹⁵.

- 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг – “Хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх ба амаар, бичгээр болон дүрслэлээр түгээх, нийтэд хүртээмжтэй эх үүсвэрээс мэдлэгээ баяжуулах эрхтэй. Радио, кино урлагаар дамжуулах, хэвлэж нийтлэх, мэдээлэл авах эрхийг баталгаатай эдэлнэ”.

Хязгаарлалт: Эдгээр эрхийг Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт (бие хүний нэр төр болон залуучуудыг хамгаалах талаарх хуулийн зүйл, заалтын дагуу) заасан үндэслэлээр хязгаарлаж болно.

- 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг – “Соёл урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, багшлах эрхтэй”. Энэхүү эрхийг мөн чанарын хувьд хуулийн этгээд хэрэгжүүлэх боломжтой, тухайлбал, их сургуулиуд.

Хязгаарлалт: Уг эрхийг зөвхөн “үндсэн эрхийн өөрийн хязгаарлалт”-аар л хязгаарлаж болно¹⁶.

- 6 дугаар зүйл – “Гэрлэлт, гэр бүл төрийн онцгой хамгаалалтад байна”.

Хязгаарлалт: Уг эрхийг зөвхөн “үндсэн эрхийн өөрийн хязгаарлалт”-аар л хязгаарлаж болно¹⁷.

- 7 дугаар зүйл – “Нийт сургуулийн үйл хэрэг төрийн хяналт дор байна”. Үүгээр хүүхдээ харгалзах талаар эцэг, эхэд үүрэг үүсэхийн зэрэгцээ төрд хүүхдийг харгалзах үүрэг мөн үүсдэг байна.

- 8 дугаар зүйл – “Бүх германчууд урьдчилж мэдэгдэх болон зөвшөөрөл авалгүйгээр тайван жагсаал, цуглаан хийх эрхтэй”. Уг эрх нь зөвхөн ХБНГУ-ын иргэдэд үйлчилнэ. “Жагсаал, цуглаан хийхэд доод тал нь 2 эсвэл 3 хүн оролцох уу гэдэг дээр эрдэмтэдийн дунд маргаан өрнөдөг.

Хязгаарлалт: 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гудамж талбайд хийх жагсаал, цуглаан нь ердийн хуулиар болон хуулийн дагуу хязгаарлагдаж болно.

- 9 дүгээр зүйл – “Бүх германчууд эвлэл холбоо байгуулах эрхтэй”. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд энэ эрх үл хамаарна.

Хязгаарлалт: Уг эрхийг зөвхөн “үндсэн эрхийн өөрийн хязгаарлалт”-аар л хязгаарлаж болно¹⁸.

- 10 дугаар зүйл – “Хүний хувийн захидал, харилцааны нууц халдашгүй байна”.

Хязгаарлалт: Уг эрхийг зөвхөн ердийн хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.

14. Pieroth/Schlink, Rn. 408

15. BVerfGE 33, 23

16. Alpmann Schmidt, 146

17. Alpmann Schmidt, 151

18. Pieroth/Schlink Rn. 740


ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

- 11 дүгээр зүйл – “Бүх немцүүд холбооны нутаг дэвсгэр дээр чөлөөтэй зорчих эрхтэй”.
Хязгаарлалт: Уг эрхийг зөвхөн ердийн хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.
- 12 дугаар зүйл – “Бүх немцүүд ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхтэй”. Уг эрхээр мэдээж өөрийн үзэмж хүслээр мэргэжлээ сонгох, улмаар эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах эрх хамгаалагддаг.
Хязгаарлалт: Уг эрхийг зөвхөн ердийн хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.
- 13 дугаар зүйл – “Хүний орон байр халдашгүй байна”.
Хязгаарлалт: Энэхүү эрхийн хязгаарлалтыг тус зүйлийн 2-7 дахь хэсэгт тодорхой заасан. Жишээ нь, нэгжлэгийг зөвхөн шүүгчийн зөвшөөрлөөр л үйлдэх учиртай.
- 14 дүгээр зүйл – “Эд хөрөнгө өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй”.
Хязгаарлалт: 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу нийтийн ашиг сонирхлын үүднээс хувийн өмчид төр халдаж болно. Мөн тухайн харилцааг зохицуулсан бие даасан хууль гаргах шаардлагатай байдаг.
- 16 дугаар зүйл – “Иргэний харьяалалтай байх эрхтэй”. Хүн зөвхөн хуулийн дагуу иргэний харьяаллаа алдаж болох бөгөөд хэнийг ч эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглодог.
Хязгаарлалт: Уг эрхэд зөвхөн ердийн хуулийн дагуу халдаж болох ч уг этгээдийг аль ч улсын харьяалалгүй болгохгүй байх нөхцөлийг харгалздаг.
- 16а дугаар зүйл – “Улс төрийн шалтгаанаар хавчигдан мөшгөгдсөн хүн орогнох эрхтэй”. Уг эрх нь зөвхөн гадаадын иргэн болон аль ч улсын харьяалалгүй этгээдэд хамааралтай юм.
Хязгаарлалт: Европын Холбооны гишүүн аль нэг улсаас болон Дүрвэгсдийн эрх зүйн байдлын Гэрээ, хийгээд Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах тухай Конвенцийн хэрэгжилт хангагдсан аль нэг гуравдахь улсаас ирсэн хүмүүст уг заалт үл үйлчилнэ. Өөрөөр хэлбэл, уг этгээд эх орондоо байхад нь бодит аюул занал учраагүй тохиолдолд орогнол олгодоггүй.
- 17 дугаар зүйл – “Хүн бүр эрх бүхий төрийн байгууллага болон ардын төлөөлөгчдийн байгууллагад өргөдөл, гомдол гаргах эрхтэй”.
Хязгаарлалт: Уг эрхийг зөвхөн “үндсэн эрхийн өөрийн хязгаарлалт”-аар л хязгаарлаж болно¹⁹.
- 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг – “Үндсэн хуульт байгуулалд халдах оролдлого хийсэн хэн бүхэнтэй бүх германчууд эсэргүүцэн тэмцэх эрхтэй”. Хэдийгээр уг эрх нь үндсэн эрхийн жагсалтад багтдаггүй ч түүнийг үндсэн эрх болохыг нийтээр хүлээн зөвшөөрдөг байна²⁰.
Хязгаарлалт: Энэхүү эрх нь ямар ч хязгаарлалтгүй.
- 38 дугаар зүйл – “Сонгох, сонгогдох эрх”. Бундестагийн депутатыг сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, тэгш сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгодог. Уг эрх нь мөн л иргэдийн үндсэн эрхийн нэг юм.

19. Pieroth/Schlink, Rn. 1003

20. Alpmann Schmidt, 253



Хязгаарлалт: Энэхүү эрх нь ямар ч хязгаарлалтгүй.

II. Эрх тэгш байх талаарх үндсэн эрх:

Эрх тэгш байх үндсэн эрхүүд нь хоорондоо адил төстэй асуудлыг өөр өөрөөр шийдвэрлэх төрийн үйл ажиллагааны эсрэг чиглэсэн байдаг. Дараах эрхүүдийг уг бүлэгт хамааруулна:

- 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг – “Хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байна”. Энэхүү зүйл нь тэгш эрхийн талаарх зохицуулалтын хамгийн гол үндэс болдог. Тэгш бус хандсан эсэхийг дараах байдлаар шалгана:

А) Өөр хоорондоо маш төстэй буюу нэг төрлийн харилцаанд төр тэгш бус хандсан эсэх. Энэ хэсэгт “маш төстэй” харилцаа байгаа эсэхийг юуны өмнө шалгана. Үүнд²¹:

1. Тодорхой нэг хүний тал болон оролцсон харилцааг хуулиар зохицуулсан байх шаардлагатай.
2. Өөр нэг хүний тал болон оролцсон харилцааг төр өөрөөр зохицуулсан байх шаардлагатай.
3. Эдгээр оролцогч хүмүүс болон харилцаа нэгэн ерөнхий ухагдахуунд хамаарах боломжтой байх учиртай.

Б) Тэгш бус хандах нь Үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн эсэх: Тухайн хэсэгт тэгш бус хандах нь Үндсэн хууль зөрчсөн эсэхийг шалгадаг. Ямар тохиолдолд Үндсэн хууль зөрчсөн болох талаар Үндсэн хуульд тодорхой заагаагүй байна. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн боловсруулсан “Дур зоргын томъёо” хэмээх томъёогоор “маш төстэй асуудалд дур зоргоор тэгш бус хандсан, эсвэл шал өөр асуудалд дур зоргоор тэгш хандсан байх ёстой ажээ²².

Түүнчлэн эрх тэгш байх үндсэн эрхээс гадна бусад нарийвчлан заасан үндсэн эрхүүд бий. Үүнд:

- 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг – “Эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй”. Уг эрхэд зөвхөн байгалийн буюу жам ёсны шаардлагаар л халдаж болно²³.
- 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг – “Хэнийг ч хүйс, гарал үүсэл, арьсны өнгө, хэл, төрсөн газар, яс үндэс, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлаж болохгүй”.
- 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг – “Тахир дутуу хүнийг ялгаварлан гадуурхаж болохгүй”.
- 33 дугаар зүйл – “Герман хүн бүр аль ч муж улсад адилхан иргэний эрх эдэлж, үүрэг хүлээнэ”. Германчууд өөрийн мэдлэг, мэргэжлийн чадварын дагуу төрийн алба хаах эрхтэй байна.

III. Шүүгдэгчийн үндсэн эрх:

Шүүгдэгчийн үндсэн эрхүүд нь шүүн таслах ажиллагаатай холбоотой бөгөөд үүнд дараах эрхүүдийг хамруулдаг ба ямар ч тохиолдолд тэдгээрийг зөрчиж үл болно:

- 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг – “Нийтийн засаглалын зүгээс эрх нь

21. Alpmann Schmidt, 257

22. BverfGE 1, 14;

23. BverfGE 97, 35;

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

зөрчигдсөн аливаа этгээд шүүхэд хандах эрхтэй”. Нийтийн засаглалыг хэрэгжүүлэгч гэдэгт гол төлөв гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааг хамруулан ойлгодог²⁴.

- 101 дүгээр зүйл – “Хэний ч хэргийг шүүхээр хууль ёсоор томилогдсон шүүгчийг үндэслэлгүйгээр өөрчилж үл болно”. Энэ нь хэргийг харьяалах шүүгчийг дур мэдэн өөр шүүгчээр сольж болохгүй гэсэн үг. Нөгөө талаас хүн тодорхой асуудлаар шүүхэд хандсан л бол зохих журмын дагуу шүүн таслах ажиллагаа явуулж шийдвэрлэх ёстой гэсэн санааг агуулдаг.
- 103 дугаар зүйлийн 1 дэх хэсэг – “Хүн бүр хуулийн дагуу шүүхэд үг хэлэх эрхтэй”.
- 103 дугаар зүйлийн 2 дахь хэсэг – “Үйлдэгдэхээс өмнө хариуцлага хүлээлгэх талаар хуулиар тогтоосон тохиолдолд гэмт үйлдлийн төлөө шийтгэл ногдуулна”.
- 103 дугаар зүйлийн 3 дахь хэсэг – “Хэнийг ч эрүүгийн хуулийн дагуу нэг үйлдлийн төлөө дахин дахин шийтгэж үл болно”.

Дасгалын хичээлийн бодлого бодох аргачлал²⁵

А. Нийтлэг үндэслэл:

Бодлого бодох нь оюутны ямар нэгэн бодит баримтын талаар асуулт тавих, тухай бүрийн тодорхой нөхцөлүүдэд юу чухал болохыг олж тодорхойлж, тэдгээрийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, тохиолдол бүрд эргэцүүлэн бодох боломж олгодог. Тохиолдлыг шинжлэх явцдаа цээжлэн тогтоохоос эхлээд бодит баримтыг үнэлэх хүртэл сэтгэхүйн үйлдлүүдийг хийж байдаг юм.


Үндсэн хуулийн эрх зүй нь нийгмийн суурь харилцааг зохицуулдаг утгаараа бусад салбар эрх зүйн зохицуулах зүйлийн үндэс нь болно. Өөрөөр хэлбэл, нийгмийн харилцааны ерөнхий зохицуулалт хийх бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг бусад салбар эрх зүйгээр зохицуулдаг. Ийм учраас Үндсэн хуулийн эрх зүйн хичээл дээр бодлого бодохдоо тухайн тохиолдол нь Үндсэн хуулийн ерөнхий зохицуулалт, үндсэн зарчимтай хэр нийцэж байгаад дүн шинжилгээ хийж бусад хуулиудын нарийвчилсан зохицуулалтаар баталгаажуулахад оршино. Учир нь бусад хууль, хуулийн дэд актууд Үндсэн хуульд нийцэж байх учиртай. Түүнчлэн Үндсэн хуулийн эрх зүйн бодлого бодоход материаллаг хэм хэмжээг голлон хэрэглэдэг онцлогтой.

Аль ч аргачлалаар бодсон хамгийн эхлээд бодлогын өгөгдлийг сайтар уншиж ойлгох хэрэгтэй. Энэ нь уг бодлогын өгөгдөл чухам ямар салбар эрх зүйн хүрээнд үүссэн харилцааг хөндөж буйг тогтоох, улмаар ямар аргаар бодлогоо бодохыг тодорхойлоход дөхөм болно. Хоёр аргачлалын тухайд, алхам тус бүрд өөр өөр зүйл хийх шаардлагатай мэт боловч ерөнхий дүгнэлт ижил гарах учиртай.

Үндсэн хуулийн эрх зүйн бодлого бодох хоёр аргыг голлон тайлбарлая.

24. Pieroth/Schlink, Rn. 1011

25. Үндсэн хуулийн эрх зүйн бодлого бодох аргачлалыг тогтоох зорилгоор зохиогч АНУ болон ХБНГУ-ын хууль зүйн сургуулиудад тухайн салбар эрх зүйн бодлогыг ямар аргачлалаар боддог талаар сонирхон судалсны үндсэн дээр дор толилуулах 2 үндсэн аргачлалыг зохистой хэмээн үзсэн болно. Док (ScD), проф.Ц.Сарантуяа Үндсэн хуулийн эрх зүйн бодлого бодох аргачлалыг өөрийн номонд дэлгэрэнгүй авч үзснийг зохиогч мөн үлгэр болгосон.



Б. Таван алхмаар бодох:

Нэгдүгээр алхам – Товч дүгнэлт хийх. Тухайн шатанд юу хийх вэ?

- Өгөгдлийг сайтар уншсан байх тул өгөгдөлд хэний хооронд харилцаа үүсч вэ гэдгийг тогтоох;
- Өгөгдсөн үзэгдэл, ойлголт, харилцаа, субъекттэй холбоотой онолын тодорхойлолт, тайлбар хийх;
- Өгөгдөлд үүссэн харилцаа эрх зүйн, тэр тусмаа Үндсэн хуулийн эрх зүйн харилцаа мөн эсэхийг тодорхойлох;
- Бодлогыг цаашид үргэлжлүүлэн бодох шаардлага бий эсэхийг тогтоох;
- Энэ бүхнийг дүгнэх;
- Хэрэв өгөгдөлд туссан харилцаа нь эрх зүйн биш, эсхүл Үндсэн хуулийн эрх зүйн биш бол үндэслэлээ гаргаад дүгнэн, бодолтыг төгсгөнө.

Энэ алхам нь оюутны онолын мэдлэгийн түвшинг илэрхийлдэг болно.

Хоёрдугаар алхам – Асуудал дэвшүүлэх. Тухайн шатанд юу хийх вэ?

- Өгөгдлөөс хууль зүйн фактыг олох;
- Үүн дээрээ тулгуурлаад асуудал дэвшүүлэх;
- Асуудал нь хуулийн хэм хэмжээ ашиглан шалгах шаардлагатай бүх асуудлыг хамарсан байх учиртай;
- Асуудал дэвшүүлэх нь логик дэс дараалалтай байх нь чухал.

Энэ алхам нь мөн л оюутны онолын мэдлэгийн түвшинг илэрхийлдэг болно.

Гуравдугаар алхам – Эрх зүйн зохицуулалтыг олох.

- Дэвшүүлсэн асуудлыг шалгахад шаардагдах хуулийг сонгох;
- Сонгосон хуулиас зайлшгүй хэрэгтэй зүйл, заалтыг сонгох;
- Холбогдох хуулиуд дахь өрсөлдөх хэм хэмжээг сонгох;
- Шалгуулагч цагийн багтаамжаас хамаарч энэ шатанд сонгосон зүйл, заалтаа бүрэн бичихгүй, зөвхөн хуулийн нэр, зүйл, заалтын дугаарыг тэмдэглэж болно.

Энэ алхам нь оюутны чадварын түвшинг илэрхийлдэг.

Дөрөвдүгээр алхам – Дүн шинжилгээ хийх

- Дэвшүүлсэн асуудлыг сонгосон хэм хэмжээний дагуу бодлогын өгөгдөлд тулгуурлан шалгах;
- Хуулийн хэм хэмжээг өгөгдөлд нийцүүлэн тайлбарлах;
- Тухайн фактууд хууль зөрчсөн эсэхийг товч дүгнэх.

Энэ алхам нь оюутнаас мэдлэг, чадвар шаардсан хамгийн чухал алхам юм. Өөрөөр хэлбэл, өгөгдлийн агуулгыг ойлгосон байдал, сонгосон хуулийн зүйл, заалтыг зөв хэрэглэх чадвар зэргийг илэрхийлнэ.

Тавдугаар алхам - Эцсийн дүгнэлт хийх

- Өмнө нь хийсэн бүх зүйлээ цэгцтэй нэгтгэн дүгнэнэ.
- Өгөгдөлд тусгагдсан харилцаанд оролцогчдын хэний зөв, буруу болохыг тогтооно.
- Хохирогч хаана хандаж зөрчигдсэн эрхээ сэргээлгэж болохыг товчхон тогтооно.

Энэ алхам нь мөн чадварын түвшинг илэрхийлдэг болно.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

В. Зургаан алхмаар бодох:

Энэ нь шинжилгээ хийх гэж буй тухайн тохиолдолд тодорхой зорилго бүхий шалгуурын дагуу анализ хийж, дүгнэлт гаргах арга юм. Хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэхийг шалган тогтоох агуулга бүхий өгөгдөхүүнтэй бодлого бодоход их тохиромжтой арга болно.

Нэгдүгээр алхам: Үндсэн хуулиар хамгаалагддаг нийгмийн харилцааг тодорхойлох

1. Субъектээр нь шалгаж үзнэ. Энэ нь тухайн өгөгдөхүүнд дурдсан субъект Үндсэн хуульд заасан үндсэн эрх эдлэх субъект мөн эсэхийг шалгах явдал юм.
2. Харилцаагаар нь шалгаж үзнэ. Энэ нь тухайн өгөгдөхүүнд үүсч буй харилцаа нь Үндсэн хуулийн эрх зүйн харилцаа буюу Үндсэн хуулиар хамгаалагдах харилцаанд хамаарах эсэхийг шалгана.

Энэ шатанд бодлого бодогчийн онолын мэдлэгийн түвшин харагдана.

Хоёрдугаар алхам: Халдлага тодорхойлох

Энэ шатанд халдлага буй эсэх, халдлагын хэлбэр, шинж зэргийг тодорхойлох юм.

1. Уг халдлага нийтийн засаглалын эрх бүхий байгууллага, албан тушаалтны зүгээс хэрэгжүүлсэн арга хэмжээ мөн эсэхийг тогтоох, өөрөөр хэлбэл, нийтийн засаглалын байгууллага, албан тушаалтан уг халдлагыг үйлдсэн эсэхийг шалгана.
2. Халдлагын ямар хэлбэр болохыг тодорхойлно. Тухайлбал:
 - А. Хууль
 - Б. Хэм хэмжээний акт
 - В. Бодит үйлдэл, эс үйлдэл
 - Г. Тухайн халдлага хүний үндсэн эрхийг хөндсөн, хязгаарласан эсвэл явцууруулсан аль шинжийг агуулсан болохыг тогтоон тодорхойлно.

Энэ шатанд мөн онолын мэдлэгийн түвшин харагдана.

Гуравдугаар алхам: Халдлагыг зөвтгөх үндэслэлийг шалгах

Холбогдох хууль зүйл заалтыг сонгоод нийтийн засаглалын байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй нь тэдгээрт нийцэж буйг шалган тогтоогоод үндэслэлээ гаргана. Хэрэв хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэр, хийсэн үйлдэл, эс үйлдэхүй байвал зөвтгөх үндэслэл байна гэж үзнэ.

Дөрөвдүгээр алхам: Тухайн өгөгдөхүүнд тусгагдсан үндсэн эрхийн хязгаарлалтыг тодорхойлох

Үндсэн эрхийг хязгаарлаж болох эсэхийг холбогдох хууль, зүйл, заалтын дагуу шалган тогтооно. Энэ шатанд оюутны мэдлэг, чадвар харагдана. Өөрөөр хэлбэл, олж авсан онолын мэдлэгээ харуулахын зэрэгцээ өгөгдөлд тусгагдсан харилцааг шалгахад шаардагдах хууль, зүйл, заалтыг зөв сонгох чадвар, тэдгээрийг хэрэглэх чадварыг харуулна.

Тавдугаар алхам: Тухайн өгөгдөхүүнд тусгагдсан үндсэн эрхийн хязгаарын хязгаарлалтыг тодорхойлох

Энэ шатанд шаардлагатай гэж үзвэл холбогдох хуульд нийцүүлэн гаргасан



хуулийн дэд актын дагуу үндсэн эрх хязгаарлагдсан эсэх, энэхүү акт нь Үндсэн хууль, бусад хуульд нийцэж буй эсэхийг тодорхойлно.

Зургадугаар алхам: Дүгнэлт хийх

Дээрх алхмаар шалгаад дүгнэлт хийж, үндсэн эрх нь зөрчигдсөн гэх субъект хаана хандахыг тодорхойлно.

Σ Бодлого 1 (орчуулга²⁶)

Иргэн “Б”-гийн С хотод хийхээр төлөвлөж, урьдчилан мэдэгдсэн ажилгүйдлийн эсрэг цуглааныг хоригложээ. Үүнийгээ цагдаагийн газрын мэдээллээр зарим нэгэн цуглаанд оролцогчид хүч хэрэглэж болзошгүй байна гэсэн үндэслэлээр тайлбарласан байна. Хэдийгээр цуглаанд оролцогчдын дийлэнх олонх нь хүч хэрэглэхийн эсрэг байлаа ч цөөн хэдэн хүний учруулж болзошгүй аюулыг хүлээн зөвшөөрч болохгүй гэжээ. Цуглааныг хориглосон энэхүү шийдвэрийн эсрэг холбогдох төрийн захиргааны байгууллагуудад хандсан боловч амжилтад хүрээгүй учраас цуглааныг зохион байгуулагч иргэн “Б” Үндсэн хуулийн шүүхэд өргөдөл гаргажээ.

Үндсэн хуулийн 8 дугаар зүйлд заасан үндсэн эрх нь зөрчигдсөн хэмээн өргөдөлдөө дурьдсан байна. Мөн жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 15 дугаар зүйл жагсаалыг хориглох боломж олгож байгаа нь Үндсэн хуулийг зөрчиж байна. Уг цуглааны үеэр хүч хэрэглэхэд бэлэн оролцогчдын эсрэг арга хэмжээ авахад л хангалттай байсан гэжээ. Иргэн “Б”-гийн Үндсэн хуулийн 8 дугаар зүйлд заасан үндсэн эрх нь зөрчигдөж байна гэсэн үндэслэлээр гаргасан өргөдөл амжилт олох болов уу?

Үндсэн хуулийн дагуу батлагдсан жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Олон нийтийн хэв журам, аюулгүй байдалд шууд аюул учруулж байвал төрийн байгууллага уг цуглааныг хориглох буюу тодорхой нөхцөлөөс хамааралтай болгох болно” гэж заасан байдаг.

I. Ангилал:

Хуулийн дагуу авсан арга хэмжээ нь Үндсэн хуульд заасан иргэний эрхийг зөрчсөн эсэх талаар Үндсэн хуульд нийцүүлж тайлбарлах шаардлагатай болдог.

II. Бүтэц:

1. Зөвшөөрөгдөх байдал
 - а) Үндсэн хуулийн шүүхийн эрх үүрэг
 - б) Өргөдөл гаргах эрх
 - в) Өргөдлийн объект
 - г) Өргөдөл гаргах үндэслэл
 - д) Бүх шатны шүүхэд хандах
 - е) Бусад
2. Үндэслэлтэй байдал

26 Die 32 Fälle, Staatsrecht, von den Profis – Hemmer/Wüst. 4.Auflage, 10/2006

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

- а) Хамгаалах салбар - Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дүгээр зүйл - Цуглаанд оролцогчдын зарим нь хүч хэрэглэхэд бэлэн байгаа ч цуглаан “тайван” үргэлжилж байна.
- б) Төрийн оролцоо
- в) Үндсэн хуулийн дагуу тайлбарлах (үндэслэх) нь
- г) Цуглаан хийх тухай хууль Үндсэн хуульд нийцэж буй байдал -
 - Хүч хэрэглэхэд бэлэн цөөнхөөс болж цуглааныг хориглох нь зохисгүй бөгөөд шаардлагагүй.
 - Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх зүйлд харшилж байна.

3. Үр дүн

Үндсэн хуулийн шүүхэд гаргасан өргөдөл амжилт олно.

III. Тайлал:

Үндсэн хуулийн шүүхэд гаргасан өргөдөл нь үндэслэлтэй, хүлээн зөвшөөрөгдөхөөр байвал амжилт олдог.

1. Хүлээн зөвшөөрөгдөх байдал:

А) Үндсэн хуулийн шүүхийн эрх үүрэг

Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн 93 дугаар зүйлийн 93.1.4-ийн а болон Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.8-ийн а заалтад заасны дагуу Үндсэн хуулийн шүүхэд гаргасан өргөдлийг шийдвэрлэх үүрэгтэй.

Б) Өргөдөл гаргах эрх

Үндсэн хуулийн 93 дугаар зүйлийн 93.1.4-ийн а-д заасны дагуу иргэн бүр өргөдөл гаргах эрхтэй. Гэхдээ үндсэн эрхүүдийг эдлэх эрхтэй байх шаардлагатай. Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар Герман улсын иргэн бүр үндсэн хуулийн эрхүүдийг эдлэх эрхтэй. Ийм учраас иргэн “Б” ч гэсэн ийм эрхтэй гэсэн үг.

В) Өргөдлийн объект

Үндсэн хуулийн 93 дугаар зүйлийн 93.1.4-ийн а-д заасны дагуу өргөдлийн объект нь төрийн засаглалын 3 хэлбэрээс (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх) авсан арга хэмжээ бүр байж болно. Иргэн “Б” төрийн байгууллагын хориглосон болон шүүхийн үгүйсгэсэн шийдвэрүүдийг эсэргүүцсэн нь өргөдлийн объект байх нөхцөлийг хангаж байна.


Г) Өргөдөл гаргах үндэслэл

Үндсэн хуулийн 93 а зүйлийн 1-ийн 4 дүгээрт болон Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу дээрх хуулиудад тусгагдсан эрхүүд зөрчигдсөн нь нотлогдох ёстой. Иргэн “Б” түүний Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дүгээр (жагсаал, цуглаан хийх эрх чөлөө)-т заасан үндсэн эрх зөрчигдсөн гэж үзэж байна.

Цуглаан хийхийг хориглосноор уг эрхийг зөрчих, хориглосон шийдвэрийг шүүх баталгаажуулах явдлыг бүр эртнээс урьдчилан хаах аргагүй юм. Иргэн “Б”-д энэ арга хэмжээ нь шууд нөлөөлсөн байна.

Д) Хуулийн дагуу бүх шатны шүүхэд хандах ба туслах (субсидар) хэм хэмжээ

Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 2 S.1-д заасны дагуу



Үндсэн хуулийн шүүхэд өргөдөл гаргахын өмнө бүх шатны шүүхэд хандсан байх ёстой. Энэ шаардлагыг жишээ болгож авсан тохиолдол хангаж байна. Үндсэн эрх зөрчигдсөнийг өөрөөр шийдэх арга зам харагдахгүй байгаа учраас туслах хэм хэмжээний зарчимд нийцэж байна гэж үзэж болно.

Хеммерийн арга:

Субсидар (туслах) хэм хэмжээ гэдэг нь Үндсэн хуулийн шүүхийн ажлыг хөнгөвчлөх үүднээсээ ч тэр ултима ратио (эцсийн арга хэмжээ) байх ёстой гэсэн үг. Үндсэн эрх зөрчигдсэн гэж нотолж байгааг өөр ямар ч аргаар шийдвэрлэх боломжгүй болсон тэр л үед Үндсэн хуулийн шүүхэд хандана. Ялангуяа, түр хугацааны хуулийн хамгаалалт болон хуулиудын эсрэг Үндсэн хуулийн шүүхэд өргөдөл гаргахад энэ хязгаарлалт чухал ач холбогдолтой байдаг. Учир нь дээрх тохиолдлуудад хуулийн дагуу авч болох арга хэмжээнүүд маш хурдан дуусдаг бөгөөд парламентаас баталсан хуулийн хувьд тийм арга зам байдаггүйтэй холбоотой.

Е) Бусад

Өөр бусад нөхцөлүүд (хэлбэр, Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйл 1 S. 1, хугацаа Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 93 дугаар зүйл 1 S. 1) байгаа гэж үзэх ёстой.

2. Үндэслэлтэй байдал

Өргөдөл гаргагчдын Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дүгээрт заасан жагсаал, цуглаан хийх үндсэн эрх зөрчигдсэн тохиолдолд Үндсэн хуулийн шүүхэд гаргасан өргөдлийг үндэслэлтэй гэж үзнэ.

А) Хамгаалах салбар

Цуглаан хийх эрх чөлөөний хамгаалах салбар нээгдсэн байх ёстой. Цуглаан гэдэг нь олон хүмүүс үзэл бодлоо илэрхийлэх нэгэн зорилгоор нэгдэн цуглахыг хэлнэ.

Ажилгүйдлийн эсрэг нэгэн зорилгоор нэгдэх байсан учраас иргэн “Б”-гийн төлөвлөсөн цуглаан нь жагсаал цуглааны шаардлагыг хангаж байна гэж үзэж болно. Иргэн “Б” нь Герман улсын иргэн мөн учраас Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дүгээрт заасан үндсэн эрхийг эдэлнэ.

Хеммерийн арга:

Гадаадын иргэн - Гадаадын иргэн (Европын холбооны улсын иргэн биш) цуглаан зохион байгуулах тохиолдолд энэ нь Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн дагуу биш Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 1 дүгээрт заасан хувь хүн чөлөөтэй хөгжин боловсрох үндсэн эрхтэй гэдэг заалтын дагуу хамгаалагдана. Эндээс энэ үндсэн эрхийн үүрэг тодорхой харагдаж байна.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

Зөвхөн зэвсэггүй, тайван замаар хийсэн цуглаан л Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дүгээрт заасны дагуу үндсэн эрхийн хүрээнд хамгаалагддаг. Цагдаагийн газрын мэдээллээр бол хүч хэрэглэхэд бэлэн этгээдүүд цуглаанд оролцож үймээн самуун гаргаж болзошгүй байгаа учраас энэ хамгаалалт үйлчлэх эсэх нь эргэлзээтэй юм.

Хүч хэрэглэхэд бэлэн оролцогчид тайван биш нь ойлгомжтой юм. Тийм учраас тэд Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дүгээрт заасан үндсэн эрхийн хамгаалалт эдлэхгүй. Гэхдээ Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1-д заасан цуглааныг бүхэлд нь “тайван бус” гэж үзэх үү гэдэг нь асуудалтай хэрэг.

Ингэж үзвэл хэсэг бүлэг сэтгэл хангалуун биш эсвэл зэвсэглэсэн оролцогчдоос болж цуглаанд оролцож байгаа бусад хүмүүс болон цуглааныг зохион байгуулагчид Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дүгээрт заасан үндсэн эрхээ эдэлж чадахгүйд хүрнэ.

Цуглааныг зохион байгуулагчид тайван бус цөөнхийг цуглаанд оролцуулахыг зорьсон буюу зөвшөөрсөн тохиолдолд л энэ нь цуглааныг бүхэлд нь тайван бус зам руу хөтөлж болох юм. Бусад тохиолдолд цуглаан нь Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн дагуу хамгаалагдана.

Цуглааныг зохион байгуулагч иргэн “Б” болзошгүй үймээн самууныг зөвхөн хүлцсэн эсэх нь тодорхойгүй учраас энэ цуглаан бол Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дүгээрт заасны дагуу тайван цуглаанд тооцогдоно.

Б) Төрийн оролцоо

Цуглаан хийхийг хориглосон нь иргэн “Б”-гийн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхийг зөрчиж байгаа явдал бөгөөд төрийн оролцоо байна гэсэн хэрэг.

В) Төрийн оролцоог үндсэн хуулийн дагуу үндэслэн тайлбарлах

Г) Жагсаал, цуглаан хийх тухай Үндсэн хуульд нийцэж буй байдал

Энэ жишээн дээр бол жагсаал, цуглаан хийх тухай хууль Үндсэн хуульд нийцэж байна гэж үзнэ.




Хеммерийн арга:

Федерализмын шинэтгэлийн хүрээнд Үндсэн хуулийн 74 дүгээр зүйлийн 1-ийн 3 дугаар заалт өөрчлөгдсөн бөгөөд жагсаал, цуглаан хийхтэй холбоотой хууль тогтоомж тогтоох эрх нь Холбооны муж улсуудын мэдэлд шилжинэ. Холбооны муж улсууд хууль тогтоох шинэ эрх мэдлээ хэрэгжүүлж эхэлтэл жагсаал, цуглаан хийх тухай Холбооны хууль хүчин төгөлдөр хэвээр байна.

Үндсэн хуулийн 12а зүйлийн 1 дүгээр заалт.

Жагсаал, цуглаан хийх тухай хуулийг хэрэглэхдээ Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 S. 2-т заасан эш татах тухай журмыг анхаарвал зохино. Уг журмаар үндсэн эрхийг хязгаарласан хуульд тухайн үндсэн эрхийг агуулсан хуулийн зүйл ангийг заавал нэрлэх ёстой байдаг. Энэ нөхцөлийг жагсаал, цуглаан хийх тухай хуулийн 20 дугаар зүйл хангаж байна.

Хууль нь материалын хувьд Үндсэн хуульд нийцэж байх ёстой. Энэ нь тодорхой ганцхан асуудалд зориулсан хууль гаргахыг хориглодог.



Бодлого 2

УИХ-ын сонгуульд нэр бүхий 3 нам эвсэл болон орж 36 суудал авсан бөгөөд эвслийн бүлэг байгуулан ажиллаж байгаад 2 жилийн дараа уг эвсэл тарсан байна. Эдгээр 3 намаас “Х” нам дангаараа 25 суудал авсан байсан тул эдгээр гишүүд хамтарсан үйл ажиллагаа явуулахаар болж “Зөвлөл” хэмээн өөрсдийн үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэрийг нэрлэжээ. УИХ-ын нэгдсэн хуралдаанаар Ашигт малтмалын тухай хуулийн төсөл хэлэлцэж байх үеэр “Х” намын УИХ дахь зөвлөлийн ахлагч тус хуулийн талаар өөрсдийн байр суурийг илэрхийлж санал, дүгнэлтээ хэлэлцүүлэх хүсэлт гаргав. Гэтэл УИХ-ын дарга танай эвслийн бүлэг тарсан тул танай намын гишүүд нийлж шинээр бүлэг байгуулах эрхгүй, иймээс нэгдсэн хуралдаанаар та бүхний байр суурийг сонсч, санал дүгнэлтийг хэлэлцэх эрх зүйн үндэс байхгүй гэж хэлээд хэлэлцэхээс татгалзсан байна.

Хууль зүйн дүн шинжилгээ хийнэ үү.

С-Товч дүгнэлт:

УИХ дахь нам, эвслийн бүлэг байгуулах, бүлгийн бүрэн эрх, бүлэг, УИХ-ын хоорондын харилцааг Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулдаг. Энэхүү харилцаа нь Төрийн эрх зүйн харилцаа болно. Өгөгдөлд тусгагдсан “Х” намын зөвлөлийн эрх зүйн байдал, тэдний ахлагчийн хүсэлтийг УИХ-ын дарга хүлээн аваагүй нь хууль зүйн үндэслэлтэй эсэхийг холбогдох хуулийн дагуу шалган тогтоох шаардлагатай юм.

I-Асуудал:

- Намууд УИХ-ын сонгуульд эвсэл байгуулан орж болох эсэхийг тодорхойлох
- УИХ-ын зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох
- УИХ дахь нам, эвслийн бүлгийг тодорхойлох
- УИХ дахь эвслийн бүлэг тарахад үүсэх эрх зүйн үр дагаврыг тодорхойлох
- УИХ дахь нам, эвслийн бүлгийн бүрэн эрхийг тодорхойлох
- “Х” намын гишүүд УИХ-д хамтарсан үйл ажиллагаа явуулж болох эсэхийг тогтоох
- “Х” намын зөвлөлийн ахлагчийн гаргасан хүсэлт хууль зүйн үндэслэлтэй эсэхийг тогтоох
- УИХ-ын даргын гаргасан шийдвэрийн үндэслэлийг тогтоох

R-Эрх зүйн зохицуулалт:

Үндсэн хууль

27.1. УИХ бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

УИХ-ын тухай хууль

13.1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон дэд, түр хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

26.1. Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг (цаашид “бүлэг” гэж) байгуулж болно.

26.2. Бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс нэр нь албан ёсоор нэр дэвшиж сонгогдсон гишүүд орно.

26.3. Сонгуульд эвсэл байгуулж оролцсон намууд Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал авсан бол эвслийн нэг бүлэг байгуулна.

26.4. Улсын Их Хуралд 8-аас дээш суудал авсан нам татан буугдсан, эвсэл тарсан бол бүлгийг татан буугдсанд тооцох ба түүний бүрэлдэхүүнд байсан гишүүд дахин бүлэг байгуулахыг хориглоно.

27.1. Бүлэг дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

27.1.1. хэлэлцэж байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, төрийн гадаад, дотоод бодлогын асуудлаар бодлого, байр сууриа тодорхойлж санал, дүгнэлт гарган зохих Байнгын хорооны, эсхүл нэгдсэн хуралдаанаар шууд хэлэлцүүлэх;

28.1. Дор дурдсан тохиолдолд бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болно:

28.1.1. бүлэг байгуулсан нам татан буугдсан, эсхүл эвсэл тарсан;

28.1.2. энэ хуулийн 6.6-д заасан үндэслэлээр орон гарч нөхөн сонгууль явуулсан боловч тухайн нам, эвсэл суудал авч чадаагүйгээс бүлгийн гишүүдийн тоо энэ хуулийн 26.1-д заасан тооны доод хязгаарт хүрэхгүй болсон;

28.1.3. гишүүн бүлгээс гарч үлдсэн гишүүдийнх нь тоо энэ хуулийн 26.1-д заасан доод хязгаарт хүрэхгүй болсон.

28.1.4. бүлэг өөрөө тарах шийдвэр гаргасан.

28.3. Эвслийн бүлэг тарсны дараа түүний бүрэлдэхүүнд байсан нам Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудалтай бол тухайн намаас сонгогдсон гишүүд Улсын Их Хуралд хамтарсан үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ингэхдээ энэ хуулийн 27.1.1- 27.1.6, 27.1.8-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

24.1. Сонгууль зарлахаас өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй.

24.2. Хоёр буюу хэд хэдэн нам сонгуульд нэгэн эвсэл болж оролцож болох ба энэ тохиолдолд энэ хуулийн 24.1 дэх хэсгийн заалт эвсэлд нэгдэн орж байгаа нам тус бүрд хамаарна.

25.12. Энэ хуулийн 25.9-25.11-д заасны дагуу эвсэл нэгэнт тарсан бол Улсын Их Хурлын тухайн сонгуулийн явцад болон түүний үр дүнд байгуулагдсан Улсын Их Хуралд эвслийн бүрэлдэхүүнд орж байсан намууд дахин нэгдэж эвсэл байгуулах, түүнчлэн Улсын Их Хуралд нэг бүлэг болон зохион байгуулагдахыг хориглоно.

А-Анализ:

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 24.2-т заасны дагуу хоёр буюу хэд хэдэн нам сонгуульд нэгэн эвсэл болж оролцож болно гэсэн байх тул өгөгдөлд дурьдсан 3 нам эвсэл болж оролцсон нь хуульд нийцэх байгаа ба нийт 36 суудал авчээ.

Үндсэн хуулийн 27.1-д “УИХ бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэж заасан бол УИХ-ын тухай хуулийн 13.1-д Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон дэд, түр хороо, намын бүлэг, зохион



байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэснээс үзвэл намын бүлэг нь УИХ-ын зохион байгуулалтын үндсэн хэлбэрийн нэг юм.

УИХ-ын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3-т “Сонгуульд эвсэл байгуулж оролцсон намууд Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал авсан бол эвслийн нэг бүлэг байгуулна” гэснээс үзвэл УИХ-ын сонгуульд эвсэл болж оролцсон 3 нам нийтдээ 36 суудал авснаар эвслийн Бүлэг байгуулах эрх зүйн үндэс хангагдаж байна.

УИХ дахь эвслийн бүлэг тарахад үүсэх эрх зүйн үр дагаврыг холбогдох хуулиар хэрхэн зохицуулсныг авч үзвэл: УИХ-ын тухай хуулийн 26.4. “Улсын Их Хуралд 8-аас дээш суудал авсан нам татан буугдсан, эвсэл тарсан бол бүлгийг татан буугдсанд тооцох ба түүний бүрэлдэхүүнд байсан гишүүд дахин бүлэг байгуулахыг хориглоно”. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 25.12, 25.9-25.11-д заасны дагуу эвсэл нэгэнт тарсан бол Улсын Их Хурлын тухайн сонгуулийн явцад болон түүний үр дүнд байгуулагдсан Улсын Их Хуралд эвслийн бүрэлдэхүүнд орж байсан намууд дахин нэгдэж эвсэл байгуулах, түүнчлэн Улсын Их Хуралд нэг бүлэг болон зохион байгуулагдахыг хориглоно” гэжээ. Өгөгдөлд дурьдсан 3 намын эвсэл нэгэнт тарсан тул тэд дахин бүлэг байгуулах эрх зүйн үндэс алга байна. Иймээс эдгээр 3 намын бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болох бөгөөд УИХ-ын тухай хуулийн 28.1.1-д бүлэг байгуулсан эвсэл тарсан ба 28.1.4-т бүлэг өөрөө тарах шийдвэр гаргасан. хэмээн бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болох үндэслэлийг илүү тодорхой хуульчилсан байна. Иймээс бүлэг өөрөө тарсан гэсэн үндэслэл нь тухайн өгөгдөлд тохирч байгаа ба ингэснээр эвслийн бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болно.

“Х” намын гишүүд УИХ-д хамтарсан үйл ажиллагаа явуулж болох эсэхийг тогтоох

Харин УИХ дахь эвслийн бүлэг тарсны дараагаар УИХ-ын тухай хуулийн 28.3-т заасны дагуу “Эвслийн бүлэг тарсны дараа түүний бүрэлдэхүүнд байсан нам Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудалтай бол тухайн намаас сонгогдсон гишүүд Улсын Их Хуралд хамтарсан үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ингэхдээ зөвхөн энэ хуулийн 27.1.1- 27.1.6, 27.1.8-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Иймээс “Х” намаас сонгогдсон 25 гишүүн хамтарсан үйл ажиллагаа явуулах боломжтой юм байна.

УИХ дахь нам, эвслийн бүлгийн бүрэн эрхийг УИХ-ын тухай хуулийн 27.1-д “Бүлэг дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ” гэж заажээ:

27.1.1. хэлэлцэж байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, төрийн гадаад, дотоод бодлогын асуудлаар бодлого, байр сууриа тодорхойлж санал, дүгнэлт гарган зохих Байнгын хорооны, эсхүл нэгдсэн хуралдаанаар шууд хэлэлцүүлэх;

27.1.2. ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал, түүний дарааллын талаар Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын даргад саналаа илэрхийлэх;

27.1.3. нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;

27.1.4. нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны үед завсарлага авах;

27.1.5. Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;

27.1.6. Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгох саналаа Улсын Их Хурал, Байнгын хороонд оруулах;

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

27.1.7 бүлгийн төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;

27.1.8. нэгдсэн болон Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг оролцуулах, хуралдааны ирцийг хангах, хуралдааны дэгийг чанд сахиулах;

27.1.9. хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсэг байгуулж ажиллуулах;


27.1.10. бүлгийн ажлын албаны ажилтныг ажилд томилох, чөлөөлөх.

УИХ дахь “Х” намын зөвлөл 27.1.1-ийн дагуу “хэлэлцэж байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, төрийн гадаад, дотоод бодлогын асуудлаар бодлого, байр сууриа тодорхойлж санал, дүгнэлт гарган зохих Байнгын хорооны, эсхүл нэгдсэн хуралдаанаар шууд хэлэлцүүлэх эрхтэй юм байна. Иймээс хамтарсан үйл ажиллагаа явуулах эрх бүхий тус зөвлөлийн ахлагчийн гаргасан хүсэлт хууль зүйн үндэслэлтэй ажээ.

УИХ-ын сонгуулийн хуулийн 25.12-т Энэ хуулийн 25.9-25.11-д заасны дагуу эвсэл нэгэнт тарсан бол Улсын Их Хурлын тухайн сонгуулийн явцад болон түүний үр дүнд байгуулагдсан Улсын Их Хуралд эвслийн бүрэлдэхүүнд орж байсан намууд дахин нэгдэж эвсэл байгуулах, түүнчлэн Улсын Их Хуралд нэг бүлэг болон зохион байгуулагдахыг хориглоно” гэсэн ёсоор “Х” нам хэдийгээр сонгуулийн үр дүнгээр дангаараа 25 суудал авсан ч эвсэл тарсны дараагаар бие даан бүлэг байгуулаагүй. Мөн УИХ-ын тухай хуулийн 28.3-т “Эвслийн бүлэг тарсны дараа түүний бүрэлдэхүүнд байсан нам Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудалтай бол тухайн намаас сонгогдсон гишүүд Улсын Их Хуралд хамтарсан үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ингэхдээ энэ хуулийн 27.1.1- 27.1.6, 27.1.8-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ” гэсний дагуу хэлэлцэж буй хуулийн төслийн талаар хүсэлт гаргасан тул УИХ-ын даргын шийдвэр хууль бус юм.

С-Ерөнхий дүгнэлт:

УИХ-ын дарга, УИХ дахь “Х” намын зөвлөлийн хоорондын харилцааны эрх зүйн үндсийг холбогдох хуулийн дагуу шалган үзэхэд УИХ-ын даргын шийдвэр хууль зүйн үндэслэлгүй бөгөөд тэрээр тус намын зөвлөлийн бүрэн эрхэд халдсан байна.



Бодлого 3

Иргэн “Б” амралтын өдрөө эхнэр, 2 хүүхдийн хамт Төв аймгийн нутагт амьдардаг найзынхаараа зочилж 2 хоноод хотод гэртээ ирснийхээ орой телевиз үзэж суутал тэдний очсон газрын ойролцоо малын гоц халдварт өвчин гарсны улмаас энэ өдрийн 19 цагаас эхлэн хөл хорио тогтоосон, уг өвчин хүнд халдварладаг тул ойрын 7 хоногийн хугацаанд тэр хавиар явсан, байсан хүмүүс яаралтай эмнэлэгт хандахыг анхааруулсан мэдээ дамжуулжээ.

“Б”-гийнхэн ихэд сандарч 103 дугаарт залган түргэн тусламж дуудахад утас авсан эмч тэдний биеийн байдлыг лавлаад одоогоор ямар нэг өөрчлөлтгүй гэсэн хариу хэлэхэд “сандарч тэвдэх хэрэггүй, маргааш Халдвар судлалын үндэсний төвд очиж нарийн мэргэжлийн эмчид үзүүл” хэмээн зөвлөсөн байна.

Ингээд “Б” өглөө болгоод гэрийнхэнтэйгээ тухайн эмнэлэгт очоод үзүүлэх гэтэл өвчтөнийг бүртгэж дугаар олгогч ажилтан эрүүл мэндийн даатгалын дэвтэргүй гэсэн шалтгаанар бүртгэж дугаар олгохоос татгалзав. “Б” эмнэлгийн даргатай уулзаж учраа хэлэхэд нэгэнт даатгалын дэвтрээ орхиод ирсэн юм бол хүн тус бүр 3000 төгрөг төлөөд үзлэг шинжилгээнд хамрагдаж болно гэсэн хариу өгчээ.

Хууль зүйн дүн шинжилгээ хийнэ үү.

1. Харилцааг тодорхойлох:

А. Субъектээр – Иргэн “Б”, түүний эхнэр, хүүхдүүд, нөгөө талаас эмнэлгийн ажилтан (1.103-ын буюу түргэн тусламжийн эмч, 2. Дугаар олгогч ажилтан, 3. Эмнэлгийн дарга) нарын хооронд харилцаа үүссэн байна.

Иргэн “Б” түүний эхнэр, хүүхдүүд Үндсэн хуулийн 16.6-д заасны дагуу эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.1-д “эрүүл мэнд” гэж хүн өвчин эмгэггүй байх төдийгүй бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг хэлнэ гэж заасан. Энэхүү эрх нь эрүүлийг хамгаалах байгууллага, ажилтны шууд оролцоо, үйлчилгээгээр хангагддаг болно. Мөн хуулийн 3.1.2-т зааснаар “эрүүл мэндийг хамгаалах” гэж хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах замаар хүн амын эрүүл мэндийг хангахад чиглэсэн анагаах ухаан, нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээг хэлдэг байна.

Түүнчлэн хуулийн 3.1.3-т “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ” гэж хүн амын эрүүл мэндийн байдлыг тандах, хянах, хамгаалах, бэхжүүлэх, өвчин, эмгэгээс сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, анагаах ухааны сургалт, эрдэм шинжилгээний ажил явуулах, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх хүчин зүйлийг судлах, тэдгэрийг арилгахад чиглэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дангаар болон төр, олон нийт, байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран явуулах үйл ажиллагааг хамааруулах тухай заажээ.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

Мөн Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.3-т “аюулт үзэгдэл” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан хуульчилжээ. Мөн хуулийн 4.1.5. “гамшгийн эрсдэл” гэж гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг үзэх тухай заажээ. Иймээс “Б”-гийнхэн гамшгийн эрсдэлтэй учирсан байна.

Б. Энэхүү эрх нь хүний суурь, үндсэн эрхийн нэг бөгөөд түүнийг эдэлж хэрэгжүүлэхтэй холбогдож үүссэн харилцааг Үндсэн хуулиар хуульчлан тогтоохын зэрэгцээ Эрүүл мэндийн болон Иргэний эрүүл мэндийн даатгалын, Нийгмийн даатгалын тухай хуулиар голлон дэлгэрүүлж зохицуулдаг.

Эрүүл мэндийн тухай хуульд иргэний эрх, үүргийг 47, 48 дугаар зүйлд маш тодорхой хуульчилснаас өгөгдөлд шууд холбогдох хэсгийг нь дурдъя: Тухайлбал,

Иргэний эрх (47 дугаар зүйл):

47.1.1. эмч, эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах;

47.1.2. эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эмнэлэг, эмчийг өөрөө сонгох;

47.1.4. халдварт өвчнөөс бусад тохиолдолд эмчилгээ, оношлогоо, шинжилгээ хийлгэхээс татгалзах;

47.1.5. хүний эрүүл мэндэд харш үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэний талаар холбогдох байгууллагад өргөдөл, гомдол гаргах гэж мөн үүргийн талаар

48 дугаар зүйл. Иргэний үүрэг:


48.1.4. халдварт өвчин тархахаас сэргийлж, хөл хорионы журмыг сахиж мөрдөх;

48.1.5. хүний эрүүл мэнд болон нийгэмд аюул бүхий өвчин, хордлого, осол, гэмтэл, орчны сөрөг хүчин зүйлийн талаар эрүүл мэндийн байгууллагад цаг тухайд нь мэдээлэх;

48.1.7. халдварт өвчний үзлэг, шинжилгээнд өөрийн санаачилгаар болон эмч, эмнэлгийн байгууллагын шаардлагаар орох хэмээн тодорхой хуульчилсан байгаа. Иймээс иргэн “Б”-гийн гэр бүлийн гишүүд эмч, эмнэлгийн ажилтан, даргын хооронд үүссэн харилцаа Үндсэн хуулиар хамгаалагдсан, холбогдох хуулиар нарийвчлан зохицуулсан харилцаа мөн болно.

2. Халдлагыг тодорхойлох:

А. Иргэн “Б”-гийн гэр бүлийнхнийг нийслэлд ирсэн өдрийн 19 цагт хөл хорио тогтоосон. Тэдний байсан газрын орчимд гоц халдварт өвчин гарсан бөгөөд сүүлийн 7 хоногийн хугацаанд тухайн нутагт зорчсон, байсан хүмүүс эмнэлгийн байгууллагад хандахыг телевизээр зарлаж мэдэгдсэний дагуу 103 руу залгаж түргэн тусламж дуудсан. Энэхүү үйлдэл нь тэдний эрх төдийгүй үүрэг юм. Учир нь Эрүүл мэндийн тухай хуулийн 48.1.4, 48.1.5, 48.1.7-д (48.1.4. халдварт өвчин тархахаас сэргийлж, хөл хорионы журмыг сахиж мөрдөх; 48.1.5. хүний эрүүл мэнд болон нийгэмд аюул бүхий өвчин, хордлого, осол, гэмтэл, орчны сөрөг хүчин зүйлийн талаар эрүүл мэндийн байгууллагад цаг тухайд нь мэдээлэх; 48.1.7. халдварт



өвчний үзлэг, шинжилгээнд өөрийн санаачилгаар болон эмч, эмнэлгийн байгууллагын шаардлагаар орох) заасны дагуу гоц халдварт өвчин гарсан газраас ирсэн “Б” болон түүний гэр бүлийн гишүүд (аль нэг нь ч байж болно) өвчилсөн буюу өвчилсөн байх магадлалтай тул олон нийтийн дунд орж холилдолгүй эмнэлгийн байгууллагад даруй хандсан нь зөв атал 103-ын эмч дуудлагаар очиж тусламж үзүүлээгүй, дугаар олгогч эмнэлгийн ажилтан эрүүл мэндийн даатгалын дэвтэргүй гэдэг шалтгаанаар бүртгэж эмчид үзүүлэх дугаар олгохоос татгалзсан, эмнэлгийн дарга хүн тус бүрээс 3000 төгрөг нэхсэнээр дээрх эрхэд халдсан байна. Учир нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1.1.”захиргааны байгууллага” гэж нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага, түүнчлэн Засгийн газрын байгууллагын зарим үүргийг төлөөлөн гүйцэтгэдэг Засгийн газрын бус байгууллага, хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг сургууль, эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны болон шашны байгууллага зэрэг нийтийн эрх зүйн субъект болох байгууллагыг хэлнэ хэмээн хуульчлан тодорхойлсон. Иймээс эмнэлгийн байгууллага захиргааны байгууллагад хамаарах нь тодорхой байна. Харин 103-ийн эмч, эмнэлгийн ажилтаны тухайд өгөгдөлд дурьдсан эрх нь заавал эмнэлгийн байгууллага, эмч ажилтны шууд оролцоогоор хэрэгжих боломжтойг анхаарах шаардлагатай.

Түүнчлэн 3.1.4.”захиргааны акт” гэж нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас амаар буюу бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон эрх зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан үйл ажиллагааг; энэ хуулиар захиргааны байгууллагын хэм хэмжээ тогтоосон шийдвэр (тогтоол, дүрэм, заавар, журам)-ийг захиргааны актад хамааруулна гэснээс эмч, эмнэлгийн ажилтан, эмнэлгийн дарга иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн тусламж үзүүлэх үүргээ биелүүлээгүй, тэдний эрхэд халдсан гэж үзэх үндэслэлтэй байна.

Б. Халдлагын хэлбэрийн тухайд эмч, эмнэлгийн ажилтан, эмнэлгийн даргын шийдвэрийг ЗХХШТХ-ийн 3.1.4-т заасныг үндэслэн эмнэлгийн түргэн тусламж үзүүлээгүй, даатгалын дэвтэргүй гэсэн шалтгаанаар өвчтөнийг бүртгэж, мэргэжлийн эмчид үзүүлэх дугаар олгоогүй, дарга иргэдээс төлбөр нэхсэн зэргээр тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар амаар гаргасан захирамжилсан шийдвэр гэж үзнэ.

В. Халдлагын шинж:

Энэхүү халдлага нь иргэн “Б”-гийнхний эрхийг:

103-ын эмч - хязгаарласан;

Эмнэлгийн ажилтан-хязгаарласан;

Эмнэлгийн дарга-явцууруулсан байна.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

3. Халдлагыг зөвтгөх үндэслэлийг шалгах:

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.1-д эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээнд хамрагдах үйлчилгээнд:

1. Дотрын өвчин
2. Мэдрэлийн тогтолцооны өвчин
3. Нүд, чих, арьс ба халимын яс, булчин, холбох нэхдэлийн өвчин
4. Яаралтай бус гэмтэл, мэс заслын өвчин зэргийг хамруулжээ.

Бодлогын өгөгдөлд даатгалд хамрагдах дээрх 4 төрөл үйлчилгээ бус, харин бусдын эрүүл мэндэд аюул бүхий гоц халдварт өвчтэй байж болзошгүй тухай дурьдагдсан тул ЭМТХ-ийн 26.1.2, 28.1.1., 28.1.2, 31.1-д эмнэлгийн байгууллага, ажилтны үүргийг тэдний үзүүлэх үйлчилгээ, тухайн тохиолдолд төлбөргүй тухай хуульчлагдсан байх тул 103-ын эмч, эмнэлгийн ажилтан, дарга “Б”-гийн гэр бүлийнхний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхэд халдсаныг зөвтгөх үндэслэл алга.

4. Үндсэн эрхийн хязгаарыг тогтоох:


Бодлогын өгөгдлөөс иргэн “Б”, түүний эхнэр, хүүхдийн үндсэн эрхэд халдаж дараах байдлаар хязгаарласан гэж үзэх үндэслэлтэй байна. Үүнд:

- а. 103-ын эмч нь Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.5-д заасан “хүний өвчин, эмгэг, гэмтлийг илрүүлэх, оношлох, магадлах, илааршуулах, сэргээн засах, сэргийлэхэд чиглэгдсэн эмч, эмнэлгийн бусад мэргэжилтний дангаар буюу хамтран гүйцэтгэх үйл ажиллагааг болон мөн хуулийн 31.1-д заасан “Бусдын эрүүл мэндэд аюул бүхий халдварт өвчтэй хүн, нян тээгчийг эмнэлэгт тусгаарлан эмчлэх ба шаардлагатай үед тэдгээртэй хавьтагчийг тусгаарлан хөл хорио тогтоох үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- б. Дугаар олгогч ажилтан нь ЭМТХ-ийн 26.1.2-т заасан “гэнэтийн өвчин, осол, гэмтлээс амь насанд нь аюул учирсан иргэн, амаржих гэж байгаа эхэд энэ хуулийн 25.1.3-т зааснаас бусад тохиолдолд эмнэлгийн тусламжийг ямар ч нөхцөлд үзүүлэх үүргээ биелүүлээгүй байна.
- в. Эмнэлгийн дарга нь ЭМТХ-ийн 28.1.1-д заасан халдвар судлалын үйлчилгээг төрөөс төлбөрийг хариуцах ёстой байтал “Б”-гийн гэр бүлийн гишүүн тус бүрээс төлбөр нэхсэн нь буруу байна.

Дээрх гурван субъект ЭМТХ-ийн 31.1-д заасны дагуу халдварт өвчний голомтот газраас ирсэн, өвчилсөн буюу нян тээгч байж болзошгүй хүмүүсийг нэн даруй шинжилгээнд хамруулаад нян илэрсэн тохиолдолд эмнэлэгт тусгаарлах ба шаардлагатай бол хавьтагчдыг тогтоох, хөл хорио тогтоох үүргээ тус тус биелүүлээгүй байна.

5. Үндсэн эрхийг хязгаарлаж болох эсэх:

ЭМТХ-ийн 25.1.3-т эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн эрх, үүрэгт өвчтөний амь насанд харш үйлдэл хийлгэхээр шаардсан тохиолдолд түүнийг эмчлэх, үйлчлэхээс татгалзах гэж иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг хязгаарлаж болох үндэслэлийг заасан байдаг. Бодлогын өгөгдөлд тухайн үндэслэл бүрдсэн тухай дурьдагдаагүй болно.



6. Дүгнэлт:

Иргэн “Б”, түүний эхнэр, хүүхдүүд Үндсэн хуулийн 16.6-д заасны дагуу эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж авах эрх бүхий субъект мөн болохыг холбогдох хуулиар шалган тогтоолоо. Иймд 103-ын эмч, эмнэлгийн ажилтан, дарга бүгд тэдний уг эрхэд халджээ. Учир нь ЭМТХ-ийн 3.1.6-д “эрүүл мэндийн байгууллага” гэж хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үндсэн зорилго, чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг тооцдог тухай хуульчлан тодорхойлсон байна.

Гэнэтийн өвчний улмаас эдгээр иргэдийн өөрсдийн амь нас, эрүүл мэнд болон бусад хүмүүст халдварлаж болох нөхцөл байдал үүссэн байхад ямар ч тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэх үүргээ тус тус биелүүлээгүй байх тул “Б”, түүний гэр бүлийнхэн гомдол гаргавал ЭМТХ-ийн 51 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага хүлээнэ.



Бодлого 4

Иргэн “А” цахилгааны инженер мэргэжилтэй. Тэрээр эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу бие даан бизнес эрхлэхээр шийдэж, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах үйл ажиллагаа дагнан эрхлэх “Эрчим” хувьцаат компани байгуулав. Уг компани Хан-Уул дүүрэгт байрладаг юм. Ингээд тусгай зөвшөөрөл авахаар холбогдох төрийн захиргааны байгууллагад хандаж, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн өгчээ. Гэтэл төрийн захиргааны байгууллага түүний хүсэлтийг биелүүлэлгүй, “Нийслэлийн Засаг даргын саналыг аваагүй байна” гэсэн үндэслэлээр татгалзсан хариуг утсаар өгсөн байна.

Хууль зүйн дүн шинжилгээ хийнэ үү.

С-Товч дүгнэлт:

Бодлогын нөхцөлд өгөгдсөн харилцаа нь хүний үндсэн эрх буюу ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй холбогдож үүссэн харилцаа байна. Иргэн “А” Үндсэн хуулиар хамгаалагдсан уг эрхийнхээ дагуу холбогдох төрийн захиргааны байгууллагад хандсан боловч татгалзсан хариу авчээ. Иймээс цаашид өгөгдөлд дурьдсан иргэн “А”-гийн үндсэн эрх зөрчигдсэн эсэхийг холбогдох хуулийн дагуу шалган дүгнэлт хийнэ.

I-Асуудал:

- Иргэн “А”-гийн ямар эрх зөрчигдсэн, уг эрхийн агуулгыг тодорхойлох;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл гэж юу болохыг тодорхойлох;
- “Эрчим” хувьцаат компани үйл ажиллагаагаа явуулахын тулд тусгай зөвшөөрөл авах шаардлагатай эсэх;
- Иргэн “А”-гийн байгуулсан компани эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах үйл ажиллагаа эрхэлж болох эсэх;
- Хэрэв тус компани тусгай зөвшөөрөл авах бол ямар бичиг баримт бүрдүүлэх шаардлагатайг тодорхойлох;
- Төрийн захиргааны байгууллагын гаргасан шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг тодорхойлох.
- Хэрэв тухайн шийдвэр иргэний эрхэд үндэслэлгүй халдсан бол хаана хандахыг тодорхойлох.


R-Эрх зүйн зохицуулалт:

Монгол Улсын Үндсэн хууль

16.4. ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль

3.1.1. “аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл” (цаашид тусгай зөвшөөрөл гэх) гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг;



7.1. Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны холбогдох төв байгууллага олгоно.

7.3. Тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг тус тусын хуулиар зохицуулна.

8 дугаар зүйл. Хориглох аж ахуйн үйл ажиллагаа

8.1.1. хар тамхи, хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах бодис үйлдвэрлэх, импортлох, худалдах;

8.1.2. садар самуун явдлыг зохион байгуулах, түүнийг аливаа хэлбэрээр сурталчлах, дэмжих;

8.1.3. казиногийн үйл ажиллагаа эрхлэх;

8.1.4. олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа.

10.1. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь дараах эрхтэй.

10.1.1. хуульд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл олгох;

10.1.3. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих;

11.1.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл (эрхлэх үйлдвэр, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах);

11.1.2. тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;

11.1.4. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

11.1.5. тухайн үйлдвэрлэл үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг;

11.1.6. энэ хуулийн 15.5.7; 15.5.8; 15.6.1-15.6.5; 15.8.3; 15.8.8; 15.8.18; 15.8.20; 15.10.4-15.10.6; 15.11.2; 15.12.1-15.12.6-д заасан аж ахуйн үйл ажиллагааг эрхлэхэд аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг авсан байна.

11.2. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардаж болохгүй.

12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

12.1. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж, тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.

12.2. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлийг зааж бичгээр хариу өгнө.

15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл

15.8. Дэд бүтцийн чиглэлээр;

17 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон маргааныг шийдвэрлэх.

17.1. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон маргааныг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын холбогдох дээд шатны байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

Эрчим хүчний тухай хууль

6 дугаар зүйл. Төрийн захирганы төв байгууллагын бүрэн эрх

6.1.6. Тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргах;

8 дугаар зүйл. Зохицуулах газар

8.1. Зохицуулах газар нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэгтэй байна.

9 дүгээр зүйл. Зохицуулах газрын бүрэн эрх

9.1.2. энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

12 дугаар зүйл. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, түүнийг олгох

12.1. Хуулийн этгээд дараах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

12.1.11. эрчим хүчний барилга байгууламж барих.

20 дугаар зүйл. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл

20.1. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг санхүүгийн чадавхитай, уг барилга байгууламжийг барих хүсэлт гаргасан хуулийн этгээдэд олгож болно.

21 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авах

21.1. Сонирхогч хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлөө Зохицуулах газар буюу аймаг, нийслэлийн зөвлөлд гаргана.

21.2. Сонирхогч хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөлдөө эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан дараах бичиг баримтыг хавсаргана:

21.2.1. техник эдийн засгийн үндэслэл;

21.2.2. эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах эрчим хүчний нөөцийн судалгаа;

21.2.3. үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах эрчим хүчний төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт;

21.2.4. үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт;

21.2.5. үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл;

21.2.6. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;


21.2.7. байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;

21.2.8. тухайн хуулийн этгээдийн санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи;

21.2.9. үйл ажиллагаагаа эхлэх хугацаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр;

21.2.10. мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага, туршлага.

21.5. Хэрэв өргөдөл түүнд хавсаргасан баримтыг шаардлага хангаагүй гэж үзвэл түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор өргөдөл гаргагчид буцаана.



21.7. Тусгай зөвшөөрлийг санхүүгийн чадавхитай, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан буюу явуулах боломжтой хуулийн этгээдэд олгоно.

А-Анализ:

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.4-т заасны дагуу иргэн нь ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, .. хувийн аж ахуй эрхлэх эрхтэй бөгөөд иргэн “А” уг эрхээ эдлэх үндсэн дээр хувийн компани байгуулж, үйл ажиллагаагаа эхлэхийн тулд эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах тусгай зөвшөөрөл хүсч төрийн захиргааны холбогдох байгууллагад ханджээ. Иргэн “А”-гийн хувийн аж ахуй эрхлэх эрх нь Үндсэн хуулиар хуульчлан хамгаалагдсан ба бодлогын өгөгдлөөс харахад энэхүү эрхэд нь төрийн захиргааны тодорхой байгууллагын зүгээс халдлага учирсан байна. Тэрээр уг эрхээ эдлэхэд шаардагдах нөхцөл, журмыг холбогдох хуулиар хэрхэн дэлгэрүүлэн зохицуулсныг тодорхойлох нь чухал юм.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 3.1.1-т “аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл” (цаашид тусгай зөвшөөрөл гэх) гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг хэлнэ гэжээ. Үүнээс үзэхэд тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэхэд энэхүү тусгай зөвшөөрлийг авах шаардлагатай болох нь илэрхий байна.

Иргэн “А” өөрийн эзэмшсэн мэргэжилдээ түшиглэн байгуулсан компани нь эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах чиглэлээр дагнан ажиллах болох нь өгөгдлөөс тодорхой байна. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.8-д тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөлд дэд бүтцийн чиглэлээр гэж заасан тул тухайн компани үйл ажиллагаагаа эхлэн явуулахын тулд тусгай зөвшөөрлийг зайлшгүй авах шаардлагатай юм байна. Мөн Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлд Зохицуулах газрын талаар 8.1. “Зохицуулах газар нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэгтэй байна” гээд Зохицуулах газрын бүрэн эрхэд 9.1.2. энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохыг хамааруулан хуульчилсан байна. Тухайн хуулийн 12.1-д “Хуулийн этгээд дараах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ” гэж заасны дотор 12.1.11-д эрчим хүчний барилга байгууламж барихад тусгай зөвшөөрөл авах талаар хуульчилжээ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгай зөвшөөрөл олгох журмын талаар дараах байдлаар хуульчилсан байна: 7.1-д “энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны холбогдох төв байгууллага олгоно”; 7.3-д “тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг тус тусын хуулиар зохицуулна” гэжээ. Эрчим хүчний тухай хуулийн 21.1-д “Сонирхогч хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлөө Зохицуулах газар буюу аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлд гаргана” гэснээс үзвэл “Эрчим” компани холбогдох төрийн захиргааны байгууллагад хандсан болох нь тодорхой байна. Иймээс Эрчим хүчний тухай хуулийн 20.1-д “Эрчим хүчний барилга

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

байгууламж барих тусгай зөвшөөрлийг санхүүгийн чадавхитай, уг барилга байгууламжийг барих хүсэлт гаргасан хуулийн этгээдэд олгож болно” гэж заасны дагуу “Эрчим” компани тусгай зөвшөөрөл авах эрхтэй юм.

“Эрчим” компани тусгай зөвшөөрөл авахын тулд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1-д заасны дагуу дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

11.1.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл (эрхлэх үйлдвэр, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах);

11.1.2. тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;

11.1.4. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

11.1.5. тухайн үйлдвэрлэл үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг зэргийг бүрдүүлэх ба тэрээр дэд бүтцийн бүр тодруулбал эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулахын тулд Эрчим хүчний тухай хуулиар нарийвчлан зохицуулсан дараах баримт бичгийг хавсаргасан байх учиртай. Үүнд:

21.2.1. техник, эдийн засгийн үндэслэл;

21.2.2. эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах эрчим хүчний нөөцийн судалгаа;

21.2.3. үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах эрчим хүчний төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт;

21.2.4. үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт;

21.2.5. үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл;

21.2.6. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

21.2.7. байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;

21.2.8. тухайн хуулийн этгээдийн санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи;

21.2.9. үйл ажиллагаагаа эхлэх хугацаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр;

21.2.10. мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага, туршлага зэрэг болно.

Эдгээрээс үндэслэн үзвэл дээрх баримт бичиг шаардлагыг “Эрчим” компани хангасан гэх үндэслэл өгөгдлөөс тодорхой байна. Тус компани Хан-Уул дүүрэгт байрладаг тул тусгай зөвшөөрөл авахаар Төрийн захиргааны байгууллага болох Нийслэлийн зохицуулах зөвлөлд хүсэлт гаргана. Харин тус зөвлөл тус компанийн өргөдөлд нийслэлийн Засаг даргын саналыг аваагүй гэсэн үндэслэлээр татгалзсан хариу өгсөн байгаа. Аж ахуйн тусгай зөвшөөрлийн хуулийн 11.1.6-д тусгай зөвшөөрөл авахын тулд аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг заавал авсан байх үйл ажиллагааны төрлийг хуульчилсан:


15.5.7. төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах;

15.5.8. галт зэвсэг үйлдвэрлэх, худалдах;

15.6.1. озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах;

15.6.2. тэсэрч, дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх;

15.6.3. химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах;



15.6.5. стандартаар хүлцэх хэмжээг нь тогтоогоогүй бохирдуулах бодис агаарт гаргах;

15.8.3. эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, диспетчерийн зохицуулалт хийх, түгээх, хангах, борлуулах үйл ажиллагаа эрхлэх;

15.10.4. химийн хорт болон аюултай бодис экспортлох, худалдах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах;

15.10.5. ашигт малтмалын хайгуул хийх;

15.10.6. ашигт малтмал ашиглах;

15.11.2. сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх;

15.12.1. мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэх;

15.12.2. хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох;

15.12.3. эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ эрхлэх;

15.12.4. мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, тэдгээрийн угтвар бодис болон эмийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, импортлох;

15.12.5. улсын хэмжээний болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;

15.12.6. өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх зэрэг. Эндээс үзвэл “Эрчим” компанийн эрхлэх үйл ажиллагааны төрлөөр тусгай зөвшөөрөл авахад нийслэлийн Засаг даргын саналыг авах шаардлага хуульчлагдаагүй байна. Тэгээд ч Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.2-д “Энэ зүйлийн нэг дэх хэсэгт зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардаж болохгүй” гэсэн тул иргэн “А”-гийн хүсэлтийг биелүүлэхээс татгалзсан хууль зүйн үндэслэлгүй юм.

Иймээс иргэн “А” Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 17.1. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан маргааныг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын холбогдох дээд шатны байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно; мөн Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу - 6.1.6. тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргуулахаар бүрэн эрхэд нь хуулиар хамааруулсан Төрийн захиргааны төв байгууллагад хандана.

С-Ерөнхий дүгнэлт:

Иргэн “А” Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхээ эдлэн хувийн аж ахуй эрхлэхээр болж компани байгуулсан ба тус компанийн эрхлэх үйл ажиллагааны төрөл нь хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл заавал авсны үндсэн дээр хэрэгжих юм байна. Ингээд тэрээр холбогдох байгууллагад шаардагдах бичиг баримтыг бүрдүүлж хүсэлт гаргахад “Нийслэлийн Засаг даргын санал аваагүй” гэсэн үндэслэлээр татгалзсан хариу өгснөөр төрийн захиргааны холбогдох байгууллага (нийслэлийн зохицуулах зөвлөл) түүний үндсэн эрхэд халдсан бөгөөд энэхүү халдлагыг зөвтгөх үндэслэл байгаа эсэхийг хуулийн дагуу шалгахад тогтоогдоогүй тул хууль бус байна. Түүнчлэн Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12.2-т заасан “тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлийг зааж бичгээр хариу өгнө” гэсэн заалтыг мөн зөрчсөн байна.



Бодлого 5

“А” охин ээжтэйгээ хоёулаа амьдарч байв.Түүнийг 10 настай байхад ээж нь өвчний улмаас нас барж тэрээр улсын асрамжийн газар амьдрах болжээ. Охиныг 11 нас хүрч байхад Австри улсын иргэд болох эхнэр, нөхөр хоёр тус асрамжийн газарт зочилохдоо түүнтэй анх танилцсан байна. Улмаар охинтой болон асрамжийн газрын удирдлагатай байнгын харилцаа тогтоож байгаад тодорхой хугацааны дараа түүнийг үрчилж авах тухай хүсэлтээ зохих журмын дагуу гаргаж “А”-г үрчилж авчээ.

Үрчилж авсан эцэг, эх нь бас охины иргэний харьяаллыг өөрчлөх хүсэлт гаргаж шийдвэрлүүлсэн байна. Ингээд “А” охин Австри улсын иргэн болж тэнд 9 жил амьдраад уугуул эх орондоо ирж амьдрах, хуучин иргэний харьяаллаа сэргээлгэхээр шийдэж Монгол Улсаас Австри улсад суугаа элчин сайдын яаманд өргөдөл гаргасан.

Түүний хүсэлтийн дагуу Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба “А”-гийн иргэний харьяаллыг сэргээн тогтоохоос татгалзсан дүгнэлт гаргажээ. Дүгнэлтдээ улсын үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс гэсэн үндэслэл заасан байна. Ийнхүү харьяаллыг сэргээн тогтоохоос татгалзсан утгатай дүгнэлт гаргахад Тагнуулын төв байгууллагаас тус албанд ирүүлсэн тодорхойлолтод тусгагдсан мэдээлэл нөлөөлсөн юм. Учир нь охины үрчилж авсан эцэг, эх нь олон улсын алан хядах байгууллагын гишүүн байсан бөгөөд Европын нэгэн оронд явагдсан террорист ажиллагаанд оролцсоны төлөө хорих ялаар шийтгэгдсэн байжээ.

Хууль зүйн дүн шинжилгээ хийнэ үү.


С-Товч дүгнэлт:

Иргэний харьяалал гэдэг нь төр, иргэний харилцан эрх, үүргээр нөхцөлдсөн, хүний нэр төр, эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хүлээн зөвшөөрөх зарчимд тулгуурласан эрх зүйн тогтвортой харилцаа юм. Монгол Улсын Үндсэн хуульд иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно гэж заасныг үндэслэн бодлогын нөхцөлийг авч үзвэл “А” охин өмнө нь Монгол Улсын иргэн байсан, улмаар өмнөх иргэний харьяаллаа сэргээлгэх хүсэлт гаргасан байна.

Дүгнэвэл: Иргэний харьяаллын харилцааны үндсийг Үндсэн хуулиар тогтоосон, түүнчлэн түүнтэй холбогдон үүсэх харилцааг хуулиар нарийвчлан зохицуулдаг болох нь тодорхой тул өгөгдөлд тусгагдсан харилцаа нь эрх зүйн, тэр тусмаа төрийн эрх зүйн харилцаа байна.

I-Асуудал:

- “А” охин аль улсын харьяат болох;
- Австри улсын иргэд “А” охиныг үрчилж авах хүсэлт гаргах эрх зүйн үндэслэл;
- Үрчилж авсан гадаад улсын иргэд Монгол Улсын иргэн хүүхдийн иргэний харьяаллыг өөрчлөх хүсэлт гаргах эрхтэй эсэх;



- Иргэний харьяаллыг сэргээн тогтоох хууль зүйн үндэслэлийг тогтоох;
- “А” охины харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлтийн үндэслэл;
- “А” охин Монгол Улсаас Австри улсад суугаа элчин сайдын яаманд өргөдөл гаргасан нь зөв эсэх;
- Иргэний харьяаллыг сэргээн тогтоох асуудлыг эрхэлдэг төрийн байгууллагыг тогтоох;
- Иргэний харьяаллыг сэргээхэд санал, дүгнэлт гаргаж оролцох байгууллагууд;
- Эцэг, эх, төрөл төрөгсдийн гэмийг үр хүүхдэд нь халдаан хэрэглэж болох эсэх;
- Гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн асуудал эрхлэх албаны дүгнэлт үндэслэлтэй эсэх.

R-Эрх зүйн зохицуулалт:

Монгол Улсын Үндсэн хууль

Арван тавдугаар зүйл

1. Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно.
2. Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно.

Гэр бүлийн тухай хууль

54 дүгээр зүйл. Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх

- 54.1. Хүүхдийг тэдний ашиг сонирхлын үүднээс үрчлүүлнэ.
- 54.2. Хүүхдийг энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмын дагуу гадаадын иргэнд үрчлүүлж болно.

58 дугаар зүйл. Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах

58.1. Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол Улсын эрх бүхий байгууллагад гаргана.

58.2. Монгол Улсад зургаан сараас доошгүй хугацаанд оршин сууж байгаа гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авахад энэ хуулийн 58.1 хамаарахгүй.

58.3. Хүүхэд үрчлэн авахыг хүсэгч гадаадын иргэн нь энэ хуулийн 55.1, 55.3-т заасан зөвшөөрлөөс гадна дор дурдсан бичиг баримт бүрдүүлнэ:

58.3.1. хүүхэд үрчлэн авахыг хүсэгчийн (нөхөр, эхнэртэй бол хамтарч гаргасан) хүсэлт, түүний нотариатаар гэрчлүүлсэн албан ёсны орчуулга;

58.3.2. үрчлэгч нь сүрьеэ, ДОХ, сэтгэцийн өвчтэй эсэх талаарх эмнэлгийн магадлагаа;

58.3.3. өргөдөл гаргагчийн гэрлэлтийн гэрчилгээний хуулбар (гэр бүлтэй бол);

58.3.4. өргөдөл гаргагчийн байнга оршин суугаа газрын талаар холбогдох байгууллагын тодорхойлолт (цагдаагийн байгууллагын тодорхойлолт хамаарна);

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

58.3.5. өргөдөл гаргагчийн амьдралын болон санхүүгийн боломжийн тухай тухайн улсын холбогдох байгууллагын тодорхойлолт;

58.3.6. өргөдөл гаргагчийн талаарх хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолт.

58.4. Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авсныг “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 111 дүгээр зүйлд заасан байгууллага бүртгэнэ.

58.8. Хүүхдийнхээ эх орон, эцэг, эхийг нь мэдүүлэх үүргийг үрчлэн авсан эцэг, эх нь хүлээнэ.

58.9. Үрчлэгдсэн хүүхэд харьяатаа сонгох эрхийг Харьяатын тухай Монгол Улсын хууль 1-д заасны дагуу эдэлнэ.

Харьяатын тухай хууль

13 дугаар зүйл. Үрчлэгдсэн хүүхдийн иргэний харьяаллыг шийдвэрлэх

1. Гадаадын иргэн эхнэр, нөхрийн үрчлэн авсан Монгол Улсын харьяат 16 нас хүрээгүй хүүхэд Монгол Улсын харьяат хэвээр байна.

2. Хэрэв гадаадын иргэн, эхнэр, нөхөр нь Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах үед түүний иргэний харьяаллыг өөрчлөх хүсэлт гаргавал үрчлүүлж буй эцэг, эхийн саналыг харгалзан тухайн хүүхдийн иргэний харьяаллыг шийдвэрлэж болно.

14 дүгээр зүйл. Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтоох

1. Дор дурьдсан тохиолдолд Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтооно:

- 1) үрчлэгдсэнтэй холбогдож Монгол Улсын иргэн энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр иргэний харьяаллаа алдсан;
- 2) эцэг, эхийн нь харьяат өөрчлөгдсөнтэй холбогдож Монгол Улсын иргэн иргэний харьяаллаа алдсан бол 18 нас хүрснээс хойш таван жилийн дотор;
- 3) 1921 оны долдугаар сарын 11-ний өдөр болон түүнээс хойш Монгол Улсын харьяат байсан бөгөөд аль нэг гадаад улсын харьяат болсон хүмүүс.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан тохиолдолд иргэний харьяаллаа сэргээлгэхийг хүссэн хүн өргөдлөө Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд гаргана.


3. Иргэний харьяаллыг сэргээн тогтоолгох тухай өргөдлийг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаар уламжлан Монгол Улсын Ерөнхийлөгчид гаргана.

19 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх хэмжээ

Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд дор дурьдсан асуудлаар шийдвэр гаргана: 1) гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсын харьяат болгох; 2) Монгол Улсын харьяатаас гаргах; 3) Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтоох.

20 дугаар зүйл. Төрийн захиргааны байгууллагын эрх хэмжээ

1. Монгол Улсын иргэний харьяалалтай холбогдсон асуудлаар Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болон гадаад улсад оршин суугаа хүний хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэхээр холбогдох бусад бичиг баримт, саналын хамт Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчид өргөн барина.



2. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаар гарсан шийдвэрийн дагуу Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон, иргэний харьяаллаа алдсан хүний нэгдсэн бүртгэлийг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба хөтөлнө.

3. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаар гаргасан өргөдлийг шийдвэрлэхэд тус улсын тагнуулын болон цагдаагийн төв байгууллага, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, орон нутгийн цагдаагийн байгууллага, иргэний бүртгэл, мэдээллийн алба, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар энэ хуульд заасан журам, тус тусын чиг үүргийн дагуу оролцоно.

4. Тагнуулын төв байгууллага иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргасан хүний талаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үүднээс дүгнэлт хийж, асуудлыг хэрхэн шийдвэрлүүлэхээр тодорхой санал гаргана.

5. Цагдаагийн төв байгууллага болон Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв нь холбогдох албадаараа дамжуулан иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргасан хүний иргэний бүртгэлийн талаар лавлагаа өгөх, бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнчлэн бусад асуудлаар санал дүгнэлт өгөх ажиллагаа тус тус явуулна.

6. Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, орон нутгийн цагдаагийн байгууллага болон иргэний бүртгэл, мэдээллийн алба нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргасан хүний, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар нь гадаад улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа мөн асуудлаар хүсэлт гаргасан хүний хувийн байдлыг тодорхойлж дүгнэлт гаргана.

21 дүгээр зүйл. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргах

1. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаарх хүсэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр дээр гаргана.

2. Монгол Улсын харьяат болох, харьяатаа сэргээн тогтоолгох, харьяатаас гарах тухай хүсэлт гаргагч энэ хуулийн 22 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан журмаар тогтоосон жагсаалтын дагуу зохих бичиг баримтыг бүрдүүлнэ.

22 дугаар зүйл. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргах журам

1. Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах тухай хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг дарга, хэрэв Монгол Улсын иргэн гадаад улсад оршин суугаа бол Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчдийн буюу консулын газар, Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаар дамжуулан Ерөнхийлөгчид уламжилна.

3. Хүсэлтийг хүлээн авсан аймаг, нийслэлийн Засаг дарга, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар холбогдох бусад баримт бичгийн бүрдлийг шалган хэрвээ уг баримт бичиг нь гадаад хэл дээр үйлдэгдсэн бол түүний албан ёсоор баталгаажуулсан орчуулга, тодорхой саналын хамт Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд хүргүүлнэ.

4. Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

хүний талаарх санал, дүгнэлтийг тагнуулын болон цагдаагийн төв байгууллагаас авсан байна.

6. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бичиг баримтын жагсаалтыг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба тогтооно.

23 дугаар зүйл. Иргэний харьяаллын асуудлаар дүгнэлт гаргах

1. Энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулж Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба дүгнэлт гаргана.

2. Иргэний харьяаллын асуудлаар гаргасан хүсэлтийн дагуу Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба дүгнэлт гаргахдаа хүсэлт гаргагчийн ашиг сонирхол, улсын үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, гаргасан өргөдлийн агуулга, харьяатын асуудлаар бусад байгууллагаас гаргасан тодорхойлолт болон санал, дүгнэлт түүнчлэн уг асуудлаар шийдвэр гаргахад ач холбогдол бүхий бусад баримт бичгийг тал бүрээс нь нягтлан үзэж, дүгнэлт өгнө. Дүгнэлтэд Монгол Улсын харьяат болгох, харьяатаас гаргах, иргэний харьяаллыг сэргээн тогтоох болон тэдгээрээс татгалзах үндэслэл, нөхцөлийг тодорхой зааж тусгасан байна.

3. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба нь иргэний харьяаллын асуудлаар дүгнэлт гаргахад шаардлагатай баримт бичгийг төр, олон нийт, аж ахуйн аль ч байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авна. Эдгээр байгууллага, албан тушаалтан холбогдох баримт бичгийг харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шаардсан хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.

28 дугаар зүйл. Иргэний харьяаллын асуудлаар гарсан шийдвэрт гомдол гаргах


Иргэний харьяаллын асуудлаар гаргасан өргөдлийг хүлээн авахаас үндэсгүй татгалзсан, уг өргөдлийн шийдвэрлэх хугацааг тодорхой шалтгаангүйгээр хэтрүүлсэн, сунгасан, хойшлуулсан иргэний харьяаллын асуудлыг хянан хэлэлцэх болон мөнхүү асуудлаар гарсан шийдвэрийг биелүүлэх журмыг зөрчсөн тухай гомдлыг холбогдох дээд шатны нь байгууллагын албан тушаалтан болон шүүхэд гаргаж болно.

А-Анализ-дүн шинжилгээ:

- Харьяатын тухай хуулийн 13.1-д заасны дагуу гадаадын иргэн эхнэр, нөхрийн үрчлэн авсан Монгол Улсын харьяат 16 нас хүрээгүй хүүхэд Монгол Улсын харьяат хэвээр байна. Гэхдээ бодлогын өгөгдлийн дагуу “А” охин хүсэлт гаргах үедээ Австри улсын иргэн байсан.
- Харьяатын тухай хуулийн 13.2-ийн дагуу хэрэв гадаадын иргэн эхнэр, нөхөр нь Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах үед түүний иргэний харьяаллыг өөрчлөх хүсэлт гаргавал үрчлүүлж буй эцэг, эхийн саналыг харгалзан тухайн хүүхдийн иргэний харьяаллыг шийдвэрлэж болно. Чухам үүний дагуу “А” охины харьяалал өөрчлөгдсөн.

Гэр бүлийн тухай хуулийн 54.2-т хүүхдийг энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмын дагуу гадаадын иргэнд үрчлүүлж болно гэжээ. Үүнд:

58.1. Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол Улсын эрх бүхий байгууллагад гаргана.



58.3. Хүүхэд үрчлэн авахыг хүсэгч гадаадын иргэн нь энэ хуулийн 55.1, 55.3-т заасан зөвшөөрлөөс гадна дор дурдсан бичиг баримт бүрдүүлнэ:

58.3.1. хүүхэд үрчлэн авахыг хүсэгчийн (нөхөр, эхнэртэй бол хамтарч гаргасан) хүсэлт, түүний нотариатаар гэрчлүүлсэн албан ёсны орчуулга;

58.3.2. үрчлэгч нь сүрьеэ, ДОХ, сэтгэцийн өвчтэй эсэх талаархи эмнэлгийн магадлагаа;

58.3.3. өргөдөл гаргагчийн гэрлэлтийн гэрчилгээний хуулбар (гэр бүлтэй бол);

58.3.4. өргөдөл гаргагчийн байнга оршин суугаа газрын талаар холбогдох байгууллагын тодорхойлолт (цагдаагийн байгууллагын тодорхойлолт хамаарна);

58.3.5. өргөдөл гаргагчийн амьдралын болон санхүүгийн боломжийн тухай тухайн улсын холбогдох байгууллагын тодорхойлолт;

58.3.6. өргөдөл гаргагчийн талаарх хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолт.

58.4. Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авсныг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль-ийн 111 дүгээр зүйлд заасан байгууллага бүртгэнэ гэсэн тодорхой журам үйлчилдэг байна. Бодлогын өгөгдлийг эдгээр зүйлээр шалгахад “А” охин үрчлэгдээд нэгэнт 9 жил өнгөрсөн байх тул дээрх нөхцөлүүд хангагдсан байсан гэж ойлгогдож байна.

- Харьяатын тухай хуулийн 14.1-д Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтоох дараах үндэслэлийг заажээ: 1) үрчлэгдсэнтэй холбогдож Монгол Улсын иргэн энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр иргэний харьяаллаа алдсан бол гэсэн нь “А” охинд хамаарах буюу үрчилж авсан гадаадын харьяат эцэг, эхийн хүсэлтээр түүний харьяалал өөрчлөгдсөн тул үйлчилж буй хуулийн дагуу харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргах эрхтэй болно.

- Харьяатын тухай хуулийн 21.1-д “Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаарх хүсэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр дээр гаргана” гэжээ. Харин 22.1-д “Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах тухай хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг дарга, хэрэв Монгол Улсын иргэн гадаад улсад оршин суугаа бол Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчдийн буюу консулын газар, Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаар дамжуулан Ерөнхийлөгчид уламжилна” хэмээн харьяаллын асуудлаар хүсэлт гаргах журмыг тогтоосон. Эндээс үзвэл “А” охин хүсэлт гаргах үедээ Австри улсад амьдарч байсан тул элчин сайдын яаманд хандах нь үндэслэлтэй байна.

А. Харьяатын тухай хуулийн 19.3-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтоох асуудлаар шийдвэр гаргана. Үүнээс

Б. 20.1. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болон гадаад улсад оршин суугаа хүний хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэхээр холбогдох бусад бичиг баримт, саналын хамт Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчид өргөн барина.

В. 20.3. тус улсын тагнуулын болон цагдаагийн төв байгууллага

Г. 20.3. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв

Д. 20.3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

- Е. Орон нутгийн цагдаагийн байгууллага, иргэний бүртгэл, мэдээллийн алба
- Ё. Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар энэ хуульд заасан журам, тус тусын чиг үүргийн дагуу оролцоно.

Тус хуулийн 20.4-т “Тагнуулын төв байгууллага иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргасан хүний талаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үүднээс дүгнэлт хийж, асуудлыг хэрхэн шийдвэрлүүлэхээр тодорхой санал гаргана” гэж заасан байх тул Гадаадын иргэн, харьяатын албаны хүсэлтээр дүгнэлт гаргасан нь хууль зүйн үндэслэлтэй юм.

- Монгол Улсын Үндсэн хуулийн 16.14-д “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэж заасны дагуу үрчилж авсан эцэг эхийн гэм буруут “А” охинд халдаан хэрэглэх нь хууль зүйн үндэслэлгүй байна.
- Эндээс үзвэл Гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн асуудал эрхлэх албаны дүгнэлт Үндсэн хуулийн 16.14-т харшилжээ.

С-Ерөнхий дүгнэлт:

- А. Үрчлэгдэхдээ 9 настай байсан “А” охин 16 нас хүртлээ Монгол Улсын иргэн байх боловч үрчилж авсан эцэг, эхийн хүсэлтээр түүний иргэний харьяаллыг өөрчилж болох нь хууль зүйн үндэслэлтэй.
- Б. Холбогдох хуулийн зүйл, заалтын дагуу шалгаж үзэхэд үрчилж авсан эцэг, эх нь “А” охины харьяаллыг өөрчлөх хүсэлт гаргаж болох юм байна.
- В. Хуульд иргэний харьяаллыг сэргээн тогтоох 3 үндэслэлийг зааснаас “А” охинд гуравдахь буюу гадаадын харьяат хүнд үрчлэгдсэний улмаас иргэний харьяаллаа алдсан гэсэн нь тохирч байгаа тул тэрээр иргэний харьяаллаа сэргээлгэх эрх бүхий субъект мөн.
- Г. Ерөнхийлөгч иргэний харьяаллыг сэргээн тогтоох асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй ч хүсэлт гаргагч хүмүүс гадаад улсад амьдарч байгаа бол тус улсад Монгол Улсаас суугаа дипломат төлөөлөгчдийн газарт хандаж болохыг хуулиар тогтоосон юм. “А” охин зөв хаягаар ханджээ.
- Д. Иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд Ерөнхийлөгч болон Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба, Монгол Улсын Ерөнхий сайд, Тагнуулын болон цагдаагийн төв байгууллага, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, Орон нутгийн цагдаагийн байгууллага, иргэний бүртгэл, мэдээллийн алба, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар энэ хуульд заасан журам, тус тусын чиг үүргийн дагуу оролцоно.



Эдгээрээс Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд асуудлыг шийдвэрлэх нь хамаардаг бол холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх, хууль зүйн шаардлагыг хангах нь Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд хамаарах ба бусад байгууллага, албан тушаалтан шаардлагатай санал, дүгнэлт гаргаж өгөх үүрэгтэй оролцдог байна. Иймээс Тагнуулын төв байгууллага дүгнэлт гаргаж өгөх бүрэн эрхтэй байна.

- Е.** Харин эцэг, эхийн гэмийг үр хүүхдэд халдаан хэрэглэхийг Үндсэн хуулиар хориглосон байтал Гадаадын иргэн, харьяатын алба үүнийг үл харгалзан “А” охины харьяаллыг сэргээн тогтоохоос татгалзсан хариу өгсөн нь охины эрхэд халдсан хэрэг. Тус алба нь нийтийн засаглалын байгууллага болох тул охин гомдлоо дээд шатны байгууллагад гаргаж зөрчигдсэн эрхээ сэргээлгэх эрхтэй болно.

ХОЁР. ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ БОЛОН ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН БОДЛОГО БОДОХ АРГАЧЛАЛ

Нийтийн эрх зүйн (захиргааны) бодлого бодохын тулд дараах гурван асуултыг тавих хэрэгтэй. Үүнд:²⁷

- Бодлогоор ямар асуулт тавигдсан бэ?
- Талууд юуг хүсэж байна вэ?
- Эрх зүйн ямар үр дагаварт (үр дүнд) хүрэх вэ?

Дээрх гурван асуултын хариу тухайн тохиолдлыг бодлого бодох аргачлалын дагуу дүгнэхэд туслах шинж чанартай байдаг.

Тухайн бодлогоор тавигдсан асуулт чухал бөгөөд бодогч тавигдсан асуултад хариулах ёстой. Уг асуултын хариултад хүргэхгүй тайлбарууд илүүц бөгөөд зарим тохиолдолд бүр алдаанд ч хүргэж болдог. Нэг үгээр хэлбэл хариулт зөвхөн тухайн бодлогод тавигдсан асуултад л чиглэгдэх ёстой.

Жишээ 1:

“А” болон “Д” нар нэг байранд амьдардаг хөршүүд. “А” өөрийн сууцандаа баар ажиллуулах зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас аван үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Гэтэл “А”-ийн хөрш “Д” нь “баар ажиллуулсны улмаас орц бохир заваан болж, дуу чимээ ихдэн өөрийнх нь болон бусад оршин суугчдын ая тухтай байдал алдагдахад хүрлээ хэмээн шүүхэнд хандсан.

Асуулт:

Д-ийн эрх зөрчигдсэн үү?

Аргачлал:

Бодлогын өгөгдөлд зөвхөн “Д”-ийн эрхийн талаар асуусан тул хариулт түүнд чиглэгдэх ёстой. Өөрөөр хэлбэл, асуултад холбогдолгүй хариулт (тухайлбал “А”-ийн эрхтэй холбоотой) илүүц юм. “Д”-ийн эрх зөрчигдсэн эсэхийг тогтоохын тулд шүүх түүний нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэх, тухайн нэхэмжлэл нь үндэслэлтэй эсэхийг шалгана гэсэн үг юм.

1. Зарим тохиолдолд бодлогын асуулт өгөгдсөн боловч түүнд шууд хариулах боломжгүй байдаг. Асуултад шууд хариулах боломжгүй үед хэргийн оролцогч талуудын зорилго буюу сонирхлыг тодорхойлох хэрэгтэй. Ийнхүү сонирхлыг тодорхойлсноор тухайн зорилгод хэрхэн хүрэх, зорилго нь хангагдах боломжтой эсэхийг тогтоох юм.

Жишээ 2:

“Д” сангийн яаманд ажилладаг. Тэрээр нэгэн аж ахуйн нэгжийн захиалгаар татвараас зайлсхийх боломжийн талаар лекц унших хүсэлтэй тул газрын даргаасаа зөвшөөрөл хүссэн байна. Гэвч газрын дарга “төрийн албан хаагч нь давхар ажил эрхлэх эрхгүй” гэсэн үндэслэлээр “Д”-ийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан тул тэрээр яамынхаа төрийн нарийн бичгийн даргад гомдол гаргасан. Төрийн нарийн бичгийн дарга газрын даргын шийдвэрийг хэвээр үлдээсэн. Иймд “Д” захиргааны хэргийн шүүхэд хандсан.

27. Хайнрих Шоллер, Хууль зүйн дүгнэлт болон шүүхийн шийдвэр гаргах зарим асуудал, х.14-21.



Асуулт:

“Д” шүүхэд ямар нэхэмжлэл гаргах вэ?

Аргачлал:

Бодлогын асуултад шууд хариулах боломжгүй байна. Иймд талуудын сонирхлыг тодорхойлох шаардлагатай. Бодлогын нөхцөлөөс харахад “Д”-ийн хүсэл зориг нь лекц унших зөвшөөрлийг авахад чиглэгдэж байна. Иймд тэрээр зорилгодоо хүрэхийн тулд нэхэмжлэлийн ямар төрлийг сонгох нь зүйтэй вэ? гэдэг асуулт тавигдаж байна. Хуулийн дагуу хүчингүй болгох, даалгах, илт хууль бусыг тогтоох, эрх зүйн харилцааг тогтоох, хохирлыг тогтоох нэхэмжлэлийн төрлүүдийг гаргах боломжтой байна. “Д” хүчингүй болгох нэхэмжлэл гаргасан тохиолдолд хэрэв захиргааны шийдвэр (газрын даргын татгалзсан шийдвэр) хууль бус байгаад хүчингүй боллоо гэхэд тэрээр зорилгодоо хүрч чадахгүй. Учир нь түүнд лекц унших зөвшөөрөл байхгүй л байсаар байна. Иймд “Д” нь шууд даалгах нэхэмжлэл гаргавал зорилгодоо илүү хурдан хүрэх бололцоотой юм. Нэхэмжлэлийн бусад төрлийг гаргаснаар зорилгодоо хүрэх боломжгүй буюу түүнд эрх зүйн хамгаалалт дутагдах юм. Иймд даалгах нэхэмжлэлийг сонгох бөгөөд уг нэхэмжлэлийг гаргах урьдчилсан нөхцөл хангагдсан эсэхийг шалгана.

2. Үр дагаварыг асуусан асуулт нь хэргийн нөхцөл байдалд чиглэгдсэн асуулт юм. Хэргийн нөхцөл байдал өөрөө маш олон асуултыг агуулж байдаг. Иймд тухайн хэргийн нөхцөл байдлаас урган гарч ирж байгаа асуултыг оновчтой сонгон авснаар зөв шийдэлд хүрэх боломжтой.

Жишээ 3:

“Б” хуулийн этгээд нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэр дээр барилга барих зориулалтаар 0,3 га газрыг эзэмших эрхийг дүүргийн Засаг даргаас авсан. Түүнээс хойш 3 жил өнгөрөхөд “Б” хуулийн этгээд нь уг газар дээрээ барилгын ажлаа эхлүүлээгүй боловч Засаг дарга түүний газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоогүй. Энэ үед “Д” хуулийн этгээд нийслэлийн Засаг даргад “Б” хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх тухай дүүргийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгуулах тухай гомдлыг дараах хоёр үндэслэлээр тавьжээ. Үүнд:

1. “Б” хуулийн этгээд нь эзэмшиж буй газраа хуульд заасан хугацаанд зориулалтын дагуу ашиглаагүй,
2. Дүүргийн Засаг дарга нь “Б” хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх эрхийг олгохдоо дуудлага худалдаа болон төсөл шалгаруулах журмыг зөрчиж олгосон тул хууль бус гэжээ.

Асуулт:

Эрх зүйн ямар үр дагаварт хүрэх вэ? (Дээрх тохиолдолд хууль зүйн дүн шинжилгээ хийнэ үү)

Аргачлал:

Бодлогын асуулт нь ерөнхий тул түүнийг дотор нь эрх зүйн харилцаа болгоноор нь нарийвчлан задлах шаардлагатай. Гэхдээ бодлогын нөхцөл “Д”-ийн гомдолд чиглэгдэж байгаа тул түүний гомдлын шаардлага нь үндэслэлтэй эсэхийг тогтоох нь зүйтэй. “Д” гомдолдоо 2 үндэслэл гаргасан байх бөгөөд ач холбогдлын хувьд хоёр дахийг нь эхлээд шалгах нь оновчтой юм.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

Үүний тулд:

1. Дүүргийн Засаг дарга нь “Б” хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх эрхийг олгохдоо дуудлага худалдаа болон төсөл шалгаруулах журмыг зөрчиж олгосон нь “Б”-ийн газар эзэмших эрхийг хүчингүй болгох үндэслэл болох уу?
2. “Б” хуулийн этгээд нь эзэмшиж буй газраа хуульд заасан хугацаанд зориулалтын дагуу ашиглаагүй нь мөн түүний эрхийг хүчингүй болгох үндэслэл болох уу? гэдгийг шалгах хэрэгтэй.
3. Хэдийгээр дээрх хоёр үндэслэл нь хууль зөрчсөн гэдэг нь тогтоогдсон ч энэ нь гуравдагч этгээд “Д”-ийн гомдлоор хүчингүй болгох боломжтой юу гэдгийг мөн шалгах шаардлагатай.

Дээр тавигдсан гурван асуулт нь бодлого бодох гурван аргыг тодорхойлж өгдөг. Үүнд түүхчлэх, логик, топик аргууд хамаарна.

Эхний асуулт нь бодлого бодох логик аргыг илэрхийлдэг бол хоёр дахь асуулт нь түүхчлэх, харин гурав дахь асуулт нь топик аргаар тодорхой нөхцөл байдалд тулгуурлан бодлого бодоход хүргэдэг байна.

Логик аргаар бодлого бодоход эхний асуулт хэрэглэгдэнэ. Логик аргын гол зарчим нь эрх зүйн үр дагавраас урьдчилсан нөхцөл байдалд хүрэх юм. Жишээ нь, захиргааны акт хууль ёсны эсэх, нэхэмжлэл үндэслэлтэй эсэхийг, хуульд заасан урьдчилсан нөхцөлүүд тухайн тохиолдолд яаж хангагдсаныг тодорхойлох хэрэгтэй гэсэн үг юм. Логик арга нь **“Ийм учраас Тийм”** гэсэн үгээр илэрхийлэгдэнэ.

Түүхчлэх арга нь захиргааны хэргийг анх болсон үйл явдлаас эхлээд цаг хугацааны дэс дараалалтайгаар авч үздэг. Түүхчлэх аргыг ижил асуудлаар хэд хэдэн нэхэмжлэгч шүүхэд хандсан тохиолдолд цаг хугацааны дарааллаар ангилж нэхэмжлэл болгоныг шалгах, эсхүл захиргааны хэм хэмжээний актын үндсэн дээр захиргааны акт гарсан тохиолдол эхэлж хэм хэмжээний акт хууль ёсны эсэхийг шалгах зэргээр хэрэглэгдэнэ. Уг аргыг **“Хэзээ? Юу?”** гэсэн үгээр илэрхийлж болох юм.

Гурав дахь асуулт нь топик аргаар буюу тодорхой нөхцөл байдалд тулгуурлан бодлого бодоход ашиглагдана. Нийтийн эрх зүйн бодлого бодоход материаллаг болон процессын эрх зүйн хэсэгт тодорхой топой буюу хэлэлцэх асуудлын дарааллыг логик дэс дараалалтайгаар (иймээс топик гэж нэрлэсэн) тогтоодог. Топойн дараалал заавал баримтлах зүйл биш боловч ерөнхий логик болон практик дэс дарааллыг системчлэхэд хэрэглэгддэг. Жишээ нь, материаллаг эрх зүйн хувьд захиргааны актын эрх зүйн шаардлагыг, процессын эрх зүйн хувьд нэхэмжлэлийн тогтоох болон үндэслэлт хэсгийг шалгах топойг хэрэглэдэг²⁸. Топик аргыг **“Иймээс Тийм, Тиймээс Ийм...”** гэсэн үгээр илэрхийлж болох юм.

Бодлогын асуултаас хамаарч хэрэглэх аргаа сонгоно. Тухайлбал, хэрэв асуултад шууд хариулах боломжтой бол логик аргыг, хэрэв асуултад шууд хариулах боломжгүй бол топик аргыг, хэрэв хэд хэдэн хууль зүйн факт өгөгдсөн бол түүхчлэх аргыг хэрэглэх боломжтой.

28. Энд захиргааны дотоодод үүсэх, өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага хоорондын маргааныг авч үзээгүй болно.



Нэгдүгээр хэсэг.

Захиргааны эрх зүй - Ерөнхий болон тусгай анги



Бодлого 1

Улс төрийн “Х” намын гишүүн иргэн “А” УИХ-ын гишүүн “Д”-ийн эсрэг мэдээлэл бүхий хуудсыг Сүхбаатарын талбай дээр иргэдэд тарааж байгаад үүрэгт ажлаа гүйцэтгэж явсан цагдаагийн ажилтан “Б”-тэй таарчээ. “Б” нь “А”-ийн энэхүү үйлдлийг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжтэй хэмээн үзэж түүнийг таслан зогсоох зорилгоор ухуулах хуудсуудыг хураан авч “А”-г түр саатуулсан байна. “А” нь “Б”-ийн энэхүү үйл ажиллагааг Үндсэн хуулийн 16 зүйлийн 16-д заасан “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх”-ийг нь хязгаарласан, түүнчлэн халдашгүй байх эрхэд нь халдсан хууль бус үйлдэл хэмээн үзэж эрх бүхий байгууллагад гомдол гаргажээ.

Асуулт 1:

Иргэн “А” болон цагдаагийн ажилтан “Б”-ийн хооронд үүссэн харилцаа нь нийтийн эрх зүйн маргаан мөн үү?

Аргачлал:

Субъектын шинэ онолын үндсэн дээр нийтийн эрх зүйн маргааныг тодорхойлох арга байдаг. Тодруулбал, аливаа маргаан нь “нийтийн эрх зүйн маргаан” мөн эсэхийг тодорхойлохын тулд дараах асуултад хариулах хэрэгтэй. Үүнд:

1. Тухайн маргааны зүйл нь юу вэ?
2. Түүнийг шийдвэрлэх хэм хэмжээ нь ямар хэм хэмжээ (хууль, тогтоомж) вэ?
3. Тухайн хэм хэмжээ нь нийтийн эрх зүйн хэм хэмжээ мөн үү?
4. **Хэрэв мөн бол нийтийн эрх зүйн маргаан мөн.**

Өөрөөр хэлбэл, тухайн маргааныг хянан шийдвэрлэх хэм хэмжээ нь нийтийн эрх зүйн хэм хэмжээ бол энэ нь нийтийн эрх зүйн маргаан байна хэмээн дүгнэж болно.

Хариулт 1:

1. Цагдаагийн ажилтан “Б” нь иргэн “А”-ийн ухуулах хуудсыг хураан авч, түүнийг түр саатуулсны улмаас тэдний хооронд маргаан үүссэн. Тодруулбал “А” нь “Б”-ийн **үйл ажиллагааг** Үндсэн хуульд заасан эрхийг нь хязгаарласан хууль бус үйлдэл хэмээн буруутгаж байгаа бөгөөд энэ нь уг маргааны зүйл нь болно.
2. Цагдаагийн ажилтан “Б” нь иргэн “А”-аас ухуулах хуудсыг хураан авч, түр саатуулахдаа Цагдаагийн байгууллагын тухай хууль (ЦБтХ), Захиргааны хариуцлагын тухай хууль (ЗХтХ), Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тухай хууль (ЭБШАтХ), Эрүүгийн хууль (ЭХ) зэргийг үндэслэсэн байх боломжтой.
3. Эдгээр хууль тогтоомж нь бүгд нийтийн эрх зүйн хэмжээ юм.

Иймд иргэн “А” болон цагдаагийн ажилтан “Б”-ийн хооронд үүсэн харилцаа нь нийтийн эрх зүйн маргаан мөн.

Асуулт 2:

Иргэн “А” болон цагдаагийн ажилтан “Б”-ийн хооронд үүссэн нийтийн эрх зүйн маргаан нь “захиргааны маргаан” мөн үү?

Аргачлал:

Бид өмнө нь “А” болон “Б”-ийн хооронд үүссэн харилцаа нь нийтийн эрх зүйн маргаан болохыг тогтоосон. Харин одоо уг нийтийн эрх зүйн маргаан нь “захиргааны маргаан” мөн эсэхийг шалгах шаардлагатай. Үүний тулд захиргааны маргааныг бусад нийтийн эрх зүйн маргаанаас (тухайлбал: үндсэн хуулийн²⁹, эрүүгийн, олон улсын нийтийн эрх зүйн гм.) ялгах хэрэгтэй болно.

Захиргааны маргаан гэдгийг иргэн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын үйл ажиллагааг хууль бус гэж үзэж, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар эрх бүхий захиргааны байгууллагад болон захиргааны шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргасантай холбоотой үүссэн нийтийн эрх зүйн маргаан гэж тодорхойлж болох юм.³⁰ Эндээс захиргааны маргааны үндсэн шинжийг дурдвал:

1. Маргааны нэг тал нь заавал захиргааны байгууллага, албан тушаалтан байна.
2. Захиргааны (хууль бус) захирамжилсан үйл ажиллагаа байна.
3. Захиргааны байгууллага гэдэг нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага, түүнчлэн Засгийн газрын байгууллагын зарим үүргийг төлөөлөн гүйцэтгэдэг Засгийн газрын бус байгууллага, хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг сургууль, эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны болон шашны байгууллага зэрэг нийтийн эрх зүйн субъект болох байгууллагыг хэлнэ (ЗХХШТХ-ийн 3 зүйлийн 3.1.1.). Захиргааны албан тушаалтан гэж 3.1.1-д заасан байгууллагын нийтийн эрх зүйн хүрээнд захирамжлах, зохион байгуулах бүрэн эрхийг бие даан хэрэгжүүлдэг төрийн жинхэнэ албан хаагч, түүнчлэн нийтийн эрх зүйн холбогдолтой асуудлаар бусдыг захирамжилсан шийдвэр гаргадаг төрийн бус албан тушаалтныг хэлнэ (ЗХХШТХ-ийн 3 зүйлийн 3.1.2)

Захиргааны үйл ажиллагаа нь эрх зүйн олон хэлбэрээр илрэх үйлдэл, эс үйлдэл юм. Тухайлбал, захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны дотоод журам, захиргааны гэрээ, захиргааны эрх зүйн үр дагаваргүй бусад үйл ажиллагаа гм. Захиргааны байгууллага нь эдгээр үйл ажиллагааны аль нэг хэлбэрээр иргэн, хуулийн этгээдийн эрхийг хөндсөн тохиолдолд тухайн этгээд нь түүнийг хууль бус хэмээн үзэж зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр гомдол гаргана. Гэхдээ захиргааны үйл ажиллагааны дээрх хэлбэрүүдээс захиргааны акт болон захиргааны хэм хэмжээний акт нь гадагш чиглэсэн (иргэн, хуулийн этгээдийн эрхийг хөндсөн), зохицуулалт агуулсан, захирамжилсан шинжтэй байдаг тул захиргааны маргаан нь ихэвчлэн эдгээр актын улмаас үүсдэг.

29. Үндсэн хуулийн маргааныг тодорхойлох шууд хоёр шинж гэж байдаг. Үүнд: 1. Үндсэн хуулийн субъектууд хоорондоо 2. Үндсэн хуульд заагдсан эрх хэмжээнийхээ талаар маргалдаж байвал түүнийг үндсэн хуулийн маргаан гэж үздэг.

30. Энд захиргааны дотоодод үүсэх, өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага хоорондын маргааныг авч үзээгүй болно.



Хариулт 2:

1. Цагдаагийн ажилтан “Б” нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг цагдаагийн байгууллагын³¹ нийтийн эрх зүйн хүрээнд захирамжлах, зохион байгуулах бүрэн эрхийг бие даан хэрэгжүүлдэг албан тушаалтан юм.
2. “Б” нь “А”-ийн үйлдлийг таслан зогсоох зорилгоор хуудсуудыг хураан авч, түүнийг түр саатуулсан захиргааны үйл ажиллагаа (үйлдэл) хийсэн байна. Анхаар! “Б”-ийн үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах шинжтэй байх боломжтой. Хэрэв “Б”-ийн энэхүү үйлдэл нь эрүүгийн хэрэг үүсгэсэн шинжтэй бол уг маргаан нь ердийн шүүхээр шийдвэрлэгдэнэ.³² Иймээс цагдаагийн ажилтан “Б”-ийн үйлдлийн зорилгыг тодорхойлох шаардлагатай. Тодруулбал, “Б”-ийн үйлдэл нь нийгмийн хэв журмын зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд чиглэгдэж байна уу, эсхүл гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэх, мөрдөн шалгахад чиглэгдэж байна уу гэдгийг тодруулна гэсэн үг юм.
“Б” ухуулах хуудсыг бүгдийг нь хураан авсан нь “А”-ийн үйлдлийг таслан зогсоох, иргэдэд буруу мэдээлэл очихоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байна. Хэрэв гэмт хэргийг бүртгэх, мөрдөн шалгах зорилгоор нотлох баримтыг цуглуулахад чиглэгдсэн бол ухуулах хуудсаас зөвхөн нэгийг л авахад хангалттай байсан. Иймд “Б”-ийн үйл ажиллагаа нь захиргааны зөрчлийг таслан зогсооход чиглэгдсэн захиргааны үйл ажиллагаа байна.
3. Иргэн “А” нь “Б”-ийн үйл ажиллагааг үндсэн хуульд заасан эрхийг нь хязгаарласан хууль бус үйл ажиллагаа хэмээн түүний эсрэг эрх бүхий байгууллагад гомдол гаргасан байна.

Иймд иргэн “А” болон цагдаагийн ажилтан “Б”-ийн хооронд үүссэн маргаан нь захиргааны маргаан мөн.

Асуулт 3:

Цагдаагийн ажилтан “Б”-ийн ухуулах хуудас хураан авсан үйл ажиллагаа нь захиргааны акт мөн үү?

Аргачлал:

Б-ийн үйл ажиллагаа нь захиргааны акт мөн эсэхийг тогтоохын тулд ЗХХШТХ-ийн 3 зүйлийн §3.1.4-д заасан захиргааны актын шинжийг шалгах хэрэгтэй. Уг зүйлийн дагуу “захиргааны акт” гэж нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас амаар буюу бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон эрх зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан үйл ажиллагааг хэлнэ. Энэхүү тодорхойлолтоос захиргааны актын үндсэн шинжүүдийг тодорхойлбол:

- нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн,

31. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн ЦБТХ-ийн 4.1.

32. ЗХХШТХ-ийн §4.3.Шүүх, прокурорын байгууллага, түүнчлэн эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын байцаан шийтгэх, эсхүл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу явуулсан үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдээс шүүхэд гаргасан гомдлыг эрүүгийн болон иргэний хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

- тодорхой нэг тохиолдол,
- захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан,
- захирамжилсан шинжтэй,
- эрх зүйн үр дагавар шууд бий болгосон буюу зохицуулалтыг агуулсан,
- гадагш чиглэгдсэн шинжтэй байна³³.

Хэрэв захиргааны үйл ажиллагаа нь дээрх шинжүүдийг агуулж байвал тэр нь захиргааны акт болно.

Хариулт 3:

- Иргэн “А” болон цагдаагийн ажилтан “Б”-ийн хоорондын маргаан нь нэг талаас “А” Үндсэн хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх, нөгөө талаас “Б” Цагдаагийн байгууллагын тухай болон Захиргааны хариуцлагын тухай хууль зэрэг нийтийн эрх зүйн хэм хэмжээний үндсэн дээр үүрэгт ажлаа гүйцэтгэхтэй холбоотой үүссэн тул **нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тохиолдол** байна. Уг тохиолдол нь зөвхөн иргэн “А”-д (өөр хэн нэгэн этгээдэд бус) хамааралтай, зөвхөн нэг удаагийн шинжтэй тул **тодорхой нэг тохиолдол** байна.
- Дээрх тохиолдлыг (үйлдлийг) зохицуулахыг зорьсон цагдаагийн байгууллагын ажилтан “Б”-ийн үйл ажиллагаа байна. “Б” нь ЗХХШТХ-ийн 3.1.1 болон 3.1.2-т заасан нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагын нийтийн эрх зүйн хүрээнд захирамжлах, зохион байгуулах бүрэх эрхийг хэрэгжүүлдэг төрийн жинхэнэ албан хаагч буюу **захиргааны байгууллага (албан тушаалтан)** юм.
- Б-ийн үйл ажиллагаа нь албадлагын шинжтэй, “А”-ийн хүсэл зоригоос үл хамаарч байгаагаараа **захирамжилсан** шинжтэй байна.
- Б-ийн үйл ажиллагааны улмаас “А”-ийн эрх хязгаарлагдаж байгаа (өөрөөр хэлбэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг нь хязгаарласан) тул **зохицуулалт** агуулсан **эрх зүйн үр дагаврыг шууд бий болгосон** байна.
- Б-ийн үйлдэл нь иргэн “А”-д чиглэгдэж буйгаараа (өөрөөр хэлбэл, захиргааны байгууллагын дотоод хүрээнээс хальсан тул) **гадагш чиглэсэн** байна.
- ЗХХШТХ-ийн §3.1.4-д “захиргааны акт” гэж нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас амаар буюу бичгээр гаргасан захирамжилсан **шийдвэр болон** эрх зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан **үйл ажиллагааг** хэлнэ. Энэхүү тодорхойлолтоос үзэхэд захиргааны акт нь тодорхой шийдвэр болон үйл ажиллагаагаар илрэхээр байна. “Үйл ажиллагаа” гэж үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ (ЗХХШТХ-ийн §3.1.5).

Цагдаагийн ажилтан “Б”-ийн ухуулах хуудсыг хураан авсан үйл ажиллагаа нь “үйлдэл”-ээр илэрч буй захиргааны акт мөн.

33. ЗХХШТХ-ийн 3.1.4-т захиргааны актын “гадагш чиглэсэн” шинжийг заагаагүй, харин уг хуулийн 4.2-т захиргааны байгууллагын зөвхөн гадагш дагаж мөрдөх актыг захиргааны хэргийн шүүхэд хамаарахаар зохицуулсан байдаг. Гэхдээ захиргааны акт гэдэг нь “сонгодог” утгаараа гадагш чиглэсэн байх бөгөөд энэ шинжээрээ бусад актаас ялгагддаг.



Бодлого 2

Оюутан Т өөрийн оюутны картаа гээгдүүлсэн тул дахин шинээр авахаар Монголын Оюутны Холбоонд хүсэлт гаргажээ. Гэвч холбооноос ямар нэгэн хариу хэлэлгүйгээр 3 сар болсон. Энэхүү МОХ-ны идэвхгүй байдлаас болж Т нь оюутны хөнгөлөлтөө эдэлж чадахгүй байгаа тул тэрээр эрхээ сэргээлгэхээр захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Асуулт:

МОХ захиргааны байгууллага мөн үү?

Аргачлал:

МОХ нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээн дэх төв, орон нутгийн байгууллага биш тул захиргааны байгууллагад хамаарч болох бусад байгууллага буюу “нийтийн эрх зүйн хуулийн этгээд” (нийтийн эрх зүйн субъект)-ийн талаар мэдэх шаардлагатай. “Нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гэдэг нь нийтийн эрх зүйн захирамжилсан акт юмуу нийтийн эрх зүйн хүлээн зөвшөөрөлтийн үндсэн дээр (жишээ нь, сүм хийд) зохион байгуулагдсан, нийтийн болон хувийн эрх зүйн хүрээнд эрх зүйн чадамжийг өөртөө агуулсан хуулийн этгээд юм. Тэдгээрийн нийтлэг шинж бол үйл ажиллагаа нь төрийн хяналтан дор байх бөгөөд өөрөө удирдлагатай, үйл ажиллагаагаа дүрэм, журмаараа зохицуулж болдог. ЗХХШТХ-ийн §3.1.1-ийн дагуу Захиргааны байгууллага гэдэгт үндсэн гурван төрлийн “нийтийн эрх зүйн субъект” хамаарч байна. Үүнд:

- Төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд буюу шууд захиргаа (төрийн төв болон орон нутгийн захиргааны байгууллагууд),
- Хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр засгийн газрын зарим үүргийг эрх шилжүүлэн авч гүйцэтгэж буй засгийн газрын бус байгууллагууд (ГББ, хувийн эрх зүйн хуулийн этгээд, хувь хүн),
- Нийтийн эрх зүйн бусад хуулийн этгээд (хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг сургууль, эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны болон шашны байгууллага зэрэг) гэсэн шууд бус захиргааны байгууллагууд хамаарч байна.

Нийтийн эрх зүйн бусад хуулийн этгээд: Төрийн гүйцэтгэх байгууллагаас харьцангуй бие даасан захиргааны хуулийн этгээд буюу байгууллагыг нийтийн эрх зүйн бусад хуулийн этгээдэд хамааруулна. Энэ нь нийтийн эрх зүйн гишүүнчлэл бүхий нэгдэл, албан газар, нийтийн эрх зүйн сан гэсэн гурван хэсэгт хуваагдах бөгөөд эдгээр нь захирамжилсан актын үндсэн дээр зохион байгуулагддаг.

а. Нийтийн эрх зүйн гишүүнчлэл бүхий нэгдэл: Нийтийн эрх зүйн гишүүнчлэл бүхий нэгдэл гэдэг нь нийтийн эрх зүйн үндсэн дээр зохион байгуулагддаг ба нийтийн эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулдгаараа хувийн эрх зүйн гишүүнчлэл бүхий этгээдээс ялгарна. Эдгээр хуулийн этгээд өөрийн захиргаатай байх бөгөөд төрийн чиг үүргийг хэрэгжүүлж, холбогдох асуудлыг бие даан хариуцах эрх зүйн чадвартай байгууллага юм. Нийтийн эрх зүйн гишүүнчлэл

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

бүхий нэгдэл нь хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд хэм хэмжээ тогтоосон актыг батлан гаргах бөгөөд гишүүдийнхээ үндсэн эрхийг ямар нэгэн байдлаар хөндөх боломжтой. Гишүүнчлэл бүхий нэгдлийг гишүүдийнх нь нийтлэг шинжээр дараах байдлаар ангилна:

- 1) Нутаг дэвсгэрийн гишүүнчлэл: Тодорхой нутаг дэвсгэрт байнга амьдарч буй бүх хүн гишүүнчлэлд хамаарна. Үүнийг албан ёсны гишүүнчлэл хэмээнэ. Тухайлбал: ИТХ нь тухайн орон нутагт оршин суугаа бүртгэл бүхий иргэдийн гишүүнчлэлтэй хэмээн үзнэ.
- 2) Тодорхой өмч хөрөнгөөр болон эдийн засгийн үйл ажиллагаагаараа хоршсон гишүүнчлэл бүхий нэгдлүүд хамаарна. Тухайлбал, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг гэх мэт.
- 3) Субъектийн (хувь хүний) шинж чанараараа нэгдсэн гишүүнчлэл: Тодорхой нутаг дэвсгэрт амьдарч буй бүх хүнийг хамрахгүй бөгөөд гишүүд нь мэргэжил болон бусад ерөнхий шинжээрээ нэгдсэн нэгдлүүд хамаарна. Үүнд: Монголын өмгөөлөгчдийн холбоо, Шинжлэх ухааны академи гэх мэт.

Эдгээр нь бүгд нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ихэвчлэн гишүүдийн татвараар санхүүждэг. Гишүүнчлэл бүхий нэгдлийн нэг онцгой хэлбэр нь сүм, хийд юм. Нийтийн эрх зүйн хувьд гишүүнчлэл нь сайн дурын үндсэн дээр болон хууль ёсны гэсэн хоёр янз байна.

б. Албан газар. Нийтийн эрх зүйн албан газар нь хуулиар эсвэл хуульд үндэслэн байгуулагдаж, өөрчлөгдөж, татан буугддаг бөгөөд захиргааны тодорхой зорилт, нэг төрлийн чиг үүргийг байнга гүйцэтгэхийн тулд байгуулагддаг. Эдгээрийг зорилтоор нь соёлын газрууд (Их дээд сургууль, дунд сургууль, номын сан, музей, театр ...), эрдэм шинжилгээ судалгааны газрууд (шинжлэх ухааны академи, хууль зүйн үндэсний хүрээлэн ...), банкны газар (монгол банк, улсын банкууд) ... гэх мэт.

Нийтийн эрх зүйн гишүүнчлэл бүхий нэгдлийн хувьд гишүүд нь удирдлагаа сонгох боломжтой байхад харин албан газар нь удирдлагаа бие даан сонгох боломжгүй байдаг. Тухайлбал: ОНРТ, Төрийн өмчийн эмнэлэг, сургууль гэх мэт.

в. Нийтийн эрх зүйн сан. Сан нь тодорхой хөрөнгийн тусламжтайгаар өмнөө тавьсан зорилгыг хэрэгжүүлэх хэрэгслүүр юм. Нийтийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд захиргааны байгууллага болон бусад нийтийн эрх зүйн этгээдээс байгуулдаг. Үүнд: Сургалтын төрийн сан, сумыг хөгжүүлэх сан, байгаль орчныг хамгаалах сан гэх мэт. Энд мөнгийг нь биш байгууллагыг нь хэлнэ.³⁴

Хариулт:

МОХ нь “оюутан-гишүүн”-ээс бүрддэг, нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулдаг, нийтийн эрх зүйн нэгдэл буюу нийтийн эрх зүйн бусад субъектэд хамаарах этгээд юм. **Иймд МОХ нь Захиргааны байгууллага мөн.**

34. П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 2.Хэвлэлт, х.123-125.



Бодлого 3

МУИС-ийн ректор тус сургуулийн НУФ-ын багш “Г”-г ёс зүйн зөрчил удаа дараа гаргасан гэсэн үндэслэлээр ажлаас халжээ. “Г” үүний эсрэг салбарын сайдад гомдол гаргасан ч амжилт олоогүй. Иймд тэрээр Захиргааны хэргийн шүүхэд хандах уу, эсхүл ердийн шүүхэд хандах уу гэдгээ мэдэхгүй байна.

Асуулт:

Ректорын тушаал захиргааны акт мөн үү?

Хариулт:

1. МУИС нь ... хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг сургууль буюу нийтийн эрх зүйн субъект бөгөөд түүнийн захиргаа нь ректор тул **захиргаа мөн** юм. (ЗХХШтХ-ийн 3 зүйлийн 3.1.1.).
2. Уг шийдвэр нь зөвхөн “Г”-д хамааралтай, нэг удаагийн тул **тодорхой нэг тохиолдол** байна.
3. Шийдвэр нь зөвхөн ректорын хүсэл зоригийг илэрхийлсэн, заавал биелэгдэх шинжтэй тул **захирамжилсан** байна.
4. Шийдвэрийн улмаас “Г”-ийн хөдөлмөрлөх (багшлах) эрх хязгаарлагдаж буй тул **зохицуулалт** агуулсан эрх зүйн үр дагавартай.
5. Шийдвэр нь сургуулийн дотоод хүрээнээс хальсан, “Г”-ийн үндсэн эрхэд чиглэсэн тул **гадагш чиглэсэн**.
6. Ректорын тушаал нь **нийтийн эрх зүйн харилцаанд үүссэн** (нэг) тохиолдлыг зохицуулахаар гарсан эсэх:
 - МУИС-ийн ректор болон тус сургуулийн багш нар нь хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилладаг.
 - Хөдөлмөрийн гэрээ нь Хөдөлмөрийн хуулиар зохицуулагддаг.
 - Хөдөлмөрийн хууль нь хувийн эрх зүйн хэм хэмжээ.
 - Хувийн эрх зүйн хэм хэмжээний үндсэн дээр үүссэн тохиолдол нь хувийн эрх зүйн харилцаа болно, өөрөөр хэлбэл, нийтийн эрх зүйн харилцаа биш.

Иймээс Ректорын тушаал нь захиргааны актын үндсэн шинж болох нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тохиолдлыг зохицуулахаар гараагүй, өөрөөр хэлбэл, хувийн эрх зүйн хүрээнд үүссэн тул захиргааны акт биш.



Бодлого 4

Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-т улсын бүртгэгчээр ажиллаж байсан “А” нь 2010 оны 1 сарын 1-нд “албан тушаалаа урвуулан ашигласан, авлига авсан хэргээр цагдаагийн байгууллагаас шалгагдаж байгаа” гэсэн үндэслэлээр УБЕГ-ын даргын тушаалаар ажлаас халагдсан байна. Уг тушаал нь Төрийн албаны тухай хуулийн 25 зүйлийн 25.1.2 дахь хэсэгт үндэслэсэн байна. “А” тушаалыг мөн оны 1 сарын 2-нд албан ёсоор мэдсэн даруйдаа Төрийн албаны зөвлөлд гомдол гаргажээ.

Асуулт:

УБЕГ-ын даргын тушаал нь хууль зүйн үндэслэлтэй юу?

Аргачлал:

УБЕГ-ын даргын тушаал нь захиргааны акт тул түүнийг захиргааны акт хууль ёсны эсэхийг тогтоох аргачлалын дагуу шалгана. Захиргааны акт хууль ёсны байхын тулд түүнд тавигдах эрх зүйн шаардлага бүрэн хангагдсан байх ёстой. Захиргааны актад тавигдах эрх зүйн шаардлагыг формаль буюу хэлбэрийн, материаллаг буюу агуулгын гэж ангилна.

I. Формаль эрх зүйн шаардлагад:

1. Захиргааны байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хамаарах:
 - А. Нутаг дэвсгэрийн
 - Б. Шатлан захирах ёсны
 - В. Чиг үүргийн
2. Шийдвэр гаргах ажиллагааны журмыг хангасан байх:
 - А. Нийтлэг журам
 - Б. Тусгай журам (хэрэв тухайн актыг гаргах талаар хуулиар тусгайлан заасан журам байгаа бол түүнийг хангасан эсэхийг шалгах шаардлагатай. Тухайлбал, тухайн актыг гаргахын тулд бусад этгээдийг оролцуулах, санал авах, хамтран шийдэх, сонгон шалгаруулалт явуулах, холбогдох этгээдэд мэдэгдэх гм.)
3. Хэлбэрийн шаардлагыг хангасан байх:
 - А. Чөлөөтэй (зарчмын хувьд захиргааны актыг ямар ч хэлбэрээр гаргах боломжтой)
 - Б. Тусгайлан заасан (хэрэв хуулиар захиргааны актыг бичгээр гаргахаар заасан бол)
 - В. Үндэслэлийг заах (гэхдээ хүний эрхэд халдаагүй, өөрөөр хэлбэл эерэг үйлчлэлтэй³⁵, нөхцөл байдал нь олон нийтэд тодорхой болсон, ижил төстэй олон актууд гарсан, хэм хэмжээний актыг үндэслэн гарсан зэрэг тохиолдолд захиргааны актын хуулийн үндэслэлийг заахгүй байж болно.)

35. Гэхдээ эерэг үйлчлэл бүхий захиргааны акт ч гэсэн шууд бус байдлаар хандсан этгээдийн хувьд үүрэг хүлээлгэх нь цөөнгүй тул сүүлийн үед эерэг үйлчлэлтэй акт ч гэсэн хуулийн үндэслэлтэй байна гэж үздэг болсныг анхаарна уу.



Г. Гомдол гаргах этгээд, хугацааг заах

II. Материаллаг эрх зүйн шаардлагад:

1. Эрх зүйн үндэслэлтэй байх:
 - А. Эрх зүйн үндэслэл тодорхой байх
 - Б. Эрх зүйн үндэслэл нь хүчин төгөлдөр байх (үндэслэл болгосон хэм хэмжээ нь бусад эрх зүйн хэм хэмжээтэй, эсхүл дээд хүчин чадал бүхий хэм хэмжээтэй, тухайлбал хэм хэмжээний акт нь хуультай нийцсэн байх)
 - В. Эрх зүйн үндэслэлийн урьдчилсан нөхцөл нь (гипотез, диспозиц) нь хэргийн бодит байдалтай нийцсэн байх
2. Хаяглагч буюу хандсан этгээдийг зөв сонгосон байх
3. Нийтлэг шаардлагыг хангасан байх:
 - А. Тодорхой байх (ямар ч хүнд ойлгомжтой байх)
 - Б. Хэрэгжих боломжтой байх (бодит байдлаас хэтэрсэн зүйлийг шаардаагүй байх)
 - В. Харьцангуй байх (зорилго, арга хэрэгсэл нь хуулиар зөвшөөрөгдсөн, зайлшгүй шаардлагатай, тохиромжтой, зохистой байх)
4. Үзэмжээр шийдэх (сонгох боломжтой) шийдвэрийн хувьд алдаагүй байх:
 - А. Боломжийг хэрэглээгүй (хэрэглэх ёстой байтал хэрэглээгүй)
 - Б. Боломжийг хэтрүүлсэн (хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэсэн)
 - В. Боломжийг буруу хэрэглэсэн (хэргийн нөхцөл байдлыг буруу тогтоосон, хамааралгүй нөхцөл байдлыг хамруулсан, логик алдаатай, зөрчилтэй зүйл, заалтыг хэрэглэсэн, боломжгүй зүйлийг шаардсан, хүний эрхийг зөрчсөн гм.) гэсэн шалгуурууд хамаарна.

Хариулт:

УБЕГ-ын даргын 2010 оны 1 сарын 1-ний “А”-г ажлаас халсан тушаал буюу захиргааны акт нь:

I. Формаль эрх зүйн шаардлагын хувьд:

1. Захиргааны байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хамаарах:

УБЕГ-ын дарга нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль (УБЕХ)-ийн 9 зүйлийн 1.4-ийн дагуу “улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь салбар, нэгжийн дарга, улсын бүртгэгчийг томилж, чөлөөлөх” бүрэн эрхтэй тул уг шаардлагыг хангаж байна. Нутаг дэвсгэрийн болон шатлан захирах ёсны хамааралыг шалгах шаардлагагүй.
2. Шийдвэр гаргах ажиллагааны журмыг хангасан байх:

УБЕГ-ын албан хаагчдыг ажлаас халах тушаал буюу шийдвэр гаргах ажиллагаатай холбоотой хуулиар тусгайлан зохицуулсан журам байхгүй тул нийтлэг журмын дагуу уг шийдвэрийг гаргасан гэж үзэх үндэслэлтэй.
3. Хэлбэрийн шаардлагыг хангасан байх:

Тушаалыг бичгээр гаргаж, түүнд ажлаас халагдах болсон шалтгааныг дурьдаж “А”-д албан ёсоор мэдэгдсэн нь бодлогын нөхцөлөөс харагдаж буй тул хэлбэрийн шаардлагыг хангасан гэж үзнэ.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

II. Материаллаг эрх зүйн шаардлагад:

1. Эрх зүйн үндэслэлтэй байх:

- А. УБЕГ-ын дарга нь “А”-г ажлаас халах тушаал гаргахдаа Төрийн албаны тухай хууль (ТАТХ)-ийн 25 зүйлийн 25.1.2 дахь хэсгийг үндэслэсэн байна. Иймд тушаалд эрх зүйн үндэслэлийг заасан байна.
- Б. ТАТХ-ийн 25 зүйлийн 25.1.2-т төрийн жинхэнэ албан хаагч “гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон” тохиолдолд халагдаж болохоор заажээ. Гэтэл бодлогын нөхцөлд “А” нь “албан тушаалаа урвуулан ашигласан, авлига авсан хэргээр **цагдаагийн байгууллагаас шалгагдаж байгаа**” гэсэн үндэслэлээр ажлаас халагдсан гэсэн байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн гэдэг нь нотлогдоогүй, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол гараагүй байхад “А”-г ажлаас нь халсан байна. Иймд шийдвэр гаргасан эрх зүйн үндэслэлийн (ТАТХ-ийн 25.1.2 зүйл) урьдчилсан нөхцөл нь (гипотез, диспозиц) нь хэргийн бодит байдалтай нийцэхгүй байгаа тул уг тушаал нь **эрх зүйн алдаатай** байна.

Иймд УБЕГ-ын даргын “А”-г ажлаас халсан тухай 2010 оны 1 сарын 1-ний өдрийн тушаал (захиргааны акт) нь хууль бус байна.



Бодлого 5

“Ш” ХХК нь Булган аймгийн Тэшиг сумын нутагт газар тариалангийн зориулалтаар 2987 га газрыг 1998 оноос эзэмшиж байсан. Тус компани өөрийн эзэмшлийн газраас 1053 га газрыг эргүүлэн өгөхөөр сумын засаг даргатай тохиролцсон байна. Гэтэл Тэшиг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2004.04.26-ны өдрийн 13 тоот тогтоолоор “Ш” ХХК-ний газраас 1937 га газар авахаар шийдвэрлэсэн тул сумын Засаг дарга энэхүү тогтоолд үндэслэн 2004.6.7-ны өдрийн 55 тоот захирамж гаргаж, тус компанийн 1937 га газар эзэмших эрхийг хүчингүй болгож төрийн мэдэлд шилжүүлэх шийдвэр гаргасан. “Ш” ХХК нь 1937 га ба 1053 га-гийн зөрүү болох 884 га газар эзэмших эрхээ зөрчсөн хэмээн үзэж дээд шатны засаг даргад уг захирамжийг хүчингүй болгуулахаар гомдол гаргасан байна.

Асуулт:

1. “Ш” ХХК-ний гомдол үндэслэлтэй юу?
2. Засаг даргын захирамжийн эрх зүйн үр дагаврыг тодорхойлно уу.

Хариулт 1:

Гомдлын зүйл нь Тэшиг сумын засаг даргын 2004 оны 6 сарын 7-ны өдрийн 55 тоот захирамж буюу захиргааны акт байна. Иймд гомдлын үндэслэлийг шалгахын тулд уг актын эрх зүйн үндэслэлийг шалгана.

I. Формаль эрх зүйн шаардлага:

1. **Бүрэн эрх:** МУ-ын ЗЗНДНГТХ-ийн 29.3-д сумын Засаг дарга гаргасан захирамжаа өөрөө хүчингүй болгох эрхтэй.

А. Нутаг дэвсгэрийн хамаарал: Маргаж буй газар Тэшиг сумын нутаг дэвсгэр байгаа тул засаг дарга уг асуудлаар захирамж гаргах эрхтэй.

Б. Чиг үүргийн хамаарал: Сумын Засаг дарга нь “Ш” ХХК-ний газар ашиглалтад хяналт тавьж зөрчлийг арилгуулахаар шийдвэр гаргах, мөн газар эзэмших эрхийг хүчингүй болгох эрхтэй болох нь дараах байдлаар батлагдаж байна:

ГтХ §20.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газрын харилцааны талаар дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

§20.2.2 газар эзэмшигч, ашиглагчаас, газар, түүний баялагийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах.

С. Шатлан захирах ёсны хамаарал: Тухайн газар нь инженерийн шугам сүлжээ бүхий газар биш, тариалангийн талбай тул эзэмшүүлэх, ашиглуулах асуудал сумын Засаг даргын чиг үүрэгт хамаарна.

ГтХ-ийн §21.3.2. аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ. Уг асуудлыг шийдвэрлэхэд тухайн сумын Засаг даргын саналыг авсан байна.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

ГтХ-ийн §21.4.3 энэ хуулийн §21.3.2-т зааснаас бусад газрыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах.

2. Шийдвэр гаргах ажиллагааны журам: Газар эзэмших эрхийг хүчингүйд тооцох шийдвэр гаргах ажиллагааг тусгайлан зохицуулаагүй, засаг дарга бие даан шийдвэрлэнэ.

3. Хэлбэр: Захирамж зохих шаардлага хангасан байна.

4. Бусад этгээдийн оролцоо: Сумын засаг дарга нь газар эзэмшигч нь үүргээ биелүүлээгүйн улмаас хохирол учирч болохоор бол мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах эрхтэй. Газар эзэмших эрхийг хүчингүйд болгоход бусад этгээдийн санал зөвшөөрлийг авах хуулийн зохицуулалт алга байна.

ГтХ §20.2.9 газар эзэмшигч, ашиглагч нь хууль тогтоомж, гэрээнд заасан үүргээ хангалтгүй биелүүлснээс байгаль орчинд сөргөөр нөлөөлж байгаа тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан санал, гомдлын талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулах хүсэлтээ газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргах.

II. Материаллаг эрх зүйн шаардлага:

- 1. Эрх зүйн үндэслэлтэй эсэх:* Газар эзэмших эрхийг зөвхөн ГтХ-ийн §40.1-д заасан үндэслэлээр хүчингүйд тооцно. Гэтэл бодлогын нөхцөлд газар эзэмших эрхийг хүчингүйд болгох нөхцөл өгөгдөөгүй байна. Иймд Засаг даргын 2004 оны №55 захирамж нь эрх зүйн үндэслэлгүй байна.
- 2. Агуулга тодорхой байх:* Сумын Засаг даргын 55 тоот захирамж нь хоёрдмол салаа утгагүй агуулга ойлгомжтой байна.
- 3. Дээд шатны байгууллагын эрх зүйн акт:* Зөрчөөгүй. Засаг даргын 2004 оны №55 захирамж нь ГтХ 40.1.5 ба 40.1.6-д заасан нөхцөл бүрдээгүй байхад хэрэглэх ёсгүй хуулийн зүйл, заалтыг хэрэглэсэн эрх зүйн алдаатай акт байна.

Иймд “Ш” ХХК-ний гомдол үндэслэлтэй.

Хариулт 2:

Булган аймгийн Засаг даргын 2004 оны №55 захирамжийн “Ш” ХХК-ний 884 га-д холбогдох газар эзэмших эрхийг хүчингүйд тооцсон хэсэг нь ЗХХШТХ §9.1.7-д зааснаар эрх зүйн үндэслэлгүй гарсан байна. Иймд:

ЗХХШТХ §9.1 Захиргааны байгууллага, албан тушаалтан дараах тохиолдолд захиргааны актыг илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргана.

§9.1.7 Захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй.

Засаг даргын 55 тоот захирамж нь илт хууль бус акт мөн. Иймд гарсан цагаасаа хойш эрх зүйн үр нөлөөгүй.



Бодлого 6

“Б” нь Богд хан уулын дархан цаазат газарт аялал жуулчлалын төв байгуулах зорилгоор газар ашиглахаар тухайн дүүргийн Засаг дарга, хамгаалалтын захиргаа болон Байгаль орчны яаманд хүсэлт гаргасан бөгөөд Байгаль орчны яамнаас холбогдох хүсэлт болон эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн 2004 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Богдхан уулын дархан цаазат газрын нутаг дэвсгэрт “Б”-д 0.8 га газрыг аялал жуулчлалын зориулалтаар ашиглуулахаар 1/25 тоот дугаар гэрчилгээг олгосон. Гэтэл уг газарт Нийслэлийн Засаг даргын 2004 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 541 дүгээр захирамжаар “Д”-д сургуулийн барилгын зориулалтаар газар ашиглуулахаар шийдвэрлэжээ. Засаг даргын 541 дүгээр захирамжийг “Б” өөрийн хууль ёсны эрх ашгийг хөндсөн хэмээн үзээд Нийслэлийн Засаг даргад улмаар захиргааны хэргийн шүүхэд хандсан байна.

Асуулт:

1. Нийслэлийн засаг даргын 541 дүгээр захирамж нь захиргааны акт мөн үү?
2. Нийслэлийн засаг даргын захирамж хууль ёсны юу?
3. Нийслэлийн засаг даргын захирамжийн эрх зүйн үр дагаврыг тодорхойлно уу.

Хариулт 1:

Нийслэлийн Засаг даргын 541 дүгээр захирамж нь:

1. Нийслэлийн Засаг дарга нь ЗХХШТХ 4.1.10-д заасны дагуу ЗХШ-д хариуцагч болох тул захиргааны байгууллага мөн байна.
2. Иргэн “Д”-д сургуулийн барилгын зориулалтаар тусгай хамгаалалттай газарт газар ашиглуулах зөвшөөрлийг олгосон Нийслэлийн Засаг даргын 2004 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 541 дүгээр захирамж нь нэг талын хүсэл зоригоор эрх зүйн харилцаа үүсгэсэн бичгэн шийдвэр байна.
3. Уг захирамж нь иргэн “Д”-д сургуулийн зориулалтаар газар ашиглуулах асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна. Иргэн “Д”-д газар эзэмших ашиглах эрх бий болж, эрх зүйн харилцаа үүссэн байна.
4. Төрийн өмчийн газрыг бусдад эзэмшүүлж, ашиглуулах зөвшөөрөл олгох нь тусгай эрхийн харилцаа байна. Дээрх харилцаа ГтХ, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (ТХГНТХ)-иар зохицуулагдана. Дээрх хуулиар олгогдсон тусгай эрхийг хэрэгжүүлж байгаа тул нийтийн эрх зүйд хамаарна.
5. Нийслэлийн Засаг даргын 2004 оны 541 дүгээр захирамж нь иргэн “Д”-д газар ашиглах эрх олгосон учир тодорхой этгээдэд хандсан байна. Уг захирамжаар өөр бусад этгээдэд газар ашиглах эрх үүсэхгүй тул нэг удаагийн зохицуулалттай байна.
6. Нийслэлийн Засаг дарга болон иргэн “Д” нь манай тохиолдолд ямар нэгэн төрийн албаны чиг үүргийн хүрээнд дотогш чиглэсэн харилцаанд (дарга, цэргийн) ороогүй бөгөөд Иргэн “Д” хууль эрхээ эдлэж байгаа тул уг харилцаа ЗХХШТХ4.2 дагуу гадагш чиглэсэн байна.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

Иймд Нийслэлийн Засаг даргын 2004 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 541 дүгээр захирамж нь ЗХХШтХЗ.1.4 заасан нөхцөлийг бүрэн хангасан мөн ЗХХШтХ4.2 заасан гадагш, бусдаас дагаж мөрдөх шинжийг агуулсан тул “Захиргааны акт” мөн байна.

Хариулт 2.

Нийслэлийн Засаг Даргын 541 дүгээр захирамж нь:

I. Формаль эрх зүйн шаардлага (шийдвэр гаргах ажиллагааны шаардлага) хангасан эсэх:

1. Эрх хэмжээ (бүрэн эрх)-ний хамаарлыг шалгах:

- A. Нийслэлийн Засаг даргын захирамжийг нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа бүх иргэн, аж ахуйн нэгж байгууллага биелүүлэх үүрэгтэй (ЗЗНДНТУтХ14).
- Б. Дархан цаазат газарт иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах эсэх асуудлыг ТХГНтХ §36.1-д Төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт хамааруулж шийдвэрлэх тусгай эрхийг олгож хуульчилсан байна. Гэтэл Нийслэлийн Засаг дарга 541 дүгээр захирамжаараа иргэн “Д”-д Богд уулын дархан цаазат газарт газар ашиглах эрх олгон өөрийн чиг үүрэгт хамаарахгүй асуудлаар шийдвэр гаргаж ТХГНтХ §36.1-ийг зөрчин эрх хэмжээгээ хэтрүүлсэн байна.
- В. Шатлан захирах ёсны хамаарал нь чиг үүргийн хамааралтай адил байна.

2. Шийдвэр гаргах ажиллагаанд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг тодруулах:

Иргэн “Д” ТХГНтХ-ийн §35.1-д заасны дагуу Дархан цаазат газарт газар ашиглах тухай хүсэлтээ хамгаалалтын захиргаа буюу хамгаалалтын захиргаа байгуулаагүй тусгай хамгаалалттай газар нутагт сум, дүүргийн Засаг даргад гаргах бөгөөд уг байгууллага нь ТХГНтХ-ийн §35.2 дагуу тухайн хүсэлт болон түүний талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллагад уламжилна. ТХГНтХ-ийн §36.1 дагуу дээрх саналыг үндэслэн Төрийн захиргааны байгууллагаас тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах шийдвэр гаргахаар зохицуулжээ. Гэтэл иргэн “Д” газар ашиглах хүсэлтээ зөвхөн Нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлсэн байх тул Дархан газрын хамгаалалтын захиргаа болон Дүүргийн Засаг даргын санал зөвшөөрлийг авалгүйгээр ТХГНтХ35.1 болон ТХГНтХ 35.2 заалтууд зөрчигдсөн байна.

Богд Хан уулын Дархан цаазат газарт сургуулийн зориулалтаар барилга барих зөвшөөрөл олгохын өмнө Төрийн захиргааны төв байгууллагаас ТХГНтХ §27.9-д заасны дагуу дээрх зориулалтаар ашиглаж болох газар, түүний хэмжээ, ашиглах журмыг тогтоосон байх, ТХГНтХ-ийн §27.8-д заасны дагуу уг төслийг хянан баталсан эсэх мөн ГтХ-ийн §31.3-ийн дагуу тухайн газар бусдын эзэмшил, ашиглалтад буй газартай ямар нэгэн хэмжээгээр давхацсан эсэхийг хянан шалгаж тогтоосон байх ёстой. Гэтэл иргэн “Д” нь хамгаалалтын захиргаа, дүүргийн Засаг дарга, Байгаль орчны яаманд хандаагүй учир дээрх хуулиар шаардсан үйл ажиллагаанууд хийгдэлгүйгээр газар ашиглах зөвшөөрөл олгогдож ТХГНтХ-ийн §27.8 ба 9 болон ГтХ-ийн §31.3 заалтууд зөрчигдсөн байна.



3. Хэлбэрийн шаардлага:

Нийслэлийн Засаг даргын 541 дүгээр захирамж бичгэн хэлбэрээр гарсан байна.

II. Материаллаг эрх зүйн шаардлага:

1. Богд хан уулын дархан цаазат газарт ТХГНтХ §11.7-д заасан “аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар” зориулалтаас өөр барилга байгууламж барихыг ТХГНтХ-ийн §12.5-р хориглосон байна. Иймд иргэн “Д”-д Дархан цаазат газарт сургуулийн зориулалтаар барилга барих зөвшөөрөл олгох эрх зүйн үндэслэл байхгүй тул Нийслэлийн Засаг дарга 541 дүгээр захирамжаараа ТХГНтХ-ийн §12.5 заалтыг зөрчсөн байна.
2. Нийслэлийн Засаг даргын 541 дүгээр захирамжаар иргэн “Д”-д Дархан цаазат газарт сургуулийн зориулалтаар газар ашиглах асуудлыг шийдвэрлэсэн тул агуулга нь тодорхой байна.
3. ТХГНтХ, ГтХ зөрчсөн байна.

Иймд Нийслэлийн Засаг даргын 2004 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 541 дүгээр захирамж ТХГНтХ-ийн § 36.1 (чиг үүргийн хамаарал), §§35.1, 35.2, 27.8, 27.9 болон ГтХ-ийн §31.3 (шийдвэр гаргах ажиллагааны журам) мөн ТХГНтХ-ийн §12.5 (эрх зүйн үндэслэл) зүйл, заалтыг тус тус зөрчсөн хууль бус захиргааны акт байна.

Хариулт 3.

1. ТХГНтХ-ийн §36.1 зөрчсөн тухайд: Тусгай хамгаалалттай газар нутаг болох Богд хан уулын Дархан цаазат газарт газар ашиглуулах зөвшөөрөл олгох эрх ТХГНтХ-ийн §36.1-д зааснаар ТЗГБ-ын чиг үүрэгт хамаарч байна. Нийслэлийн Засаг дарга дээрх зөвшөөрлийг олгосноороо ЗХХШтХ-ийн §9.1.3-д заасан “Захиргааны акт гаргах эрх хэмжээгүй этгээд гаргасан” гэсэн нөхцөлийг хангасан тул 2004 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 541 дүгээр захирамж “**илт хууль бус**” байна.
2. ТХГНтХ-ийн §§35.1, 35.2, 27.8, 27.9 болон ГтХ-ийн §31.3 зөрчсөн тухайд: (шийдвэр гаргах ажиллагааны журам) Газар ашиглуулах хүсэлтээ хамгаалалтын захиргаа болон дүүргийн Засаг даргад гаргаагүй (ТХГНтХ-ийн §35.1), дээрх байгууллагуудын санал зөвшөөрлийг төрийн захиргааны байгууллагад өгөөгүй (ТХГНтХ-ийн §35.2), Төрийн захиргааны байгууллагаас хянаж батлаагүй (ТХГНтХ-ийн §27.8 ба 9), уг газар бусдын эзэмшил ашиглалттай давхацсан эсэхийг тодруулаагүй (ГтХ-ийн §31.3) зэрэг шийдвэр гаргах ажиллагааны журам зөрчсөн нь ЗХХШтХ-ийн §9.1.9 дэх “бусад байдлаар холбогдох хууль зөрчсөн” нөхцөлийг хангасан тул НЗД-ын 541 захирамж “**илт хууль бус**” байна.
3. ТХГНтХ-ийн §12.5 зөрчсөн тухайд: (эрх зүйн үндэслэл) Тусгай хамгаалалттай газар нутагт ТХГНтХ-ийн §11.7-д заасан “аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар” зориулалтаас өөр барилга байгууламж барихыг ТХГНтХ-ийн §12.5 хориглосон тул сургуулийн зориулалтаар барилга барих зөвшөөрөл олгох эрх зүйн үндэслэл байхгүй. Иймд НЗД 541 захирамж нь ЗХХШтХ-ийн §9.1.7 заасан “Захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

байхгүй” байхад гаргасан гэсэн нөхцөлийг хангаж байгаа тул уг захирамж “илт хууль бус” байна

Иймд Нийслэлийн Засаг дарга 2004 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 541 дүгээр захирамжаараа Иргэн “Д”-д сургуулийн барилгын зориулалтаар газар ашиглуулах зөвшөөрлийг олгохдоо:

1. ТХГНтХ-ийн §36.1 –ийг зөрчиж эрх хэмжээгүй асуудлаар шийдвэр гаргаж ЗХХШтХ §9.1.7 нөхцөлийг хангасан,
2. ТХГНтХ-ийн §§35.1 ба 35.2 дагуу хамгаалалтын захиргаа болон дүүргийн Засаг даргад хандаж саналыг аваагүй мөн тухайн төсөл нь ТХГНтХ-ийн §27.8 ба 9 дагуу Төрийн захиргааны байгууллагаар хянагдаж батлагдсан болон ГтХ-ийн §31.3 дагуу уг газар бусдын эзэмшил ашиглалтад байгаа эсэхийг тодруулж шалгахгүйгээр холбогдох хууль зөрчиж ЗХХШтХ-ийн §9.1.9 дэх нөхцөлийг хангасан,
3. Тусгай хамгаалалттай газар нутагт сургуулийн зориулалтаар барилга барихыг ТХГНтХ-ийн §12.5-аар хориглосон байхад зөвшөөрөл олгож ЗХХШтХ-ийн §9.1.7-д заасан “Захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй” нөхцөлийг хангасан тул Нийслэлийн Засаг Даргын 2004 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 541 захирамжийг ЗХХШтХ-ийн §9.2 дагуу “илт хууль бусад” тооцно.



Хоёрдугаар хэсэг.

Захиргааны процессын эрх зүйн бодлого бодох аргачлал

Захиргааны процессын эрх зүйн бодлогыг таних энгийн арга нь бодлогын нөхцөлд өгөгдсөн үг, өгүүлбэрт анхаарлаа хандуулах юм. Хэрэв бодлогын нөхцөлд захиргааны шүүх, захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах (нэхэмжлэлийн ямар төрлийг сонгох вэ?, нэхэмжлэлийг захиргааны шүүх хүлээн авах уу?, нэхэмжлэлийн үндэслэлт байдлыг шалгана уу гм.) гэсэн үг, өгүүлбэр байгаа бол түүнийг захиргааны процессын бодлого байна гэж үзнэ. Захиргааны процессын бодлогын асуулт буюу даалгавар нь ихэнхдээ ерөнхий байдаг, энэ нь дэс дараалсан олон ажиллагаа шаарддаг (олон нөхцөлийг шалгадаг) тул бодлогыг логик дараалалтай, цэгцтэй, алдаагүй бодохын тулд тодорхой топойг хэрэглэх нь хялбар байдаг. Захиргааны процессын бодлогыг бодох топой нь хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. **Болохуйц байдал.** Энэ хүрээнд захиргааны хэргийн шүүх тухайн нэхэмжлэлийг хүлээн авах эсэхийг, өөрөөр хэлбэл, нэхэмжлэлээс татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгана.
2. **Үндэслэлт байдал.** Хэрэв захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлээс татгалзах үндэслэл байхгүй бол нэхэмжлэл үндэслэлтэй эсэхийг шалгана. Нэхэмжлэлийн үндэслэлт байдлыг шалгахын тулд эхлээд нэхэмжлэлийн зүйл болох захиргааны акт (хэм хэмжээний акт) хууль ёсны эсэхийг шалгаад, дараа нь хэрэв хууль бус бол түүний улмаас нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн эсэхийг тогтоох юм.

А. Болохуйц байдлын хүрээнд дараах зүйлсийг шалгана.

1. §34.1.1. Захиргааны хэргийн шүүхийн харьяаллын хэрэг мөн үү?
 - Нийтийн эрх зүйн маргаан мөн үү?
 - Захиргааны маргаан мөн үү? а. Захиргааны байгууллагаас гаргасан б. Захиргааны акттай холбоотой хэрэг эсэхийг (§§4.1, 3.1.1, 3.1.2, 3.1.4, 4.2-ыг) шалгана.
Энэ хүрээнд ЗХХШТХ-ийн §4.3-ыг давхар шалгахад илүүдэхгүй. Тодруулбал, Шүүх, прокурорын байгууллага, түүнчлэн эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын байцаан шийтгэх, эсхүл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу явуулсан үйл ажиллагаа (шийдвэр)-ны талаар гаргасан гомдол бол эрүүгийн болон иргэний хэргийн шүүх хянан шийдвэрлэх тул захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамаарахгүй.
2. §34.1.2. Тухайн захиргааны хэргийн шүүхийн харьяаллын маргаан мөн үү?
 - нутаг дэвсгэрийн харьяалал §14.
 - тухайн шатны шүүхийн харьяалал §15-г тус тус шалгана.
3. §34.1.3. Урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагатай эсэх?, Шаардлагыг биелүүлсэн эсэх? Энэ журмыг хэрэглэх боломжтой эсэх?
 - ЗХХШТХ-ийн §§6-12-ыг шалгана.
4. §34.1.4. Нэхэмжлэгч эрх зүйн чадамжтай эсэх?
 - §§17, 18-ыг шалгана.
5. §34.1.5. Хууль ёсны төлөөлөл байгаа эсэх? (Нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй болон нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан эсэх)

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

- §§26, 27, 28-ыг тус тус шалгана.
- 6. §34.1.6. Маргаж буй зүйлийн талаар гарсан өөр хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байгаа эсэх?
- 7. §34.1.7. Хууль ёсны эрх залгамжлал байгаа эсэх?
- 8. §34.1.8. Нэхэмжлэл гаргах хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн эсэх?
- §12.1, 12.2³⁶
- 9. §32. Нэхэмжлэгч нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх (Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангасан эсэх)?

ЗХХШТХ-ийн §34-д заасан дээрх 8 шаардлагаас гадна §32-д нэхэмжлэлийн хэлбэр, бүрдүүлбэр, агуулгыг тусгайлан зохицуулсан байдаг. Гэхдээ уг шаардлагыг шалгах дараалал нь шүүгчээс §34-ийг шалгахын өмнө буюу зөвхөн нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй гэсэн нөхцөлөөр нэхэмжлэлийг буцаах, эсхүл §34-ийг шалгах явцад мөн үндэслэлээр буцааж болох талтай.

Нэхэмжлэлийн бүрдүүлбэрийн хүрээнд шалгах ёстой гол урьдчилсан нөхцөл бол нэхэмжлэгч “нэхэмжлэл гаргах эрх”-тэй эсэхийг шалгана. Энэ нь §32.2.3-д нэхэмжлэлд “нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл”-ийг заавал заах бөгөөд үүнд (§32.5.1-5.3):

- захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус актын улмаас нэхэмжлэгчийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрхэн зөрчигдсөн болох,
- захиргааны хэргийн шүүхээс ямар шийдвэр гаргуулж зөрчигдсөн эрхээ хэрхэн сэргээлгэхийг хүсэж байгаа, түүний үндэслэл,
- захиргааны хууль бус актын улмаас ямар хохирол учирсан, түүнийг хэрхэн шийдвэрлүүлэх талаар нэхэмжлэгч дурьдах ёстой.

Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч захиргааны хууль бус актын улмаас зөвхөн “өөрийнх” нь (өөр хэн нэгний бус) “нийтийн эрх зүйн субъектив эрх”, хууль ёсны ашиг сонирхол (хувийн эрх зүйн субъектив эрх биш) нь хэрхэн зөрчигдсөн болохыг үндэслэх буюу нотлох, тэрхүү зөрчигдсөн эрхээ шүүхээр хэрхэн сэргээлгэх (хууль бус актыг хүчингүй болгуулах уу, илт хууль бусыг нь тогтоолгох уу, эс үйлдэхүйн эсрэг даалгах уу, учирсан хохирлоо тогтоолгон гаргуулах уу, эсхүл эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох уу)-ийг хүсэж байгаагаа тодорхой заана гэсэн үг. Хэрэв нэхэмжлэгч өөрийнх нь эрх зөрчигдсөн гэдгээ үндэслээгүй, эсхүл өөрт хамааралгүй асуудлаар шаардлага тавьсан, түүнчлэн юу шаардаад байгаа нь тодорхойгүй бол шүүх нэхэмжлэлийг буцаана.³⁷

Түүнээс гадна нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд нэхэмжлэгч захиргааны хэргийн шүүхээс ямар шийдвэр гаргуулж зөрчигдсөн эрхээ хэрхэн сэргээлгэхийг хүсэж байгаа, түүний үндэслэлээ заах ёстой (ЗХХШТХ-ийн §32.5.2) бөгөөд

36. Хэрэв эдгээрийн аль нэг нь хангагдахгүй бол шүүх нэхэмжлэлээс татгалзсан шалтгааныг зааж, уг нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх, эсхүл шүүх түүнийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж өгч, нэхэмжлэлийг нэхэмжлэгчид буцаана (ЗХХШТХ-ийн §34.2).

37. Энэхүү нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангасан эсэхийг тухайн нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгч шалгаад хэрэв хангаагүй бол тодорхой хугацаа (7-14 хоног) тогтоон уг шаардлагыг хангах боломжийг нэхэмжлэгчид олгоно. Нэхэмжлэгч шүүгчийн тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй бол уг нэхэмжлэлийг шүүгчийн захирамжаар буцаана (ЗХХШТХ-ийн §33).



нэхэмжлэгч юуг хүсэж байгаагаас хамааран нэхэмжлэлийн төрөл тодорхойлогдох тул тухайн нэхэмжлэлд тавигдах тусгай урьдчилсан нөхцөлийг давхар шалгах хэрэгтэй.³⁸

Дээрх нийтлэг болон тусгай урьдчилсан нөхцөл бүрэн хангагдсан тохиолдолд шүүх хэрэг үүсгэнэ.

Б. Үндэслэлт байдал-ын хүрээнд нэхэмжлэлийн шаардлага үндэслэлтэй эсэхийг шалгах юм. Нэхэмжлэлийн үндэслэлт байдлыг тогтоохын тулд:

- нэхэмжлэлийн зүйл болох захиргааны акт эрх зүйн шаардлага хангасан эсэхийг,
- хэрэв хангаагүй бол тухайн акт хууль бус байх бөгөөд түүний улмаас нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн эсэх (нэхэмжлэгчийн нотолж байгаачлан)-ийг шалгана:

Нэхэмжлэлийн зүйл болох захиргааны акт эрх зүйн шаардлага хангасан эсэхийг дараах аргачлалаар шалгаж болно.

I. Формаль эрх зүйн шаардлагад:

1. Захиргааны байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хамаарах:
 - А. Нутаг дэвсгэрийн
 - Б. Шатлан захирах ёсны
 - В. Чиг үүргийн
2. Шийдвэр гаргах ажиллагааны журмыг хангасан байх:
 - А. Нийтлэг журам
 - Б. Тусгай журам (тухайн актыг гаргах талаар хуулиар тусгайлан заасан журам байгаа бол түүнийг хангасан эсэхийг шалгах шаардлагатай. Тухайлбал, тухайн актыг гаргахын тулд бусад этгээдийг оролцуулах, санал авах, хамтран шийдэх, сонгон шалгаруулалт явуулах, холбогдох этгээдэд мэдэгдэх гм.)
3. Хэлбэрийн шаардлагыг хангасан байх:
 - А. Чөлөөтэй (зарчмын хувьд захиргааны актыг ямар ч хэлбэрээр гаргах боломжтой)
 - Б. Тусгайлан заасан (хэрэв хуулиар захиргааны актыг бичгээр гаргахаар заасан бол)
 - В. Үндэслэлийг заах (гэхдээ хүний эрхэд халдаагүй, өөрөөр хэлбэл, эерэг үйлчлэлтэй³⁹, нөхцөл байдал нь олон нийтэд тодорхой болсон, ижил төстэй олон актууд гарсан, хэм хэмжээний актыг үндэслэн гарсан зэрэг тохиолдолд захиргааны актын хуулийн үндэслэлийг заахгүй байж болно).
 - Г. Гомдол гаргах этгээд, хугацааг заах

II. Материаллаг эрх зүйн шаардлагад:

1. Эрх зүйн үндэслэлтэй байх:
 - А. Эрх зүйн үндэслэл тодорхой байх

38. Нэхэмжлэлийн төрөл тус бүрт тавигдах тусгай урьдчилсан нөхцөлийн талаар холбогдох бодлогын нөхцөлөөр тодорхойлсон (шалгасан) байгаа

39. Гэхдээ эерэг үйлчлэл бүхий захиргааны акт ч гэсэн шууд бус байдлаар хандсан этгээдийн хувьд үүрэг хүлээлгэх нь цөөнгүй тул сүүлийн үед эерэг үйлчлэлтэй акт ч гэсэн хуулийн үндэслэлтэй байна гэж үздэг болсныг анхаарна уу.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

- Б. Эрх зүйн үндэслэл нь хүчин төгөлдөр байх (үндэслэл болгосон хэм хэмжээ нь бусад эрх зүйн хэм хэмжээтэй, эсхүл дээд хүчин чадал бүхий хэм хэмжээтэй, тухайлбал, хэм хэмжээний акт нь хуультай нийцсэн байх)
- В. Эрх зүйн үндэслэлийн урьдчилсан нөхцөл нь (гипотез, диспозиц) нь хэргийн бодит байдалтай нийцсэн байх
2. Хаяглагч буюу хандсан этгээдийг зөв сонгосон байх:
3. Нийтлэг шаардлагыг хангасан байх:
 - А. Тодорхой байх (ямар ч хүнд ойлгомжтой байх)
 - Б. Хэрэгжих боломжтой байх (бодит байдлаас хэтэрсэн зүйлийг шаардаагүй байх)
 - В. Харьдангуй байх (зорилго, арга хэрэгсэл нь хуулиар зөвшөөрөгдсөн, зайлшгүй шаардлагатай, тохиромжтой, зохистой байх)
4. Үзэмжээр шийдэх (сонгох боломжтой) шийдвэрийн хувьд алдаагүй байх:
 - А. Боломжийг хэрэглээгүй (хэрэглэх ёстой байтал хэрэглээгүй)
 - Б. Боломжийг хэтрүүлсэн (хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэсэн)
 - В. Боломжийг буруу хэрэглэсэн (хэргийн нөхцөл байдлыг буруу тогтоосон, хамааралгүй нөхцөл байдлыг хамруулсан, логик алдаатай, зөрчилтэй зүйл, заалтыг хэрэглэсэн, боломжгүй зүйлийг шаардсан, хүний эрхийг зөрчсөн гм.) гэсэн шалгуурууд хамаарна.

Хэрэв дээрх шаардлагын аль нэгийг нь болон хэд хэдийг нь зөрчиж байвал тухайн захиргааны актыг эрх зүйн алдаатай гэж үзнэ.

Гэхдээ захиргааны акт эрх зүйн алдаатай байх нь нэхэмжлэлийн шаардлагыг хангах шууд үндэслэл болохгүй. Иймд тухайн хууль бус актын улмаас нэхэмжлэгчийн эрх бодит байдал дээр зөрчигдсөн эсэхийг тогтоох шаардлагатай.⁴⁰

Анхаар! Процессын эрх зүйн бодлогыг бодох дээрх аргачлалын дагуу болохуйц байдлын хүрээнд шалгагдах нөхцөлүүдийг заавал шалгах болон заавал шалгах шаардлагагүй нөхцөл гэж ангилж болно. Үүнийг тухайн бодлогын өгөгдлөөр тодорхойлно. Тухайлбал, заавал шалгах нөхцөлд:

1. Нэхэмжлэл захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах эсэх буюу захиргааны маргаан мөн эсэх, тухайн маргаан нь өөр шүүхэд харьяалагдах эсэх,
2. Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай эсэх, түүнийг шаардлагын дагуу явуулсан эсэх,
3. Нэхэмжлэл гаргах хугацааг баримталсан эсэх,
4. Нэхэмжлэгч нэхэмжлэл гаргах эрхтэй (нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлсон) эсэх,
5. Тухайн нэхэмжлэлийн төрөлд тавигдах тусгай урьдчилсан нөхцөл хангагдсан эсэхийг ямар ч бодлогын хувьд заавал шалгах хэрэгтэй.

40. Үүнийг ЗХХШТХ-ийн §1.1 болох “Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус гэж үзэж, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар гаргасан гомдол, нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх болон уул захиргааны хэргийг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэсэн зохицуулалт, түүнчлэн §3.1.7 дахь “нэхэмжлэл”-ийн тухай тодорхойлолт зэргийн агуулгаас харж болно.



Харин бусад туслах нөхцөл буюу тухайлбал, нэхэмжлэгчийн эрх зүйн чадамж, хууль ёсны төлөөлөл, эрх залгамжлал, шүүхийн нутаг дэвсгэрийн харьяалал зэрэг шаардлагууд нь бодлогын өгөгдлөөс хамаарч заавал шалгах шаардлагатай эсэхийг тодорхойлох юм. Иймд шалгуулагч (оюутан) тухайн бодлогыг ямар аргаар бодохоо (бүх нөхцөлийг нь шалгах уу, эсхүл шаардлагатай нөхцөлийг нь шалгах уу) өөрөө тодорхойлж болно. Гагцхүү ямар ч аргыг нь сонгосон бай шалгагдах ёстой бүх урьдчилсан нөхцөлийг шалгасан байх ёстой гэдгийг анхаарна уу.



Бодлого 7

Иргэн “А” нь зохих журмын дагуу хуульч сонгон шалгаруулах шалгалт өгсний дараа мэргэшлийн шалгаруулалтад тэнцэж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авчээ. Тэрээр 4 жил өмгөөллийн үйл ажиллагаа явуулахдаа МӨХ-д гишүүний татвараа нэг ч удаа төлөөгүй байна. Иймээс МӨХ-ны Сахилгын хороо нь “А”-д Сахилгын хорооны дүрмийн 14.3-ын дагуу сахилгын хэрэг үүсгээд уг дүрмийн 23.1-т заасны дагуу түүний өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгуулах тухай асуудлыг хууль зүйн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд тавьжээ. Хууль зүй Дотоод хэргийн сайд нь Сахилгын хорооны шийдвэрийг үндэслэн “А”-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. “А” нь уг шийдвэрийг хууль бус гэж үзэж буй тул түүнийг хүчингүй болгуулахаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа зохих ёсоор явагдсан.

Асуулт:

1. Шүүх нэхэмжлэлийг хүлээн авах уу?

2. Нэхэмжлэлийн шаардлага үндэслэлтэй юу?

Жич: МӨХ-ны Сахилгын хорооны дүрмийн 14.3 дахь зүйлд “Өмгөөлөгч хүндэтгэх шалтгаангүйгээр гишүүний татвараа 3 сараас доошгүй хугацаанд төлөөгүй бол” сахилгын хэрэг үүсгэнэ.

23.1 дэх зүйлд: “Тухайн өмгөөлөгчийн сахилгын зөрчил гаргасан нь тогтоогдвол зөрчлийн шинж байдлыг харгалзан сануулах сахилгын шийтгэл оногдуулах, өмгөөллийн үйл ажиллагаа явуулах эрхийг нь 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх, өмгөөллийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах тухай асуудлыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тавих шийдвэрүүдийн аль нэгийг гаргана.”

Хариулт 1:

Шүүх нэхэмжлэлээс татгалзах үндэслэл байхгүй тохиолдолд түүнийг хүлээн авна. Иймд уг асуултад хариулахын тулд ЗХХШТХ-ийн 34 зүйлийн 1-т заасан нийтлэг урьдчилсан нөхцөлийг шалгана.

1. §34.1.1. Захиргааны хэргийн шүүхийн харьяаллын хэрэг: (+)

Захиргааны хэргийн шүүхэд хуулиар бусад шүүхэд харьяалуулснаас бусад “захиргааны маргаан” харьяалагдана. Захиргааны маргаан гэдэг нь “захиргааны байгууллага”-аас гаргасан “захиргааны акт”-

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

тай холбоотойгоор иргэн (хуулийн этгээд)-ээс гаргасан гомдол, нэхэмжлэлээр үүсэх нийтийн эрх зүйн маргаан байна.

Иргэн “А” нь Хууль зүй дотоод хэргийн сайдын шийдвэрийн эсрэг нэхэмжлэл гаргасан байна. Сайд нь ЗХХШТХ-ийн §3.1.2-ын дагуу “захиргааны албан тушаалтан” бөгөөд §4.1.2-т заасан этгээд тул түүнээс гаргасан захиргааны актад холбогдох маргаан нь захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамаарна.

Сайдын тушаал нь:

Өмгөөллийн тухай хууль, тогтоомжид (Сахилгын хорооны дүрэм) үндэслэсэн тул нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн; зөвхөн иргэн “А”-д чиглэгдсэн бөгөөд нэг удаагийн шинжтэй тул тодорхой нэг тохиолдол; хууль зүйн асуудал эрхэлсэн сайдаас гаргасан тул захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан; зөвхөн сайдын буюу нэг талын хүсэл зоргийг илэрхийлж буй тул захирамжилсан шинжтэй; иргэн “А”-ийн өмгөөллийн үйл ажиллагаа явуулах эрхийг дуусгавар болгож байгаа тул эрх зүйн үр дагавар үүсгэх буюу зохицуулалтыг агуулсан; захиргааны байгууллагын дотоод хүрээнээс хальж иргэн “А” руу чиглэгдэж буйгаараа гадагш чиглэгдсэн шинжтэй тул “захиргааны акт” мөн байна. ЗХХШТХ-ийн §4.3-т заасан шинж алга байна. Иймд “А”-ийн нэхэмжлэл нь захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах маргаан мөн байна.

2. §34.1.2. Тухайн захиргааны хэргийн шүүхийн харьяаллын маргаан: (+)

Тухайн захиргааны хэргийн шүүхийн харьяаллын маргаан байхын тулд нэхэмжлэл нь нутаг дэвсгэрийн харьяалал (ЗХХШТХ-ийн §14) болон тухайн шатны шүүхийн харьяалал (ЗХХШТХ-ийн §15)-д хамаарах ёстой. Бодлогын нөхцөлд энэ талаар тодорхой зүйл өгөгдөөгүй тул хангагдсан гэж үзнэ.

3. §34.1.3. Урьдчилан шийдвэрлүүлэх шаардлага: (+)

Бодлогын нөхцөлд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа зохих ёсоор явагдсан гэж өгөгдсөн тул уг шаардлага биелэгдсэн гэж үзнэ.

4. §34.1.4. Оролцогчид эрх зүйн чадамжтай: (+)

Оролцогчдын эрх зүйн чадамжийг ЗХХШТХ-ийн §17, 18-аар шалгана. Гэхдээ бодлогод энэ талаар өгөгдөл өгөөгүй тул уг шаардлага хангагдсан гэж үзнэ.

5. §34.1.5. Хууль ёсны төлөөлөл: (+)

Хууль ёсны төлөөлөл нь ЗХХШТХ-ийн §26, 27, 28-ийн дагуу байна. Бодлогод энэ талаарх өгөгдөл байхгүй тул уг шаардлага хангагдсан гэж үзнэ.

6. §34.1.6. Маргаж буй зүйлийн талаар гарсан өөр хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байхгүй (+)

Энэ талаар бодлогын нөхцөлд дурьдаагүй тул уг шаардлага хангагдсан гэж үзнэ.

7. §34.1.7. Хууль ёсны эрх залгамжлал: (+)

Энэ талаар бодлогын нөхцөлд дурьдаагүй тул уг шаардлага хангагдсан гэж үзнэ.

8. §34.1.8. Захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах хугацаа (+)

Энэ талаар бодлогын нөхцөлд тодорхой зүйл өгөгдөөгүй тул шаардлага хангагдсан гэж үзнэ.



Тусгай урьдчилсан нөхцөл буюу нэхэмжлэлийн бүрдүүлбэр §32:

“А” сайдын шийдвэрийг хүчингүй болгуулахыг зорьж байгаа. Хэрэв сайдын шийдвэр хууль бус байгаад хүчингүй болсон тохиолдолд “А”-ийн өмгөөллийн үйл ажиллагаа явуулах эрх сэргэх тул эрх зүйн хамгаалалт бий болох боломжтой. Иймд “А” хүчингүй болгох нэхэмжлэлийн шаардлага гаргах нь зүйтэй. Үүний тулд:

1. А-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон сайдын шийдвэр буюу захиргааны акт байна. Уг акт нь эрх зүйн үйлчлэлтэй болсон бөгөөд үйлчлэл нь үргэлжилж байна.
2. Уг актын улмаас “А” өмгөөлөлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй буюу эрх нь хөндөгдөж байгаа тул тэрээр хүчингүй болгох нэхэмжлэлийн шаардлага гаргах боломжтой.

Иймд Захиргааны хэргийн шүүх “А”-ийн нэхэмжлэлийг хүлээн авна.

Хариулт 2:

Сайдын шийдвэр хууль бус, түүний улмаас нэхэмжлэгч (иргэн А)-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн нь тогтоогдвол шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангана. Өөрөөр хэлбэл, захиргааны актыг хүчингүй болгоно. Үүний тулд шүүх сайдын шийдвэр хууль ёсны эсэхийг, өөрөөр хэлбэл, эрх зүйн шаардлагыг хангаж буй эсэхийг шалгана.

Захиргааны акт нь формаль болон материаллаг эрх зүйн шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд хууль ёсны байна. Хэрэв аль нэг шаардлагыг зөрчсөн бол алдаатай буюу хууль бус акт болно.

I. Формаль эрх зүйн шаардлагын хувьд:

1. Захиргааны байгууллагын эрх хэмжээний хүрээнд хамаарах:

Өмгөөллийн тухай хуулийн дагуу (Өм.тХ-ийн §17, 18, 19) Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу сайд өмгөөлөлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрхтэй.

2. Шийдвэр гаргах ажиллагааны журмыг хангасан байх:

Өмгөөллийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохдоо Өм.тХ-ийн §19.2-т заасны дагуу Сахилгын хорооны саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ. Уг журмыг хангасан байна.

3. Хэлбэрийн шаардлагыг хангасан байх:

Бичгээр гаргасан байна.

II. Материаллаг эрх зүйн шаардлагын хувьд:

1. Эрх зүйн үндэслэлтэй байх

Өмгөөллийн тухай хуулийн 19.1 зүйлд Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох нөхцөлийг тусгайлан заажээ. Иймд Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу Хууль зүй дотоод хэргийн сайд нь уг зүйлд заасан 5 нөхцөлийн аль нэг үндэслэлээр (урьдчилсан нөхцөл хангагдсан бол) тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох эрхтэй. Гэтэл тэрээр Сахилгын хорооны шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тушаал гаргасан тул уг шийдвэр нь эрх зүйн үндэслэлгүй буюу эрх зүйн алдаатай байна.

Иймд нэхэмжлэлийн шаардлага үндэслэлтэй.

ГУРАВ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО БОДОХ АРГАЧЛАЛ

1. Иргэний эрх зүйн хэм хэмжээний хэрэглээний тухай ойлголт, ач холбогдол
2. Иргэний эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх аргачлал:
 - Өгөгдсөн нөхцөлийг анхааралтай унших;
 - Бодлогын нөхцөлийн хүрээнд тавигдсан асуултыг ойлгон, өмнө нь тавигдаж буй зорилгыг тодорхойлох;
 - Шаардах эрхийн үндэслэлийг тодорхойлох.
3. Шаардах эрхийн үндэслэлийг шалгах.
4. Субсумци.
5. Шаардах эрхийг шалгах дараалал.

1. Иргэний эрх зүйн хэм хэмжээний хэрэглээний тухай ойлголт, ач холбогдол

Ойлголт: Иргэний эрх зүйн хэм хэмжээний хэрэглээ гэдэг нь Иргэний хууль тогтоомжийн хэм хэмжээг амьдралын тодорхой нэг тохиолдлын хувьд авч хэрэглэхийг ойлгодог байна. Хууль тогтоомжуудад агуулагдаж буй хэм хэмжээнд хийсвэр тохиолдлуудыг тусгасан бөгөөд эдгээрийн хувьд бий болох эрх зүйн үр дагаврыг хуульчилсан байдаг онцлогтой. Хэм хэмжээний хэрэглээний явцад амьдралд бий болсон нөхцөл байдал нь хуулийн хэм хэмжээнүүдэд хуульчилсан нөхцөлтэй тохирч буй эсэхийг шалгадаг.

Хэм хэмжээний хэрэглээний гүйцэтгэх чиг үүрэг: Хэм хэмжээний хэрэглээ нь эрх зүйн асуудлуудыг маргаан үүсэхээс өмнө болон маргаан үүссэнээс хойш шийдвэрлэх чиг үүргийг гүйцэтгэдэг байна.

2. Иргэний эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх аргачлал

а) Бодлогын өгөгдлийг анхааралтай унших

Бодлогын буюу тохиолдлын өгөгдлийг анхааралтай уншин, эрх зүйн ач холбогдолтой нөхцөлийг эрх зүйн ач холбогдолгүй нөхцөлөөс ялгах шаардлагатай.

б) Бодлогын эцэст тавигдсан асуудлыг ойлгох

Иргэний эрх зүйн хэм хэмжээг хэрэглэн, бодлого бодохын тулд бодлогын эцэст тавигдсан асуудлыг анхааралтай уншин, ямар зүйл, нөхцөлийг шалган, хариулах шаардлагатайг тодруулах нь зүйтэй.

Иргэний эрх зүйн тохиолдлуудад асуудлыг өөр өөрөөр томьёолсон боловч шалган хариулах асуудал нь нэг байх тохиолдлууд түгээмэл байдаг.

в) Шаардах эрхийн үндэслэлийг тогтоох

Шаардах эрхийн үндэслэлийг тогтоохын тулд дараах асуултад хариулах нь зүйтэй:

Хэн хэнээс юу хүсч байна?

Дээрх асуултад хариулсны дараа иргэний хууль тогтоомжийн ямар хэм хэмжээний дагуу буюу үндсэн дээр тодорхой үйлдэл хийх эсхүл эс хийхийг шаардаж буйг тогтооно. Энэ хэм хэмжээг **шаардах эрхийн үндэслэл** гэж нэрлэнэ.



3. Шаардах эрхийн үндэслэлийг шалгах

Шаардах эрхийн үндэслэлийг тогтоосны дараа түүнийг дараах 3 алхмаар шалгах нь зүйтэй:

- а. Шаардах эрх үүссэн үү?
- б. Шаардах эрх үүсээд, хүчин төгөлдөр хэвээр үйлчилж байна уу?
- в. Шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжтой юу?

4. Субсумци

Иргэний эрх зүйн хэм хэмжээний хэрэглээний явцад субсумцийн тухай ойлголт гардаг. Субсумци гэдэгт хэрэглэгдэж буй хэм хэмжээнд агуулагдаж буй хийсвэр урьдчилсан нөхцөл болон бодлогын буюу тохиолдлын бодит нөхцөл хоёр тохирч буй эсэхийг тогтоохыг ойлгодог байна.

Субсумци хийх жишээ:

Шаардах эрхийн үндэслэл буюу хэм хэмжээ: Согтууруулах ундааг тогтмол хэрэглэдэг хүнийг архичин гэнэ.

Өгөгдөл буюу бодлогын нөхцөл: Дорж долоо хоногт хоёр удаа архи уудаг.

Асуулт: Дорж архичин мөн үү?

Хэм хэмжээг авч хэрэглэхийн тулд дараах нөхцөлүүд үүссэн байх шаардлагатай байна: хүн, согтууруулах ундаа, хүн согтууруулах ундаа хэрэглэдэг, хэрэглэхдээ тогтмол хэрэглэдэг.

Хэм хэмжээг авч хэрэглэхэд үүссэн байх шаардлагатай урьдчилсан нөхцөлийг тогтоосны дараа бодит өгөгдөлтэй тохирч буй эсэх талаар субсумци хийе:

Хэм хэмжээ	Хүн	Согтууруулах ундаа	Хэрэглэдэг	Байнга
Өгөгдөл	Дорж	Архи	Уудаг	Долоо хоногт хоёр удаа
	Дорж хүн тул нөхцөл тохирч байна.	Архи согтууруулах ундааны төрөлд багтдаг тул нөхцөл тохирч байна.	Согтууруулах ундааг зориулалтын дагуу хэрэглэхийн нэг жишээ бол уух байдаг тул нөхцөл тохирч байна.	Байнга гэх ойлголт нь тодорхой бус байна. Өдөр болгон хоногт хэрэглэхийг байнга гэх үү, эсхүл долоо хоногт 2 удаа хэрэглэхийг байнга гэх үү? Эхний тохиолдолд нөхцөл тохирохгүй байх болно, хоёр дахь тохиолдолд тохирно.

Хэм хэмжээний бүх урьдчилсан нөхцөлүүд өгөгдлийн нөхцөлүүдтэй тохирч буй тохиолдолд Дорж архичин мөн байна, эсрэг тохиолдолд Дорж архичин биш байна.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

5. Хэд, хэдэн шаардах эрхийг шалгах шаардлагатай тохиолдолд шалгах дараалал

Нэг бодлого буюу тохиолдлын хүрээнд хэд, хэдэн шаардах эрх шалгах шаардлагатай нөхцөлд шаардах эрхийн үндэслэлийг дараах журмын дагуу шалгана:

- Гэрээнээс үүдэлтэй шаардах эрх;
- Гэрээтэй төсөөтэй харилцаанаас үүдэлтэй шаардах эрх;
- Эдийн баялгийн шаардах эрх;
- Бусдад гэм хор учруулснаас үүсэх шаардах эрх;
- Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөнөөс үүссэх шаардах эрх;
- Бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэснээс үүсэх шаардах эрх.



Бодлого 1

“Г” нь “В”-гийн унаж байсан машиныг сонирхож, улмаар “В”-тэй уулзахдаа 3 сая төгрөгөөр худалдах тухай асуужээ. “В”-д 3 сая төгрөгөөр худалдах нь ашиггүй санагдаж, татгалзсан байна. Гэвч “Г”-тэй уулзсанаас хойш 7 хоногийн дараа “В” шийдвэрээ өөрчилж, “Г” руу утасдаж машиныг 3 сая төгрөгөөр худалдахыг зөвшөөрч байгаа тухай хэлжээ.

Асуулт:

“В” нь “Г”-гээс 3 сая төгрөгийг төлөхийг шаардах эрхтэй юу?

Бодолт:

Хэн хэнээс юу хүсч байна?

“В” нь “Г”-гээс 3 сая төгрөгийг төлөхийг шаардаж байна.

Юуны дагуу?

Иргэний Хуулийн 243.1-р зүйлийн дагуу “В” нь “Г”-гээс 3 сая төгрөг төлөхийг шаардаж болох юм.

Иргэний хуулийн 243.1-р зүйлд заасны дагуу **“Худалдах худаалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ”**.

1. Шаардах эрхийн үндэслэл – Иргэний хуулийн 243.1-р зүйл.

Шаардах эрх үүссэн үү?

Шаардах эрх үүсэхийн тулд Иргэний хуулийн 243.1-р зүйлийн дагуу “В”, “Г” хоёрын хооронд машин 3 сая төгрөгөөр худалдах худалдан авах гэрээ байгуулагдсан байх ёстой.

Гэрээ байгуулагдсан эсэхийг шалгая. Иргэний эрх зүйд гэрээ байгуулагдахын тулд харилцан нэг нэг рүү чиглэгдсэн илэрхийлэгдсэн хүсэл зоригийн илэрхийлэл агуулгын хувьд давхацах ёстой. Агуулгын хувьд давхацахын тулд хүсэл зоригийн илэрхийлэл байх шаардлагатай, өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн дагуу гэрээ байгуулах санал, саналын хариу байх шаардлагатай юм.



Гэрээ байгуулах саналыг гаргасан уу? Хэн гаргасан бэ?

Иргэний хуулийн 195.1-р зүйлд заасны дагуу “Нэг этгээд өөрийн хүсэл зоригийг хүлээн зөвшөөрсөн этгээдтэй эрх үүргийн хувьд холбогдохоор нэг буюу хэд хэдэн тодорхой этгээдэд хандан хүсэл зоригоо бодитойгоор, хангалттай тодорхой илэрхийлсэн илэрхийллийг гэрээ байгуулах санал гэнэ”.

Үүнээс дүгнэвэл, хүсэл зоригийн илэрхийлэл гэрээ байгуулах санал байхын тулд дараах урьдчилсан нөхцөлийг хангасан байх ёстой:

- Хүсэл зоригийн илэрхийлэл тодорхой нэг буюу хэд, хэдэн этгээдэд хандан илэрхийлэгдсэн;
- Эрх, үүргийн хувьд холбогдохоор илэрхийлэгдсэн;
- Худалдах худалдан авах гэрээний гол нөхцөлийг агуулсан байх ёстой.

Гэрээ байгуулах саналыг “Г” гаргасан байж болно. Бодлогын нөхцөлөөс дүгнэвэл “Г” нь “В”-д хандан, унаж байгаа машинаа 3 сая төгрөгөөр зарах уу гэж асуусан нь тодорхой этгээд “В”-д чиглэсэн, худалдах худалдан авах гэрээний гол нөхцөл болох юуг, ямар үнээр худалдан авах тухай хүсэл зоригийн илэрхийлэл тул Иргэний хуулийн 195.1-р зүйлийн дагуу гэрээ байгуулах санал байна.

“В” нь “Г”-гийн гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрсөн үү? Бодлогын нөхцөлөөс үзвэл “В”-д машинаа 3 сая төгрөгөөр худалдах нь ашиггүй санагдаж татгалзсан гэж байна. Улмаар “В” нь “Г”-гийн гэрээ байгуулах саналыг зөвшөөрөөгүй тул машиныг 3 сая төгрөгөөр худалдах худалдан авах гэрээ “Г”, “В” хоёрын хооронд байгуулагдаагүй байна.

Бодлогын нөхцөлөөс үзвэл “В” 7 хоногийн дараа “Г”-руу утасдаж зөвшөөрч байгаа тухай хэлсэн байна. Энэ нь гэрээ байгуулах шинэ санал байна. Худалдах худалдан авах гэрээ байгуулагдахын тулд “Г” нь “В”-гийн саналыг зөвшөөрөх ёстой. Бодлогын нөхцөлөөс үзвэл “Г”, “В”-гийн саналыг зөвшөөрсөн тухай дурьдаагүй тул зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл алга. Улмаар “Г”, “В” хоёрын хооронд Иргэний хуулийн 243.1-р зүйлд заасан машин 3 сая төгрөгөөр худалдах худалдан авах гэрээ байгуулагдаагүй тул “В” нь “Г”-гээс Иргэний хуулийн 243.1-р зүйлийн дагуу 3 сая төгрөгийг төлөхийг шаардах эрхгүй.



Бодлого 2

МУИС-ийн 5-р дамжааны оюутан болох “А”, “Б” хоёр гэрлэлтээ бүртгүүлж, өрх тусгаарлахаар шийджээ. Улмаар 3-р хорооллын 6 давхар байшингийн мансардны 1 өрөө орон сууцыг сарын 450.000 төгрөгөөр хөлсөлсөн байна. Орон сууцанд тавилга байхгүй байсан тул “А”, “Б” хоёр дараах зарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараажээ: “Байнгын орлогогүй оюутан гэр бүлд хуучин тавилга өгч тусална уу”. Зарын дагуу “Д” гэгч “А”, “Б” хоёр руу утасдан: “Манай гэрийн зооринд хэрэглэхээ больсон тавилга байгаа. Очиж үзээд, сонгоод ав” гэжээ. “А”, “Б” хоёр буйдан, ширээ, 4 сандал сонгон авч, гэртээ аваачин байрлуулжээ. Гэтэл 2 хоногийн дараа “Д” утасдан: “Авсан тавилгын үнэ болох 250.000 төгрөгөө төл” гэхэд “А”, “Б” хоёр гайхан “бэлэглэсэн гэж бодсон шүү дээ” гэжээ.⁴¹

Асуулт:

“Д” нь “А”, “Б” хоёроос 250.000 төгрөг төлөхийг шаардах эрхтэй юу?

Бодолт:

Иргэний Хуулийн 243.1-р зүйлийн дагуу **“Худалдах худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ”**.

“Д” болон “А”, “Б” нарын хооронд тавилга худалдах, худалдан авах гэрээ байгуулагдсан бол тавилгын үнийг “Д” нь “А”, “Б” хоёроос шаардах эрхтэй.

1. Шаардах эрхийн үндэслэл: Иргэний хуулийн 243.1-р зүйл

Шаардах эрх үүсэн үү?

“А”, “Б” болон “Д” нарын хооронд тавилгыг 250.000 төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээ байгуулагдсан бол “А”, “Б” хоёр “Д”-д 250.000 төгрөг төлөх үүрэг хүлээнэ. Гэрээ байгуулагдахын тулд гэрээ байгуулах санал болон саналын хариу нь адил агуулгатай байх шаардлагатай. Үүний тулд гэрээ байгуулах санал, саналын хариу байх шаардлагатай.

Гэрээ байгуулах санал нь Иргэний хуулийн 195.1-р зүйлд заасны дагуу **“Нэг этгээд өөрийн хүсэл зоригийг хүлээн зөвшөөрсөн этгээдтэй эрх үүргийн хувьд холбогдохоор нэг буюу хэд хэдэн тодорхой этгээдэд хандан хүсэл зоригоо бодитойгоор, хангалттай тодорхой илэрхийлсэн илэрхийллийг гэрээ байгуулах санал гэнэ”**.

Үүнээс дүгнэвэл, хүсэл зоригийн илэрхийлэл гэрээ байгуулах санал байхын тулд дараах урьдчилсан нөхцөлийг хангасан байх ёстой:

- Хүсэл зоригийн илэрхийлэл тодорхой нэг буюу хэд хэдэн этгээдэд хандан илэрхийлэгдсэн;
- Эрх, үүргийн хувьд холбогдохоор илэрхийлэгдсэн;
- Худалдах худалдан авах гэрээний гол нөхцөлийг агуулсан байх.

41 L.Michalski, Uebungen im Buerg. Recht fuer Anfaenger, 2005.



Гэрээ байгуулах саналыг гаргасан уу? Хэн гаргасан бэ?

Гэрээ байгуулах саналыг “А”, “Б” хоёр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар өгөн зарлуулснаар гаргасан байж болох юм. Гэвч энэхүү зар нь тодорхой нэг буюу хэд, хэдэн этгээдэд хандан гаргасан хүсэл зоригийн илэрхийлэл гэж үзэх үндэслэлгүй юм, учир нь хэн сонин авч унших, зурагтын зарыг үзэх нь тодорхойгүй буюу тогтоох боломжгүй. Иймээс ИХ-ийн 195.1-р зүйлд заасан нэг шаардлага хангагдахгүй байгаа тул зар гаргасан нь гэрээ байгуулах санал биш, харин Иргэний хуулийн 195.4-р зүйлд заасны дагуу саналын дуудлага юм.

Иргэний хуулийн 195.4-р зүйл заасны дагуу: **“Тодорхой бус этгээдүүдэд хандсан хүсэл зоригийн илэрхийлэлд гэрээ байгуулах санал болохыг шууд заагаагүй бол түүнийг санал гаргах дуудлага гэнэ”.**

Гэрээ байгуулах саналыг “Д” нь “А”, “Б” хоёр руу утасдан “таарсан зүйлээ сонгоод ав” гэж хэлснээр гаргасан байж болох юм. Гэвч энэ нь худалдах, худалдан авах гэрээний эсхүл бэлэглэлийн гэрээний санал болох эсэх нь тодорхойгүй байна.

Гэрээ байгуулах санал бол хүсэл зоригийн илэрхийлэл бөгөөд тодорхой эрх зүйн үр дагавар бий болгоход чиглэгддэг. Тухайн хүсэл зоригийн илэрхийлэл ямар агуулгатай байна вэ, эсхүл ямар эрх зүйн үр дагавар бий болгоход чиглэгдсэн эсэхийг Иргэний хуулийн 41.1, 41.2-р зүйлд заасны дагуу хүсэл зоригийн илэрхийллийг тайлбарлах аргаар тодорхойлно.

Иргэний хуулийн 41.1, 41.2-р зүйлд заасны дагуу **“Хүсэл зоригийн агуулгыг тайлбарлахдаа үгийн шууд утгыг анхаарна. Хүсэл зоригийн илэрхийллийн утга ойлгомжгүй бол хүсэл зоригоо илэрхийлэгчийн хэрэгцээ, шаардлага, үг болон үйлдэл, эс үйлдэхүй, бусад нөхцөл, байдалд дүн шинжилгээ хийх замаар тайлбарлана”.**

Ингэхдээ энэ нь тодорхой этгээдэд чиглэгдэн гарсан хүсэл зоригийн илэрхийлэл тул энэ нь нөгөө талд хүргэх шаардлагатай хүсэл зоригийн илэрхийлэл юм. Нөгөө талд хүргэх ёстой хүсэл зоригийн илэрхийллийг тайлбарлахдаа нөгөө талд яаж ойлгогдохоор байна вэ гэх үүднээс тайлбар хийдэг.

“Ирээд хэрэгтэй тавилгыг сонгоод ав” гэх үгнээс дүгнэвэл, энд худалдах, худалдан авах гэрээ байгуулах санал гэж хэлэх үндэслэлгүй байна. Үүнийг бусад нөхцөл байдлаар баталж болох юм. Гэрээний дуудлага гаргасан “А”, “Б” хоёрын зараас харвал энэ хоёр хэвлэл мэдээллийн хэрэгслээр “орлогогүй оюутан гэр бүлд туслаач” гэсэн нь үнэ төлбөргүй, хуучин хэрэглэж байсан тавилга авахыг хүсч байгаа нь тодорхой. Энэхүү дуудлагын дагуу хандсан “Д”-гийн үгнээс үзвэл “А”, “Б” хоёрт худалдах, худалдан авах гэрээ бус, харин бэлэглэлийн гэрээ байгуулах санал гаргаж байна гэж ойлгогдохоор байна. Иймд талуудын хооронд худалдах, худалдан авах гэрээ биш, харин Иргэний хуулийн 276.1-р зүйлд заасан бэлэглэлийн гэрээ байгуулагдсан тул “А”, “Б” хоёр “Д”-д 250.000 төгрөг төлөх үүрэг хүлээхгүй.

Иргэний хуулийн 276.1-р зүйлд: **“Бэлэглэлийн гэрээгээр бэлэглэгч нь бэлэг хүлээн авагчийн зөвшөөрснөөр түүний өмчлөлд тодорхой хөрөнгө хариу төлбөргүй шилжүүлнэ”** – гэж заасан байна.

1. “Д” нь “А”, “Б” хоёроос тавилгыг өөрт нь өгөхийг Иргэний хуулийн 106.1-р зүйлийн дагуу шаардаж болох юм.

Иргэний хуулийн 106.1-р зүйлд заасны дагуу: **“Өмчлөгч хөрөнгөө бусдын хууль бус эзэмшлээс шаардах эрхтэй”.**

Үүний тулд Иргэний хуулийн 106.1-р зүйлд заасан тухайн хэм хэмжээг авч хэрэглэх урьдчилсан нөхцөлүүд хангагдсан байх ёстой, үүнд:

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

- “Д” тавилгын өмчлөгч байх;
- Тавилга бусад этгээдийн эзэмшилд орсон байх;
- Эзэмшил нь хууль бус байх.

Бодлогын нөхцөлөөс үзвэл, тавилгын өмчлөгч нь “Д” байсан. “Д” тавилгыг өмчлөх эрхээ “А”, “Б” хоёрт Иргэний хуулийн 111.1-р зүйлийн дагуу шилжүүлсэн байж болно.

Иргэний хуулийн 111.1-р зүйлд заасны дагуу: **“Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол өмчлөх эрх олж авч байгаа этгээдийн зохих журмын дагуу тавьсан шаардлагаар түүний эзэмшилд тухайн эд хөрөнгийг шилжүүлснээр хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно”.**

Үүний тулд талуудын хооронд өмчлөх эрх шилжүүлэхэд чиглэгдсэн гэрээ байх ёстой. Иргэний хуулийн 111.1-р зүйлийн дагуу тавилгын өмчлөх эрх шилжихийн тулд талуудын хооронд гэрээ байгуулагдсан байх ёстой. Бодлогын хүрээнд эхний шаардах эрхийг шалгаж байх явцад “Д” болон “А”, “Б” нарын хооронд Иргэний хуулийн 276.1-р зүйлд заасны дагуу Бэлэглэлийн гэрээ байгуулагдсаныг шалган тогтоосон.

Түүнчлэн бодлогын нөхцөлөөс үзвэл, “А”, “Б” хоёр тавилгыг “Д”-гийн зоориноос авч, гэртээ авч ирж тавьснаар эзэмшилдээ шилжүүлсэн байна. Улмаар тавилгыг өмчлөх эрх нь Иргэний хуулийн 111.1-р зүйлд заасны дагуу “А”, “Б” хоёрт шилжсэн байна.

Иргэний хуулийн 106.1-р зүйлийг хэрэглэх урьдчилсан нөхцөлийн нэг болох “Д” тавилгын өмчлөгч байх гэсэн шаардлага хангагдахгүй байгаа тул бусад нөхцөлийг шалгах шаардлагагүй бөгөөд Иргэний хуулийн 106.1-р зүйлийн дагуу тавилгыг өөрт нь шилжүүлэхийг шаардах эрхгүй байна.



Бодлого 3

Д нь М-ээс 4 өрөө орон сууцыг 120 сая төгрөгөөр худалдан авахаар тохирчээ. Улсын үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд төлөх хураамж болон нотариатаар гэрээг гэрчлүүлэхэд төлөх хөлсийг хэмнэхийн тулд “Г”, “М” хоёр орон сууц худалдах, худалдан авах гэрээг 50 сая төгрөгөөр байгуулж, нотариатаар гэрчлүүлжээ. Орон сууцны өмчлөх эрхийг Улсын хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх замаар шилжүүлэх гэж очиход “М” нь “Д”-гээс орон сууцны төлбөрийн үлдэгдэл болох 60 сая төгрөгийг бүртгүүлэхээс өмнө өг гэхэд “Д” татгалзсан байна.

Асуулт: “М” нь “Д”-гээс 60 сая төгрөг төлөхийг шаардах эрхтэй юу?

Бодолт:

1. “М” нь “Д”-гээс Иргэний хуулийн 243.1-р зүйлийн дагуу орон сууцны үнийг төлөхийг шаардах эрхтэй байж болно.

Иргэний Хуулийн 243.1-р зүйлийн дагуу **“Худалдах, худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ”**.

Шаардах эрх үүссэн үү?

Үүний тулд талуудын хооронд орон сууц худалдах худалдан авах гэрээ байгуулагдсан байх ёстой. Бодлогын хүрээнд орон сууцны үнэ болох 120 сая төгрөг болон 50 сая төгрөг гэх хоёр өөр янзын үнийн асуудал яригдаж байна. Үүнийг тус тусад нь шалгах шаардлагатай.

1. Эхлээд “М” нь “Д”-гээс 50 сая төгрөгийг төлөхийг шаардах эрхтэй эсэхийг шалгая. Шаардах эрхийн үндэслэл Иргэний хуулийн 243.1-р зүйл: талуудын хооронд орон сууц 50 сая төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээ байгуулагдсан байх ёстой. Бодлогын нөхцөлөөс үзвэл, “М”, “Д” хоёр энэхүү гэрээг бичгээр байгуулан нотариатаар гэрчлүүлсэн гэж байна. Иргэний хуульд үл хөдлөх эд хөрөнгийг худалдах худалдан авах гэрээг заавал бичгээр байгуулах тухай шууд заалт үгүй ч, Иргэний хуулийн 109.2-р зүйлд заасанчлан үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой гэрээг бичгээр байгуулан, нотариатаар гэрчлүүлэх шаардлага урган гарч ирж байгаа.

Иргэний хуулийн 109.2-р зүйлд заасны дагуу: **“Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх хэлцэл, холбогдох бусад баримт бичигт өмчлөх эрх шилжүүлэх болсон үндэслэлийг тодорхой зааж нотариатаар гэрчлүүлэх бөгөөд хэрэв талуудын аль нэг нь төлөөлөгчөөр дамжуулан уг харилцаанд оролцож байвал төлөөлөгч болон түүний итгэмжлэлийг дээрх баримт бичигт тэмдэглэх буюу хавсаргана”**.

Иймээс “М”, “Д” хоёр орон сууцыг 50 сая төгрөгөөр худалдах худалдан авах гэрээг хуульд заасан хэлбэрийн дагуу хийсэн гэж үзнэ.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

Гэвч хэлцэл гэдэг нь эрх зүйн үр дагавар бий болгоход чиглэгдсэн хүсэл зоригийн илэрхийлэл болох талаар Иргэний хуулийн 39.1-р зүйл зохицуулсан.

Иргэний хуулийн 39.1-р зүйлд заасны дагуу: **“Иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-г хэлцэл гэнэ”**.

Хүсэл зоригийн илэрхийлэл нь - “М”, “Д” хоёрын хүсч байсан эрх зүйн үр дагавар бол орон сууцыг 50 сая төгрөгөөр биш, харин 120 сая төгрөгөөр худалдах явдал байсан. Иймд Иргэний хуулийн 56.1.3-р зүйлд заасанчлан өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл гэж үзэх үндэслэлтэй, учир нь, энэ гэрээг Улсын бүртгэлийн хураамж болон нотариатын хураамжийг хэмнэхийн тулд талууд хийсэн нь тодорхой.

Иргэний хуулийн 56.1.3. дугаар зүйлийн дагуу:

56.1. Дараах хэлцэл хүчин төгөлдөр бус байна:

56.1.1. хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцэл;

56.1.2. дүр үзүүлэн хийсэн хэлцэл;

56.1.3. өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл.

Иймээс Иргэний хуулийн 56.1.3.-ын дагуу орон сууцыг 50 сая төгрөгөөр ХХАГ хүчин төгөлдөр бус байна.

2. Халхавчиж буй хэлцэл хүчин төгөлдөр бус байх нь халхавчлагдаж буй хэлцэл хүчин төгөлдөр бус байна гэсэн үг биш. Иймээс “М”, “Д” хоёрын хооронд 120 сая төгрөгөөр орон сууц худалдах худалдан авах гэрээний дагуу шаардах эрх байгаа эсэхийг шалгах ёстой.

Иргэний эрх зүйд гэрээ байгуулагдсан гэж тооцогдохын тулд нэг тал нь гэрээ байгуулах санал гаргаж, нөгөө тал нь саналыг хүлээн зөвшөөрсөн байх ёстой. Өөрөөр хэлбэл, талууд гэрээний нөхцөлийн тухай харилцан тохиролцсон байна гэсэн үг. Бодлогын нөхцөлөөс дүгнэхэд, “М”, “Д” хоёр 4 өрөө орон сууцыг 120 сая төгрөгөөр худалдах худалдан авах тухай тохирсон нь тодорхой байна.

Гэвч 4 өрөө орон сууцыг 120 сая төгрөгөөр худалдах худалдан авах гэрээ байгуулагдсан гэж тооцохын тулд “М”, “Д” хоёр харилцан тохирохоос гадна хэлцэл хийхэд тавигдаж буй хэлбэрийн шаардлагыг хангасан байх ёстой.

Дээр дурьдсанчлан Иргэний хуулийн 109.2-р зүйлийн зохицуулалтын дагуу шууд бус утгаар үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой хийгдэж буй гэрээнүүдийг бичгэн хэлбэрээр хийж, нотариатаар гэрчлүүлэх шаардлага тавигддаг.

Иймээс, хэдийгээр “М”, “Д” хоёр 4 өрөө орон сууцыг 120 сая төгрөгөөр худалдах талаар тохиролцсон боловч, энэхүү хэлцэл нь хэлбэрийн хувьд тавигдаж буй шаардлагыг хангахгүй байгаа тул байгуулагдсан гэж тооцохгүй. Улмаар “М” нь “Д”-гээс 120 сая төгрөгийг төлөхийг шаардах эрхгүй байна.



Бодлого 4

“О” нь шинэ жилийн үдэшлэгт оролцохын тулд гоёлын дашинз удаан хугацааны турш хайжээ. “Т” дэлгүүрийн шилэн хоргонд өөрийнх нь төсөөлөн, хүсч байсан дашинз 150.000 төгрөгийн үнэтэй байхыг олж харан, дэлгүүрт орон өмсч үзэхэд өөрт нь зориулж хийсэн юм шиг сайхан таарчээ. “О” нь дэлгүүрийн худалдагч “Р”-д хандан “энэ дашинзыг би авлаа” гэжээ. “Р” нь “Та маш зөв сонголт хийлээ” хэмээн дашинзыг уутанд хийжээ. Кассан дээр бичихэд дашинзны жинхэнэ үнэ 550.000 төгрөг болох нь тогтоогджээ. Шилэн хоргонд үнийг нь бичихдээ алдаа гаргасан нь тогтоогдсон байна. “О” нь 550.000 төгрөг төлөхийг татгалзсан тул “Р” дашинзыг “О”-д өгсөнгүй. Ихэд бухимдсан “О” дэлгүүрээс гаран явж байтал гадаа өөрийн танил, хуулийн ангийн оюутан “Ү”-тэй дайралдан, болсон явдлын тухай ярихад “Ү” “чи хоргонд байсан үнийг төлөөд дашинзыг авч явах эрхтэй” гэжээ.

Асуулт: Эрх зүйн дүгнэлт хийнэ үү.

Бодолг:

“О” нь “Р”-ээс дашинзыг өөрт нь шилжүүлэхийг иргэний хуулийн 243.1.-р зүйлийн дагуу шаардах эрхтэй байж болох юм.

Иргэний хуулийн 243.1-р зүйлд заасны дагуу: Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ.

Шаардах эрх үүссэн үү?

Шаардах эрх үүсэхийн тулд талуудын хооронд худалдах худалдан авах гэрээ байгуулагдсан байх ёстой. Иргэний эрх зүйд харилцан нэг нэг рүү чиглэгдэн илэрхийлэгдсэн хүсэл зоригийн илэрхийлэл агуулгын хувьд давхацвал гэрээ байгуулагдсанд тооцогддог. Үүний тулд гэрээ байгуулах санал, саналын хариу байх ёстой.

Гэрээ байгуулах саналыг хэн гаргасан бэ? Гаргасан уу?

Гэрээ байгуулах саналыг дэлгүүрийн зүгээс шилэн хоргонд дашинзыг тавьснаар гаргасан байж болох юм. Үүний тулд хүсэл зоригийн илэрхийлэл нь Иргэний хуулийн 195.1-р зүйлд заасны дагуу урьдчилсан нөхцөлийг хангасан байх ёстой.

Иргэний хуулийн 195.1-р зүйлийн дагуу: Нэг этгээд өөрийн хүсэл зоригийг хүлээн зөвшөөрсөн этгээдтэй эрх үүргийн хувьд холбогдохоор нэг буюу хэд хэдэн тодорхой этгээдэд хандан хүсэл зоригоо бодитойгоор, хангалттай тодорхой илэрхийлсэн илэрхийллийг гэрээ байгуулах санал гэнэ.

Улмаар хүсэл зоригийн илэрхийлэл гэрээ байгуулах санал байхын тулд дараах нөхцөлийг хангасан байх шаардлагатай:

- Тодорхой нэг буюу хэд, хэдэн этгээдэд хандсан;
- Хангалттай тодорхой;

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

- Эрх, үүргийн хувьд холбогдохоор.

Шилэн хоргонд тодорхой нэг загварын дашинз тавигдсан бөгөөд дашинзны үнэ нь тодорхой байсан боловч дэлгүүрийн шилэн хоргоны дэргэдүүр хэн гарч өнгөрөх нь тодорхой биш тул энийг тодорхой этгээдэд хандсан хүсэл зоригийн илэрхийлэл гэж үзэхгүй. Иймээс Иргэний хуулийн 195.1-р зүйлд заасан нөхцөл хангагдахгүй байгаа тул дэлгүүрийн зүгээс гэрээ байгуулах санал гаргаагүй, харин Иргэний хуулийн 195.4-р зүйлд заасны дагуу энэ нь гэрээний саналын дуудлага юм.

Иргэний хуулийн 195.4-р зүйлийн дагуу: “Тодорхой бус этгээдүүдэд хандсан хүсэл зоригийн илэрхийлэлд гэрээ байгуулах санал болохыг шууд заагаагүй бол түүнийг санал гаргах дуудлага гэнэ”.

Дуудлагын дагуу “О” дэлгүүрт орж ирэн, дашинзыг өмсч үзэн, дэлгүүрт хандан “би энэ дашинзыг авлаа” гэж хэлсэн нь гэрээ байгуулах санал болох юм. Гэвч энд “О”-гийн саналын агуулга нь тодорхойгүй байна, ө.х. “О” дашинзыг 150.000 төгрөгөөр, эсхүл 550.000 төгрөгөөр авах санал гаргасан эсэхийг тодруулах шаардлагатай. Үүнийг Иргэний хуулийн 41.1-р зүйлд заасны дагуу хүсэл зоригийн илэрхийлэлд тайлбар хийх аргаар гүйцэтгэнэ.

Иргэний хуулийн 41-р зүйлийн дагуу:

41.1. Хүсэл зоригийн агуулгыг тайлбарлахдаа үгний шууд утгыг анхаарна.

41.2. Хүсэл зоригийн илэрхийллийн утга ойлгомжгүй бол хүсэл зоригоо илэрхийлэгчийн хэрэгцээ, шаардлага, үг болон үйлдэл, эс үйлдэхүй, бусад нөхцөл, байдалд дүн шинжилгээ хийх замаар тайлбарлана.

Гэрээ байгуулах санал нь дэлгүүрт хандан илэрхийлэгдсэн тул энэ нь нөгөө тал хүлээн авах шаардлагатай хүсэл зоригийн илэрхийлэл юм. Үүнийг нөгөө талд яаж ойлгогдохоор байсан бэ гэх үүднээс тайлбарлана.

“О” нь дашинзыг худалдан авах санал гаргахдаа шилэн хоргонд байгаа үнээр буюу 150.000 төгрөгөөр авах санал гаргасан нь тодорхой. Харин энэ саналыг “Р” яаж ойлгохоор байна вэ? “Р” нь дашинзны үнийг шилэн хоргонд байгаа үнэ гэж ойлгож байгаа нь тодорхой, ө.х. 150.000 төгрөгийн үнэтэй гэдгийг. Улмаар дашинзыг 150.000 төгрөгөөр худалдах худалдан авах гэрээ “О”, “Р” хоёрын хооронд байгуулагдсан байна. Иймээс “О” нь “Р”-ээс дашинзыг өөрт нь шилжүүлэхийг шаардах эрхтэй байна.

Гэвч “Р” нь энэхүү гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулж болох юм. Үүний тулд хүчин төгөлдөр бус гэж тооцуулах үндэслэл байх шаардлагатай. Бодлогын нөхцөлөөс үзвэл, “Р” нь дашинзыг 150.000 төгрөгөөр бус, харин 550.000 төгрөгөөр худалдахыг хүсч байсан. Гэвч хариу өгөхдөө төөрөгдөлд орсон байна. Иймээс “Р” нь хүсэл зоригоо илэрхийлэхдээ төөрөгдөлд орсон гэж үзэх үндэслэлтэй.

Хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахын тулд үндэслэлээс гадна **Иргэний хуулийн 58.6.-р зүйлд “Төөрөгдлийн улмаас хэлцэл хийсэн этгээд төөрөгдсөн болохоо мэдмэгц нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”** гэж заасны дагуу төөрөгдөлд орсныгоо мэдэнгүүт нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх ёстой.

Бодлогын нөхцөлөөс дүгнэвэл, “Р” нь дашинзыг кассан дээр бичихдээ төөрөгдөлд орсныгоо мэдсэн бөгөөд улмаар дашинзыг 150.000 төгрөгөөр худалдахаас татгалзаж, 550.000 төгрөг төлөхийг шаардсан байна. Түүнчлэн дашинзыг “О”-д өгөөгүй үлдээсэн нь “Р” бодит үйлдлээр төөрөгдөлд орсныгоо мэдмэгц “О”-д мэдэгдсэн гэж үзэх үндэслэлтэй.



Иймээс даашинзыг 150.000 төгрөгөөр худалдах худалдан авах гэрээ “О”, “Р” хоёрын хооронд байгуулагдсан боловч, хүсэл зоригийн илэрхийллийн төөрөгдөлд орсон гэх үндэслэлээр хүчин төгөлдөр бус гэж тооцуулан, “О”-гийн шаардах эрх хүчингүй болсон байна.



Бодлого 5

“Д” хууль зүйн нөхөрлөл эрхлэн ажиллуулдаг өмгөөлөгч “З” нь “Н” компьютерийн компаниас өөрийн нөхөрлөлийн үйл ажиллагаанд зориулж тусгай программ худалдан авчээ. Тохирсны дагуу “Н” ХХК нь 2010.10.20 гэхэд программыг хүргэн өгч, суулгаж, товчооны ажилтнуудад сургалт зохион байгуулахаар болжээ. Үйлчилгээний нийт үнийг 4.000.000 төгрөг гэж тохирчээ. 2010.10.20. гэхэд программыг хүргэн өгч, суулгасан боловч, ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулаагүй ажээ. Улмаар “З” нь 4.000.000 төгрөгийг төлөхөөс татгалзахад, “Н” ХХК-ийнхэн 3.000.000 төгрөг төлөх юм бол сургалтыг зохион байгуулна гэжээ. 3.000.000 төгрөг нь программын үнэ болон хүргэн өгч, суулгасны хөлс ажээ.

Асуулт: Эрх зүйн дүгнэлт хийнэ үү

Бодолт:

1. “Н” ХХК нь өмгөөлөгч “З”-гээс Иргэний хуулийн 243.1-р зүйлийн дагуу 3,000.000 төгрөг төлөхийг шаардаж болох юм.

Иргэний Хуулийн 243.1-р зүйлийн дагуу “Худалдах худаалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ” гэж заасан.

Шаардах эрх үүссэн үү?

Үүний тулд талуудын хооронд гэрээ байгуулагдсан байх ёстой. Бодлогын нөхцөлөөс дүгнэвэл, гэрээ байгуулагдсан нь тодорхой байна. Харин үүнд маргаантай асуудал нь гэрээний дагуу талууд ямар үүрэг хүлээсэн тухай асуудал билээ. Бодлогын нөхцөлөөс дүгнэвэл, “Н” ХХК нь программыг хүргэн өгч, суулгахаас гадна сургалт зохион байгуулах үүрэг хүлээсэн. Сургалт зохион байгуулан явуулах нь худалдах, худалдан авах гэрээний дагуу гол үүрэг биш, харин дагалдах үүрэг болж байгаа.

Гэрээний дагуу хүлээсэн үүргийг талууд яаж гүйцэтгэх талаар онцгойлон тохироогүй бол үүргүүдийг нэгийг нь гүйцэтгэсний дараа үлдсэнийг нь гүйцэтгэх ёстой байдаг. Нэгэнт гэрээгээр тохирсон үүргийг бүхэлд нь гүйцэтгээгүй тул, “З” нь төлбөрийг төлөхөөс татгалзах эрхтэй байна.

2. “Н” ХХК нь хугацаандаа үүргээ гүйцэтгээгүй тулд хугацаа хэтрүүлсэн гэж үзнэ. Гэрээний дагуу бүх үүргийг гүйцэтгэх эцсийн хугацааг 2010.10.20 гэж тохирсон байхад, “Н” ХХК энэ хугацаа болоход сургалтыг зохион байгуулж явуулаагүй байна. Сургалт зохион байгуулан, хэрэгжүүлэх нь хэдийгээр дагалдах

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

үүрэг боловч гол үүрэг болох программ авах болсон үйлдлийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Программыг ажиллууулж чадаж байж зориулалтын дагуу ашиглана гэхээс биш, эсрэг тохиолдолд программ авсны ашиг тус, үр нөлөө гэж гарахгүй. Иймээс программ хүргэж өгөх, суулгах болон сургалт явуулах зэрэг үүргийг хуваах үүрэг биш, харин нэгдмэл үүрэг гэж үзэх үндэслэлтэй байна. Иймд сургалтыг зохион байгуулан, хэрэгжүүлээгүй тул “Н” ХХК үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй гэж үзнэ. Энэ тохиолдолд “З”-д дараах үйлдэл хийх эрх зүйн боломж байгаа:

2.1. Гэрээнээс татгалзах

Иргэний хуулийн 204.1, 225-р зүйлд заасны дагуу “З” нь гэрээнээс татгалзаж болох юм.

Иргэний хуулийн 225.1-р зүйлд заасны дагуу: “Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бөгөөд үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч үр дүн гараагүй бол нөгөө тал гэрээнээс татгалзах эрхтэй”.

Иргэний хуулийн 204.1-р зүйлд заасны дагуу “Аль нэг тал гэрээнээс татгалзах бол энэ тухай нөгөө талдаа мэдэгдэнэ”.

Иргэний хуулийн 205.1-р зүйлд заасны дагуу: “Хууль буюу гэрээнд заасны дагуу аль нэг тал гэрээнээс татгалзсан бол талууд гэрээний гүйцэтгэлийг биет байдлаар нь, түүнчлэн гэрээ биелснээс олсон ашгийг харилцан буцааж өгөх үүрэгтэй”.

Улмаар, гэрээнээс татгалзахын тулд татгалзах үндэслэл байх ёстой, хоёрдугаарт, нэг тал татгалзаж байгаа тухайгаа гэрээний нөгөө талд мэдэгдэх шаардлагатай.

“Н” ХХК үүргээ хугацаанд нь буюу 2020.10.20 гэхэд гүйцэтгээгүй хугацаа хэтрүүлэн, үүргээ зөрчсөн байгаа. Иргэний хуулийн 225.1-р зүйлд заасны дагуу үүрэг гүйцэтгэх боломжит хугацааг тогтоож болдог.

Хэрэв үүрэг гүйцэтгэх боломжит хугацааны дотор “Н” ХХК сургалтыг явуулахгүй бол, “З” нь гэрээнээс татгалзах эрхтэй болно. Татгалзсан тохиолдолд Иргэний хуулийн 205.1-р зүйлд заасны дагуу талууд өгсөн, авсан зүйлээ буцаан өгөх үүрэг хүлээдэг. Үүний дагуу “З” нь программыг “Н” ХХК-д буцаан өгч, харин үүргээ гүйцэтгээгүйн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхийг Иргэний хуулийн 219.1-р зүйлийн дагуу шаардах эрхтэй байна.

2.2. Үүргээ гүйцэтгэхийг шаардах

“З” нь “Н” ХХК-гаас сургалтыг зохион байгуулж, явуулахыг шаардаж болно. Энэ тохиолдолд “Н” ХХК үүргээ гүйцэтгэвэл “З” нь 4.000.000 төгрөгийг төлөх үүргээ биелүүлэх ёстой болно.



Бодлого 6

“Г”, “Л” хоёр 2002 онд танилцан, 2003 онд гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлжээ. 2004 онд нөхөр “Г”-гийн ажиллаж байсан төмөр замын газар орон сууц хувьчилж, байгууллагад олон жил сайн ажилласан “Г”-д 2 өрөө орон сууцыг өөрийнх нь нэр дээр хувьчилсан байна. 2005 онд охин “А” нь төржээ. Гэвч 2007 онд “Г”, “Л” хоёр таарахаа больж, эхнэр “Л” охиноо аван өөрийн аав ээжийнд амьдрахаар очсон ажээ. Энэ хугацаанд нөхөр “Г” нь эхнэр нь орон сууцнаас өөрийн хувиа авна гэх байх гэж болгоомжлон, эцэгтэйгээ зөвлөлдөн, өөрийн эцэг “Х”-д орон сууцаа бэлэглэн, улмаар бизнес хийнэ гэж банкинаас зээл авахдаа энэхүү орон сууцыг барьцаанд тавьсан. Эхнэр “Л” энэ тухай мэдэнгүүт өмчлөх эрхээ хамгаалуулахаар шүүхэд ханджээ.

Асуулт: Эрх зүйн дүгнэлт хийнэ үү.

Бодолт:

Шаардах эрхийн үндэслэл: Эхнэр “Л” нь Иргэний хуулийн 106.1, 128.4-р зүйлийн дагуу өөрийн өмчлөх эрхээ сэргийлгэх, бусдын эзэмшлээс эд хөрөнгөө гаргуулахыг шаардах эрхтэй байж болно.

Иргэний хуулийн 106.1-р зүйлд заасны дагуу: **“Өмчлөгч хөрөнгөө бусдын хууль бус эзэмшлээс шаардах эрхтэй”.**

Иргэний хуулийн 128.4-р зүйлийн дагуу: **“Гэрлэснээс хойш гэр бүлийн гишүүний хэн нэг нь эд хөрөнгөө дур мэдэн бусдад шилжүүлсэн, олсон ашиг орлогоо санаатайгаар нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол эрх нь зөрчигдсөн гэр бүлийн гишүүн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрхтэй”.**

Шаардах эрх үүссэн үү?

Үүний тулд Иргэний хуулийн 106.1-р зүйлд заасан урьдчилсан нөхцөл үүссэн байх шаардлагатай:

- “Л” нь орон сууцны өмчлөгч байх;
- Орон сууц бусдын эзэмшилд байх;
- Эзэмшил хууль бус байх.

“Л” нь орон сууцны өмчлөгч мөн эсэхийг тогтооё. Бодлогын нөхцөлөөс дүгнэвэл, “Л” нь орон сууцыг дангаараа биш, харин нөхөр “Г”-тэй хамтран өмчлөгч байж болох юм.

Иргэний хуулийн 126.2.4-р зүйлд: **“... гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгө ... “ нь гэр бүлийн гишүүдийн дундын хөрөнгөд хамаарна”** – гэж заасны дагуу “Г”, “Л” хоёр гэрлэснээс хойш орон сууцыг нөхөр “Г” хувьчилж авсан бөгөөд энэ нь нөхөр “Г”-гийн нэр байгаагаас үл шалтгаалан гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө болно. Түүнчлэн энэ орон сууцыг гэр бүлээрээ амьдрах зориулалттай авсан нь тодорхой байна, иймээс эхнэр “Л” нь орон сууцыг нөхөр “Г”-тэй хамт дундаа өмчлөх эрх эдэлж байна.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

Магадгүй, “Л” нь орон сууц хамтран өмчлөх эрхээ орон сууцыг нөхөр “Г” эцэг “Х”-д бэлэглэснээр алдсан байж болох юм.

Иргэний хуулийн 110.1-р зүйлд: “Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хэлцлийн үндсэн дээр нэг этгээдээс нөгөөд шилжиж байгаа бол уг хэлцлийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлснээр өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно” гэж заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийг Улсын бүртгэлд бүртгүүлснээр түрүүчийн өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болж, шинэ өмчлөгч өмчлөх эрхээ олж авдаг. Гэвч үүний тулд өмчлөх эрх шилжих болсон үндэслэл болж буй үүрэг бий болгож буй хэлцэл “Х”, “Г” хоёрын хооронд хийгдсэн байх ёстой. Энэ нь Иргэний хуулийн 276.1-р зүйлд заасан Бэлэглэлийн гэрээ юм.

Иргэний хуулийн 276.1-р зүйлд заасны дагуу: “Бэлэглэлийн гэрээгээр бэлэглэгч нь бэлэг хүлээн авагчийн зөвшөөрснөөр түүний өмчлөлд тодорхой хөрөнгө хариу төлбөргүй шилжүүлнэ”.

Бодлогын нөхцөлөөс үзэхэд бэлэглэлийн гэрээг “Г”, “Х” хоёр хийсэн нь тодорхой.

Гэвч Иргэний хуулийн 56.1.1, 128.1.–р зүйлийн дагуу нөхөр “Г” эхнэр “Л”-ээс зөвшөөрөл авах шаардлагатай байсан.

Иргэний хуулийн 56.1, 56.1.1-р зүйлийн дагуу: “... хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцэл” хүчин төгөлдөр бус байна.

Иргэний хуулийн 128.1-р зүйлийн дагуу: “Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах адил эрх эдэлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна”.

Энэ нөхцөл хангагдахгүй байгаа тул утга агуулгаараа хууль зөрчсөн буюу хамтран өмчлөгчөөс зөвшөөрөл авах заалтыг зөрчиж хийсэн хэлцэл нь хүчин төгөлдөр бус байна.

Энэ тохиолдолд Иргэний хуулийн 109.3-р зүйлийн дагуу “Г”-гийн эцэг “Х” нь орон сууц “Г”, “Л” хоёрын дундын өмч гэдгийг мэдэж байсан бол орон сууцыг шударгаар олсон гэж үзэх үндэслэлгүй юм.

Иргэний хуулийн 109.3-р зүйлийн дагуу: “Эрх шилжүүлэгч нь өмчлөгч бус этгээд байсан ч улсын бүртгэлд өмчлөгчөөр бүртгүүлсэн бол өмчлөх эрх олж авч байгаа этгээдийн хувьд уг эрхийг шилжүүлж байгаа этгээд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч байх боловч өмчлөх эрх олж авч байгаа этгээд нь уг эрхийг шилжүүлж байгаа этгээд өмчлөгч биш болохыг мэдэж байсан бол энэ заалт хамаарахгүй”.

Бодлогын нөхцөлөөс дүгнэвэл, эцэг “Х” нь орон сууцны хамтран өмчлөгч нь эхнэр “Л” гэдгийг мэдэж байсан эсхүл мэдэх боломжтой байсан гэдэг нь тодорхой байна, учир нь, “Г” өөрийн эцэг “Х”-тэй зөвлөлдөж, түүнд орон сууцаа бэлэглэсэн билээ. Улмаар эцэг “Х” нь орон сууцны өмчлөх эрхийг шударгаар олж авсан гэж үзэх үндэслэлгүй байна.

Иймээс, эхнэр “Л” нь орон сууцыг шаардах эрхтэй.



Бодлого 7

“Д” нь “Х” банктэй лизингийн гэрээ байгуулан шинэ жийп машиныг эзэмшилдээ авч, хэрэглэх болжээ. Лизингийн гэрээний дагуу жийп машиныг “Д” зориулалтын дагуу ашиглаж, зардал, засвар хөлсийг нь хариуцаж байжээ. Нэгэн удаа “Д” машиныг унаж яваад осол гарган, иргэн “Г”-г гэмтээж, машиныг эвдэлсэн байна. Учруулсан гэм хорыг арилгах асуудал үүсэхэд анхан шатны шүүхээс машины өмчлөгч болох “Х” банкинд гэм хорыг арилгах үүргийг хүлээлгэжээ.

Асуулт: Эрх зүйн дүгнэлт хийнэ үү?

Бодолт:

1. “Г” нь өөрт нь учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн үндэслэл нь Иргэний хуулийн 499.1-р зүйл юм.

Иргэний хуулийн 499.1-р зүйлд “Зорчигч болон ачаа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс нь эвдэрч, устаж, гэмтсэн бол тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч учирсан гэм хорыг нөхөн төлөх үүрэгтэй” гэж хуульчилсан.

Үүний дагуу тээврийн хэрэгслийг жолоодож байх явцад бусдад гэм хор учруулсан бол учирсан гэм хорыг тээврийн хэрэгслийг эзэмшигч гэм хорыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

Үүнтэй холбоотойгоор тээврийн хэрэгслийн эзэмшигчийг тодорхойлох асуудал үүсч байна.

Эзэмшигч гэж хэн болохыг Иргэний хуульд шууд тодорхойлоогүй ч, Иргэний хуулийн 89.1-р зүйлд: **“Хүсэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах замаар эзэмшил үүснэ”** – гэж заасан байна.

Түүнчлэн Иргэний хуулийн 90.1-р зүйлийн дагуу: **“Хөрөнгийг хууль ёсоор эзэмшиж байгаа буюу түүнийг эзэмших эрхтэй болох нь тодорхой байгаа этгээдийг шударга эзэмшигч гэнэ”**.

Дээрх заалтуудын зохицуулалтыг бодлогын өгөгдөлтэй субсумци хийхийн тулд нэгдүгээрт, лизингийн гэрээний зохицуулалтыг анхаарах шаардлагатай.

Иргэний хуулийн 312.1-р зүйлд: **“Санхүүгийн түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь гэрээнд заасан хугацаагаар түрээслэгчийн ашиглалтад эд хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь тогтмол хугацаанд түрээсийн төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ”** – гэж заасан байна.

Улмаар, Иргэний хуулийн 312.1-р зүйлийн дагуу лизингийн гэрээгээр банк нь машиныг өөрийн мөнгөөр компанид зориулан худалдан авч, компани нь зориулалтын дагуу ашиглаж, түрээсийн төлбөрийг банкинд төлж, гэрээний хугацаа дууссаны дараа машиныг банк компанид худалдах үүрэгтэй байдаг. Энэ тохиолдолд банк машины өмчлөгч нь, харин компани машиныг зориулалтыг дагуу ашиглаж буй субъект болж байна.

Үүнтэй холбоотойгоор машины эзэмшигч гэж хэнийг хэлэх вэ гэсэн асуудал үүсч байна.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

Дээр дурьдсанчлан, эзэмшигч гэж хэнийг хэлэх тухай тодорхойлолтуудаас дүгнэвэл, машиныг шууд өөрийн мэдэлд байлгаж буй, зориулалтын дагуу ашиглаж буй этгээд болох компани машины өмчлөгч гэж тооцогдож болох юм. Учир нь, лизингийн гэрээний дагуу компани машиныг зориулалтын дагуу ашиглах эрхтэй байгаа. Энэ нь хууль ёсны дагуу өөрийн шууд мэдэлд байлгаж байна гэсэн нөхцөл таарч байгааг нотолж байна.

Гэвч нөгөө талаас, Иргэний хуулийн 89.2-р зүйлд заасны дагуу компани эзэмшигч биш, харин банк эзэмшигч гэж тооцогдох магадлалтай юм.

Иргэний хуулийн 89.2-р зүйлд: “Өөр этгээдээс бүрэн эрх олгогдсоны дагуу түүний ашиг сонирхлын үүднээс эд хөрөнгийг тухайн үед өөрийн мэдэлд байлгаж байгаа этгээдийг эзэмшигч гэж үзэхгүй. Энэ тохиолдолд бүрэн эрх олгосон этгээд эзэмшигч байна” гэж заасан.

Иргэний хуулийн 89.2-р зүйлийн зохицуулалтыг тайлбарлавал, бүрэн эрх олгогдсоны дагуу түүний ашиг сонирхлыг үүднээс хөрөнгийг өөрийн мэдэлд байлгаж буй этгээд гэдэг нь Иргэний хуулийн тусгай ангид зохицуулсан үүргийн гэрээнүүдийн үндсэн дээр биш, тухайн тохиолдолд лизингийн гэрээний дагуу биш, харин жишээ нь, хөрөнгийг удирдах этгээд байж болох юм.

Түүнчлэн, дээрх асуудалд эцсийн хариу өгөхийн тулд тээврийн хэрэгслийг жолоодож явсны улмаас бусдад учирсан хохирлыг нөхөн төлөх зохицуулалтын онцлогийг харгалзах нь зүйтэй.

Тээврийн хэрэгсэл нь хэдийгээр Иргэний хуульд шууд тодорхойлогдоогүй боловч дэлхий даяар тогтсон үзэл бодлын дагуу орчин тойрондоо нэн аюултай зүйлсийн тоонд багтдаг. Энэ нь тээврийн хэрэгсэл өөрийн байж байгаа байдал, мөн чанарын хувьд орчиндоо аюул учруулж болзошгүй өндөр эрсдэл буюу магадлалтай гэж тооцогддог. Ийм учир, тээврийн хэрэгслийг өөрийн өмчлөлд байлгаж буй буюу зориулалтын дагуу ашиглаж буй этгээд энэхүү зүйлийг авч, хэрэглэж байгаагийн хувьд бусдад учруулах хохирлыг хариуцах үүрэг хүлээдэг.

Гэхдээ тээврийн хэрэгсэл нь өөрөө хөдөлж эхэлсэн буюу замын хөдөлгөөнд орж эхэлсэн үеэс орчин тойрондоо аюултай байх эрсдэл бий болдог гэж үздэг. Иймээс тээврийн хэрэгслийг жолоодож байх явцад бусдад учруулсан гэм хорыг тээврийн хэрэгслийг тухайн үед жолоодож байсан этгээд буюу эзэмшигч, шууд өөрийн мэдэлд байлгаж байсан этгээд хариуцах үүрэг хүлээдэг байна.

Иймээс, тээврийн хэрэгслийг жолоодож байхдаа “Г”-д учруулсан гэм хорын тухайн тээврийн хэрэгслийг жолоодож байсан “Д” буюу компани хариуцах үүрэг хүлээнэ.

Иргэний хуулийн 499.1-р зүйлийн дагуу гэм хорыг нөхөн төлүүлэхийн тулд нэгдүгээрт, тээврийн хэрэгсэл байх ёстой, энэ нь бодлогын нөхцөлөөс тодорхой байна.

Хоёрдугаарт, тээврийн хэрэгслийг унаж байх явцад бусдад гэм хор учирсан байна.

Бодлогын нөхцөлөөс дүгнэхэд, тээврийн хэрэгслээс болж осол гарсан нь тодорхой байна.

Гуравдугаарт, хэрэгслийг жолоодож явсан этгээдийн гэм буруугийн асуудал энд яригддаггүй, учир нь энэ нь орчин тойрондоо аюултай зүйлсийн ангилалд багтдаг тул.

Эцэст нь, гэм хор болон тээврийн хэрэгсэл хоёрын хооронд шалтгаант холбоо байна. Энэ нь бодлогын нөхцөлөөс тодорхой байна.

Иймд, тээврийн хэрэгсэл жолоодож явсны улмаас бусдад учирсан хохирлыг банк биш, Иргэний хуулийн 499.1-р зүйлийн дагуу компани нөхөн төлөх үүрэг хүлээх нь.



Бодлого 8

Иргэн “Б” “ХХ” амралтын газрын буудалд нь орж ажилтан “А”-гаас буудалд өглөөний цай ууж нэг хоноход ямар үнэтэй байдаг тухай асуухад “А” 6.000 төгрөг гэсэн хариу өгчээ. 1 хоногийн дараа иргэн “Б” өөрийн эхнэртэй хамт ирж буудалд нийт 10 хоножээ. Явах өдрөө буудлын тооцоо хийхэд иргэн “Б”-гээс нийт 120.000 төгрөг төлөхийг шаарджээ. Иргэн “Б” үүнд 60.000 төгрөг төлөхөд бэлэн байгаагаа илэрхийлжээ. Учир нь 2 хүн нэг хоноход 6.000 төгрөг гэж ойлгосон гэж хариулжээ. Зочид буудлын зүгээс үүнд нэг хүн хоноход 6.000 төгрөг, харин 2 хүн бол 12.000 төгрөг болдог гэсэн хариу өгсөн байна.⁴²

Асуулт: Зочид буудлын зүгээс иргэн “Б”-гээс 120000 төгрөгийг төлөхийг шаардах эрхтэй юу?

Тайлбар:

Хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахын тулд хуульд заасан үндэслэл байх хэрэгтэй бөгөөд хүчин төгөлдөр бус болгохыг хүссэн нэхэмжлэл гаргах шаардлагатай. Хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон тохиолдолд уг хэлцэл нь байгуулсан үеэс эхлэн хүчин төгөлдөр бус байна.

Иргэний эрх зүйн бодлого бодож байхад хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэлийг бодлого бодох аргачлалын хүрээнд системчлэлийн хувьд шаардах эрх үгүй болсон, дуусгавар болсон гэдгийг шалгах үе шатанд шалгах нь зүйтэй.

Хэлцлийг хүчин төгөлдөр бус болгохыг хүсч буй этгээд хэлцлийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хүчин төгөлдөр бус гэж тооцуулж болдог. Хэлцлийг хэсэгчлэн хүчин төгөлдөр бус гэж тооцуулахын тулд хуульд заасан урьдчилсан нөхцөлүүдийг шалгах шаардлагатай.

Бодолт:

1. Зочид буудлын зүгээс иргэн “Б”-гээс 120 000 төгрөгийг төлөхийг шаардах эрх

Зочид буудалд бууж, үйлчлүүлэх гэрээний төрлийг Иргэний хуулийн тусгай ангид зохицуулаагүй. Гэвч Иргэний хуулийн 189-р зүйлийн зохицуулалтаас дүгнэвэл, Иргэний хуульд Гэрээний эрх чөлөөт байдлын зарчмыг тусгаж өгсөн.

Иргэний хуулийн 189-р зүйлд заасны дагуу:

189 дүгээр зүйл. Гэрээний талуудын чөлөөт байдал

189.1. Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй.

189.2. Нийгэм, хувь хүний ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор зарим төрлийн гэрээг гагцхүү төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулж болно. Тусгай зөвшөөрөл олгох журмыг хуулиар тогтооно.

189.3. Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулсан гэрээ нь эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг авснаар хүчин төгөлдөр болно.

42. Hemmer/Wurst, Faelle fuer Fortgeschr.,

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

189.4. Тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил, үйлчилгээ эрхлэх талаар тухайн зах зээлд давамгайлж байгаа этгээд энэхүү үйл ажиллагааны хүрээнд түүнд хандсан этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй бөгөөд нөгөө талдаа тэгш бус нөхцөл тулган санал тавих буюу гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй.

189.5. Энэ хуулиар зохицуулаагүй, шууд нэрлэгдээгүй боловч гэрээний үндсэн шинж, хэлбэрийг илэрхийлсэн өвөрмөц агуулга бүхий гэрээг нэрлэгдээгүй гэрээ гэнэ. Нэрлэгдээгүй гэрээнд энэ хуулийн үүргийн тухай нийтлэг үндэслэл хамаарна.

Иргэний хуулийн 189.1, 189.5-р зүйлийн зохицуулалтаас дүгнэвэл, гэрээний эрх чөлөөт байдлын зарчмын дагуу гэрээний талууд ямар гэрээ байгуулах, ямар агуулгаар гэрээг байгуулах, хэнтэй байгуулах эсэхээ өөрсдөө шийдэх эрхтэй байна. Гэвч гэрээний эрх чөлөөт байдлын зарчим хязгаарлалтгүй биш, хуулиар агуулгыг нь хориглоогүй тохиолдолд л гэрээг яаж, ямар агуулгатай байгуулахаа шийдэх эрхтэй юм.

Түүнчлэн, гэрээний эрх чөлөөт байдлын зарчмын дагуу хуулиар зохицуулагдаагүй гэрээний төрлүүдийг нэрлэгдээгүй гэрээ гэх нэгдсэн нэр томъёогоор нэрлэж байна. Нэрлэгдээгүй гэрээний төрөлд бас холимог төрлийн гэрээнүүд багтаж болно.

Энэхүү ойлголт, зохицуулалтыг бодлогын өгөгдөлтэй субсумци хийвэл, зочид буудалд бууж, үйлчлүүлэх гэрээ нь зочид буудлын зүгээс иргэн орон сууц хөлслөх гэрээний элементүүдыг ихэвчлэн агуулсан, ажил гүйцэтгэх гэрээ, худалдах худалдан авах гэрээ, эд хөрөнгө хөлслөх гэрээ гэх мэт гэрээний төрлөөс бүтсэн холимог хэлбэрийн гэрээ болж байна.

Иймд, Иргэний хуулийн 189.1, 189.5-р зүйлийн дагуу зочид буудлын зүгээс иргэн “Б”-гээс 120.000 төгрөгийг шаардах эрхтэй байж болно.

Үүний тулд зочид буудал болон иргэн “Б” нарын хооронд хүчин төгөлдөр гэрээ байгуулагдсан байх шаардлагатай.

1. Гэрээ байгуулагдсан уу?

а) Диссенс

Хэлцэл хийх явцад диссенс үүссэн байж болно. Диссенс гэдэг нь гэрээний талууд харилцан тохиролцоонд хүрээгүй байх явдлыг ойлгодог. Энэ тохиолдолд байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус байна. Талууд хоногийн хөлсийг өөр, өөр ойлгосон тул энэ тохиолдолд нуутгдмал диссенс бий болсон байж болно. Нуутгдмал диссенсын үед талууд гэрээ байгуулагдсан гэж өөрсдөө итгэдэг боловч, бодит байдал дээр гэрээ байгуулагдаагүй байдаг. Талуудын хооронд харилцан тохиролцоон дээрх дутагдал үнэхээр байгаа эсэхийг тогтоохын тулд хүсэл зоригийг тайлбарлах шаардлагатай. Хүсэл зоригийн тайлбарласны үр дүнд талуудын хооронд харилцан тохиролцоо байна гэж тогтоогдвол диссенс үүсээгүй байна.

б) Хүсэл зоригийг тайлбарлах

Бодлогын нөхцөлөөс үзвэл, зочид буудлын зүгээс нэг хоноход 6.000 төгрөг гэсэн хариу “Б”-д өгсөн. Бодлогын явцад тавигдаж буй асуулт бол иргэн “Б” энэхүү хариуг хэрхэн ойлгох вэ?

Иргэний хуулийн 41.1, 41.2-р зүйлд заасны дагуу **“Хүсэл зоригийн агуулгыг тайлбарлахдаа үгийн шууд утгыг анхаарна. Хүсэл зоригийн илэрхийллийн утга ойлгомжгүй бол хүсэл зоригоо илэрхийлэгчийн хэрэгцээ, шаардлага,**



үг болон үйлдэл, эс үйлдэхүй, бусад нөхцөл, байдалд дүн шинжилгээ хийх замаар тайлбарлана”.

Ингэхдээ энэ нь тодорхой этгээдэд чиглэгдэн гарсан хүсэл зоригийн илэрхийлэл тул энэ нь нөгөө талд хүргэх шаардлагатай хүсэл зоригийн илэрхийлэл юм. Нөгөө талд хүргэх ёстой хүсэл зоригийн илэрхийллийг тайлбарлахдаа нөгөө талд яаж ойлгогдохоор байна вэ гэх үүднээс тайлбар хийдэг.

Бодлогын нөхцөлөөс үзэхэд иргэн “Б” зочид буудалд орж үнэ сонирхохдоо ганцаараа байсан бөгөөд энэ тохиолдолд зочид буудлын ажилтан нэг хүний үнийг сонирхож байна гэж ойлгохоор байна. Үүнээс гадна амралтын газрын зочид буудалд хоёр хүн нэг хонож өглөөний цай уухад нийт үнэ 6.000 төгрөг болно гэдэг нь өнөөдрийн зах зээлд бодит байдалд нийцэхгүй билээ. Иргэн “Б” 6.000 төгрөг гэх нэг хоногийн үнийг нэг хүний хувьд тогтоосон үнэ гэдгийг ойлгохоор байсан. Ийм учир талуудын хооронд 6.000 төгрөг гэж нэг хүний хувьд тогтоосон үнийн талаар харилцан тохиролцоонд хүрсэн гэж үзэхээр байна. Ийм учир энэ тохиолдлын хувьд диссенс үүсээгүй тул гэрээ байгуулагдсан байна. Зочид буудлын зүгээс иргэн “Б”-гээс 120.000 төгрөгийн шаардах эрхтэй байна.

1.2. Хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцох

Хэлцлийг иргэн “Б”-гийн зүгээс хүчин төгөлдөр бус гэж тооцуулахыг хүсч болно. Хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон тохиолдолд хэлцэл хийгдсэн үеэс эхлэн хүчин төгөлдөр бус байна.

Хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах зохицуулалт Иргэний хуулийн 57-58-р зүйлд тусгагдсан. Хүчин төгөлдөр бус гэж тооцуулахын тулд дараах нөхцөлийг шалгах шаардлагатай:

- хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл бий эсэх
- хэлцлийг хүчин төгөлдөр гэж тооцуулах хүсэлтэй байгаа тухай нөгөө талд мэдэгдэх

а) Хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл

Иргэн “Б” хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах үндэслэл бий эсэхийг шалгах шаардлагатай. Бодлогын нөхцөлөөс үзвэл энэ тохиолдолд агуулгын төөрөгдөлд орсон нь хүчин төгөлдөр бус гэж тооцуулах үндэслэл болж болох юм.

Иргэний хуулийн 58.2.2-р зүйлд “... хэлцэл хийгч этгээд хүссэн хэлцлийнхээ агуулгыг эндүүрсэн” бол хэлцлийг ноцтой төөрөгдөлд орсон гэх үндэслэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцож болно.

Иргэн “Б” зочид буудлын зүгээс тавьсан нэг хүний хувьд өглөөний цайтай нэг хоногийн амралтын үнэ 6.000 төгрөг гэсэн саналыг хүлээж авч байгаагаар объектив байдлаар илэрхийлсэн. Гэвч хүсэл зоригоо илэрхийлэх үедээ иргэн “Б” нэг хүний хувьд биш хоёр хүний хувьд үйлчлэх үнийг зөвшөөрсөн гэж бодож байсан. Энэ тохиолдолд иргэн “Б”-гийн объектив болон субъектив хүсэл нэг нэгнээсээ зөрж байна. Бодлогын нөхцөлөөс үзвэл иргэн “Б” үүнийг мэдэж байсан бол зочид буудлын саналыг хүлээн зөвшөөрөхгүй байх байсан. Үүнээс үзвэл хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах үндэслэл байна.

б) Иргэний хуулийн 58.6-р зүйлд заасны дагуу “Төөрөгдлийн улмаас хэлцэл хийсэн этгээд төөрөгдсөн болохоо мэдмэгц нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”.

Иргэн “Б” төөрөгдөлд орсноо нэн даруй нөгөө талд мэдэгдэх ёстой. Иргэн “Б” 120.000 төгрөгийг төлөхгүй гэж хариулснаар төөрөгдөл орсноо мэдэж нөгөө талдаа мэдэгдэж байгаа хэлбэр болно.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

в) Эрх зүйн үр дагавар

Дээр дурьдсанаар иргэн “Б”-гийн хүсэлтээр хэлцлийг хүчин төгөлдөр бус болгох боломжтой байна. Энэ тохиолдолд хэлцэл хийгдсэн үеэс эхлэн хүчин төгөлдөр бус байна.

Бодлогын хүрээнд анхаарах ёстой зүйл бол иргэн “Б” хэлцлийг бүхэлд нь бус харин зөвхөн хэсгийг нь хүчин төгөлдөр бус болгохыг хүсч байгаа. Иргэн “Б” хэлцлийн тодорхой хэсгийн хүчин төгөлдөр бус болгож, үлдсэн хэсгийг хүчин төгөлдөр хэвээр үлдээх боломжтой.

Иргэний хуулийн 61.1-р зүйлд: **“Хэлцлийн зарим хэсэг хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон боловч үлдсэн хэсэг нь уг хэлцлийн зорилгыг хангаж чадахуйц байвал хэлцэл хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ”** гэж заасан.

Энэ хүсэлтээ иргэн “Б” илэрхийлсэн байгаа: 60 000 төгрөгийг төлөхөд бэлэн байгаагаа илэрхийлсэн. Хэлцлийг хэсэгчлэн хүчин төгөлдөр бус болгож болдог. Энэ тохиолдолд мөнгөн төлбөрийн үүргийн тухай яригдаж байгаа учир хэцвийг хуваан хэсэгчлэн хүчин төгөлдөр бус болгох боломжтой.

1.3. Үр дүн

Иргэн “Б” агуулгын хувьд төөрөгдөлд орсон тул хэлцлийг хэсэгчлэн хүчин төгөлдөр болгож зочид буудалд 60.000 төгрөг төлөх үүрэгтэй байна.

2. Зочид буудлын зүгээс иргэн “Б”-гээс үндэслэлгүй хөрөнгөжсөн гэж үзэж Иргэний хуулийн 492-р зүйлийн дагуу үлдсэн 60.000 төгрөгийг төлөхийг шаардаж болно.

Иргэний хуулийн 492.1., 492.1.1. – р зүйлд заасны дагуу:

492.1. Бусдын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэхээр хэн нэгэн этгээдэд хөрөнгө шилжүүлсэн этгээд уг зүйлийг олж авсан этгээдээс дээрх хөрөнгөө дараах тохиолдолд буцаан шаардах эрхтэй:

492.1.1. хөрөнгө олж авсан этгээд болон үүрэг гүйцэтгэгч этгээдийн хооронд үүрэг үүсээгүй, эсхүл үүрэг нь хожим дуусгавар болсон буюу хүчин төгөлдөр бус болсон;

Үүний тулд дараах урьдчилсан нөхцөл бий болсон байх шаардлагатай.

- Эд хөрөнгийн, ашгийн давуу байдал зочид буудалд бий болсон.

Бодлогын өгөгдлөөс үзвэл, иргэн “Б” нь 10 хоногийн туршид зочид буудалд буудаллаж, үйлчлүүлсэн.

- Зочид буудлын зүгээс хийсэн ухамсарт, зорилгот үйлдлийн үндсэн дээр “Б”-д давуу тал бий болсон

Иргэн “Б” болон түүний эхнэрт 10 хоногийн турш зочид буудлын зүгээс үйлчилсэн.

- Эрх зүйн үндэслэлгүйгээр давуу тал бий болсон байх

Иргэн “Б” хэлцлийг хэсэгчлэн хүчин төгөлдөр бус болгосон гэж үзвэл иргэн “Б” болон түүний эхнэр 10 хоног буудалд байж үйлчлүүлэх эрх зүйн үндэслэлгүй.

Үр дагавар:

Иргэний хуулийн 493.2-р зүйлд: **“Үндэслэлгүй олж авсан зүйлийн чанар байдлын улмаас буюу өөр шалтгаанаар түүнийг буцааж өгөх боломжгүй бол олж авсан этгээд түүний үнийг төлнө”** гэж заасан.

Үүний дагуу үндэслэлгүй олж авсан зүйлийг биет байдлаар буцаан гаргаж өгөх боломжгүй тул иргэн “Б” үндэслэлгүй хөрөнгөжсөн гэдэг үндэслэлээр 60.000 төгрөгийг зочид буудалд гаргаж өгөх үүрэг хүлээнэ.



ДӨРӨВ. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОН ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН БОДЛОГО БОДОХ АРГАЧЛАЛ

Нэгдүгээр хэсэг. Эрүүгийн эрх зүйн бодлого бодох аргачлал

Эрүүгийн эрх зүйн бодлого нь тухайн салбарын хүрээнд тодорхой өгөдлийг хууль хэрэглэж шийдвэрлэх, эрх зүйн үнэлэлт дүгнэлт өгөх, оюутнаас мэдлэг, чадварыг нь сориход чиглэгдсэн байна.

Эрүүгийн эрх зүйд тодорхой тохиолдлыг шийдвэрлэхэд өгөгдсөн нөхцөлд Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг шинж байгаа эсэхийг шалгах, хэрэв гэмт хэрэг мөн бол гэмт хэргийн бүрэлдэхүүнийг (объект, объектив тал, субъект, субъектив тал) тодорхойлох, тохиолдлыг шийдвэрлэхэд хэрэглэгдэх Эрүүгийн хуулийн ерөнхий болон тусгай ангийн хэм хэмжээ, бусад эх сурвалжийг ашиглах (Улсын Дээд Шүүхийн тогтоол), тэдгээрийн агуулгыг тайлбарлаж, гэмт хэргийн зүйлчлэл хийх, ойролцоо төрлийн бусад гэмт хэргээс ялгах, дээрх гэмт хэрэг нь төгссөн гэмт хэрэг мөн эсэхийг авч үзэх, тухайн үйлдэл нийгмийн хор аюулыг үгүйсгэх нхцөл байдал бий эсэхийг тогтоох, гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон этгээдүүдийн оролцооны байдлыг үйлдэл тус бүрээр нь ерөнхий ангийн хэм хэмжээг хэрэглэн дүгнэлт хийж тайлбарлах, ял ногдуулах журмыг тодорхойлно.

Оюутан бүр юуны түрүүнд бодлогын өгөгдлийг сайтар уншиж ойлгох хэрэгтэй. Үүний дараа хэрэглэх хуулийн заалт, онол, хуулийн тайлбарын хүрээ хязгаарыг тогтоох замаар эх сурвалжаа тодорхойлох ёстой.

Эрүүгийн эрх зүйн бодлогыг дараах 8 алхмаар бодно.

I. Өгөгдсөн нөхцөлд гэмт хэргийн шинж тэмдэг байгаа эсэхийг шалгах

Гэмт хэрэг гэдэг нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй” гэж тодорхойлсон билээ. Харин Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцдоггүй.

Гэмт хэргийг заавал хуульчлах бөгөөд түүнийг үйлдсэн тохиолдолд ял ногдуулахаар заана. Нийгэмд аюултай хор хохирол учруулсан үйлдэл, эс үйлдлийг хийсэн боловч гэмт хэрэг гэж Эрүүгийн хуульд хуульчилж өгөөгүй бол түүнийг гэмт хэрэгт тооцдоггүй.

Нийгэмд аюултай байх нь гэмт хэргийн гол материаллаг шинж бөгөөд энэ нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт ямар нэг хохирлыг бодитойгоор учруулсан, эсвэл учруулж болох боломжтой байснаар илэрнэ.

Гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай болон болгоомжгүйн аль нэг хэлбэрээр үйлдэгдэнэ. Гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэм буруугүйгээр Эрүүгийн хуульд заасан хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Ямар нэгэн хэргийг гэмт хэрэгт тооцсон бол уг гэмт хэрэгт ногдуулах ялын төрөл хэмжээг заавал заах ёстой. Өөрөөр хэлбэл, тодорхой гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд Эрүүгийн хуульд заасан ял шийтгэлийг зайлшгүй ногдуулах ёстой бөгөөд тодорхой гэмт хэрэгт ногдуулах ялыг Эрүүгийн

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

хуульд заагаагүй бол гэмт хэрэг гэж үзэхгүй.

Дээрх бүхнээс үндэслэн гэмт хэрэг нь:

- Эрүүгийн хуульд заасан үйлдэл, эс үйлдэл;
- Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл;
- Гэм буруутай этгээдийн үйлдэл, эс үйлдэл;
- Эрүүгийн хуульд заасан ял ногдуулдаг гэсэн шинжүүдээрээ эрх зүйн бусад зөрчлөөс ялгагддаг байна.

Бодлогын нөхцөлөөс хэдэн хууль бус үйлдэл байгааг тогтоож, тэдгээр нь дээр дурьдсан шинжүүдийг агуулж байгаа эсэхийг тодорхойлно.

II. Гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болон Эрүүгийн хуулийн ямар хэм хэмжээ хэрэглэгдэхийг тодорхойлж, гэмт хэргийн зүйлчлэл хийх

Гэмт хэрэг мөн бол түүний бүрэлдэхүүний талуудыг тодорхойлно. Гэм буруутай этгээдийн үйлдсэн хэрэгт гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй байх явдал нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно. Энэ тухай Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Энэ хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг агуулсан хэрэг үйлдэгдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно” гэж заажээ.

Гэмт хэргийн бүрэлдэхүүн нь нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдлийг гэмт хэрэгт тооцох объектив болон субъектив шинжүүдийн нийлбэр. Эрүүгийн хуулийн тусгай ангид хуульчлагдсан тодорхой төрлийн гэмт хэргүүдэд дээр дурьдсан шинжүүд заавал байх бөгөөд энэ нь объект, объектив тал, субъект, субъектив талаас тус тус бүрдэх бөгөөд эдгээрийн аль нэг нь байхгүй байвал тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүн үгүйсгэгдэнэ.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний объект бол гэмт халдлагын явцад гэм хор учирсан буюу учирч болох байсан Эрүүгийн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө, нийгмийн болон төрийн эрх ашиг, сонирхол бөгөөд дотор нь ерөнхий (Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийт эрх ашиг), төрлийн (ерөнхий объектын нэг хэсэг өөрийн агуулга, үндсэн шинж чанараараа нийтлэг шинжтэй эрх ашиг), шууд (гэмт халдалагад шууд өртөгдөж буй эрх ашиг) гэж ангилна. Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектоос халдлагын зүйлийг ялган авч үзэх хэрэгтэй. Гэмт хэргийн объект нь тодорхой эрх ашиг байдаг ба харин тэрхүү эрх ашгийг тусгасан бодит ертөнцийн эд юмс нь халдлагын зүйл болно. Өөрөөр хэлбэл, гэмт этгээдийн санаа бодол чиглэгдсэн, түүний үйлдэлд шууд өртөгдөж байгаа материаллаг зүйл юм.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал гэж Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашгийн эсрэг чиглэгдсэн нийгэмд аюултай гэмт халдлагын гадаад байдал юм. Объектив талын шинжүүдийг үндсэн буюу заавал байх (хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт гэмт үйлдэл, эс үйлдэл, харин материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт гэмт үйлдэл, эс үйлдэл, хор уршиг, шалтгаант холбоо) болон нэмэгдэл шинжид (гэмт хэрэг үйлдсэн арга, газар, цаг хугацаа, нөхцөл байдал, зэвсэг хэрэгсэл зэрэг) хуваан авч үздэг. Объектив талын үндсэн шинж нь тодорхой гэмт хэрэгт заавал байх ёстой шинжүүд бөгөөд уг шинж байхгүй бол гэмт хэрэг биш болно. Харин хууль тогтоогч нэмж зарим нэг шинжийг гэмт хэргийн бүрэлдэхүүн болгон заасан байвал нэмэгдэл шинж гэж үзнэ. Нэмэгдэл шинж нь зарим тохиолдолд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг



тогтооход, гэмт хэргийг зөв зүйлчлэх, ял ногдуулахад харгалзан үзэх үндэс болдог ба байхгүй тохиолдолд тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүн үгүйсгэгдэнэ.

Гэмт хэргийн халдлагын зүйлийг гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэх зэвсэг хэрэгслээс ялгах хэрэгтэй. Гэмт хэргийн зэвсэг хэрэгсэл нь гэмт хэрэг үйлдэх зорилгоор ашигласан, бэлтгэсэн, төрөл бүрийн зэвсэг, эд зүйл болон бусад зүйл байдаг бөгөөд зэвсэг хэрэгслийг халдлагын зүйлд халдах зорилгоор ашигладаг. Халдлагын зүйл нь гэмт хэргийн объектын шинж байдаг бол зэвсэг хэрэгсэл нь объектив талын шинж юм. Гэхдээ нэг гэмт хэргийн халдлагын зүйл өөр гэмт хэргийн зэвсэг, хэрэгсэл болж болно.

Гэмт хэрэг мөн эсэхийг тодорхойлоход гэмт хэрэг үйлдсэн этгээдийн уг үйлдэлдээ хандсан сэтгэхүйн харьцаа буюу үйлдэл, эс үйлдлийн дотоод эх сурвалжийг тогтоох нь чухал ач холбогдолтой. Гэмт хэрэг нь нийгмийн харилцааны нэг хэлбэр болохын хувьд ухамсарлагдсан байх шаардлага зайлшгүй тавигдана. Гэмт хэргийн объектив талын шинжүүд бүрдсэн байвч оюун ухаанаар жолоодогдоогүй аливаа хэргийг гэмт хэрэгт тооцох аргагүй. Гэмт хэргийн дотоод тал буюу оюун санаатай холбоотой нөхцөлүүдийг үйлдлийн шинж байдалд дүн шинжилгээ хийх замаар тогтооно. Гэмт хэргийн субъектив тал нь гэмт хэргийн дотоод шинжийг, өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэл, түүний улмаас бий болох хор уршигт сэтгэхүйн хувьд хэрхэн хандсаныг нь илэрхийлэх бөгөөд үндсэн (гэм буруу) болон нэмэгдэл (сэдэлт, зорилго) шинжүүдээс бүрдэнэ.

Гэмт хэргийг ямагт тодорхой этгээд үйлдэж байдаг бөгөөд тэрхүү этгээдийн хувийн чанар, эрүүгийн хариуцлагын зорилгоос үүдэн үйлдлийг гэмт хэрэгт тооцох эсэхийг шийдвэрлэх ач холбогдолтой байдаг. Гэмт хэрэг үйлдсэн бүх хүнд эрүүгийн хариуцлага хүлээх нь зүй ёсны хэрэг боловч энэ нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх зорилгын үүднээс ач холбогдолгүй юм. Тухайлбал, сэтгэл мэдрэлийн өвчний улмаас өөрийн үйлдлийн уг чанарыг ухамсарлаж ойлгох чадваргүй хүн гэмт хэрэг үйлсэн бол. Ийм учраас эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хуульд заасан тодорхой насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай байх шалгуурыг тавих шаардлагатай болдог. Гэмт хэргийн субъект нь нийтлэг болон тусгай гэж ангилагддаг байна. Нийтлэг субъект нь дээр дурьдсан шинжийг агуулсан байдаг бол тусгай субъект нь нийтлэг шинжээс гадна хуульд заасан нэмэлт шинжийг шаардаж байдаг. Энэ нь тухайн этгээдийн ажил мэргэжил, албан тушаал, иргэний харьяалал, хүйс, зэргээс хамааралтай.

Хэрэг шийдвэрлэхэд гэмт хэргийн бүрэлдэхүүний талуудыг тогтоосны дараа Эрүүгийн хуулийн ямар хэм хэмжээг хэрэглэхийг сонгоно. Хэрэг шийдвэрлэхэд зөвхөн тусгай ангид заасан гэмт хэргийг тогтоох биш ерөнхий болон тусгай ангийн хэм хэмжээг хамт хэрэглэж байж зохих үр дүнд хүрдэг учир бодлого нь Эрүүгийн хуулийн хэд хэдэн хэм хэмжээ болон бусад эх сурвалжийг ашиглах (онолын тайлбар, Улсын Дээд Шүүхийн тогтоол), тэдгээрийн агуулгыг тайлбарлах, болж өнгөрсөн үйл явдлыг эх сурвалжтай харьцуулан сумсумбци хийх үндсэн дээр шийдвэрлэгдэх ёстой.

III. Гэмт хэрэгт бэлтгэсэн, завдсан шинж байгаа эсэхийг тодорхойлох

Эрүүгийн эрх зүйд гэмт хэрэг үйлдэх нь гэмт хэрэгт бэлтгэх, гэмт хэрэгт завдах, гэмт хэрэг үйлдэж төгсөх гэсэн үе шаттай байна. Үйлдэл, эс үйлдэл нь

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг агуулсан байвал гэмт хэрэг үйлдэгдэж төгссөнд тооцно. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн, завдсаныг төгсөөгүй гэмт хэрэг гэж үздэг. Гэмт хэрэгт бэлтгэх, завдах (төгссөн болон төгсөөгүй завдалт) шинж нь санатайгаар гэмт хэрэг үйлдэх үед яригддаг ойлголт. Тэрнээс болгоомжгүйгээр гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийг шууд бус санаагаар үйлдэх үед гэмт хэрэгт бэлтгэх, завдах үе шат байдаггүй байна. Гэмт хэргийн завдалтын үед субъект тодорхой үр дүнд хүрэхэд чиглэсэн үйлдэл хийж байдаг бол бэлтгэх үед ирээдүйд гэмт хэрэг үйлдэх нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Бэлтгэх шатанд хуулиар хамгаалсан ямар нэгэн ашиг сонирхолд халдаагүй байдаг бол завдалтын үед нэгэнт бодит аюул заналхийлж эхэлсэн байдаг.

Түүнчлэн гэмт хэрэгт бэлтгэх, завдах үе шат нь материаллаг бүрэлдэхүүнтэй (материаллаг бүрэлдэхүүнтэй гэж тухайн гэмт хэргийн төгсгөлд бодитой хор уршиг шаардагдах хэргийг хэлнэ. Гэмт хэргийн төгссөн үеийг зөв тодорхойлохын тулд энэ ангилалтыг хийдэг ба ихэнх хэрэг заавал хор уршиг учирсан тохиолдолд л төгссөнд тооцдог, харин хор уршиг бүрэн учраагүй бол гэмт хэрэгт бэлтгэсэн, завдсаны аль нэгээр хариуцлага хүлээлгэдэг) хэргийн хувьд яригдахаас биш хэлбэрийн бүрэлдэхүүнтэй хувьд яригдахгүй (хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг гэж хэргийн эцэст заавал бодит хор уршиг шаардахгүй, нийгэмд аюултай үйлдэл хийгдсэнээр төгссөнд тооцогддог гэмт хэргийг хэлнэ. Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй хэргийн хувьд урьдчилсан үе шат байхгүй шууд төгссөнд тооцож ял ногдуулна). Гэхдээ хэлбэрийн бүрэлдэхүүнтэй хэргийн хувьд бэлтгэх үе шат байж болохыг үгүйсгэхгүй.

IV. Ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх

Эрүүгийн хуульд гэмт хэргийн бүрэлдэхүүний зарим нэг шинжээрээ төстэй гэмт хэргүүд байдаг. Иймд тэдгээр гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэргээс ямар шинжээрээ ялгаатай болох түүний үндэслэл, ямар хэм хэмжээг удирдлага болгон ялган зүйлчилж байгааг тайлбарлана.

V. Гэмт хэрэгт хамтран оролцсон шинж байгаа эсэхийг тодорхойлох

Гэмт хэрэгт хамтран оролцох гэдэгт гэмт хэрэг санаатай үйлдэхэд хоёр буюу түүнээс дээш этгээд нэгдсэнийг ойлгох бөгөөд гэмт хэрэгт хамтран үйлдсэнийг хүндрүүлэн авч үздэг.

Гэмт хэрэгт хамтран оролцож байгаа этгээдүүдийн оролцооны байдлыг (захиалагч, зохион байгуулагч, хатгагч, гүйцэтгэгч, хамжигч) үйлдэл тус бүрээр нь ерөнхий ангийн хэм хэмжээг хэрэглэн дүгнэлт хийж тайлбарлана.

Үүнээс гадна зөрчиж гүйцэтгэсэн эсэхийг харгалзах хэрэгтэй. Гэмт хэргийг гардан гүйцэтгэж буй этгээд бусад оролцогчдын мэдээгүй, өөрөөр хэлбэл, тэдэнтэй тохиролцоогүйгээр гэмт хэрэг үйлдэх явдал юм. Гэмт хэргийг зөрчиж гүйцэтгэсэн хэрэгт бусад хамтран оролцогчдод эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Хамтран оролцогчдын хэлбэрийг тодорхойлно. Хамтран оролцогчдын хэлбэр гэж гэмт этгээдүүдийн хамтын ажиллагааны арга, тохиролцооны хэр хэмжээ, зохион байгуулалтыг тодорхойлж буй хамтран оролцоохын гадаад тал юм. Тухайлбал, гэмт хэрэг бүлэглэн гүйцэтгэх, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл зэрэг болно.



VI. Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдал бий эсэхийг тодорхойлох

Халдсан нийгмийн харилцаа, учирсан хохирол зэрэг гадаад илрэх байдлаараа гэмт хэргийн шинжтэй мэт боловч үйлдэл хийгчийн санаа, зорилго, агуулгаараа нийгэмд ашигтай байдаг учир нийгмийн хор аюул нь үгүйсгэгддэг үйл явдлыг гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал гэж үздэг. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн хувьд агуулсан боловч үйлдэгдэх болсон онцгой нөхцөл, нийгэмд ашигтай сэдэлтийн улмаас гэмт хэрэгт тооцохгүй, эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар хуульд заасан онцлог нөхцөл байдлууд юм.

Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 40-44 дүгээр зүйлд заасан байдаг, тухайлбал, аргагүй хамгаалалт, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах, гарцаагүй байдал, үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл, тушаал, захирамж биелүүлэх. Эдгээр нөхцөл байдлууд бодлогын нөхцөлд байгаа эсэхийг тогтооно.

VII. Ял ногдуулах журмыг тодорхойлох

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн ял ногдуулахтай холбогдох зүйлийг бодлогын өгөгдөлтэй холбон тайлбарлана.

Ял ногдуулах нийтлэг зарчим нь ялын зорилгыг хэрэгжүүлэх хэрэгсэл болдог. Шүүх Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнд чанд нийцүүлэн, шударга ёс, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор ял ногдуулна.

Шүүх ял ногдуулахдаа гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хор уршгийн шинж чанар, хохирлын хэр хэмжээ, хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзэх зарчмыг мөрдлөг болгоно. Иймд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 55-64 дүгээр зүйлд заасныг ял ногдуулахдаа шалгаж үзнэ.

VIII. Эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөгдөх үндэслэл байгаа эсэхийг тодорхойлох

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх гэж гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага хүлээлгэхээс татгалзахыг ойлгох бөгөөд уг арга хэмжээ нь эрүүгийн хэрэг үүсгэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд буюу шүүхийн тогтоол гарахаас өмнө хэрэгждэг байна. Ялаас чөлөөлөх гэж хуульд заасан үндэслэл, журмын дагуу төрийн эрх барих байгууллага гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ногдуулсан ялыг эдлүүлэхээс татгалзсан шийдвэр гаргахыг ойлгох бөгөөд шүүхийн шийдвэр гарсны дараа хэрэгждэг арга хэмжээ байдаг.

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх төрлүүдийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 70-73 дугаар зүйлд, ялаас чөлөөлөх төрлүүдийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 74-77 дугаар зүйлд зааж өгдөг бөгөөд эдгээр нь бодлогын өгөгдөлд бий эсэхийг шалгана.



Бодлого 1

Хувиараа таксины үйлчилгээ хийдэг “Л” гэгч 2008 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн шөнийн 23 цагийн орчим найз “Б”-ийн хамт явж байгаад гарцгүй газраар зам хөндлөн гарч явсан иргэн “П”-г мөргөж амь насанд нь аюултай гэмтэл учруулж хохирогчид эмнэлгийн тусламж үзүүлэлгүй хэргийн газраас зугтсан байна. Үүний улмаас хохирогч “П” нас барсан бөгөөд осол гарах үед тэнд байсан гэрчүүдийн мэдүүлгийг үндэслэн осол гаргасан жолоочийг эрэн сурвалжилж 5 хоногийн дараа “Л”-ийг баривчилсан. “Л”-ийн хэргийг шалгах явцад дараах нөхцөл байдлууд илэрсэн. Үүнд: Жолооч “Л” мөрдөн байцаалтад мэдүүлэхдээ хохирогчийг мөргөсний дараа би машинаасаа бууж тусламж үзүүлэх гэсэн боловч надтай хамт явж байсан манай найз “Б” бууж хохирогч дээр очоод “энэ хүн үхсэн юм шиг байна, ойр хавьд хүн алга эндээс хурдан хөдтөө гэсэн”, би тухайн үед сандраад юу хийснээ мэдэхгүй байсан. Гэтэл “Б” миний машиныг унаад явсан тэгээд тэдний гаражид машинаа тавьж машины хамар дээр тогтсон цусыг “Б” арилгасан мөн машины эвдрэлийг тэр засаж өгсөн гэж мэдүүлсэн. Ийм үйлдэл хийснээ “Б” хүлээн зөвшөөрсөн байна.

Шийдвэрлэх асуудал:

1. Шүүгдэгч нарын үйлдлийг зүйлчилнэ үү.
2. Ял ногдуулах журмыг тодорхойлно уу.



3х сурвалж:

Ном, сурах бичиг, гарын авлага:

1. Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (тусгай анги). УБ., 2003
2. Эрдэнэбат Г. Эрдэнэбулган Ж. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал. УБ., 2004
3. Хамтын бүтээл. Хууль зүйн бодлого бодох аргачлал. УБ., 2012
4. Хамтын бүтээл. Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2010

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002
2. УДШ-ийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 27 дугаар тогтоол
3. Өршөөл үзүүлэх тухай хууль. УБ., 2009

Бодолт:

1. “Л”, “Б” нарын үйлдэлд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тодорхойлох

Гэмт хэрэг гэдэг нь Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д зааснаар “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй”.



Гэмт хэрэг нь:

- Эрүүгийн хуульд заасан үйлдэл, эс үйлдэл;
- Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл;
- Гэм буруутай этгээдийн үйлдэл, эс үйлдэл;
- Эрүүгийн хуульд заасан ял ногдуулдаг гэсэн шинжүүдээрээ эрх зүйн бусад зөрчлөөс ялгагддаг байна.

Бодлогын нөхцөлөөс харахад дараах хэд хэдэн хууль бус үйлдлүүд байна.

Үүнд:

1. “Л” нь машинаараа иргэн “П”-г мөргөж амь насанд аюултай гэмтэл учруулсан хууль бус үйлдэл;
2. “Л” нь осол болсон хэргийн газраас зугтаасан хууль бус үйлдэл;
3. “Б” нь “П”-г амь биед нь аюултай нөхцөлд байхад нь тусламж үзүүлээгүй эс үйлдэл.

“Л”, “Б” нарын үйлдлүүд нь дээр дурьдсан гэмт хэргийн шинжийг агуулж байх тул тэднийг Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх бүрэн үндэстэй. Иймд бүрэлдэхүүний шинжийг тодорхойлох зайлшгүй шаардлагатай.

2. Гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болон Эрүүгийн хуулийн ямар хэм хэмжээ хэрэглэгдэхийг тодорхойлж, гэмт хэргийн зүйлчлэл хийх

Дээр дурьдсан үйлдэл тус бүрээр нь авч үзье.

1. “Л” нь машинаараа иргэн “П”-г мөргөж амь насанд аюултай гэмтэл учруулсан хууль бус үйлдэл

Объект: Хөдөлгөөний аюулгүй байдал, иргэн “П”-н амь нас, эрүүл мэнд

Объектив тал: “Л” нь машинаараа иргэн “П”-г мөргөж амь насанд нь аюултай гэмтэл учруулсан үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн болгоомжгүй хэлбэр

Субъект: Тээврийн хэрэгсэл жолоодож явсан “Л”

“Л” нь машинаараа иргэн “П”-г мөргөж амь насанд нь аюултай гэмтэл учруулсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйл болох “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байгаа тул бүрэлдэхүүнийг шалгаж үзье.

215 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих

215.1. Жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдын бие махбодод хүндэвтэр гэмтэл, эсхүл үлэмж хэмжээний хохирол учирсан бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

215.2. Энэ хэргийг согтуугаар үйлдсэн, бусдын бие махбодод хүнд гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

215.3. Энэ хэргийн улмаас бусдын амь нас хохирсон, эсхүл онц их хэмжээний хохирол учирсан бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг дөрвөн жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

215.4. Энэ хэргийн улмаас хоёр ба түүнээс дээш хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Объект: Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, техник ашиглалтын журам. Хүний амь нас, эрүүл мэнд нэмэгдэл объект болно

Объектив тал: Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн санаатай болон болгоомжгүй хэлбэр

Субъект: Тээврийн хэрэгсэл жолоодож явсан жолоодох эрхийн үнэмлэхтэй, үнэмлэхгүй аливаа этгээд

Жолооч “Л” нь иргэн “П”-г мөргөж амь насанд нь аюултай гэмтэл учруулж, үүний улмаас хохирогч “П” нас барсан нь Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй нийцэж байгаа тул эрүүгийн хариуцлага ногдуулж болохоор байна. Иймд “Л”-ийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлийн 215.3-д зааснаар зүйлчилнэ.

2. “Л” нь осол болсон хэргийн газраас зугтаасан хууль бус үйлдэл

Объект: Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал. “П”-ийн амь бие, эрүүл мэнд

Объектив тал: “П”-г мөргөж, зам тээврийн осол гарсан газрыг санаатай орхисон үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн санаатай хэлбэр

Субъект: Тээврийн хэрэгсэл жолоодож явсан “Л”

“Л” нь “П”-г машинаараа мөргөн осол гарсан газрыг санаатай орхисон үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 216 дугаар зүйл болох “Зам тээврийн ослын



үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байгаа тул бүрэлдэхүүнийг шалгаж үзье.

216 дугаар зүйл. Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах

216.1. Зам тээврийн осол гаргасан жолооч хохирсон хүнд яаралтай тусламж үзүүлэх, осол гарсан талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хоёр жилийн хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

216.2. Жолооч зам тээврийн осол гарсан газрыг санаатай орхиж зугтаасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс далан тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Объект: Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн осолд орсон хүний амь бие, эрүүл мэнд

Объектив тал: Зам тээврийн осол гаргасан жолооч хохирсон хүнд яаралтай тусламж үзүүлэх, осол гарсан талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүргээ биелүүлээгүй эс үйлдэл, осол гарсан газрыг санаатай орхиж зугтаасан үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн санаатай хэлбэр

Субъект: Зам тээврийн осол гаргасан тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд.

Бодлогын нөхцөлд хамааралтай зарим нэг ойлголтыг авч үзвэл:

Улсын Дээд Шүүхийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 27 дугаар тогтоолд “Хэргийн газраас зугтаасан” гэдэгт тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд зам тээврийн осол гаргасан үйлдлээ нуух, хариуцлагаас зайлсхийх зорилгоор ослын газрыг тээврийн хэрэгслээр, эсхүл явганаар санаатай орхиж явсан үйлдлийг хэлнэ гэжээ.

Мөн “... Тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг үйлдсэний дараа хохирогчид яаралтай тусламж үзүүлээгүй, осол гарсан талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдээгүй, эсхүл хэргийн газраас зугтаасан бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 216 дугаар зүйлд зааснаар давхар зүйлчилнэ” гэж заасан билээ.

Жолооч “Л”-ийн үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 216 дугаар зүйлийн 216.2-д заасан гэмт хэргийн шинжийг агуулж байна. Ингэснээр “Л”-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлийн 215.3 болон 216 дугаар зүйлийн 216.2-оор давхар зүйлчлэх үндэстэй. Харин энд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 107 дугаар зүйлээр давхар зүйлчлэхгүй.

3. “Б” нь “П”-г амь биед нь аюултай нөхцөлд байхад нь тусламж үзүүлээгүй эс үйлдэл.

Объект: “П”-ийн амьд явах эрх

Объектив тал: “П”-д тусламж үзүүлээгүй эс үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай

Субъект: “Б”

“Б” нь “П”-ийн амь насанд нь аюултай нөхцөлд байхад нь тусламж үзүүлээгүй эс үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 107 дугаар зүйл болох “Бусдыг амь биед нь аюултай нөхцөлд байхад нь тусламж үзүүлэхгүй байх” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байгаа тул холбогдох зүйл ангийнх нь бүрэлдэхүүнийг шалгаж үзье.

107 дугаар зүйл. Бусдыг амь биед нь аюултай нөхцөлд байхад нь тусламж үзүүлэхгүй байх

107.1. Бусдыг амь биед нь аюултай нөхцөлд байхад нь өөртөө болон бусдад хохирол учруулахгүйгээр туслах бололцоо байсан боловч яаралтай тусламж үзүүлээгүй, эсхүл тусламж үзүүлэх шаардлагатайг зохих байгууллагад мэдэгдээгүйгээс гэм хор учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

107.2. Өндөр настан, бага насны, өвчний болон бусад шалтгааны улмаас биеэ хамгаалж чадахгүй хүнийг амь биед нь аюултай нөхцөлд байхад нь туслах бололцоотой бөгөөд халамжлах үүрэгтэй этгээд тусламж үзүүлээгүй зориуд орхисон, эсхүл түүнийг амь биед нь аюултай байдалд зориуд оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

107.3. Энэ хэргийн улмаас хохирогч нас барсан, бусад хүнд хор уршиг учирсан бол гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Объект: Амь нас нь аюултай нөхцөлд байгаа хүмүүсийн амь бие, эрүүл мэнд

Объектив тал: Бусдыг амь насанд нь аюултай нөхцөлд байхад нь тусламж үзүүлээгүй, зохих байгууллагад мэдэгдээгүй эс үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд болон шууд бус санаатай

Субъект: Туслах бололцоотой хэр нь тусламж үзүүлээгүй энэ тухай мэдэгдээгүй 16 насанд хүрсэн эрх зүйн чадвартай этгээд

Улсын Дээд Шүүхийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 27 дугаар тогтоолд “... Харин жолоочтой цуг явсан этгээд осол болсныг болон хохирогчийн биед гэмтэл учирсныг мэдсээр байж түүнд яаралтай тусламж үзүүлээгүй, эсхүл тусламж үзүүлэх шаардлагатайг зохих байгууллагад мэдэгдээгүй бол Эрүүгийн хуулийн 107 дугаар зүйлийн аль тохирох хэсгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан.



Иймд “Б”-ийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 107 дугаар зүйлийн 107.3-т зааснаар зүйлчлэх боломжтой юм.

Гурав. Гэмт хэрэгт бэлтгэсэн, завдсан шинж байгаа эсэхийг тодорхойлох

1. “Л” нь машинаараа иргэн “П”-г мөргөж амь насанд аюултай гэмтэл учруулсан хууль бус үйлдэл. Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйл нь материаллаг бүрэлдэхүүнтэй, өөрөөр хэлбэл, заавал хуульд заасан хохирол учирч байж төгсдөг. Иймд “Л”-ийн үйлдэл нь төгссөн бөгөөд гэмт хэрэгт бэлтгэх, завдах үе шат байхгүй.

2. “Л” нь осол болсон хэргийн газраас зугтаасан хууль бус үйлдэл. Зам тээврийн осол гарсан газрыг санаатай орхих гэмт хэрэг нь үйлдэл хийснээр төгсдөг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй, хэргийн газраас зугтсан идэвхтэй үйлдэл хийснээр дуусах тул гэмт хэрэгт бэлтгэх, завдах гэсэн шинж байхгүй бөгөөд “Л”-ийн үйлдлийг төгссөн гэж үзнэ.

3. “Б” нь “П”-ийн амь бие нь аюултай нөхцөлд байхад тусламж үзүүлээгүй эс үйлдэл. Эрүүгийн хуулийн 107 дугаар зүйл нь материаллаг бүрэлдэхүүнтэй, эс үйлдэл, гэм хор хоёрын хооронд шалтгаант холбоотой байна. Иймд “Б”-ийн үйлдлийг төгссөн гэж үзэх бүрэн үндэстэй. Гэмт хэрэгт бэлтгэх, завдах үе шат байхгүй болно.

Дөрөв. Ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 94 дүгээр зүйлтэй ялган үзье.

Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих	Эрүүгийн хуулийн 94 дүгээр зүйл. Бусдыг болгоомжгүй алах
Объект: Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон техник ашиглалтын журам. Хүний амь нас, эрүүл мэнд нэмэгдэл объект болно	Объект: Бусдын амьд явах эрх
Объектив тал: Үйлдэл, эс үйлдэл. Үүний улмаас хор хохирол учрах бөгөөд үйлдэл, хохирол шалтгаант холбоотой	Объектив тал: Үйлдэл, эс үйлдэл. Үүний улмаас хүний амь нас хохироосон хор уршиг учирна. Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл хүний амь хохирсон хор уршиг хоёрын хооронд шалтгаант холбоотой
Субъектив тал: Гэм буруугийн болгоомжгүй хэлбэртэй. Зарим тохиолдолд гэм буруугийн санаатай ба болгоомжгүйн давхардсан хэлбэртэй	Субъектив тал: Гэм буруугийн болгоомжгүй хэлбэртэй
Субъект: Тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд	Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 216 дугаар зүйлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 107 дугаар зүйлтэй харьцуулан авч үзье.

Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйл. Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах	Эрүүгийн хуулийн 107 дугаар зүйл. Бусдыг амь биед нь аюултай нөхцөлд байхад нь тусламж үзүүлэхгүй байх
Объект: Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн осолд орсон хүний амь бие, эрүүл мэнд	Объект: Амь нас нь аюултай нөхцөлд байгаа хүмүүсийн амь бие, эрүүл мэнд
Объектив тал: Зам тээврийн осол гарсан үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх эс үйлдэл, хэргийн газраас зугтасан үйлдэл	Объектив тал: Тусламж үзүүлээгүй эс үйлдэл бөгөөд үүний улмаас гэм хор уршиг учрах бөгөөд эс үйлдэл, учирсан гэм хор хоёрын хооронд шалтгаант холбоотой
Субъектив тал: Гэм буруугийн санаатай хэлбэр. Хариуцагаас зайлсхийх гэсэн зорилготой	Субъектив тал: Гэм буруугийн шууд болон шууд бус санаатай
Субъект: Зам тээврийн осол гаргасан тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд	Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд

3. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 107 дугаар зүйлийг Эрүүгийн хуулийн 106 дугаар зүйлтэй харьцуулан авч үзье.

Эрүүгийн хуулийн 107 дугаар зүйл. Бусдыг амь биед нь аюултай нөхцөлд байхад нь тусламж үзүүлэхгүй байх	Эрүүгийн хуулийн 106 дугаар зүйл. Өвчтөнд тусламж үзүүлэхгүй байх
Объект: Амь нас нь аюултай нөхцөлд байгаа хүмүүсийн амь бие, эрүүл мэнд	Объект: Өвчтэй хүний амь нас, эрүүл мэнд
Объектив тал: Тусламж үзүүлээгүй эс үйлдэл бөгөөд үүний улмаас гэм хор уршиг учрах бөгөөд эс үйлдэл, учирсан гэм хор хоёрын хооронд шалтгаант холбоотой	Объектив тал: Тусламж үзүүлээгүй эс үйлдэл бөгөөд үүний улмаас гэм хор уршиг учрах бөгөөд эс үйлдэл, учирсан гэм хор хоёрын хооронд шалтгаант холбоотой
Субъектив тал: Гэм буруугийн шууд болон шууд бус санаатай	Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай
Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд	Субъект: Эмч, эмнэлгийн ажилтан

Тав. Гэмт хэрэгт хамтран оролцсон эсэхийг тодорхойлох

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 34 дүгээр зүйлд заасан “Гэмт хэрэгт хамтран оролцох” гэдэгт гэмт хэрэг үйлдэхээр санаатай хамтарсан, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн субъект болох насанд хүрсэн, гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай, 2 буюу түүнээс дээш этгээдийг ойлгоно.

Болгоомжгүйгээр үйлдсэн гэмт хэрэгт хамтран оролцох ойлголт яригдахгүй учир гэмт хэрэгт хамтран оролцсон гэх шинж бүхэлдээ үгүйсгэгдэнэ. Бодлогын нөхцөлд жолооч “Л” нь гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр “П”-г мөргөж, амь насыг хохироосон (хэрэв санаатайгаар машинаар мөргөж амь насыг нь хохироосон бол Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлээр зүйлчлэгдэнэ) билээ. Иймд “Л”, “Б” нар хамтарсан шинж үгүйсгэгдэнэ.



“Б”-гийн үйлдэлд ч гэсэн хамтарсан шинж байхгүй.

Зургаа. Гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал байгаа эсэх

Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд болох аргагүй хамгаалалт, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах, гарцаагүй байдал, үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл, тушаал, захирамж биелүүлэх зэрэг нь бодлогын нөхцөлд байхгүй байна.

Долоо. Ял ногдуулах

“Л”-ийн хувьд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1-г журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлийн 215.3, 216 дугаар зүйлийн 216.2-д заасан гэмт хэрэгт ял ногдуулна.

Харин “Б”-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 107 дугаар зүйлийн 107.3-д заасны дагуу хариуцлага хүлээнэ.

Найм. Эрүүгийн хариуцлага ба ялаас чөлөөлөх

Бодлогын нөхцөлөөс авч үзэхэд “Л”, “Б” нар нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл тогтоогдохгүй байна.

Харин 2009 оны 7 дугаар сарын 9-ны өдрийн “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 4.4-д “... түүнчлэн хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж, анх удаа хорих ял шийтгүүлсэн ялтны эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ” хэмээн заасан.

Бодлогын нөхцөлөөс үзэхэд “Л”, “Б” нарын холбогдсон хэргүүд нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 17 дугаар зүйлийн 17.3-д зааснаар хүндэвтэр гэмт хэрэг бөгөөд дээрх хуулиар өршөөлд хамрагдах боломжтой юм.



Бодлого 2

2005 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн СБД-ийн шүүхийн шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147 дугаар зүйлийн 147.1-т зааснаар 3 жил 5 сарын хорих ялаар шийтгүүлж байсан “Б” гэгч, эрхэлсэн тодорхой ажилгүй “Д” гэгч нар мөрийтэй тоглоом тоглодог байсан бөгөөд хамаг мөнгөө тоглоомд алдаж улмаар хэрхэн мөнгөтэй болох талаар ярилцсан байна. “Б” нь “Манай нутгийн Ц гэдэг ах хүү байдаг, мөнгөний ченж хийдэг, тэрээр их хэмжээний мөнгөө гэртээ байлгадаг, маргааш тэднийд очье” гэж тохирчээ. Ингээд 2011 оны 1 дүгээр 27-ны өдрийн 12 цагийн орчим “Б” нь “Ц” рүү утсаар ярьж уулзах талаар асуухад өвчтэй гэртээ ганцаараа байгаа тул ирж уулз гэжээ. Нутгийн дүү ирлээ гээд “Ц” тэднийг архи, дарсаар дайлж хэсэг хугацааны дараа “Д” нь “Ц”-д хутга тулган гэрт нь байсан сейфийг онгойлгуулан дотроос нь бэлэн мөнгө 10 сая төгрөг, 5.000 америк доллар, 45.000 юань, үе дамжиж ирсэн хаш хөөрөг, 6 ширхэг их гарын мөнгөн аяга, гар утас, зургийн аппарат зэргийг авчээ. Дахин, нуусан мөнгөө гарга гэж нэхэхэд өөр мөнгө байхгүй хэмээн хариулмагц “Б”, “Д” нар уяагаар “Ц”-ийн хүзүүгээр оосорлон зочны өрөөнд чирч оруулах үед “Ц” боолтонд орж амьсгал хураасан байна.

Мөрдөн байцаалтын явцад “Б” эд мөрийн баримт үлдээхгүйн тулд гар утас, аппарат, мөнгөн аяга зэргийг Туул голын усанд хаясан гэж мэдүүлсэн.

Шийдвэрлэх асуудал:

1. Шүүгдэгч нарын үйлдлийг зүйлчилнэ үү.
2. Ял ногдуулах журмыг тодорхойлно уу.



3х сурвалж:

Ном, сурах бичиг, гарын авлага:

- Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (тусгай анги). УБ., 2003
- Эрдэнэбат Г. Эрдэнэбулган Ж. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал. УБ., 2004
- Хамтын бүтээл. Хууль зүйн бодлого бодох аргачлал. УБ., 2012
- Хамтын бүтээл. Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2010

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002
- УДШ-ийн 2003 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 10 дугаар тогтоол
- УДШ-ийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоол
- УДШ-ийн 2008 оны 3 дугаар сарын 26-ний өдрийн 13 дугаар тогтоол
- УДШ-ийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоол

Бодолт:

Нэг. “Б”, “Д” нарын үйлдэлд гэмт хэргийн шинж байгаа эсэх тодорхойлох

Гэмт хэрэг гэдэг нь Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.



Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэжээ.

Гэмт хэрэг нь:

- Эрүүгийн хуульд заасан үйлдэл, эс үйлдэл
- Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл
- Гэм буруутай этгээдийн үйлдэл, эс үйлдэл
- Эрүүгийн хуульд заасан ял ногдуулдаг гэсэн шинжүүдээрээ эрх зүйн бусад зөрчлөөс ялгагддаг байна

Бодлогын нөхцөлөөс харахад дараах хэд, хэдэн хууль бус үйлдлүүд байна.

Үүнд:

1. “Б”, “Д” нар нь “Ц”-гийн эд хөрөнгийг нь хууль бусаар авч, амь насыг нь хохироосон үйлдэл
2. “Б” нь “Ц”-гийн эд хөрөнгийг нь устгасан хууль бус үйлдэл
“Б”, “Д” нарын үйлдлүүд нь дээр дурьдсан гэмт хэргийн шинж агуулж байгаа тул тэднийг Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх бүрэн үндэстэй. Иймд тус бүрийнх нь бүрэлдэхүүний шинжийг тодорхойлох зайлшгүй шаардлагатай юм.

Хоёр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болон Эрүүгийн хуулийн ямар хэм хэмжээ хэрэглэгдэхийг тодорхойлох, гэмт хэргийн зүйлчлэл хийх

1. “Б”, “Д” нар нь “Ц”-гийн эд хөрөнгийг нь хууль бусаар авч, амь насыг нь хохироосон үйлдэл

Объект: “Ц”-гийн өмчлөх эрх, амь бие, эрүүл мэнд, халдашгүй байдал

Халдлагын зүйл: Бэлэн мөнгөөр 10 сая төгрөг, 5.000 америк доллар, 45.000 юань, үе дамжиж ирсэн хаш хөөрөг, 6 ширхэг их гарын мөнгөн аяга, гар утас, зургийн аппарат

Объектив тал: “Б”, “Д” нар “Ц”-ийн эд хөрөнгийг хууль бусаар авахдаа “Ц”-гийн амь насыг хохироосон идэвхтэй үйлдэл (уяагаар хоолойг нь боосон)

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай, шунахайн сэдэлтэй

Субъект: “Б”, “Д”

“Б”, “Д” нар нь “Ц”-гийн эд хөрөнгийг нь хууль бусаар авч, “Ц”-ийн амь насыг хохироосон үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйл болох “Хүнийг санаатай алах” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байгаа тул шалгаж үзье.

91 дүгээр зүйл. Хүнийг санаатай алах

91.1. Эрүүгийн хуулийн 91.2-т заасан хүндрүүлэх нөхцөл байдалгүйгээр хүнийг санаатай алсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

91.2. Хүнийг:

- 91.2.1. шунахайн сэдэлтээр;
- 91.2.2. танхайн сэдэлтээр;
- 91.2.3. өс хонзонгоор;
- 91.2.4. захиалгаар;
- 91.2.5. хохирогчийн цус, эд, эрхтэнийг ашиглах зорилгоор;
- 91.2.6. өөр гэмт хэргийг нуун далдлах буюу хялбарчлах зорилгоор;
- 91.2.7. уулгалан довтлох буюу дээрэмдэх хэргийг үйлдэхдээ;
- 91.2.8. хүн хулгайлах буюу бусдыг барьцаанд авах гэмт хэргийг үйлдэхдээ;
- 91.2.9. онц аюултай гэмт хэрэгтэн;
- 91.2.10 хүнийг санаатай алах гэмт хэргийг давтан үйлдсэн;
- 91.2.11. бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл;
- 91.2.12. онц харгис хэрцгий аргаар;
- 91.2.13. нийтэд аюултай аргаар;
- 91.2.14. хохирогчийг жирэмсэн болохыг мэдсээр байж;
- 91.2.15. хохирогчийг биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж;
- 91.2.16. хоёр буюу түүнээс олон хүнийг;
- 91.2.17. албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн үүргээ биелүүлж байгаатай нь холбогдуулан хүнийг өөрийг нь буюу түүний ойрын төрөл, садангийн хүнийг алсан бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.

“Хүнийг санаатай алах гэмт хэрэг нь бусдын амь насыг хохирооход чиглэсэн санаатай үйлдэл (эс үйлдэхүй) хийсний улмаас хүн нас барсан бөгөөд гэмт үйлдэл, амь хохирогчийн үхэл хоёрын хооронд шалтгаант холбоотой байх шинжийг заавал агуулна. Хүнийг санаатай алах гэмт хэрэг нь шууд болон шууд бус санаатай үйлдэгдэнэ” гэж Улсын Дээд Шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолд заажээ.

Объект: Хүний амьд явах эрх


Объектив тал: Бусдын амийг бүрэлгэж буй үйлдэл, эс үйлдэл түүний эцэст учирсан хор уршиг хоорондын шууд шалтгаант холбоотой

Субъектив тал: Гэм буруугийн шууд болон шууд бус санаатай

Субъект: 14 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай этгээд

Бодлогын нөхцөлд хамааралтай зарим нэг заалт, ойлголтуудыг авч үзье.

Улсын Дээд Шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолд: “Шунахай сэдэлт” гэдэгт гэмт этгээд өөртөө болон бусад этгээдэд эдийн буюу эдийн бус баялаг олж авах, эсхүл ямар нэгэн үүргийг гүйцэтгэхээс зайлсхийх гэсэн санаа зорилгыг ойлгоно. Уг сэдэлт нь гэмт хэрэг үйлдэхээс өмнө үүссэн байдаг. Шунахайн сэдэлтээр хүнийг санаатай алсан гэмт үйлдлийг



Эрүүгийн хуулийн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг гэх мэт бусад зүйл, хэсгээр давхар зүйлчлэх шаардлагагүй.

Улсын Дээд Шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолд 91.2.7 дугаар зүйлийг дараах байдлаар тайлбарласан байгаа. “Уулгалан довтолох буюу дээрэмдэх хэргийг үйлдэхдээ” гэж Эрүүгийн хуульд заасан эдгээр төрлийн гэмт хэргийг үйлдэх явцдаа хүнийг санаатай алсныг хэлнэ. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг үйлдэх явцдаа хүнийг санаатай алсан бол энэ зүйл, хэсэгт зааснаар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх бөгөөд дээрмийн гэмт хэргээр давхар зүйлчлэхгүй. Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 13 дугаар тогтоолд... дээрмийн гэмт хэргийг үйлдэхдээ хүнийг санаатай алсан бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.7-д зааснаар зүйлчлэх бөгөөд энэ тохиолдолд мөн хуулийн 147 дугаар зүйлээр давхар зүйлчлэхгүй гэжээ.

91.2.11. “... урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг...” нь Улсын Дээд Шүүхийн 2003 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 10 дугаар тогтоолд “Урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг” гэдэг нь гэмт хэрэг үйлдэж эхлэхээсээ өмнө тодорхой хэргийг хамтарч үйлдэхээр тохиролцсон байх бөгөөд харин цаашид өөр гэмт хэрэг үйлдэх санаа зорилго агуулаагүй байхыг ойлгоно. Иймд “Б”, “Д” нарын үйлдэл нь Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.11-ийг хангаж байна.

Иймд “Б”, “Д” нар нь “Ц”-ийн амь насанд халдаж, эд хөрөнгийг нь дээрэмдэн авсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.1, 91.2.7, 91.2.11-ээр зүйлчлэгдэх үндэстэй байна.

Улсын Дээд Шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолд ... “5.1. Гэмт этгээдийн үйлдэл нь уг хэсэгт заасан хоёр ба түүнээс дээш хүндрүүлэх шинжүүдийг нэгэн зэрэг агуулж байвал аль тохирох заалтуудыг давхар хэрэглэн зүйлчилнэ. Энэ тохиолдолд шүүх гэмт үйлдлийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлын талаар эрх зүйн үнэлгээ өгөхөөс бус тухайн хэсгийн заалт тус бүрээр ял оногдуулахгүй” гэжээ.

2. “Б” нь “Ц”-ийн эд хөрөнгийг нь устгасан хууль бус үйлдэл.

Объект: “Ц”-ийн өмчлөх эрх.

Халдлагын зүйл: гар утас, аппарат, мөнгөн аяга.

Объектив тал: “Б” нь гар утас, аппарат, мөнгөн аяга зэргийг устгасан идэвхтэй үйлдэл.

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай.

Субъект. “Б”.

“Б” нь “Ц”-ийн эд хөрөнгийг устгасан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйл болох “Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байгаа тул шалгаж үзье.

153 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх

153.1. Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгасан буюу гэмтээсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

153.2. Энэ гэмт хэргийг галдан шатаах буюу нийтэд аюултай бусад аргаар үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Объект: Бусдын өмчлөх эрх

Халдлагын зүйл: Бусдын өмчлөлд байгаа хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө

Объектив тал: Бусдын эд хөрөнгийг санаатай устгасан буюу гэмтээсэн идэвхтэй үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай. Хувийн сэдэлттэй

Субъект: 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд

Бусдын эд хөрөнгийг устгасан гэж түүнийг зориулалтаар нь ашиглах, эзэмших ямар ч боломжгүй болгосон, өөрөөр хэлбэл, сэргээн засварлаж болохооргүй байхыг хэлнэ.

Гэмтээсэн гэж уг эд хөрөнгийг сэргээн засварлаж болохоор байхыг хэлнэ.

Хуульд заасан хүндрүүлэх бүрэлдэхүүн бодлогын өгөгдөлд байхгүй байна.

“Б” нь “Ц”-ийн эд хөрөнгийг устгасан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйл “Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх” гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй тохирч байгаа ч дээрмийн гэмт хэргийн явцад авсан эд зүйл нь тэдний өмчид хууль бусаар бүрмөсөн шилждэг учир өөрийн өмчийн адил захиран зарцуулах боломж бүрддэг.

Иймд бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгасан, гэмтээсэн гэж үзэхгүй бөгөөд “Б”-ийн үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн үгүйсгэгдэж байна.

Гурав. Гэмт хэрэгт бэлтгэсэн, завдсан шинж байгаа эсэхийг тодорхойлох

“Б”, “Д” нар нь “Ц”-ийн эд хөрөнгийг нь хууль бусаар авч, “Ц”-ийн амь насыг хохироосон үйлдэл. Хүнийг санаатай алах гэмт хэрэг нь материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг, өөрөөр хэлбэл, үйлдэл, эс үйлдлийн улмаас хор уршиг учрах бөгөөд энэ хоёрын хооронд шалтгаант холбоотой байна. Бодлогын нөхцөлд “Б”, “Д” нар уяагаар “Ц”-ийн хүзүүг оосорлон чирч явсны улмаас “Ц” нь боолтонд нас барсан тул гэмт хэрэг төгссөн байна гэж үзнэ. Иймд уг гэмт хэрэгт бэлтгэсэн, завдсан шинж байхгүй байна.

Дөрөв. Ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 94 дүгээр зүйлтэй ялган авч үзье.

Бусдыг болгоомжгүй алах гэдэг нь уг этгээд тодорхой үйлдэл хийхгүй түүнээс болж хүний амь нас хохирч болно гэдгийг урьдчилан мэдэх ёстой байсан боловч



мэдээгүй, хайхрамжгүй хандсан, эсхүл урьдчилан мэдсэн боловч тийм хор аюулыг зайлуулж болно гэж хөнгөмсгөөр найдсанаас уг үйлдлээс учирч болох хор аюулд хүргэж бусдын амь насыг хохироосон байхыг хэлнэ.

Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйл. Хүнийг санаатай алах	Эрүүгийн хуулийн 94 дүгээр зүйл. Бусдыг болгоомжгүй алах
Объект: Хүний амьд явах эрх	Объект: Бусдын амьд явах эрх
Объектив тал: Бусдыг алсан үйлдэл, эс үйлдэл. Үүний улмаас хор уршиг учрах бөгөөл үйлдэл, эс үйлдэл, хор уршиг хоёрын хооронд шалтгаант холбоотой байна	Объектив тал: Үйлдэл, эс үйлдэл. Үүний улмаас хүний амь нас хохироосон хор уршиг учирна. Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл хүний амь хохирсон хор уршиг хоёрын хооронд шалтгаант холбоотой
Субъектив тал: Гэм буруугийн санаатай хэлбэртэй	Субъектив тал: Гэм буруугийн болгоомжгүй хэлбэртэй
Субъект: 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд	Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд

Тав. Гэмт хэрэгт хамтран оролцсон эсэхийг тодорхойлох

“Б”, “Д” нарыг гэмт хэрэг үйлдэхдээ хамтран оролцсон бөгөөд хамтран оролцох хэлбэрийн хувьд урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг гэж үзэх боломжтой. Учир нь тэд замдаа өөр мөнгөтэй айл байгаа эсэх талаар ярихад “Б” нь “Манай нутгийн “Ц” гэдэг ах хүү байдаг, мөнгөний ченж хийдэг, тэрээр их хэмжээний мөнгөө гэртээ байлгадаг, маргааш тэднийд очье” гэж тохирсон байдаг. Иймд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.3-т зааснаар урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг болно.

Зургаа. Гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал байгаа эсэхийг тодорхойлох

Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд болох аргагүй хамгаалалт, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах, гарцаагүй байдал, үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл, тушаал, захирамж биелүүлэх зэрэг нь бодлогын нөхцөлд байхгүй байна.

Долоо. Ял ногдуулах

“Б”-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 56 дугаар зүйлийн 56.1.10, 56.1.12-г журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.1, 91.2.7, 91.2.11-д заасны дагуу хариуцлага хүлээнэ.

“Д”-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 56 дугаар зүйлийн 56.1.10-г журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.1, 91.2.7, 91.2.11-д заасны дагуу ял ногдуулна.

Найм. Эрүүгийн хариуцлага ба ялаас чөлөөлөх үндэслэл буй эсэх

Бодлогын нөхцөлөөс үзэхэд “Б”, “Д” нар нь эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөгдөх үндэслэл байхгүй байна.



Бодлого 3

“О”, “Э”, “Г” нар нь бүлэглэн 2008 оны 10 дугаар сарын 14-нөөс 15-нд шилжих шөнө СБД-ийн 12 дугаар хорооны ... тоотод оршин суух БНХАУ-ын иргэн “Ж”, “П”, Монгол Улсын иргэн “М” нарыг унтаж байхад нь байшингийн цонхыг сүхээр хагалан, гартаа сүх, алх, заазуур зэргийг барин дотогш нэвтэрч ороод гэрт байсан хүмүүсийг дуугарвал ална шүү хэмээн айлган сүрдүүлж, хохирогч “Ж”-гийн ар нурууны далан тус газарт сүхнийхээ араар цохиж, “П”-ийн биеийн нурууны ар хэсэгт алхаар цохиж, дээрх хохирогчдыг дарж унаган хөл гарыг нь олсоор хүлэх зэргээр зэвсэг хэрэглэн зодож дарамтлан “Ж”, “П” нарын биед хөнгөн гэмтэл учруулжээ. “Ж”-ээс 150.000 төгрөг, 800 юань, “П”-ээс 50.000 төгрөг, 540 юань, “М”-ээс 583 сорьцын хос монетон ээмэг, 250.000 төгрөгийн үнэ бүхий бугуйн цаг 1 ширхэг, 145.000 төгрөгийн үнэ бүхий SAMSUNG маркийн гар утас 1 ширхэг зэргийг авч хохирол учруулсан байна.

Шүүгдэгч 15 настай “Г” нь “О”-ийн төрсөн дүү бөгөөд тэрээр “бага сага халтуурын ажил байна, хамт явъя” гэж хэлээд гэрээс дагуулан гарч энэ гэмт хэрэгт оролцуулсан байна.

“О” нь иргэн “Ц”-ийн хашааг давж ороод гэрийнх нь гаднаас сүх, алх, заазуур зэргийг авч үйлдэлдээ ашиглажээ. Үнэлгээний комисс эдгээрийг 98.500 төгрөгөөр үнэлсэн аж.

Шийдвэрлэх асуудал:

1. Шүүгдэгч нарын үйлдлийг зүйлчилнэ үү.
2. Ял ногдуулах журмыг тодорхойлно уу.



Зх сурвалж:

Ном, сурах бичиг, гарын авлага:

- Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (тусгай анги). УБ., 2003
- Эрдэнэбат Г. Эрдэнэбулган Ж. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал. УБ., 2004
- Хамтын бүтээл. Хууль зүйн бодлого бодох аргачлал. УБ., 2012
- Хамтын бүтээл. Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2010

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002
- УДШ-ийн 2003 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 10 дугаар тогтоол
- УДШ-ийн 2006 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 03 дугаар тогтоол
- УДШ-ийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоол
- УДШ-ийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоол
- УДШ-ийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 13 дугаар тогтоол
- УДШ-ийн 2009 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 22 дугаар тогтоол



Бодолт:

Нэг. “О”, “Э”, “Г” нарын үйлдэлд гэмт хэргийн шинж байгаа эсэх тодорхойлох

Гэмт хэрэг гэдэг нь Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасан билээ.

Гэмт хэрэг нь:

- Эрүүгийн хуульд заасан үйлдэл, эс үйлдэл;
- Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл;
- Гэм буруутай этгээдийн үйлдэл, эс үйлдэл;
- Эрүүгийн хуульд заасан ял ногдуулдаг гэсэн шинжүүдээрээ эрх зүйн бусад зөрчлөөс ялгагддаг байна.

Бодлогын нөхцөлөөс харахад дараах хэд хэдэн хууль бус үйлдлүүд байна.

Үүнд:

1. “О”, “Э”, “Г” нар нь бүлэглэн иргэн “Ж”, “П”, “М” нарын эрх чөлөөнд халдан, эд хөрөнгийг нь дээрэмдэн авсан хууль бус үйлдэл
2. “О” нь 15 настай өөрийн төрсөн дүү болох “Г”-г ”бага сага халтуурын ажил байна, хамт явъя” гэж хэлээд гэрээс дагуулан гарч энэ гэмт хэрэгт оролцуулсан хууль бус үйлдэл
3. “О” нь иргэн “Ц”-ийн хашааг давж ороод гэрийнх нь гаднаас сүх, алх, заазуур зэргийг хулгайлсан идэвхтэй үйлдэл
“О”, “Э”, “Г” нарын үйлдлүүд нь дээр дурдсан гэмт хэргийн шинж агуулж байгаа тул тэднийг Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх бүрэн үндэстэй бөгөөд бүрэлдэхүүний шинжийг тодорхойлох зайлшгүй шаардлагатай юм.

Хоёр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болон Эрүүгийн хуулийн ямар хэм хэмжээ хэрэглэгдэхийг тодорхойлж, гэмт хэргийн зүйлчлэл хийх

Дээр дурдсан үйлдэл тус бүрийн бүрэлдэхүүний шинжийг тодорхойлон шалгаж үзье.

1. “О”, “Э”, “Г” нар нь бүлэглэн иргэн “Ж”, “П”, “М” нарын эрх чөлөөнд халдан, эд хөрөнгийг нь дээрэмдэн авсан хууль бус үйлдэл

Объект: БНХАУ-ын иргэн “Ж”, “П”, “М” нарын өмчлөх эрх, эрүүл мэнд халдашгүй байдал

Объектив тал: “Ж”-ээс 150.000 төгрөг, 800 юань, “П”-ээс 50.000 төгрөг, 540 юань, “М”-ээс 583 сорьцын хос монетон ээмэг, 250.000 төгрөгийн үнэ бүхий бугуйн цаг 1 ширхэг, 145.000 төгрөгийн үнэ бүхий Samsung маркийн гар утас 1 ширхэг зэргийг дээрэмдсэн идэвхтэй үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай, шунахай сэдэлтгэй

Субъект: Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай “О”, “Э”, “Г”

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

“О”, “Э”, “Г” нар нь бүлэглэн СБД-ийн 12 хорооны тоотод оршин суугч БНХАУ-ын иргэн “Ж”, “П”, Монгол Улсын иргэн “М” нарын эд хөрөнгийг нь дээрэмдэн авсан хууль бус үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147 дугаар зүйл “Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байна.

147 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх

147.1. Бусдын эд хөрөнгийг авах зорилгоор амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

147.2. Энэ хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, урьд энэ гэмт хэрэгт болон булаах, далайлган сүрдүүлэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, эсхүл зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэсэн, энэ хэргийн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

147.3. Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, урьд нь уулгалан довтолох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол, бусдын бие махбодод хүнд гэмтэл учирсан бол эд хөрөнгийг хурааж арваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 13 дугаар тогтоолд “Дээрэмдэх” гэдэгт бусдын эд хөрөнгийг хууль бусаар авахад саад болж байгаа аливаа этгээд (өмчлөгч буюу эзэмшигч, итгэмжлэгдэн хариуцсан болон хамгаалах үүрэг бүхий этгээд гэх мэт) рүү амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон аливаа идэвхтэй үйлдлийг ойлгоно гэжээ.

Объект: Бусдын өмчлөх эрх. Эрүүл мэнд, халдашгүй байдал нэмэгдэл объект болно.

Халдлагын зүйл: Бусдын өмчлөлийн эд зүйл


Объектив тал: Бусдын эд хөрөнгийг авах зорилгоор амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон идэвхтэй үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай, шунахай сэдэлттэй

Субъект: 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, тухайн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхгүй Монгол Улсын иргэн, гадаад улсын харьяат, харьяалалгүй этгээд байж болно.

Бодлогын нөхцөлд хамааралтай зарим нэг ойлголтыг авч үзье.

Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 13 дугаар тогтоолд “Амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж” гэдэгт хохирогчийн эсэргүүцлийг дарахад чиглэгдсэн бие махбодын хүчирхийллийн аливаа үйлдэл хийснийг ойлгоно. Хүч хэрэглэсэн тухайн үйлдлийн улмаас бусдын бие махбодод хор уршиг бодитойгоор учраагүй боловч хүч хэрэглэсэн арга нь (хоолой боох, хохирогчийн толгойг усанд удаан дүрэх, өндөр дээрээс түлхэх гэх мэт) хохирогчийн амь биед нь аюултай нөхцөл байдал бий болгохоор байсан бол дээрх ойлголтод хамааруулж үзнэ. Түүнчлэн гэмт халдлагын улмаас хохирогчийн бие



махбодод хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол “амь биед нь аюултайгаар хүч хэрэглэсэн” гэдэгт хамаарах бөгөөд “Дээрэмдэх” гэмт хэргийг үйлдэхдээ бусдын бие махбодод хөнгөн, хүндэвтэр гэмтэл учруулсан бол Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлийн аль тохирох хэсгээр, хүнд гэмтэл учруулсан бол мөн зүйлийн 147.3-т зааснаар тус тус зүйлчлэхээр заажээ.

Бодлогын нөхцөлд иргэн “Ж”, “П” нарын биед хөнгөн гэмтэл учруулсан билээ. Ингэж гэмтэл учруулахдаа сүх, алх зэрэг зэвсгийн чанартай зүйл ашигласан байна.

Улсын Дээд Шүүхийн 2006 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 3 дугаар тогтоолд “Зэвсгийн чанартай бусад зүйл” гэдэгт ахуйн болон аж ахуйн зориулалт бүхий (тухайлбал, хайч, сэрээ, сүх, хөрөө, халив-отвёртка, хүрз, өрөм, лоом, гал тогооны болон сахлын хутга гэх мэт), эсхүл хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулж болох (тухайлбал, бороохой, ташуур, мод, төмөр, чулуу, шил, зодооны хэрэгсэл, бүх төрлийн химийн шингэн ба хатуу бодис гэх мэт) эд зүйл, хэрэгслийг ойлгоно хэмээн заасан.

Дээрмийн гэмт хэрэг үйлдэхдээ “О”, “Э”, “Г” нар санаатайгаар хүчээ нэгтгэн гэмт хэрэг үйлдсэн байгаа, энэ нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.3-т заасан урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг гэж үзэхээр байна.

Иймд бусдын эд хөрөнгийг дээрэмдэж, бусдад хөнгөн гэмтэл учруулсан “О”, “Э”, “Г” нарын үйлдэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147 дугаар зүйлийн 147.2-т заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангаж байгаа тул энэхүү зүйлээр зүйлчлэгдэх үндэслэлтэй байна.

2. “О” нь 15 настай өөрийн төрсөн дүү болох “Г”-г “бага сага халгуурын ажил байна, хамт явъя” гэж хэлээд гэрээс дагуулан гарч энэ гэмт хэрэгт оролцуулсан хууль бус үйлдэл

Объект: “Г”-ийн эрх, ашиг сонирхол

Объектив тал: “О” нь өөрийн төрсөн дүү болох “Г”-г гэмт хэрэгт татан оролцуулсан үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай

Субъект: “О”

“О” нь өөрийн төрсөн дүү болох “Г”-г гэмт хэрэгт татан оролцуулсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 114 дүгээр зүйл болох “Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байгаа тул шалгаж үзье.

114 дүгээр зүйл. Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах

114.1. Насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэхэд татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

114.2. Энэ хэргийг насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч үйлдсэн бол хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

114.3. Насанд хүрээгүй хүнийг зохион байгуулалттай бүлэг буюу гэмт бүлэглэлд элсүүлсэн, эсхүл онц хүнд гэмт хэрэгт татан оруулсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Объект: Насанд хүрээгүй хүний эрх, ашиг сонирхол

Объектив тал: Насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэхэд татан оролцуулсан идэвхтэй үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай

Субъект: 18 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд

Хууран мэхлэх нь насанд хүрээгүй хүний сэтгэлгээг ашиглан тухайн үйлдлийг гэмт хэрэг биш нийгэмд ашигтай үйлдэл гэх буюу ямар нэг зүйлийн болзол амлах зэрэг хэлбэртэй байдаг.

Улсын Дээд Шүүхийн 2009 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 22 дугаар тогтоолд: “Эрүүгийн хуулийн 114 дүгээр зүйлийн 114.1-д заасан “бусад арга” гэдэгт эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулахаас гадна агаархал төрүүлэх, өс хонзон сануулах, уур хорслыг дэвэргэх, ятган үнэмшүүлэх, итгэмтгий гэнэн занг ашиглах зэргийг хамааруулж үзнэ” гэжээ.

Иймд “О”-ийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 114 дүгээр зүйлийн 114.1-д зааснаар зүйлчилнэ.

3. “О” нь иргэн Ц-ийн хашааг давж ороод гэрийнх нь гаднаас сүх, алх, заазуур зэргийг хулгайлсан идэвхтэй үйлдэл

Объект: “Ц”-ийн өмчлөх эрх

Объектив тал: “Ц”-ийн эд зүйлсийг авсан идэвхтэй үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай, шунахай сэдэлттэй

Субъект: “О”

“О” нь “Ц”-ийн эд зүйлийг авсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйл болох “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байгаа тул шалгаж үзье.



145 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хулгайлах

145.1. Бусдын эд хөрөнгийг хулгайлсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөрөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

145.2. Энэ гэмт хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж буюу орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, олон тооны мал хулгайлсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөрөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

145.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хохирогчийг амьдралын эс үүсвэрээс нь салгасан буюу их хэмжээний хохирол учирсан, түүнчлэн нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулж үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуун дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөрөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

145.4. Энэ хэргийг булаах, дээрэмдэх, уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтэн, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Улсын Дээд Шүүхийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолд “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” гэдэгт бусдын эд хөрөнгийг нууц, далд аргаар, шунахай сэдэлтээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авч, бүрмөсөн, үнэ төлбөргүй өөрийн өмчийн адил захиран зарцуулах боломж бүрдүүлсэн буюу захиран зарцуулсан шууд санаатай үйлдлийг ойлгоно.

Объект: Бусдын өмчлөх эрх

Халдлагын зүйл: Эд юмс, мөнгө төгрөг

Объектив тал: Бусдын эзэмшилд байгаа эд юмсыг нууц далд, сэм аргаар өөрийн эзэмшилд авсан идэвхтэй үйлдэл

Субъектив тал: Бусдын эд хөрөнгийг зөвшөөрөлгүйгээр хулгайлан авч байгаагаа мэдэж хүсэж үйлддэг гэм буруугийн шууд санаатай, шунахай сэдэлтэй

Субъект: 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, тухайн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхгүй Монгол Улсын иргэн, гадаад улсын харьяат, харьяалалгүй этгээд байж болно.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.1-д хохирлын хэмжээг тодорхой заасан байдаг билээ. Өөрөөр хэлбэл, бага бус хэмжээний хохирол учирсан байхыг шаарддаг. Бага бус хэмжээ гэдгийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг” хэлнэ. Энэ нь 140.400-702.000 (Засгийн Газрын тогтоолоор 2011 оны 4 дүгээр сарын 1-нээс) төгрөг болно.

Бодлогын нөхцөлд иргэн “Ц”-д 98.000 төгрөгийн хохирол учирсан. Иймд “О”-ийн үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн гэмт хэргийн бүрэлдэхүүн байхгүй байгаа тул гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхгүй.

Гурав. Гэмт хэрэгт бэлтгэсэн, завдсан шинж байгаа эсэхийг тодорхойлох

1. “О”, “Э”, “Г” нар нь бүлэглэн иргэн “Ж”, “П”, “М” нарын эрх чөлөөнд халдан, эд хөрөнгийг нь дээрэмдэн авсан хууль бус үйлдэл. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй. Довтолгоон хийгдсэнээр төгсдөг тул “О”, “Э”, “Г” нарын үйлдлийг төгссөн гэж үзэх бүрэн үндэстэй.
2. “О” нь 15 настай өөрийн төрсөн дүү болох “Г”-г “бага сага халтуурын ажил байна, хамт явъя” гэж хэлээд гэрээс дагуулан гарч энэ гэмт хэрэгт оролцуулсан хууль бус үйлдэл. Уг гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй, насанд хүрээгүй этгээдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулснаар гэмт хэрэг төгсөх тул “О” үйлдлийг төгссөн гэмт хэрэг гэж үзнэ.

Иймд дээрх үйлдлүүдэд гэмт хэрэгт бэлтгэсэн, завдсан шинж байхгүй байна.

Дөрөв. Ойролцоо төрлийн гэмт хэргээс ялгах

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147 дугаар зүйлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 146 дугаар зүйлтэй ялган авч үзье.

Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг булаах
Объект: Бусдын өмчлөх эрх	Объект: Бусдын өмчлөх эрх
Объектив тал: Бусдын эд хөрөнгийг авах зорилгоор амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон идэвхтэй үйлдэл. Дээрэмдэх гэмт хэргийн хувьд хүчирхийлэл, довтолгоон нь тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний үндсэн шинж нь болж, халдлагад өргөж байгаа этгээд руу шууд чиглэсэн байна. Дээрэмдэх нь бусдын эд хөрөнгийг авч чадсан эсэхээс үл хамаарч хүч хэрэглэсэн буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолгоон хийснээр төгсдөг.	Объектив тал: Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр булаасан идэвхтэй үйлдэл. Булаах гэмт хэргийг үйлдэхэд хохирогчид ямар нэгэн хүч хэрэглэдэггүй бөгөөд үйлдэл төгсмөгц хохирогчоос зугтах, холдох шинжтэй байна. Булаах нь бусдын эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгч болон эзэмшигч, хариуцсан, эсхүл хамгаалах үүрэг бүхий этгээдээс өөртөө шилжүүлэн авснаар төгсдөг.
Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай. Шунахай сэдэлттэй	Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай. Шунахай сэдэлттэй
Субъект: 14 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай этгээд	Субъект: 14 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай этгээд



2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 114 дүгээр зүйлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 115 дугаар зүйлтэй ялган авч үзье.

Эрүүгийн хуулийн 114 дүгээр зүйл. Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах	Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах
Объект: Насанд хүрээгүй хүний эрх, ашиг сонирхол	Объект: Насанд хүрээгүй хүний эрх, ашиг сонирхол
Объектив тал: Насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэхэд татан оролцуулах үйлдэл, эс үйлдэл	Объектив тал: Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлал болон биеэ үнэлэхэд татан оруулахад чиглэгдсэн үйлдэл, эс үйлдэл
Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай	Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай
Субъект: 18 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд	Субъект: 18 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд

Тав. Гэмт хэрэгт хамтран оролцсон эсэхийг тодорхойлох

Эхний тохиолдол болох бусдын эд хөрөнгийг дээрэмдэх үйлдэлд гэмт хэрэгт хамтран оролцсон байна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.3: Гэмт хэрэг хамтран үйлдэх талаар урьдчилан үгсэж тохиролцсон хоёр буюу түүнээс дээш этгээдийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг гэнэ.

Улсын Дээд Шүүхийн 2003 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 10 дугаар тогтоолд “Урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг” гэдэг нь гэмт хэрэг үйлдэж эхлэхээсээ өмнө тодорхой хэргийг хамтарч үйлдэхээр тохиролцсон байх бөгөөд харин цаашид өөр гэмт хэрэг үйлдэх санаа зорилго агуулаагүй байхыг ойлгоно. Иймд “О”, “Э”, “Г” нарыг гэмт хэрэг үйлдэхдээ урьдчилан тохиролцсон байна гэж үзнэ.

Хоёр дахь үйлдэлд гэмт хэрэгт хамтран оролцсон шинж байхгүй байна.

Зургаа. Гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал байгаа эсэхийг тодорхойлох

Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд болох аргагүй хамгаалалт, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах, гарцаагүй байдал, үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл, тушаал, захирамж биелүүлэх зэрэг нь бодлогын нөхцөлд байхгүй байна.

Долоо. Ял ногдуулах

Иймд “О”-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1-г журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 114 дүгээр зүйлийн 114.1, 147 дугаар зүйлийн 147.2-д заасан гэмт хэрэгт яллагдах бүрэн үндэстэй.

“Э”-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147 дугаар зүйлийн 147.2-д заасны дагуу хариуцлага хүлээнэ.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

“Г”-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 55 дугаар зүйлийн 55.1.7-г журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147 дугаар зүйлийн 147.2-д заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Найм. Эрүүгийн хариуцлага ба ялаас чөлөөлөх

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэлгүй байна. Харин 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн “Өршөөл үзүүлэх тухай” хуульд зааснаар:

4.1. Гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн дор дурдсан ялтны шүүхээс оногдуулсан ялын хугацааг харгалзахгүйгээр эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ: 4.1.1. арван найман насанд хүрээгүй байхдаа үйлдсэн гэмт хэрэгт ял эдэлж байгаа ...

Иймд “Г”-г өршөөлөөр ялаас чөлөөлөх боломжтой.



Бодлого 4

“М” гэгч нь бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдэж 2007.05.07-нд шүүхээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дүгээр зүйлийн 145.2.-т зааснаар гурван жил нэг сарын хорих ял шийтгүүлж уг ялаа жирийн дэглэмтэй хорих ангид эдлэж байсан. Тэрээр ялаа эдлээд 8 сар болсны дараа гадуур ажиллаж байхдаа хорих ангиас оргосон байна. Замдаа Улаанбаатар хот орохын тулд жолооч “Г”-тэй уулзан түүнд 30.000 төгрөг өгөхөөр тохиролцож 22 цагийн орчим хот орохоор явсан. Зам зуураа тэрээр “Г”-д хутга тулган айлган сүрдүүлж хөдөө хээр буулган өөрөө машиныг авч явсан. Тэрээр Баянзүрх товчооны орчим “Г”-ийн машиныг нь орхиж явганаар хот орж ирсэн. Хотод ирсэн даруйдаа хамт ял эдлэж байсан “О” гэгчийнд очиж, хорих газраас оргож яваагаа хэлсэн бөгөөд тэднийд 2 хоножээ. Энэ хугацаанд “О”-той хамт гадуур явж архи ууж согтууран дахин танхайрах гэмт хэрэг үйлдэн иргэн “Х”-ийн биед хөнгөн гэмтэл учруулсан байна.

Шийдвэрлэх асуудал:

1. Шүүгдэгч нарын үйлдлийг зүйлчилнэ үү.
2. Ял ногдуулах журмыг тодорхойлно уу.



Эх сурвалж:

Ном, сурах бичиг, гарын авлага:

- Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (тусгай анги). УБ., 2003
- Эрдэнэбат Г. Эрдэнэбулган Ж. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал. УБ., 2004
- Хамтын бүтээл. Эрүүгийн хуулийн тайлбар.

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002
- УДШ-ийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 27 дугаар тогтоол
- Өршөөл үзүүлэх тухай хууль. УБ., 2009

Нэг. “М”, “О” нарын үйлдэлд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тодорхойлох

Гэмт хэрэг гэдэг нь Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д зааснаар Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй.

Гэмт хэрэг нь:

- Эрүүгийн хуульд заасан үйлдэл, эс үйлдэл;
- Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл;
- Гэм буруутай этгээдийн үйлдэл, эс үйлдэл;

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

- Эрүүгийн хуульд заасан ял ногдуулдаг гэсэн шинжүүдээрээ эрх зүйн бусад зөрчлөөс ялгагддаг байна.

Бодлогын нөхцөлөөс харахад дараах хэд хэдэн хууль бус үйлдлүүд байна.

Үүнд:

1. “М” нь хорих ангиас оргосон үйлдэл
2. “М” нь жолооч “Г”-гийн авто тээврийн хэрэгслийг авч явсан хууль бус үйлдэл
3. “О” нь “М”-ийн гэмт үйлдлийн талаар үл мэдээлсэн эс үйлдэл
4. “М” нь “О”-тэй нийлэн танхайрч иргэн “Х”-гийн биед хөнгөн гэмтэл учруулсан үйлдэл

“М”, “О” нарын үйлдлүүд нь дээр дурьдсан гэмт хэргийн шинжийг агуулж байх тул тэднийг Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх бүрэн үндэстэй. Иймд бүрэлдэхүүний шинжийг тодорхойлох зайлшгүй шаардлагатай.

Хоёр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болон Эрүүгийн хуулийн ямар хэм хэмжээ хэрэглэгдэхийг тодорхойлох, гэмт хэргийн зүйлчлэл хийх

Дээр дурьдсан үйлдэл тус бүрээр нь авч үзье.

1. “М” нь хорих ангиас оргосон үйлдэл

Объект: Хорих ангийн хэвийн ажиллагаа

Объектив тал: “М” нь хорих ангиас оргосон идэвхтэй үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай

Субъект: Хорих ял эдэлж байсан “М”

“М” нь хорих ангиас оргосон үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 261 дүгээр зүйл болох “Прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргох” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байгаа тул бүрэлдэхүүнийг шалгаж үзье.

261 дүгээр зүйл. Прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргох

261.1. Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргосон, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанаас зориуд зайлсхийсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.


261.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн, эсхүл харуул манаанд зэвсэг, хүч хэрэглэж буюу хорих ангийн байрилга байгууламж, хамгаалалтын тоног төхөөрөмжийг эвдэж оргосон бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Объект: Прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангийн хэвийн ажиллагаа

Объектив тал: Прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргох, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанаас зориуд зайлсхийсэн үйлдэл, эс үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай. Зайлсхийх, оргох гэсэн зорилготой

Субъект: Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан



Ялтан “М” нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 261 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй нийцэж байгаа тул эрүүгийн хариуцлага ногдуулж болохоор байна. Иймд “М”-ийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 261 дүгээр зүйлийн 261.1-д зааснаар зүйлчилнэ.

2. “М” нь жолооч “Г”-гийн авто тээврийн хэрэгслийг авч явсан хууль бус үйлдэл

Объект: “Г”-гийн авто тээврийн хэрэгсэл өмчлөх эрх

Халдлагын зүйл: “Г”-гийн авто тээврийн хэрэгсэл

Объектив тал: “М” нь “Г”-д хутга тулган айлган сүрдүүлж хөдөө хээр буулган өөрөө машиныг авч явсан үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай

Субъект: Ялтан “М”

“М” нь иргэн “Г”-гийн авто тээврийн хэрэгслийг авч зугтаасан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 223 дугаар зүйл болох “Авто тээврийн хэрэгслийг авч зугтаах” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байгаа тул бүрэлдэхүүнийг шалгаж үзье.

223 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийг авч зугтаах

223.1. Авто тээврийн хэрэгслийг ашиглан шамшигдуулах зорилгогүйгээр авч зугтаасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

223.2. Энэ хэргийг давтан буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн, түүнчлэн хохирогчийн амь бие, эрүүл мэндэд аюулгүйгээр хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

223.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл хохирогчийн амь бие, эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж үйлдсэн бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Объект: Хөдөлгөөний аюулгүй байдал, бусдын өмчлөх эрх нэмэгдэл объект болно

Объектив тал: Авто тээврийн хэрэгслийг ашиглан шамшигдуулах зорилгогүйгээр авч зугтаасан үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн санаатай хэлбэр. Шунахай зорилгогүй, хөл дайх, унах гэсэн зорилготой

Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд

Улсын Дээд Шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолд “Хүч хэрэглэхээр заналхийлж” гэдэгт бусдыг айлган сүрдүүлэх зорилгоор хийсэн сэтгэл санааны хүчирхийллийг ойлгоно. Энэхүү хүчирхийлэл нь идэвхтэй үйлдлээр илрэх бөгөөд гэмт этгээд үүнийг үгээр илэрхийлэхээс гадна биет байдлаар үзүүлсэн байж болно. Бодлогын нөхцөлд “М” жолооч “Г”-д хутга тулган айлган сүрдүүлж, авто тээврийн хэрэгслийг авч явсан байгаа нь хүч хэрэглэхээр заналхийсэн гэж ойлгоно.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

“М” нь иргэн “Г”-гийн авто тээврийн хэрэгслийг авч зугтаасан нь Эрүүгийн хуулийн 223 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй нийцэж байгаа тул эрүүгийн хариуцлага ногдуулж болохоор байна. Иймд “Л”-ийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 223 дугаар зүйлийн 223.2-д зааснаар зүйлчилнэ.

3. “О” нь “М”-ийн гэмт үйлдлийн талаар үл мэдээлсэн эс үйлдэл

Объект: Гэмт хэргийн таслан зогсоох талаарх байгууллагын хэвийн ажиллагаа

Объектив тал: “О” нь “М”-ийн хорих ангиас оргож явааг эрх бүхий байгууллагад мэдээлээгүй эс үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай

Субъект: “О”

“О” нь “М”-ийг хорих ангиас оргож явааг эрх бүхий байгууллагад мэдээлээгүй эс үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 246 дугаар зүйл болох “Гэмт хэргийг үл мэдээлэх” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байгаа тул бүрэлдэхүүнийг шалгаж үзье.

246 дугаар зүйл. Гэмт хэргийг үл мэдээлэх

246.1. Энэ хуулийн тусгай ангийн 87.2, 91, 96, 108, 112, 126.2, 126.3, 145.2, 145.3, 145.4, 146.2, 146.3, 146.4, 148.2, 148.3, 148.4, 150.2, 150.3, 147, 176, 177, 1781, 225, 268.2, 269.2, 270.2-г заасан гэмт хэргийг үйлдэхээр бэлтгэж байгаа буюу үйлдсэнийг лавтай сайн мэдсэн атлаа зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

246.2. Энэ хуулийн тусгайн ангийн 79, 80, 81, 82, 84, 85 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдэхээр бэлтгэж байгаа буюу үйлдсэнийг лавтай сайн мэдсэн атлаа зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Объект: Гэмт хэрэг таслан зогсоох талаар эрх бүхий байгууллагын хэвийн ажиллагаа

Объектив тал: 246 дугаар зүйл, хэсгүүдэд нэрлэж заасан хүнд гэмт хэргүүдийг үйлдэхээр бэлтгэж байгаа буюу үйлдсэн болохыг лавтай сайн мэдсэн атлаа зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй эс үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай, гэмт хэргийг үл мэдээлэх гэсэн зорилготой

Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд

“О” нь “М”-ийн хорих ангиас оргож явааг эрх бүхий байгууллагад мэдээлээгүй эс үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 246 дугаар зүйлд нэрлэн заасан гэмт хэргийн жагсаалтад ороогүй учир “О”-ийн үйлдэлд гэмт хэргийн шинж үгүйсгэгдэж байна.

4. “М” нь “О”-той нийлэн танхайрч иргэн “Х”-гийн биед хөнгөн гэмтэл учруулсан үйлдэл

Объект: Нийгмийн аюулгүй байдал, хэв журам, “Х”-гийн эрүүл мэнд, халдашгүй байдал



Объектив тал: “М” нь “О”-той хамтран танхайрч, иргэн “Х”-гийн биед хөнгөн гэмтэл учруулсан үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай

Субъект: “М”, “О”

“М” нь “О” гэгчтэй хамтран танхайрч, иргэн “Х”-гийн биед хөнгөн гэмтэл учруулсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйл болох “Танхайрах” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байгаа тул бүрэлдэхүүнийг шалгаж үзье.

181 дүгээр зүйл. Танхайрах

181.1. Бусдыг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг ноцтой зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

181.2. Энэ хэргийг:

181.2.1. догшин авирлаж

181.2.2. нийгмийн хэв журам хамгаалах үүргээ биелүүлж байгаа цагдаагийн ажилтан, төрийн болон олон нийтийн төлөөлөгч, танхайрсан үйлдлийг таслан зогсоох гэсэн иргэнийг эсэргүүцэж

181.2.3. урьд нь энэ хэрэгт шийтгүүлсэн этгээд

181.2.4. давтан

181.2.5. бүлэглэж үйлдсэн бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

181.2.3. Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэж үйлдсэн бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Объект: Нийгмийн хэв журам, нэмэгдэл объект нь хүний нэр төр, алдар хүнд, халдашгүй байдал

Объектив тал: Бусдыг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг зөрчсөн идэвхтэй үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай бөгөөд зөвхөн танхайрах сэдэлттэй

Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйлийн 181.3-д бол 14 насанд хүрсэн этгээд байна)

Бодлогын нөхцөлд хамааралтай зарим нэг ойлголтуудыг Улсын Дээд Шүүхийн тогтоолд хэрхэн тайлбарласныг нь авч үзье.

Улсын Дээд Шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолд:

“**Хүч хэрэглэх**” гэж бие махбодийн хүчирхийлэл хийхэд чиглэгдсэн аливаа идэвхтэй үйлдлийг хэлнэ.

“**Хүч хэрэглэхээр заналхийлэх**” гэдэгт бусдыг айлган сүрдүүлэх зорилгоор хийсэн сэтгэл санааны хүчирхийллийг ойлгоно. Энэхүү хүчирхийлэл нь идэвхтэй

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

Үйлдлээр илрэх бөгөөд гэмт этгээд үүнийг үгээр илэрхийлэхээс гадна биет байдлаар үзүүлсэн байж болно.

“Догшин авирлаж” гэж олон нийтийг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн үйлдлийг ичгүүр сонжуургүй авирлаж, харгис хэрцгий аргаар, зориуд удтал үргэлжлүүлэн хийсэн байхыг хэлнэ. Түүнчлэн танхайрах явцдаа бусдын бие махбодод хөнгөн, хүндэвтэр гэмтэл учруулсан, эд хөрөнгийг устгасан, гэмтээсэн зэргийг догшин авирласан гэж үзнэ.

Эндээс үзвэл “М”-ийн “О”-той хамтран танхайрч иргэн “Х”-гийн биед хөнгөн гэмтэл учруулсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй нийцэж байгаа тул эрүүгийн хариуцлага ногдуулж болохоор байна. Иймд “Л”, “О” нарын үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйлийн 181.2-д зааснаар зүйлчилнэ.

Гурав. Гэмт хэрэгт бэлтгэсэн, завдсан шинж байгаа эсэхийг тодорхойлох

1. “М” нь хорих ангиас оргосон үйлдэл. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 261 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй, өөрөөр хэлбэл, үйлдэл хийснээр төгсдөг. Иймд “М” нь оргосон үйлдэлд гэмт хэрэгт бэлтгэсэн, завдсан шинж байхгүй.
2. “М” нь жолооч “Г”-гийн авто тээврийн хэрэгслийг авч явсан хууль бус үйлдэл. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 223 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд үйлдэл хийснээр төгсөнө. Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй. Иймд “М”-ийн авто тээврийн хэрэгсэл авч зугтсан үйлдэл нь төгссөн гэмт хэрэг болно.
3. “М” нь “О”-тэй нийлэн танхайрч иргэн “Х”-гийн биед хөнгөн гэмтэл учруулсан үйлдэл. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй бөгөөд “М”-ийн “О”-той хамтран үйлдсэн гэмт хэрэг нь төгссөн байна.

Дөрөв. Ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 261 дүгээр зүйлийг Эрүүгийн хуулийн тусгай 262 дугаар зүйлтэй ялган авч үзье.

Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйл. Прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргох	Эрүүгийн хуулийн 262 дугаар зүйл. Хорих ял эдлэхээс зайлсхийх
Объект: Прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангийн хэвийн ажиллагаа	Объект: Хорих ял эдлүүлэх журам, хорих ангийн хэвийн ажиллагаа
Объектив тал: Прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргох, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанаас зориуд зайлсхийсэн үйлдэл, эс үйлдэл	Объектив тал: Түр чөлөөгөөр явсан ялтан тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хорих ангидаа буцаж ирэлгүй ял эдлэхээс зайлсхийсэн эс үйлдэл



Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай. Зайлсхийх, оргох гэсэн зорилготой	Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай. Хорих ял эдлэхээс зайлсхийх гэсэн зорилготой
Субъект: Сэжигтэн, яллагагч, шүүгдэгч, ялтан	Субъект: Түр чөлөөгөөр яваад ирээгүй ялтан

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 223 дугаар зүйлийн 223.2-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147 дугаар зүйлтэй ялган авч үзье.

Эрүүгийн хуулийн 223 дугаар зүйлийн 223.2. Авто тээврийн хэрэгслийг авч зугтаах	Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх
Объект: Хөдөлгөөний аюулгүй байдал, бусдын өмчлөх эрх нэмэгдэл объект болно	Объект: Бусдын өмчлөх эрх Халдагын зүйл: Материаллаг эд зүйлс
Объектив тал: Авто тээврийн хэрэгслийг ашиглан шамшигдуулах зорилгогүйгээр авч зугтаахдаа хохирогчийн амь бие, эрүүл мэндэд аюулгүйгээр хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн үйлдэл	Объектив тал: Бусдын эд хөрөнгийг авах зорилгоор амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон идэвхтэй үйлдэл
Субъектив тал: Гэм буруугийн санаатай хэлбэр. Шунахай зорилгогүй, хөл дайх, унах гэсэн зорилготой	Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай. Шунахай сэдэлтгэй
Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд	Субъект: 14 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай этгээд

3. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 99 дүгээр зүйлтэй ялган авч үзье.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйл. Танхайрах	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 99 дүгээр зүйл. Бусдын бие махбодод хөнгөн гэмтэл санаатай учруулах
Объект: Нийгмийн хэв журам, нэмэгдэл объект нь хүний нэр төр, алдар хүнд, халдашгүй байдал	Объект: Бусдын эрүүл мэнд Халдлагын зүйл: Бусад хүний бие махбодь
Объектив тал: Бусдыг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг зөрчсөн идэвхтэй үйлдэл	Объектив тал: Бусдын бие махбодод хөнгөн гэмтэл санаатай учруулсан үйлдэл, эс үйлдэл. Уг үйлдэл, эс үйлдлийн улмаас гэмтэл учрах бөгөөд энэ хоёр хоорондоо шалтгаант холбоотой

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай бөгөөд зөвхөн танхайрах сэдэлттэй	Субъектив тал: Гэм буруугийн санаатай хэлбэртэй. Хувийн сэдэлттэй
Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйлийн 181.3-д бол 14 насанд хүрсэн этгээд байна)	Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд

Тав. Гэмт хэрэгт хамтран оролцсон эсэхийг тодорхойлох

1. “М” нь хорих ангиас оргосон үйлдэл
2. “М” нь жолооч “Г”-гийн авто тээврийн хэрэгслийг авч зугтаасан хууль бус үйлдэл
3. “М” нь “О”-тэй нийлэн танхайрч иргэн “Х”-гийн биед хөнгөн гэмтэл учруулсан үйлдэл

Эхний хоёр үйлдэлд бусадтай хамтарсан шинж байхгүй байна.

Харин “М” нь “О”-той хамтран танхайрч иргэн “Х”-гийн биед хөнгөн гэмтэл учруулсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2-д зааснаар бүлэглэн гүйцэтгэгч болно. Бүлэглэн гүйцэтгэгч гэдэгт хоёр буюу түүнээс дээш этгээд урьдчилан үгсэж тохиролцоогүй боловч гэмт хэрэг үйлдэхдээ санаатай нэгдсэнийг ойлгоно.

Зургаа. Гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал байгаа эсэхийг тодорхойлох

Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд болох аргагүй хамгаалалт, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах, гарцаагүй байдал, үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл, тушаал, захирамж биелүүлэх зэрэг нь бодлогын нөхцөлд байхгүй байна.

Долоо. Ял ногдуулах

“М”-ийн хувьд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 56 дугаар зүйлийн 56.1.10, 58 дугаар зүйлийн 58.1-д заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 261 дүгээр зүйлийн 261.1, 223 дугаар зүйлийн 223.1.2, 181 дүгээр зүйлийн 181.2.1, 181.2.5-д зааснаар, харин “О”-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 56 дугаар зүйлийн 56.1.10-ыг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйлийн 181.2.1, 181.2.5-д зааснаар ял ногдуулна.

Найм. Эрүүгийн хариуцлага ба ялаас чөлөөлөх

Бодлогын нөхцөлөөс үзэхэд “М”-ийг эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөгдөх үндэслэл байхгүй байна.

Харин “О”-гийн хувьд 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан “Өршөөл үзүүлэх тухай” хуулиар өршөөлд хамруулах боломжтой юм. Уг хуулийн 4.4-д “... түүнчлэн хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж, анх удаа хорих ял шийтгүүлсэн ялтны эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ” гэж заасан билээ.



Бодлого 5

Иргэн “Ж” нь хамт ажилладаг “Ө”-д 5.000 мянган ам долларыг 2 сарын хугацаатай зээлдсэн байна. Зээлийн хугацаа өнгөрч “Ж” нь “Ө”-өөс мөнгөө эргүүлж өгөхийг удаа дараа шаардсан боловч “Ө” нь зээлсэн мөнгөө өгнө гэж худал хэлсээр дахин 2 сарын хугацаа өнгөрсөн бөгөөд сүүлдээ “Ө” нь “Ж”-д олдохоо больсон байна. “Ө”-г найз “А”-ийн гэрт байж байгаа гэсэн сургаар “Ж” нь өөрийн танил болох цагдаа ажилтай “Х”-г дагуулан шөнийн 23 цагийн орчим “А”-ийнд очиж хаалгаа тавьж өгөхийг шаардсан байна. Энэ үеэр “А” нь ямар асуудлаар явж байгаа талаар асууж хаалгаа тавьж өгөөгүй тул “Ж”, “Х” нар нь хаалгыг нь эвдэж “А”-ийн гэрт нэвтрэн ороход тэдний гэрт “Ө” байхгүй байжээ. “Ж” уурлан “А”-г “Ө”-тэй хуйвалдаж байна гээд хананд өлгөөтэй байсан “SONY” телевизорыг нь хагалан 1.200.000 төгрөгийн хохирол учруулсан байна. Иргэн “А” нь “Ж” болон цагдаа “Х” нарын үйл ажиллагааны талаар гомдол гаргасан байна.

Шийдвэрлэх асуудал:

1. Шүүгдэгч нарын үйлдлийг зүйлчилнэ үү.
2. Ял ногдуулах журмыг тодорхойлно уу.



Эх сурвалж:

Ном, сурах бичиг, гарын авлага:

- Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (тусгай анги). УБ., 2003
- Эрдэнэбат Г. Эрдэнэбулган Ж. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал. УБ., 2004
- Хамтын бүтээл. Эрүүгийн хуулийн тайлбар.

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992
- Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002
- УДШ-ийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоол
- УДШ-ийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоол
- УДШ-ийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 16 дугаар тогтоол

Бодолт:

Нэг. “Ж”, “Х” нарын үйлдэлд гэмт хэргийн шинж байгаа эсэх

Гэмт хэрэг гэдэг нь Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.

Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасан билээ.

Гэмт хэрэг нь:

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

- Эрүүгийн хуульд заасан үйлдэл, эс үйлдэл;
- Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл;
- Гэм буруутай этгээдийн үйлдэл, эс үйлдэл;
- Эрүүгийн хуульд заасан ял ногдуулдаг гэсэн шинжүүдээрээ эрх зүйн бусад зөрчлөөс ялгагддаг байна.

Бодлогын нөхцөлөөс харахад дараах хэд, хэдэн хууль бус үйлдлүүд байна.

Үүнд:

1. “Ж”, “Х” нар нь иргэдийн орон байранд нэвтрэн орсон хууль бус үйлдэл
 2. “Ж” нь бусдын эд хөрөнгийг санаатайгаар гэмтээсэн хууль бус үйлдэл
- “Ж”, “Х” нарын үйлдлүүд нь дээр дурьдсан гэмт хэргийн шинжийг агуулж байх тул тэднийг Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж болох юм.

Хоёр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болон Эрүүгийн хуулийн ямар хэм хэмжээ хэрэглэгдэхийг тодорхойлж, гэмт хэргийн зүйлчлэл хийх. Дээр дурьдсан үйлдэл тус бүрийн бүрэлдэхүүний шинжийг тодорхойлон шалгаж үзье.

1. “Ж”, “Х” нар нь иргэдийн орон байранд нэвтрэн орсон хууль бус үйлдэл

Объект: Иргэн “А”-гийн орон сууцны халдашгүй эрх

Объектив тал: “Х”, “Ж” нар хаалгыг нь эвдэн нэвтрэн орсон идэвхтэй үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай

Субъект: Эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай “Ж”, “Х”

“Ж”, “Х” нар нь иргэдийн орон байранд нэвтрэн орсон хууль бус үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 137 дугаар зүйл болох “Иргэдийн орон байрны халдашгүй байдлыг зөрчих” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байгаа тул шалгаж үзье.

137 дугаар зүйл. Иргэний орон байрны халдашгүй байдлыг зөрчих

137.1. Иргэнд хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж орон байранд нь хууль бусаар нэвтрэх, дур мэдэн орж суух, орон байрнаас гаргах, нэгжлэг хийх зэргээр орон байрны халдашгүй байдлыг зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

137.2. Энэ хэргийг албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Объект нь: Иргэдийн орон байрны халдашгүй байдал, орон байраа эзэмших, захиран зарцуулах, өмчлөх, халдашгүй чөлөөтэй байх эрх



Объектив тал: ... орон байрны халдашгүй байдлыг зөрчсөн идэвхтэй үйлдэл
Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай. Сэдэлт нь янз бүр байх бөгөөд хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд

Иргэдийн орон сууцны халдашгүй эрх бол Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний халдашгүй эрхийн нэг хэсэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т “Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасан билээ.

Улсын Дээд Шүүхийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолд “Орон байр” гэдэгт хүн байнга буюу түр амьдрахад зориулагдсан төрөл бүрийн орон сууц, байшин, гэр, урц, зочид буудал, амралт, сувиллын газар, зуслангийн байр, майхан зэргийг ойлгоно. Орон байр нь хөдөлгөөнтэй, түр зуурын шинжтэй байж болно” гэжээ.

Улсын Дээд Шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 16 дугаар тогтоолд “Нэвтрэх” гэж иргэний орон байранд зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар орохыг хэлнэ.

Улсын Дээд Шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолд “Хүч хэрэглэх” гэж бие махбодийн хүчирхийлэл хийхэд чиглэгдсэн аливаа идэвхтэй үйлдлийг хэлнэ. Харин “Хүч хэрэглэхээр заналхийлэх” гэдэгт бусдыг айлган сүрдүүлэх зорилгоор хийсэн сэтгэл санааны хүчирхийллийг ойлгоно. Энэхүү хүчирхийлэл нь идэвхтэй үйлдлээр илрэх бөгөөд гэмт этгээд үүнийг үгээр илэрхийлэхээс гадна биет байдлаар үзүүлсэн байж болно.

“Албан тушаалын байдлаа урвуулж” гэдэгт хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийн дагуу өөрт нь олгогдсон албаны болон бусад эрхийг санаатайгаар харш ашигласан явдлыг хамааруулна.

Улсын Дээд Шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 16 дугаар тогтоолд “Эрх мэдлээ хэтрүүлж” гэж хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэхийг хэлнэ.

Иймд “Ж”-ийн үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 137 дугаар зүйлийн 137.1, харин “Х”-ийн үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 137 дугаар зүйлийн 137.2-ийн гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй нийцэж байгаа тул дээрхи зүйлээр зүйлчлэх үндэстэй байна.

2. “Ж” нь бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгаж, гэмтээсэн хууль бус үйлдэл

Дээрх “Ж”-ийн үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн ямар хэм хэмжээтэй тохирч байгааг шалгая.

Объект: Иргэн “А”-гийн өмчлөх эрх

Объектив тал: “А”-гийн эд хөрөнгийг санаатайгаар устгаж, гэмтээсэн идэвхтэй үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай

Субъект: Эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай “Ж”

“Ж” нь иргэн “А”-гийн эд хөрөнгийг санаатайгаар устгаж, гэмтээсэн үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйл болох “Бусдыг эд хөрөнгийг

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

санаатайгаар устгах, гэмтээх” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж болохоор байгаа тул бүрэлдэхүүнийг шалгаж үзье.

153 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх

153.1. Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгасан буюу гэмтээсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

153.2. Энэ гэмт хэргийг галдан шатаах буюу нийтэд аюултай бусад аргаар үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Объект: Иргэдийн өмч хөрөнгөө өмчлөх зориулалтаар нь захиран зарцуулах эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал. Бусдын амь бие, эрүүл мэнд давхар объект болно

Объектив тал: Бусдын эд хөрөнгийг санаатай устгасан буюу гэмтээсэн үйлдэл

Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай. Хувийн сэдэлттэй

Субъект: 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд

Бусдын эд хөрөнгийг устгана гэдэг нь уг эд хөрөнгийг зориулалтаар нь ашиглах, эзэмших ямар ч боломжгүй болгосон, өөрөөр хэлбэл, сэргээн засварлаж болохооргүй байхыг хэлнэ.

Гэмтээнэ гэдэг нь уг эд хөрөнгийг сэргээн засварлаж болохоор байхыг хэлнэ.

Бодлогын нөхцөлд зааснаар “Ж” нь “А”-гийн эд хөрөнгийг санаатайгаар устган, гэмтээж 1.200.000 төгрөгийн хохирол учруулсан тул “Ж”-ийн үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжийг агуулж байгаа тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйлийн 153.1-р зүйлчлэх үндэстэй байна.

Гурав. Гэмт хэрэгт бэлтгэсэн, завдсан шинж байгаа эсэхийг тодорхойлох

1. “Ж”, “Х” нар нь иргэдийн орон байранд нэвтрэн орсон хууль бус үйлдэл. Иргэний орон байрны халдашгүй байдлыг зөрчих гэмт хэргийн хувьд объектив талын шинжид дурьдагдсан аль нэг үйлдлийг хийснээр гэмт хэрэг дуусгавар болно. Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг. Иймд “Ж”, “Х” нарын үйлдлийг төгссөн гэж үзэх бүрэн үндэстэй.
2. “Ж” нь бусдын эд хөрөнгийг санаатайгаар гэмтээсэн хууль бус үйлдэл. Бусдыг эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх гэмт хэрэг нь материаллаг бүрэлдэхүүнтэй. Өөрөөр хэлбэл, уг үйлдлийн улмаас хор уршиг учрах бөгөөд үйлдэл, хор уршиг хооронд шалтгаант холбоотой байна. Иймд “Х”-ийн үйлдлийг төгссөн гэж үзнэ.

Дээрх үйлдлүүдэд гэмт хэрэгт бэлтгэсэн, завдсан шинж байхгүй болно.



Дөрөв. Ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 137 дугаар зүйлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2-оос ялган авч үзье.

Эрүүгийн хуулийн 137 дугаар зүйл. Иргэний орон байрны халдашгүй байдлыг зөрчих	Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2. Бусдын эд хөрөнгийг хулгайлах
Объект: Иргэдийн орон байрны халдашгүй байдал, орон байраа өмчлөх, эзэмших, захиран зарцуулах, халдашгүй чөлөөтэй байх эрх	Объект: Бусдын өмчлөх эрх
Объектив тал: Орон байрны халдашгүй байдлыг зөрчсөн үйлдэл	Объектив тал: Орон байр, агуулах саванд нэвтэрч хулгай хийсэн үйлдэл (эд хөрөнгө хулгайлах зорилгоор бусдын орон байр, агуулах саванд зөвшөөрөлгүй, хуурч мэхлэх, хаалга, цонхыг эвдэх гэх зэрэг)
Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай. Сэдэлт нь янз бүр байна	Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай. Шунахай сэдэлтэй
Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд	Субъект: 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 153¹ харьцуулан авч үзье.

Эрүүгийн хуулийн 153 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх	Эрүүгийн хуулийн 153 ¹ дүгээр зүйл. Бусдын эд хөрөнгөд болгоомжгүйгээр хохирол учруулах
Объект: Иргэдийн өмч хөрөнгөө өмчлөх зориулалтаар нь захиран зарцуулах эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал. Бусдын амь бие, эрүүл мэнд давхар объект болно	Объект: Иргэдийн өмч хөрөнгөө өмчлөх зориулалтаар нь захиран зарцуулах эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал
Объектив тал: Бусдын эд хөрөнгийг санаатай устгасан буюу гэмтээсэн үйлдэл	Объектив тал: Бусдын эд хөрөнгөд болгоомжгүйгээр онц их хэмжээний хохирол учруулсан үйлдэл
Субъектив тал: Гэм буруугийн шууд санаатай. Хувийн сэдэлтэй	Субъектив тал: Гэм буруугийн болгоомжгүй хэлбэртэй
Субъект: 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд	Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд

Тав. Гэмт хэрэгт хамтран оролцсон эсэхийг тодорхойлох

Бодлогын нөхцөлд зааснаар нэг дэх үйлдэлд иргэн “А”-гийн гэрийн хаалгыг “Ж”, “Х” нар эвдэн орсон үйлдэл нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2-д зааснаар бүлэглэн гүйцэтгэгч болно. Бүлэглэн гүйцэтгэгч гэдэг нь

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

хоёр буюу түүнээс дээш этгээд урьдчилан үгсэж тохиролцоогүй боловч гэмт хэрэг үйлдэхдээ санаатай нэгдсэнийг ойлгоно.

Харин хоёр дахь үйлдэлд, “Ж”-ийн бусдыг эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх үйлдэлд санаатай хамтарсан шинж тогтоогдохгүй байна.

Зургаа. Гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал байгаа эсэхийг тодорхойлох

Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд болох аргагүй хамгаалалт, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах, гарцаагүй байдал, үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл, тушаал, захирамж биелүүлэх зэрэг нь бодлогын нөхцөлд байхгүй байна.

Долоо. Ял ногдуулах

“Ж”-ийн хувьд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 56 дугаар зүйлийн 56.1.2, 57 дугаар зүйлийн 57.1-д заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 137 дугаар зүйлийн 137.1, 153 дугаар зүйлийн 153.1-д зааснаар, харин “Х”-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 56 дугаар зүйлийн 56.1.2-ийг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 137 дугаар зүйлийн 137.2-д зааснаар ял ногдуулна.

Найм. Эрүүгийн хариуцлага ба ялаас чөлөөлөх

Бодлогын нөхцөлөөс үзэхэд “Х”, “Ж” нар нь эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөгдөх үндэслэл байхгүй байна.



Хоёрдугаар хэсэг.

Эрүүгийн процессын эрх зүйн бодлого бодох аргачлал

Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн (цаашид ЭБШ эрх зүй гэнэ) бодлого нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүхийн практик болон тодорхой тохиолдлыг бодлогын хэлбэрт оруулсныг оюутанаар онолын мэдлэг, чадвараа ашиглан, хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт гаргуулахад чиглэгдэнэ.

ЭБШ эрх зүйн бодлого нь бодлогын өгөгдлийг хуулийн заалт, онолын тодорхойлолт, хуулийн тайлбар зэргийг ашиглан харьцуулж, анализ хийн, няцаах, нотлох замаар шийдэлд хүрнэ.

ЭБШ эрх зүйн бодлого нь зөвхөн ганц, эсхүл хэд хэдэн тохиолдолд хариу шаардсан, мөн үндэслэлийг гаргавал хэдэн ч тохиолдол байж болохоос гадна нэг юмуу, хэд хэдэн сэдвийг нэгэн зэрэг хамарсан байж болно.

ЭБШ эрх зүйн бодлогын бэлтгэл процесс, бодолтын процесс, дүгнэлт гэсэн гурван үе шаттайгаар бодно.

Бэлтгэл процесс. Бодлогын өгөгдлийг оюутан бүрт өгч судлуулна. Оюутан бодлогын нөхцөлийн агуулгыг сайтар ойлгосон гэж үзвэл хэрэглэх хууль, онол, хуулийн тайлбарын хүрээ хязгаарыг тогтоох замаар эх сурвалжаа тодорхойлж, түүний тусламжтайгаар ямар ямар асуудлуудыг тодруулах ёстойг тогтооно. Үүнийг “зорилт” гэж томъёолж болно. Энэхүү ажиллагаа нь асуултад эцэслэн хариулах буюу дүгнэлт гаргахаас өмнө ямар асуудлуудыг шалгах, судалж, танин мэдэх болон харьцуулах шаардлагатайг тодорхойлсон асуултауд байх юм. Эдгээр зорилтыг хэрхэн зөв оновчтой тодорхойлсноос бодлого хялбар, системтэй, ойлгомжтой болох төдийгүй зөв бодох үндэс тавигдана.

Бодолтын процесс. Бэлтгэл шатанд томъёолсон зорилтууд (тодорхойлох асуудлууд) нэг бүрийг авч үзнэ. Энэ шатанд бодлогын нөхцөлийн агуулгыг эрх зүйн ерөнхий үндэслэлд (хуулийн үндэслэл, онол болон хуулийн тодорхойлолт, тайлбар) нийцүүлэх сүмсүмбци хийхэд оршино. Өөрөөр хэлбэл, үүний үр дүнд бодлогын нөхцөлийн агуулга буюу үйл явдал бүхэлдээ хууль, онол, тодорхойлолт, тайлбарт үндэслэгдэх бөгөөд эдгээрийг харьцуулан задлан үзэж, няцаалт, нотолгоо хийх замаар бодолт хийгдэнэ.

Дүгнэлт. Бодлогын нөхцөлд тавигдсан асуултад онолын ойлголт, тодорхойлолт, тайлбар, эсвэл хуулийн зүйл, заалт дээр үндэслэн дүгнэлт гаргана.



Бодлого 6

Нэгэн дээд сургуулиас оюутнуудын дунд зохиосон “Танилцах үдэшлэг” дээр эртнээс хувийн таарамжгүй харьцаатай байсан оюутан болох “Х”, “Д” нар харилцан зодолдож бие биедээ хөнгөн гэмтэл учруулсан хэрэгт ердийн журмаар хэрэг бүртгэлтийн ажиллагаа явагдаж дууссан байна. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шатанд тэр хоёр хоорондоо эвлэрчээ. Уг хэргийг СБД-ийн шүүхийн шүүгч “А” нь шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ “хоорондоо эвлэрсэн, хоёр биедээ учруулсан хохирлоо бүрэн төлсөн” гэдэг үндэслэлээр ЭБШ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-ийг баримтлан хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

Шүүгчийн захирамж үндэслэлтэй юу?

Бодолт:

Бэлтгэл процесс



Эх сурвалж:

Ном, сурах бичиг, гарын авлага:

- Амарбаясгалан Б. Эрхэсхулан Ж. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Сургалтын иж бүрэн гарын авлага 1. УБ., 2007
- Бат-Эрдэнэ Б. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2011
- Бямбаа Ж. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд. УБ., 2008
- Хамтын бүтээл. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. УБ., 2003

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002
- Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. УБ., 2002

Зорилт (тодорхойлох асуудлууд):

- Х, “Д” нар ямар гэмт хэрэг үйлдсэнийг нь тодруулах.
- Х, “Д” нарын үйлдсэн хэргийн харьяаллыг тодорхойлох.
- Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шат гэдгийг тодруулах.
- Х, “Д” нарын үйлдсэн хэргийг хэрэгсэхгүй болгох боломжтой эсэх.

Бодолтын процесс

1. “Х”, “Д” нар ямар гэмт хэрэг үйлдсэнийг нь тодруулах.

Бодлогын нөхцөлөөс харахад “Х”, “Д” нар нь “Танилцах үдэшлэг” харилцан зодолдож бие биедээ хөнгөн гэмтэл учруулсан байна. Энэ нь Эрүүгийн хуулийн



тусгай ангийн 99 дүгээр зүйл болох “Бусдын бие махбодод хөнгөн гэмтэл санаатай учруулах” гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж болохоор байна.

99 дүгээр зүйл. Бусдын бие махбодод хөнгөн гэмтэл санаатай учруулах

99.1. Бусдын бие махбодод хөнгөн гэмтэл санаатай учруулсан, өөрөөр хэлбэл эрүүл мэндийг нь түр хугацаагаар сарниулсан буюу хөдөлмөрийн чадварыг бага хэмжээгээр алдагдуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Уг гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 17 дугаар зүйлийн 17.2-д зааснаар хөнгөн гэмт хэрэгт хамаарч байна.

2. “Х”, “Д” нарын үйлдсэн хэргийн харьяаллыг тодорхойлох.

ЭБШ хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 177 дугаар зүйлийн 177.1-г зааснаар хөнгөн гэмт хэрэгт хэрэг бүртгэгч хэрэг бүртгэлт явуулдаг байна.

Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д заасан гэмт хэрэг нь ЭБШ хуулийн 414 дүгээр зүйлийн 414.1-д зааснаар хялбаршуулсан журмаар байцаан шийтгэх ажиллагаа явуулах хэрэгт хамаардаг. Энэхүү ажиллагаа явуулахыг сэжигтэн, яллагдагч, хохирогч харилцан зөвшөөрч, хүсэлт гаргасан, сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн, хохирогч хохирлын талаар маргаангүй тохиолдолд явуулдаг. Дурьдагдсан нөхцөл байдлууд нь байхгүй тохиолдолд хэрэгт ердийн журмаар хэрэг бүртгэлтийн ажиллагаа явагддаг. Бодлогын нөхцөлөөс үзвэл “ердийн журмаар хэрэг бүртгэлтийн ажиллагаа явагдаж дууссан” гэсэн нь дээр заасан хялбаршуулсан журмаар хэрэг бүртгэлтийн ажиллагаа явагдаагүй нь тодорхой байна.

3. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шат гэдгийг тодруулах.

Яллагдагчийг шүүхэд шилжүүлнэ гэдэг нь яллагдагчаар татсан тогтоол буюу прокурорын яллах дүгнэлт бүхий хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх боломжтой эсэхийг нягтлан шийдвэрлэж байгаа шүүхийн бие даасан шат юм.

Энэ шатанд яллагдагч гэм буруутайг нь нотлогдсон эсэхийг урьдчилан шийдвэрлэх буюу нотлох баримтуудыг хөдөлбөргүй, эсхүл зарим нотлох баримтыг бусад нотлох баримтаас илүү ач холбогдолтой гэж үзэж болохгүй.

Шүүхэд ирсэн хэргийн талаар шүүгч ЭБШ хуулийн 225 дугаар зүйлийн 225.1-д заасан шийдвэрийн аль нэгийг гаргадаг байна.

225 дугаар зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх

225.1. Шүүхэд ирсэн хэргийн талаар шүүгч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

225.1.1. яллагдагчийг шүүхэд шилжүүлэх

225.1.2. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр хэргийг буцаах

225.1.3. хэргийг түдгэлзүүлэх

225.1.4. хэргийг харьяалах шүүхэд нь шилжүүлэх

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

4. “Х”, “Д” нарын үйлдсэн хэргийг хэрэгсэхгүй болгох боломжтой эсэх.

Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох гэдэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн ажиллагааны явцад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тухайн эрүүгийн хэрэгт цугларсан нотлох баримтуудыг үнэлсэн боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэмт хэрэгт оролцсон болох нь нотлогдоогүй, эсхүл хуульд заасан байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал тогтоогдсоны улмаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн ажиллагааг цаашид үргэлжлүүлэн явуулах боломжгүй нөхцөл байдлыг буюу байцаан шийтгэх ажиллагааг бүрмөсөн зогсоохыг хэлдэг байна.

Эрүүгийн хэргийг шүүхийн өмнөх буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд ЭБШ хуулийн 209 дүгээр зүйлийн 209.1-д зааснаар прокурор өөрөө болон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн саналыг үндэслэн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай тогтоол гаргадаг бол шүүхийн шатанд шүүгч, шүүх бүрэлдэхүүн ЭБШ хуулийн 248 дугаар зүйлийн 248.1, 315 дугаар зүйлийн 315.1.3, 350 дугаар зүйлийн 350.1.4-д зааснаар хэрэгсэхгүй болгодог байна.

208 дугаар зүйл. Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл

208.1.1. энэ хуулийн 24.1.1-24.1.4-д заасан тохиолдолд (гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй; хөөн хэлэлцэх хугацаа дууссан; гэмт хэрэгт холбогдсон этгээд нас барсан; тухайн хэргийг урьд нь хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй байгаа);

208.1.2. нэмэлт нотлох баримт цуглуулах бүхий л ажиллагааг хийсэн боловч сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон болох нь нотлогдоогүй байвал;

208.1.3. энэ хуулийн 25.1-д заасан гэмт хэргийн хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй эвлэрсэн бол.

Үүнээс манай бодлогын нөхцөлд хамааралтай заалт нь гурав дахь нь байгаа тул ЭБШ хуулийн 25 дугаар зүйлийг авч үзье.

25 дугаар зүйл. Хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй эвлэрснээр хэргийг хэрэгсэхгүй болгох

25.1. Яллагдагч, шүүгдэгч нь Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэргийг анх удаа үйлдсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан нөхцөлд хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй сайн дураараа эвлэрсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Дээрх заалтаас харахад гагцхүү хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээдэд хамаардгаараа онцлог юм. Эл асуудлыг шийдвэрлэхдээ эрх бүхий субъект:

- а. Үйлдсэн гэмт хэрэг нь гэмт хэргийн ангиллын хувьд Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэрэг байх;
- б. Анх удаа үйлдсэн (Гэмт этгээд урьд нь гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлээгүй, эсхүл Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан ялгүйд



тооцох хугацаа өнгөрсөн байх);

- в. Гэмт үйлдлийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан;
- г. Хохирогчтой сайн дураар эвлэрсэн зэрэг нөхцөл байдлуудыг тогтоохын зэрэгцээ хохирогч яллагдагч, шүүгдэгчийн эрхшээлд байсан, өөр бусад шалтгааны улмаас өөрийн эрх ашиг сонирхлоо хамгаалж чадахгүй байгааг заавал тогтоох шаардлагатай.

Бодлогын нөхцөлөөс харахад “Х”, “Д” нар харилцан зодолдож бие биедээ хөнгөн гэмтэл учруулсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 99 дүгээр зүйлийн 99.1-д заасан хөнгөн гэмт хэргийн ангилалд багтаж байна, харин “Х”, “Д” нар анх удаа гэмт хэрэг үйлдсэн эсэх, учруулсан хохирлоо төлж, гэм хорыг арилгасан эсэх, сайн дураараа эвлэрсэн эсэх тухай дурьдагдаагүй байгаа тул дээрх шаардлагыг хангасан гэж ойлгон ЭБШ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д зааснаар хэрэг нь хэрэгсэхгүй болох боломжтой юм.

Дүгнэлт

Уг хэргийг СБД-ийн шүүхийн шүүгч “А” нь шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ “хоорондоо эвлэрсэн, хоёр биендээ учруулсан хохирлоо бүрэн төлсөн” гэдэг үндэслэлээр ЭБШ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-ийг баримтлан хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна. Гэвч дээр дурьдсанаар шүүгч яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ хэргийг хэрэгсэхгүй болгох талаар хуульд заагаагүй билээ. Иймд шүүгч “А” нь хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл байсан ч ийм захирамж гаргаж болохгүй бөгөөд хууль зөрчсөн үйлдэл болно. Харин энэ тохиолдолд шүүгч уг хэргийг ЭБШ хуулийн 228 дугаар зүйлийн 228.1-д заасан ёсоор яллагдагчийг шүүхэд шилжүүлэх захирамж гаргаж, шүүх хуралдааныг товлон зарлах ёстой болно.

228 дугаар зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх

228.1. Шүүгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд энэ хуульд заасан байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын эрхийг бүрэн хангасан, шүүх хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэхэд саад болох зүйл байхгүй гэж үзвэл яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай захирамж гаргаж, шүүх хуралдааны товыг зарлана.

Иймд СБД-ийн шүүхийн шүүгчийн захирамж үндэслэлгүй гэж үзнэ.



Бодлого 7

Тодорхой эрхэлсэн ажилгүй “Г” гэгч иргэн “Б”-ын амь насыг санаатайгаар хөнөөсөн хэрэгт холбогдон яллагдагчаар татагдан урьдчилан хорих төвд 2 сар гаруй хоригдсон бөгөөд орчны ахуй нөхцөлөөс болж түүний чихнээс булаг гоождог, мөн түүний бөөр нь хэвийн бус, суналттай болсны улмаас өмгөөлөгч “Д” түүнийг батлан даалтанд гаргахаар харьяа дүүргийн прокурор болох “С”-д зохих хүсэлтийг гаргасан байна. Гэтэл энэ хүсэлтийн хариуг 2 хоногийн дараа өгсөн бөгөөд тус хариунд “Г нь иргэн “Б”-ын амь насыг санаатайгаар хөнөөн гэм буруутай болох нь бидэнд байгаа нотлох баримтаар хөдөлбөргүй тогтоогдсон бөгөөд иймд түүнд авсан цагдан хорих арга хэмжээг өөрчлөх боломжгүй юм” гэж дурьдсан байв. Энэхүү өгсөн хариуг өмгөөлөгч “Д” нь ЭБШ хуулийг зөрчсөн байна гэж үзжээ.

Яагаад өмгөөлөгч “Д” нь ЭБШ хуулийг зөрчсөн байна гэж үзсэн бэ?

Бодолт:

Бэлтгэл процесс



Зх сурвалж:

Ном, сурах бичиг, гарын авлага:

- Амарбаясгалан Б. Эрхэсхулан Ж. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Сургалтын иж бүрэн гарын авлага 1. УБ., 2007
- Бат-Эрдэнэ Б. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2011
- Бямбаа Ж. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2008
- Хамтын бүтээл. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. УБ., 2003

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002
- Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. УБ., 2002

Зорилт (тодорхойлох асуудлууд):

- “Г”-г яллагдагчаар татагдах үндэслэлтэй байсан эсэх.
- “Г”-д цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэсэн нь үндэстэй эсэх.
- Өмгөөлөгч “Д” хүсэлт гаргах эрхтэй эсэх.
- Яллагдагчийн биеийн байдал муу гэдгээр батлан даалтанд гаргах үндэслэл болох эсэх.
- Прокурор “С”-ийн хариу хууль зүйн хувьд хир үндэслэлтэй эсэх.



Бодолтын процесс

1. “Г”-г яллагдагчаар татагдах үндэслэлтэй байсан эсэх.

Бодлогын нөхцөлд заасанчлан тодорхой эрхэлсэн ажилгүй “Г” гэгч иргэн “Б”-ын амь насыг санаатайгаар хохироосон байна. Хүний амь насыг хохироосон гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлд заасан байдаг. Уг зүйлд заасан “Хүнийг санаатай алах” гэмт хэрэг нь ердийн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдэгддэг. Уг гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 17 дугаар зүйлийн 17.5-д зааснаар хэргийн ангиллын хувьд онц хүнд гэмт хэрэгт хамаарна.

Үүний дагуу ЭБШ хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасны дагуу мөрдөн байцаалтын ажиллагаа явагдана. Мөрдөн байцаалтын шатанд “Г” нь гэмт хэрэг үйлдсэн нь хангалттай нотлох баримтаар нотлогдож байвал мөрдөн байцаагч ЭБШ хуулийн 196 дугаар зүйлийн 196.1-д зааснаар яллагдагчаар татах бөгөөд энэ тухай тогтоол үйлдэх ёстой.

36 дугаар зүйл. Яллагдагч

36.1. Энэ хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонгосон этгээдийг яллагдагч гэнэ.

Яллагдагчаар татагдсан этгээд ЭБШ хуулийн 36 дугаар зүйлийн 36.3-т заасан эрхүүдийг эдэлж, 36 дугаар зүйлийн 36.5-д заасан үүргүүдийг хүлээнэ.

Бодлогын нөхцөлд зааснаар “Г”-г яллагдагчаар татагдах үндэслэлтэй байжээ гэж ойлгогдохоор байна. Иймд гэмт хэрэг үйлдсэн нь хангалттай нотлох баримттай байна гэж ойлгоно.

2. “Г”-д цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэсэн нь үндэстэй эсэх.

Цагдан хорих арга хэмжээ нь таслан сэргийлэх арга хэмжээний хамгийн хүнд төрөл бөгөөд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг шүүгчийн зөвшөөрлөөр, тодорхой хугацаагаар, нийгмээс тусгаарлаж, эрх чөлөөг нь хязгаарлаж буй албадлагын арга хэмжээ юм.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх үндэслэлийг ЭБШ хуулийн 68 дүгээр зүйлийн 68.1-д заажээ.

68 дугаар зүйл. Цагдан хорих

68.1. Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор цагдан хорьж болно.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

“Г” нь онц хүнд гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа болохоор ЭБШ хуулийн 68 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хоригдож байгаа бөгөөд цаашид шаардлагатай гэвэл ЭБШ хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсэгт зааснаар үргэлжлүүлэн цагдан хоригдож болохоор байна.

69 дүгээр зүйл. Цагдан хорьж мөрдөх хугацаа, түүнийг сунгах журам

69.2. Яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа 2 сар хүртэл байна.

69.3. Хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан яллагдагчийг цаашид хорьж мөрдөх зайлшгүй шаардлагатай бол шүүх хорьж мөрдөх хугацааг тухай бүр 30 хүртэл хоногоор сунгах бөгөөд яллагдагчийг хорьж мөрдөх нийт хугацаа хүндэвтэр гэмт хэрэгт 4 сараас, хүнд гэмт хэрэгт 12 сараас, онц хүнд гэмт хэрэгт 24 сараас хэтэрч болохгүй.

Иймд “Г”-д цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэж 2 сар гаруй хорьсон байгаа нь үндэстэй бөгөөд хууль зөрчигдсөн зүйл байхгүй байна.

3. Өмгөөлөгч “Д” хүсэлт гаргах эрхтэй эсэх.

Юуны түрүүнд өмгөөлөгч гэж ямар оролцогч болохыг авч үзье. Өмгөөлөгч нь ЭБШ хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д зааснаар хуульд заасан журмын дагуу сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа бөгөөд ЭБШ хуулийн 172 дугаар зүйлийн 172.3-г заасан хойшлуулшгүй ажиллагаа явуулж эхэлсэн, ийм ажиллагаа явуулаагүй бол гэмт хэрэгт сэжигтнээр тооцсон үеэс эхлэн ЭБШ ажиллагаанд оролцдог этгээд. Ингэхдээ ЭБШ хуулийн 41 дүгээр зүйлд заасан эрх, үүргийг эдэлнэ.

Өмгөөлөгч нь ЭБШ ажиллагааны оролцогч болохын хувьд хүсэлт гаргах эрхтэй. Хүсэлт гэдэг нь байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах, хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шалган тогтоох, түүнчлэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах болон бусад асуудлаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд ЭБШ ажиллагааны оролцогчдоос гаргасан саналыг хэлдэг байна.

Иймд өмгөөлөгч “Д” нь ЭБШ ажиллагааны оролцогч болохын хувьд ЭБШ ажиллагааны аль ч үе шатанд өөрийн үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж, хүсэлт гаргах эрхтэй байна.

4. Яллагдагчийн биеийн байдал муу гэдгээр батлан даалтад гаргах үндэслэл болох эсэх.

Батлан даалт гэдэг нь ЭБШ хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д зааснаар байнга оршин суух хаягтай, тодорхой ажил, хөдөлмөр эрхэлдэг, хөрөнгийн эх үүсвэртэй, батлан даагчийн үүргийг бүрэн хүлээх чадвартай, насанд хүрсэн, хоёроос доошгүй хөндлөнгийн этгээдээс сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг төлөв томоотой байлгах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн дуудсан цагт ирүүлж байхыг хариуцаж бичгээр гаргасан хууль зүйн үр дагавар бүхий баталгаа юм.



Гэмт хэргийн ангилал болон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдлыг харгалзан урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох буюу өөрчилж болдог. Цагдан хоригдож буй “Г” нь урт хугацаагаар хоригдсоноос биеийн байдал нь дордож эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр хүнд өвчтэй гэсэн онош гарсан бол ЭБШ хуулийн 68 дугаар зүйлийн 68.9-д зааснаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хөнгөрүүлэн өөрчилж болно.

68 дугаар зүйл. Цагдан хорих

68.9. Хөнгөн гэмт хэрэгт сэрдэгдсэн буюу хүнд өвчтэй этгээд, жирэмсэн эмэгтэй, хөхүүл хүүхэдтэй эмэгтэйн хувьд энэ хуулийн 68.2-т заасан үндэслэл (68.2. Дараах нөхцөл байдал байвал хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорьж болно: 68.2.1. өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн; 68.2.2. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан; 68.2.3. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдсэн) байхгүй бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхийг хориглоно.

5. Өмгөөлөгч Дорж хүсэлт гаргах эрхтэй субъект үү?

Харин өмгөөлөгч нь ямар нэгэн эмнэлгийн шинжилгээ, дүгнэлт дурьдалгүйгээр “... чихнээс нь булаг гоождог, бөөр нь хэвийн бус суналттай болсон” гэсэн аман дүгнэлтэд тулгуурлажээ. Цаашид цагдан хорих нь “Г”-ийн эрүүл мэндэд муугаар нөлөөлөх тухай эмнэлгийн албан ёсны дүгнэлт гараагүй байгаа нь түүнийг батлан даалтанд гаргах үндэслэлийг бий болгож чадахгүй.

6. Прокурор “С”-ийн хариу хууль зүйн хувьд хир үндэслэлтэй эсэх.

Өмгөөлөгч “Д” нь прокурор “С”-д хүсэлтээ гаргасан боловч тухайн асуудлыг прокурор шийдвэрлэх эрхгүй, харин хариу мэдэгдэх нь зүйтэй. Прокурор ЭБШ хуулийн 70 дугаар зүйлийн 70.3, 217 дугаар зүйлийн 217.1-д зааснаар цагдан хорихоос бусад таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох эрхтэй.

Харин цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг өмгөөлөгчийн хүсэлт, хэрэг бүртэгч, мөрдөн байцаагчийн саналыг харгалзан хяналт тавьж байгаа прокурор санал гаргах ба шүүгч түүнийг үндэслэн захирамж гарган шийдвэрлэх ёстой.

Прокурор “С” нь “Г” нь иргэн “Б”-ын амь насыг санаатайгаар хөнөөн гэм буруутай болох нь бидэнд байгаа нотлох баримтаар хөдөлбөргүй тогтоогдсон...” гэсэн хариулт өгсөн байна. Прокурор нь тухайн хэргийн нотлох баримтыг үнэлж, өөрийн хувьд дотоод итгэл үнэмшилд (дотоод итгэл нь хийсвэр байх ёсгүй, хэргийн байдлыг хянаж үзсний үндсэн дээр хууль болон эрхийн ухамсрыг удирдлага болгосон тухайн албан тушаалтны итгэл үнэмшил байдаг) хүрч болохыг үгүйсгэхгүй бөгөөд уг итгэл үнэмшлээрээ бодлогын нөхцөлд гэм буруут урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоосон нь “Г”-ийн эрхийн хувьд гэм буруугүйн зарчимтай буюу ЭБШ хуулийн 13 дугаар зүйл болон ЭБШ хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-т заасантай зөрчилдөж байна.

13 дугаар зүйл. Гэм буруутгүйд тооцох

13.1. Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй.

7. Өмгөөлөгч Дорж хүсэлт гаргах эрхтэй субъект үү?

95 дугаар зүйл. Нотлох баримтыг үнэлэх

95.3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй.

Дүгнэлт:

Өмгөөлөгч “Д” нь ЭБШ хуулийн 13 дугаар зүйл болох “Шүүхийн шийтгэх тогтоол гаргах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй” байх гэсэн заалтыг үндэслэн ЭБШ хууль зөрчигдсөн гэж үзжээ. Иймд өмгөөлөгчийн дүгнэлт үндэслэлтэй байна.